

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ЭД ЭРХТНИЙГ ТАНИХ ГАРЫН АВЛАГА

Хууль сахиулах болон гааль, мэргэжлийн хяналт,
байгаль орчны ажилтнуудад зориулав.

Улаанбаатар
2017 он

ДАА 344.046
ННА 20.18
Д-893

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ЭД ЭРХТНИЙГ ТАНИХ ГАРЫН АВЛАГА

Ерөнхий редактор:

Б.Чимэддорж
С.Пүрэвсүрэн

Редактор:

Б.Гантулга (Шувуу)
С.Пүрэвдорж (Загасны ерөнхий шинж, загас)
С.Пүрэвсүрэн (Хөхтөн амьтад, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам)
Д.Суран (Ургамал)
Х.Тэрбиш (Сээр нуруутан амьтны ерөнхий шинж, мөлхөгчид)
М.Эрдэнэбаяр

Гэрэл зураг:

Н.Батсайхан © (Хулан адуу)
Б.Батхуяг © (Цэн тогоруу, бараан хэрэм, аргаль хонь)
А.Баясгалан © (Мазаалай баавгай, хавтгай тэмээ)
Б.Гантулга © (Цармын бүргэд, шилийн сар, идлэг шонхор, реликт цахлай, эгэл шаршувуу, шар үнэг, эрээн хүрэн, мануул мий, тахь адуу)
П.Ганхуяг © (Хармөрний молцог хандгай)
Б.Лхагвасүрэн © (Ойн булга, цагаан зээр)
Б.Мөнхчулуун © (Аполлон)
Д.Мөнхнаст © (Цоохор ирвэс)
Б.Мэндсайхан нар (2017) © (Загас)
Г.Нямдаваа © (Борцгор хотон, янгир ямаа)
Д.Өсөхжаргал © (Шилүүс мий)
С.Пүрэвсүрэн © (Бараан хэрэм)
Д.Суран © (Ургамал)
Х.Тэрбиш © (Мөлхөгчид)
Б.Чимэддорж © (Нөмрөг тас, монгол тарвага, хар сүүлтий, халиун буга, монгол бөхөн)
С.Шар © (Саарал чоно)
Guihong Zhang © (Соргог бөхөн)
Kanepori Miura © (Бор гөрөөс)
Интернит эх сурвалж © (Азийн минж, шарнад цөөвөр, хүрэн баавгай, цоохондой мий, баданга хүдэр, буган цаа, шивэр молцог хандгай)
WWF-Mongolia © (Бусад зураг)

Зохиогчийн эрх:

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн
Монгол дахь хөтөлбөрийн газар

Иш татах:

Чимэддорж, Б., Пүрэвсүрэн, С., Тэрбиш, Х., Гантулга, Б., Суран.
Д., Пүрэвдорж, С. (2017). *Амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтнийг таних гарын авлага*.
Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин
аялал жуулчлалын яам. Улаанбаатар хот, Монгол улс.

ISBN: 978-99978-1-460-9

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	7
УДИРТГАЛ	9
ТАЙЛБАР	11
СЭЭР НУРУУТАН АМЬТНЫ ЕРӨНХИЙ ШИНЖ	14
ДЭЭД УРГАМЛЫН БҮТЭЦ, ОНЦЛОГ	19
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАГАС	20
1.1. Тул	21
1.2. Шивэр хилэм	22
1.3. Амармөрний хилэм	23
1.4. Цагаан загас.	24
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МӨЛХӨГЧИД	25
2.1. Цоохор хонин гүрвэл	26
2.2. Замба гүрвэл	27
2.3. Нохой гүрвэл	28
2.4. Говийн гүрвэл	29
2.5. Тэмээн сүүл могой	30
2.6. Эгэл загалмайт могой.	31
2.7. Бамбай хоншоорт могой	32
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ШУВУУ	33
3.1. Нөмрөг тас	34
3.2. Цармын бүргэд	35
3.3. Шилийн сар	36
3.4. Идлэг шонхор	37
3.5. Хонин тоодог	38
3.6. Борцгор хотон	39
3.7. Цэн тогоруу	40
3.8. Реликт цахлай.	41
3.9. Эгэл шаршувуу	42
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨХТӨН АМЬТАД	43
4.1. Бараан хэрэм	44
4.2. Монгол тарвага	45
4.3. Азийн минж	46
4.4. Саарал чоно.	47
4.5. Шар үнэг.	48
4.6. Хярс үнэг	49

4.7. Шарнад цөөвөр	50
4.8. Хүрэн баавгай	51
4.9. Мазаалай баавгай	52
4.10. Ойн булга	53
4.11. Эрээн хүрэн	54
4.12. Голын халиу	55
4.13. Цоохор ирвэс	56
4.14. Шилүүс мий	57
4.15. Мануул мий	58
4.16. Цоохондой мий	59
4.17. Тахь адуу	60
4.18. Хулан адуу	61
4.19. Хавтгай тэмээ	62
4.20. Зэрлэг гахай	63
4.21. Баданга хүдэр	64
4.22. Халиун буга	65
4.23. Бор гөрөөс	66
4.24. Шивэр молцог хандгай	67
4.25. Хармөрний молцог хандгай	68
4.26. Буган цаа	69
4.27. Хар сүүлтий	72
4.28. Цагаан зээр	71
4.29. Соргог бөхөн	72
4.30. Монгол бөхөн	73
4.31. Янгир ямаа	74
4.32. Аргаль хонь	75

ТАВДУГААР БҮЛЭГ. ШАВЖ 76

5.1. Аполлон	77
------------------------	----

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. УРГАМАЛ 78

6.1. Сэрхэн хөхөөцэцэг	79
6.2. Гурвалсан шүрэнцэцэг	80
6.3. Хөхөө цүнхрэг	81
6.4. Булцуут түдэнхавх	82
6.5. Томцэцэгт саадганцэцэг	83
6.6. Цоохор саадганцэцэг	84
6.7. Шар саадганцэцэг	85
6.8. Цөлийн аргамжин цэцэг	86
6.9. Ягаан хүнхорс	87
6.10. Ягаан цээн	88
6.11. Дэрэвгэр жиргэрүү	89
6.12. Нангиад зээргэнэ	90
6.13. Жинэхэн онгол (Хусны мөөг)	91
6.14. Газрын үс (Хар өвс)	92
6.15. Монгол хунчир	93
6.16. Урал чихэр өвс	94
6.17. Зүүнгарын гоёо (Улаан гоёо)	95
6.18. Цагаан уул	96
6.19. Байгал гүүнхөх	97
6.20. Эгэл бавран	98

**ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ,
ДҮРЭМ ЖУРАМ 99**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ 100

7.1. Монгол улсын үндсэн хууль 100
7.2. Монгол улсын Хилийн тухай хууль. 101
7.3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 103
7.4. Амьтны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 120
7.5. Байгалийн ургамлын тухай. 134
7.6. Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралт Нэн ховор ургамлын жагсаалт 140
7.7. Ургамал хамгааллын тухай хууль 143
7.8. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 149
7.9. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль 155
7.10. Гаалийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 160
7.11. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль 165

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ 176

7.12. Улсын их хурлын 1998 оны 05 дугаар тогтоол (“Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай”) 176
7.13. Улсын их хурлын 1998 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалт”. 177
7.14. Улсын их хурлын 1998 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Монгол улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт”. 177

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ЖУРАМ. . . 178

7.15. Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоол (Жагсаалт батлах тухай) 178
7.16. Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолын хавсралт “Ховор ургамлын жагсаалт” 178
7.17. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол (Жагсаалт, журам батлах тухай) 186
7.18. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Ховор амьтны жагсаалт”. 186
7.19. Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоол (Жагсаалт, үнэлгээ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг батлах тухай) . . . 189
7.20. Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хэмжээ”. 190
7.21. Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоол (Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай) 192
7.22. Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ” 193
7.23. Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар

хавсралт “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”	204
7.24. Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоол (Журам батлах тухай)	217
7.25. Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам”	218

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ . . . 221

7.26. Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 139/а/148 дугаар хамтарсан тушаал (Жагсаалт батлах тухай)	221
7.27. Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 139/а/148 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Монгол оронд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалт”	221
7.28. Байгаль орчны сайдын 2007 оны 292 тушаал (Журам, загвар батлах тухай).	222
7.29. Байгаль орчны сайдын 2007 оны 292 тушаалын 1 дүгээр хавсралт “Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээжийг гадаад улсад гаргах журам”	223
7.30. Байгаль орчны сайдын 2007 оны 292 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Ан амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг гадаадад гаргах зөвшөөрөл”.	225
7.31. Байгаль орчны сайд, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн хамтарсан 2008 оны 120/51 тоот тушаал (Журам батлах тухай)	226
7.32. Байгаль орчны сайд, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн хамтарсан 2008 оны 120/51 тоот тушаалын хавсралт “Амьтныг шинжлэх ухааны зориулалтаар барьж, тэмдэглэх журам”	227
7.33. Байгаль орчны сайдын 2008 оны 213 дугаар тушаал (Журамд өөрчлөлт оруулах тухай)	229

ТАЛАРХАЛ.	236
АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ, ЦАХИМ ХУУДАС	237

ӨМНӨХ ҮГ

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн байгаль орчныхоо бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх, эрх зүй, эдийн засаг, удирдлага зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэх талаар онцгой анхаарал хандуулж, холбогдох эрх зүйн орчныг бий болгох ажлыг 1990-ээд оны дунд үеэс эхлэн эрчимтэй хийж, бие даасан 30 гаруй хууль, 200 шахам эрх зүйн актыг батлан хэрэгжүүлж байгаа боловч дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, улс орны нийгэм, эдийн засгийн эрчимтэй хөгжил, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн байгаль орчны эрх зүйн орчныг байнга шинэчлэх шаардлага тулгарсаар байна. Ийм ч учраас, УИХ-ын 2012 оны хаврын чуулганаар Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 7 хуулийн шинэчилсэн найруулга, 2 шинэ хууль болон бусад холбогдох 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 277 дугаар тогтоолоор батлагдсан “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-т нэн ховор, ховор амьтдыг хамруулан үзсэнээс гадна, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS) болон Зэрлэг амьтан ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн I, II хавсралтад бүртгэгдсэн амьтдын судалгаа, хамгаалал, сургалт сурталчилгаа, хуулийн хэрэгжилтийг хангах, боловсон хүчин бэлтгэх, чадавхжуулах зэрэг асуудлууд тусгагдсан байдаг.

Байгаль орчныг хамгаалах ялангуяа, ургамал, амьтны хууль бус агнуур, худалдааг бууруулах, таслан зогсооход олон нийтийн мэдлэг боловсролыг сайжруулах, холбогдох төрийн байгууллагуудын боловсон хүчнийг чадавхжуулах шаардлага зүй ёсоор тавигдсаар байгаа юм. Түүнчлэн байгаль орчны асуудал төрийн бодлогын тэрүүн эгнээнд тавигдаж буй өнөө үед Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санаачлага, дэмжлэгээр олны хүртээл болж буй тус бүтээлд ашиглалтад өртөмтгий зүйлүүдийг хамруулсан нь хяналтын байгууллагын улсын байцаагчид болон мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээг хангасан гарын авлага болж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Тус гарын авлагад Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS) болон Зэрлэг амьтан ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн I, II хавсралтад бүртгэгдсэн амьтан, ургамлын зүйлүүдийг хамруулснаас гадна, ер нь Монгол орны хэмжээнд хууль бус агнуур, худалдаанд ихээхэн өртөж буй ургамал, амьтны зүйлүүдийг сонгон авч оруулсан байна.

Тэдгээр ургамал, амьтны зүйлүүдийг ялган таних гадаад шинж, галбир төрх, биеийн хэмжээ болон тухайн зүйлүүдийн худалдаанд ихээр өртөж буй эд эрхтэн, бүтээгдэхүүний талаар тодорхой дурдаж, холбогдох зургуудыг оруулж, мөн тухайн зүйл Монгол улсын нэгдэн орж, соёрхон баталсан Олон улсын конвенцид бүртгэгдсэн эсэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар хэрхэн хамгаалагдсан байдлыг товч тодорхой дурджээ.

Түүнчлэн ургамал, амьтны хууль бус агнуур, худалдаатай холбогдох дээр дурдсан байгаль орчныг хамгаалах талаар шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хуулиуд, тэдгээрийн дагуу шинэчлэгдэн гарсан тогтоол шийдвэр, дүрэм журмыг Монгол Улсын хууль тогтоомж, УИХ-ын тогтоол, Монгол улсын Засгийн газрын тогтоол, журам, Монгол улсын Байгаль орчны сайдын тушаал зэргээр сэдэвчлэн оруулж, CITES-ийн зөвшөөрлийн бичиг, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, зүйлийг гадаадаас оруулах, гадаадад гаргах зөвшөөрөл, ан агнах тусгай зөвшөөрөл,

загас барих тусгай зөвшөөрөл, ахуйн зориулалтаар ан амьтан агнах, загас барих эрхийн бичиг зэргийн загваруудыг хавсаргасан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зүгээс цаашид хууль бус агнуур, худалдаатай тэмцэхэд төрийн байгууллагуудын хоорондын уялдааг сайжруулах, мэдээллийн нэгдсэн урсгалыг бий болгох чиглэл барьж байгаатай нийцсэн энэхүү гарын авлага манай орны хувьд ховордоод байгаа амьтан, ургамлын зүйлийг хамгаалахад бодит дэмжлэг болохоос гадна, байгаль хамгаалах буянтай үйлсэд зүтгэж буй хил, гааль, цагдаа, улсын мэргэжлийн хяналт, байгаль орчны ажилтан болон сонирхсон хэн бүхэнд хэрэг болох нь тодорхой юм.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

*Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга*



Г.НЯМДАВАА

Хүн төрөлхтний буруутай үйл ажиллагаа өсөн нэмэгдэхийн хирээр унаган байгаль уруудан доройтож байна. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн 1970-2012 оны хоорондох судалгаанаас үзэхэд, унаган байгалийн доройтол 2012 оны байдлаар 58% байгаа бөгөөд байгаль хамгаалах чиглэлээр бодит алхам, тууштай бодлого баримталж ажиллахгүй бол 2020 он гэхэд 67%-д хүрэхээр байна. Биологийн олон янз байдлын доройтлын хэмжээг 1970 оныхтой харьцуулж үзэхэд, хуурай газарт 38%, цэнгэг усанд 81%, далай, тэнгист 36% болсон байна. Биологийн олон янз байдлыг доройтуулж буй олон шалтгаануудын нэг нь зэрлэг амьтан, ургамлын хууль бус агнуур, худалдаа, хэт ашиглалт юм. Тухайлбал, дэлхийд жил тутам 25-30 мянган сармагчны төрлийн амьтад, 2-5 сая ховордсон зэрлэг шувууд, 500.0 мянган тоть шувуу амьдаар, 10 сая орчим мөлхөгчид, 15 сая орчим хөхтөн амьтны арьс ширийг худалдаалдаг байна.

Амьтан, ургамлын гадаад худалдаа жилээс жилд өсөн нэмэгдэж, тухайн зүйлүүд устаж болзошгүй болсныг харгалзан дэлхийн улс орнууд ховордсон амьтан, ургамлын гадаад худалдааг олон улсын хэмжээнд хянан зохицуулах зорилгоор 1973 онд АНУ-ын Вашингтон хотноо олон улсын хэлэлцээр байгуулсан нь эдүгээ “CITES-ийн конвенц” нэрээр дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн юм. Тус конвенцид манай улс 1996 онд 131 дахь гишүүн орон болж нэгдэн орсон билээ.

Манай улсаас “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн I хавсралтад хулан адуу, тахь адуу, мазаалай баавгай, голын халиу, цоохор ирвэс, бөхөн зэрэг 6 зүйл хөхтөн, хан бүргэд, эгэл шонхор, хар тогоруу, цэн тогоруу, жороо тоодог, борцгор хотон зэрэг 11 зүйлийн шувуу, II хавсралтад саарал чоно, хүрэн баавгай, шилүүс мий, мануул мий, цоохондой мий, баданга хүдэр, аргаль хонь зэрэг 8 зүйл хөхтөн, 52 зүйлийн шувуу, тэмээнсүүл могой, хармөрний ба шивэр хилэм, аполлон эрвээхэй бүртгэгдсэн байдаг. Эдгээрээс гадаад худалдаа, спорт агнуурын өндөр ач холбогдолтой зүйлд аргаль хонь, идлэг шонхор зэрэг амьтан орно.

Амьтан, ургамлын зүйл нь хүн төрөлхтний мөнхийн хэрэгцээ тул үүнийг зохистой ашиглах, хамгаалах асуудал аль ч улсын тухайд онцгой ач холбогдолтой. Иймд, улс орнууд төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээрийн дотроос амьтан, ургамлын зүйлийг хамгаалах талаарх олон улсын гэрээ хэлэлцээр чухал байр суурь эзэлнэ. Олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах үндсэн шалтгаан нь Нэгдүгээрт: олон зүйл амьтан хэд хэдэн улсын хилийг дамжин нүүдэллэдэг. Хоёрдугаарт: Олон улсын хэмжээнд биологийн бүтээгдэхүүнийг худалдаалах явдал ямарваа нэг зүйлийн нөөцийг хэтрүүлэн ашиглах, ховордуулах шалтгаан болсоор байгаа тул улс орон бүр экспорт, импортын үйл ажиллагаандаа хяналт, зохицуулалт хийх шаардлага тулгардаг. Гуравдугаарт: Амьтан ба ургамлын зүйлийн ач холбогдол нь зөвхөн нэг улсаар хязгаарлагдахгүй олон улсын хэмжээнд үнэлэгдэнэ.

Аливаа олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх нөхцөл нь тухайн гэрээнд нэгдэн орсон улс, түүний заалтыг хэрэгжүүлэх, зөрчсөн тохиолдолд тухайн улсын хууль тогтоомж зөрчсөнтэй адилаар хариуцлага тооцох, эсвэл тухайн конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дотоодын хууль тогтоомжийг баталж, хэрэгжүүлэх явдал юм. Манай улс дээрх конвенцид нэгдэн орсноор өөрийн орны ховордсон амьтан, ургамлын зүйлийг олон улсын хууль бус худалдааны уршигаар устах явдлаас сэргийлж, түүнчлэн бусад улс орны ховордсон зүйлийг хамгаалахад нь туслах үүрэг хүлээдэг. Ийм ч учраас тус конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор УИХ-аас 2002 онд “Ховордсон амьтан, ургамал,

тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль"-ийг баталж, нийтээр мөрдүүлэн хэрэгжүүлж байна.

Монгол улсын гааль, хилийн мэргэжлийн хяналт, хил хамгаалах газар, цагдаа, байгаль орчны ажилтнууд бол конвенцийн үзэл санааг хэрэгжүүлэгчид юм. Эдгээр байгууллагууд мэргэжлийн боловсон хүчний хувьд жилээс жилд өсөн бэхжиж, техник, тоног төхөөрөмжийн хангамж сайжирч байгаа ч зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг зүй бусаар наймаалах, хууль бусаар хил давуулах оролдлого тасрахгүй байна. Иймээс тус конвенцийн хавсралтад орсон болон ер нь манай орноос гадаадад худалдаалах өндөр магадлалтай зарим амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтний онцлох шинж, тодорхойлолтыг багтаасан гарын авлагыг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас 2008 онд Монгол улсын гааль, мэргэжлийн хяналтын алба, цагдаа, улсын байцаагч, байгаль хамгаалагчдын албан ажлын хэрэгцээнд зориулан гаргаж байсан билээ.

Үүнээс хойш, 2012 онд УИХ-аар Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон 7 хуулийн шинэчилсэн найруулга, 2 шинэ хууль, бусад 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиуд батлагдаж, түүний дагуу шинэчлэгдэн гарсан тогтоол шийдвэр, дүрэм журмыг тус гарын авлагат тусгах шаардлага зүй ёсоор тавигдсан юм. Тухайлбал, УИХ-аас 2012 онд "Амьтны тухай хууль"-ийг батлан гаргаснаар Амьтны аймгийн тухай болон Ан агнуурын тухай хуулиуд хүчингүй болсон байдаг.

Түүнчлэн, Монгол улсын Улаан ном (2013; 2016), Монгол орны шувууны Улаан данс (2011), Монгол орны ургамлын Улаан данс (2011) зэрэг бүтээлүүд шинээр болон шинэчлэгдэн хэвлэгдэж, олны хүртээл болсон байдаг бөгөөд тэдгээрийг тус гарын авлагат тусгав. Түүгээр барахгүй тус гарын авлагын мэдээллийн чанар, агуулгыг сүүлд хэвлэгдсэн ном, бүтээлүүдээр баяжуулан сайжруулж, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох үүднээс зураг, өнгө, загварын талаар ч анхаарч ажиллалаа.

Зөвхөн өөрийн орны хувьд ховордоод байгаа амьтан, ургамлын зүйлийг хамгаалаад зогсохгүй, олон улсын хэмжээний байгаль хамгаалах буянтай үйлсэд зүтгэж байгаа манай хил, гааль, цагдаа, улсын мэргэжлийн хяналт, байгаль орчны ажилтан нарт зориулан барьж байгаа энэхүү бяцхан гарын авлага дэлхий дахины өмнө Монголчууд бидний хүлээсэн үүргээ биелүүлэх их аяны нэгэн дөрөө болох нь дамжиггүй.

Их цагаан үйлс тань амжилт бүтээлээр дүүрэн байх болтугай.

*Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн
Монгол дахь хөтөлбөрийн газрын
Байгаль хамгааллын асуудал харууцсан захирал
Б.ЧИМЭДДОРЖ*

ТАЙЛБАР

Зүйлийн нэр - Түгээмэл нэр, шинжлэх ухааны нэр, Орос, Англи, Хятад нэрийг бичиж, цөөн зүйл дээр Монгол оронд тохиолддог салбар зүйлийн нэрийг хамт оруулав.

Биеийн хэмжээ – Тухайн амьтныг таних, бусад ижил төстэй зүйлтэй харьцуулан үзэхэд ашиглаж болох биеийн урт, сэрвээний өндөр, биеийн жин зэргийг оруулсан бөгөөд зарим зүйл дээр биеийн илүү олон хэмжээсийг нэмж оруулав.

Ерөнхий шинж – Тухайн зүйл амьтан, ургамлыг танихад ашиглаж болохуйц гадаад хэлбэр, төрх байдал, өнгө зүс, онцлог шинжүүдийг оруулав.

Ховордлын зэрэглэл – Монгол улсын Улаан ном (цаашид **Улаан ном** гэх)-ын статус хэрхэн туссан болон Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны Улаан дансны ангилал, шалгуураар Монгол орны загасны Улаан данс (2006), Монгол орны хоёрнутагтан, мөлхөгчдийн Улаан данс (2006), Монгол орны хөхтөн амьтны Улаан данс (2006), Монгол орны шувууны Улаан данс (2011), Монгол орны ургамлын Улаан данс (2011) зэрэг (цаашид **Улаан данс** гэх)-т тусгагдсан тухайн зүйл амьтан, ургамлын Олон улсын болон бүс нутгийн үнэлгээ болно. Тэдгээр улаан дансан дахь ховордлын зэрэглэлийг үнэлсэн ангиллын тодорхойлолтыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

УСТСАН (EX)	Хамгийн сүүлчийн бодгаль маргаангүйгээр үхсэн бол тухайн ангилал зүйн нэгжийг “Устсан” гэсэн ангиллаар үнэлдэг. Тухайн зүйлийн өмнө нь тархаж байсан бүх газар нутаг, амьдрах орчныг тохиромжтой цаг хугацаанд нарийн судалж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг “Устсан” гэсэн ангилалд оруулна.
БАЙГАЛЬД УСТСАН (EW)	Тухайн ангилал зүйн нэгжийн бодгалиуд зөвхөн таримал байдлаар, хэрэв зэрлэг амьтан бол тэжээмэл байдлаар үржүүлж байгаа, эсвэл тухайн зүйлийн популяцийг түүхэн тархац нутгийн гадна байгалийн нөхцөлд нь байлгаж байгаа бол “Байгальд устсан” гэсэн ангиллаар үнэлдэг. Тухайн зүйлийн уугуул нутаг, байж болох амьдрах орчныг хамруулан тохиромжтой цаг хугацаанд нарийн судалгаа хийж нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд “Байгальд устсан” гэсэн ангилалд оруулна.
БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД УСТСАН (RE)	Тодорхой бүс нутгийн хэмжээнд тухайн зүйлийн хамгийн сүүлчийн бодгаль үхсэн, эсвэл үзэгдэхээ байсан бөгөөд дахин энэ нутагт шилжин ирэх боломжгүй тохиолдолд “Бүс нутгийн хэмжээнд устсан” гэсэн ангилалд оруулдаг.
УСТАЖ БАЙГАА (CR)	Тухайн зүйлийн оршин амьдарч байгаа талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар “Устаж байгаа” гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл туйлын их байгааг илтгэх “Устаж байгаа” гэсэн ангилалд оруулдаг.

УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN)	Тухайн зүйлийн оршин амьдарч байгаа талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар “Устаж болзошгүй” гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл маш их байгааг илтгэх “Устаж болзошгүй” гэсэн ангилалд оруулдаг.
ЭМЗЭГ (VU)	Тухайн зүйлийн оршин амьдарч байгаа талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгуураар “Эмзэг” гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл их байгааг илтгэх “Эмзэг” гэсэн ангилалд оруулдаг.
ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ (NT)	Тухайн зүйлийн оршин амьдарч байгааг А-аас Е хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг гэсэн ангиллаар үнэлэх боломжгүй боловч ойрын ирээдүйд устаж, ховордож байгааг илтгэсэн дээрх ангиллын аль нэг рүү шилжин орж болзошгүй зүйлийг “Ховордож болзошгүй” гэсэн ангилалд оруулдаг.
АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ (LC)	Тухайн зүйлийн оршин амьдарч байгааг А-аас Е хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг эсвэл Ховордож болзошгүй зэрэг ангиллын аль нэгээр үнэлэх боломжгүй тохиолдолд “Анхааралд өртөхөөргүй” зүйл гэсэн ангилалд оруулдаг. Өргөн тархац нутагтай, элбэг зүйл энэ ангилалд хамаарна.
МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DD)	Тухайн зүйлийн популяцийн төлөв байдал болон тархацыг үндэслэн устах эрсдлийг тогтоох шууд ба шууд бус үнэлгээ хийхэд мэдээлэл хангалтгүй байгаа нөхцөлд “Мэдээлэл дутмаг” гэсэн ангилалд оруулдаг. Энэ нь тухайн зүйлийн талаар илүү их мэдээлэл хэрэгтэй, ирээдүйд судалгаа хийх шаардлагатай байгааг илэрхийлнэ.
ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ (NA)	Бүс нутгийн хэмжээнд үнэлэх шаардлага хангаагүй ангилал зүйн нэгжийг “Үнэлэх боломжгүй” гэсэн ангилалд оруулдаг.

Хамгаалагдсан байдал - Тухайн зүйл амьтан, ургамал “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)” болон Монгол улсын хууль, тогтоолоор хэрхэн хамгаалагдсан болохыг тайлбарлан оруулав.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora)-ийн Англи хэл дээрх товчлол болох CITES гэсэн нэрээр олны танил болсон (цаашид **CITES** гэх) байдаг. Энэ конвенц нь тодорхой зүйл болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдааг хянахад чиглэнэ. Конвенцид хамаарах зүйлүүдийн импорт, экспорт, ре-экспорт нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, шат дамжлагын дагуу хийгдэх ёстой. Конвенцид нэгдэн орсон тал, нэгдэж ороогүй аль нэгэн улстай зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйл, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн худалдаа хийх тохиолдолд Конвенцийн заалтыг мөрдөх үүрэг хүлээдэг. Конвенц нь дараах гурван хавсралттай бөгөөд хавсралт бүр нь ховордсон ургамал, амьтны зүйлийг агуулна. Үүнд:

CITES-ИЙН I ХАВСРАЛТ	Олон улсын худалдаа нь тухайн зүйлийн оршин тогтноход нөлөө үзүүлж байгаа, эсвэл нөлөө үзүүлж болох, устах аюулд орсон бүх зүйл хамаарна. Конвенцийн I хавсралтад орсон зүйлийн худалдааг хатуу хяналт зохицуулалттайгаар явуулдаг бөгөөд арилжааны зорилгоор худалдаалахыг үндсэндээ хориглож, судалгаа шинжилгээний зорилгоор экспортлох болон импортлоход экспорт, импортын баримт бичиг бүрдүүлэхийг шаарддаг.
CITES-ИЙН II ХАВСРАЛТ	Эдүгээ устах аюулд ороогүй ч тухайн зүйлийн цаашид оршин тогтноход харшлахаар ашиглалт явуулахгүй байх үүднээс олон улсын худалдааг хяналт зохицуулалттай явуулахгүй бол устах аюулд орж болзошгүй зүйлүүд багтдаг. Конвенцийн II хавсралтад багтсан зүйлүүдийг арилжааны зорилгоор худалдаалж болох бөгөөд экспортлох, импортлоход экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.
CITES-ИЙН III ХАВСРАЛТ	Аль нэгэн тал өөрийн улсын нутаг дэвсгэрийн дотор зохицуулах шаардлагатай гэж тодорхойлсон ба тэдгээрийн худалдааг хянахад бусад талуудтай хамтран ажиллах шаардлагатай хэмээн үзэж байгаа зүйлүүд багтана. Экспортлох, импортлоход гарал үүслийн гэрчилгээ болон тухайн зүйлийг энэ хавсралтад оруулсан улсаас экспортлож байгаа тохиолдолд экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS) анх байгуулагдсан газрын нэрээрээ Бонны конвенц гэж нэрлэгдэх болсон (цаашид **Бонны конвенц** гэх) бөгөөд тус конвенцийн хүрээнд нэгдэн орсон талууд өөрийн улсын нутаг дэвсгэрт амьдардаг, мөн дайран өнгөрдөг шувууд, далай тэнгисийн болон хуурай газрын зүйлүүдийг амьдрах орчныг нь хүрээнд хамгаалах үүрэг хүлээдэг. Уг конвенцид одоогоор 116 улс орон нэгдэн ороод байна. Бонны конвенцийн I ба II хавсралтын тухайд:

БОННЫ КОНВЕНЦ (CMS)-ИЙН I ХАВСРАЛТ	Тархац нутагтаа эсвэл тодорхой нэг хэсэгт нь устаж үгүй болох аюулд орсон нүүдлийн зүйлүүдийг Конвенцийн I хавсралтад оруулдаг. Аливаа улс эдгээр амьтад болон тэдний амьдрах орчныг хамгаалах, нөхөн сэргээх нүүдэллэхэд нь саад болдог бэрхшээлийг багасгах, мөн тэдэнд аюул болж болохуйц бусад хүчин зүйлийг хянах ёстой байдаг.
БОННЫ КОНВЕНЦ (CMS)-ИЙН II ХАВСРАЛТ	Тодорхой нэг зүйл амьтныг хамгаалах үйл ажиллагаанд олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байгаа тохиолдолд тухайн зүйл амьтныг Конвенцийн II хавсралтад оруулдаг. Иймээс Конвенцийн зүгээс II хавсралтад орсон нэг зүйл амьтан эсвэл ихэвчлэн нэг хэсэг бүлэг зүйл амьтдын хамгаалал болон менежментийн асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг хангах зорилгоор дэлхийн хэмжээний эсвэл бүс нутгийн хэмжээний гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллахыг шаарддаг.
Шаардлагатай бол зарим зүйлийг I ба II хавсралтын хоёуланд нь оруулж болдог.	

Мөн Монгол улсын нутаг дэвсгэрт тухайн зүйлийн тархац нутгийн хэдэн хувь нь улс тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаад байгаа талаарх мэдээллийг оруулж өгсөн бөгөөд энэ нь “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)” болон “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)”-ийн хүрээнд тухайн зүйлийн хамгаалагдаж буй тархац нутгийн хэмжээг илэрхийлнэ.


Эд эрхтэн, бүтээгдэхүүн - Тухайн зүйл амьтан, ургамлын худалдаалах боломжтой, эсвэл худалдаалагдаж буй бие, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, таних түгээмэл шинжийг зургийн хамт оруулав.

СЭЭР НУРУУТАН АМЬТНЫ ЕРӨНХИЙ ШИНЖ

Удам төрлийн холбоо, бүтцийн онцлог шинжийг үндэслэн амьтны аймгийг хүрээ, анги, баг, овог, төрөл, зүйл зэрэг ангилал зүйн үндсэн нэгжүүдэд ангилдаг. Иймээс, аливаа амьтны онцлог шинж, гадаад дүр төрх, арьс, үс, эвэр, туурай зэрэг эд эрхтний анатоми, морфологи шинжид тулгуурлан ямар анги, баг, төрөл, зүйлийн амьтан болохыг энгийн нүдэн баримжаагаар жишин тодорхойлж болно. Хууль бусаар агнагдаж байгаа амьтад, тэдгээрийн эд эрхтнийг танин мэдэхэд тухайн ангийн амьтдын ерөнхий шинжийг мэддэг байх нь чухал.

ЗАГАСНЫ ЕРӨНХИЙ ШИНЖ

Загасны биеийг толгой, их бие, сүүл гэсэн гурван хэсэгт хувааж болно. Амны дээд, доод эрүүний ирмэг дээгүүр хурц шовх олон шүдтэй. Гэхдээ тэднийг араа, соёо гэх зэргээр ялгах аргагүй, хэлбэр дүрсийн хувьд бүгд нэг адил байдаг. Загасны шүд идэш тэжээлийг заглах, хивэх чадваргүй бөгөөд аманд орсон хоол тэжээлийг гадагш алдахгүй тогтоон барих л үүрэгтэй юм. Загасны их бие, толгойн зааг дээр эвэрлэг хавтас байх ба ар тал нь их биеэсээ хөндийрэн салж, завсар гарсан байна. Үүнийг заламгайн хавхлага гэнэ. Уг хавхлагыг сөхөж харвал улаан өнгийн цацаг бүхий олон тооны нумалсан бүтэц үзэгдэнэ. Энэ бол загасны амьсгалын эрхтэн болох заламгай юм.



Загасны арьсанд олон тооны булчирхай байдаг. Тэдгээрийн шүүрэл биеийн гадаргууд ялгаран гардаг тул загасны бие маш гулгамтгай болжээ. Загасны арьсыг бие биеэ даран шигдсэн олон тооны ясан хайрс зай завсаргүй хучсан байна. Загас хос ба сондгой сэлүүртэй. Хос сэлүүр нь цээжний хоёр хажуу болон хэвлийн хэсэгт байдаг. Эдгээр хос сэлүүр нь хөдөлгөөний болон залуурын эрхтний үүрэг


гүйцэтгэнэ. Сондгой сэлүүрүүд нуруу, сүүл, сүүлний доод талд байрладаг. Эдгээр сэлүүр загасны биеийг усан дотор хөлбөрч хазайхаас хамгаалж, тэнцүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Загасны түрс гадна талаараа ямар нэг эвэрлэг бүрхүүлгүй байдаг.

Загасны нүд бол мэдрэх гол эрхтэн. Гэвч зовхигүй учир үл цавчран, байнга хараастай байдаг. Барьсан загасны нүдний байдал, хатаж хорчийсэн эсэхийг ажигласнаар агнагдаж баригдснаас хойш хэдий хугацаа өнгөрсөн, шинэ, хуучин зэргийг баримжаалан тогтоох боломжтой.

Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO)-ын мэдээгээр, дэлхийн хүн ам 50 жилийн өмнө жилд 80-90 сая тонн загас олборлож байсан бол өнөөгийн байдлаар жилд 158 сая тонн болж өссөн нь загасны түүхий эд ханаагүй тосны хүчлийн агууламж ихтэй, А, Д, Е бүлгийн амин дэм, төрөл бүрийн эрдэс бодисоор баялаг, шингэц сайтай байгалийн гаралтай түүхий эдийн эрэлт жилээс жилд ихэсч байгааг харуулдаг байна.

МӨЛХӨГЧИЙН ЕРӨНХИЙ ШИНЖ

Бидний сайн мэдэх гүрвэл, могойноос эхлээд яст мэлхий, хамелеон, матар зэрэг нь цөм мөлхөгчдийн ангид ордог. Эдгээрийг ангилал зүйн хувьд ийнхүү нэг ангид хамруулсан хэд хэдэн нийтлэг шинж бий.



Загас, хоёрнутагтантай харьцуулахад мөлхөгчид бол жинхэнэ хуурай газрын амьдралд дасан зохицсон амьтад юм. Зарим зүйлийн матар, яст мэлхий усанд амьдардаг ч тэд түүхэн хөгжлийн явцад хуурай газраас хоёрдогч удаагаа усанд шилжсэн амьтад гэж үздэг.

Мөлхөгчдийн бие гадна талаасаа эвэрлэг хайрсаар өвч бүрхэгдсэн тул арьс нь агаар нэвтрүүлэх боломжгүй болжээ. Иймээс тэд зөвхөн уушгиар амьсгална. Хавирга сайн хөгжсөн тул амьсгал авах, гаргах үйл ажиллагаанд цээжний хөндий чухал үүрэг гүйцэтгэнэ. Мөлхөгчдөд арьсны булчирхай бараг байхгүй, ялгаруулах эрхтний үүргийг аарцгийн бөөр гүйцэтгэнэ. Мөлхөгчдийн биеийн гадаад хэлбэр түрс олон янз хэдий ч толгой, их бие, сүүл гэж ялгана. Тэд таван хуруут дөрвөн


мөчтэй боловч амьдралын нөхцөлд зохицон хоёрдогч удаагаа хөлгүй болсон могой мэтийн зарим амьтад бас бий. Мөлхөгчдийн биеийн дотор үр тогтож, голдуу өндөглөн үрждэг. Тэд зузаан бүрхүүлтэй юмуу шохойлог хальстай, харилцан адилгүй тооны өндөг гаргаж газарт булна. Байгаль цаг уурын хүйтэн сэрүүн нөхцөлд тархсан зарим зүйл гүрвэл, могой амилсан зулзага төрүүлдэг. Энэ бол тухайн орчин нөхцөлдөө дасан зохицсоны үр дүн юм.

Мөлхөгчдийн нүдний ард дунд чихний хэнгэргийн хальс тод харагдах ба харин гадаад чих байхгүй. Мөлхөгчид хүйтэн цустай. Иймээс амьдрах орчныхоо дулааныг даган биеийн дулаан нь хувьсдаг.

ШУВУУНЫ ЕРӨНХИЙ ШИНЖ

Орчин үеийн дээд хөгжилтэй сээр нуруутан амьтдаас нисэх чадвартай бүлэг амьтад бол шувуу юм. Ийнхүү нисдэг болсонтой уялдан шувуудын биеийн бүтцэд бусдаас ялгарах зарим онцлог шинж бий.

Шувууны бие ерөнхийдээ өндөг маягийн хэлбэртэй, нарийн хүзүү, жижиг толгойтой байна. Дээд, доод ооч бүхий эвэр хошуутай. Дээд оочны уганд хамрын сүв, толгойн хоёр хажууд дээд, доод зовхи бүхий нүд бий. Нүд нь гуравдагч зовхи буюу завчрах хальстай. Нүдний ард хэнгэргийн хальсаар бүрхэгдсэн дунд чих өд сөдөөр бүрхэгдэн оршдог. Шувууны бие гадна талаасаа өд, сөдөөр өвч бүрхэгдсэн байна. Энэ нь шувуу биеийн дулаанаа алдаж, бээрч остохыг багасган, агаарт хөөрөн нисэхэд чухал нөлөө үзүүлнэ. Шувууны өд бүтцийн хувьд харилцан адилгүй. Тухайлбал, биеийн гадна талаар өд, түүний уганд сөд, ноолуур өд холилдон байрласан байна. Шувуу бүлээн цустай, биеийн дулаан нь тогтмол.




Шувууны өдийг гүйцэтгэх үүрэг, биеийн гадна талд хэрхэн байрласнаар нь бүрхүүл өд, дэвүүр өд, ноолуур өд гэх мэт ангилна. Бүрхүүл өд нь бүх биеийг хучин байрласнаар шувууны биеийн үндсэн хэлбрийг тодорхойлдог. Өмнөд мөчдийн араас ургаж, шувуу нисэхэд гол үүрэгтэй том өднүүдийг дэвүүр өд гэнэ. Шуу ясны араас ургасан дэвүүр өдийг нэгдүгээр зэргийн дэвэгч өд, атгаал чөмөгний араас ургасан дэвүүр өдийг хоёр дугаар зэргийн дэвэгч өд хэмээн ялган авч үздэг. Нисэх үед залуурын үүрэг гүйцэтгэдэг сүүлний том өднүүдийг залуур өд гэнэ.

Шувууны өмнөд мөчид далавч болон хувирчээ. Харин хойд мөчид болох хөл нь газраар явгалан явах эрхтэн юм. Шувууны арьс маш нимгэн, өд, сөднөөс өөр арьсны үүсэлтэй эрхтнүүд байдаггүй. Сүүлний уганд, биеийн нуруун талд байдаг сүүлний булчирхайнаас өөр арьсны ямар нэг булчирхай байхгүй. Энэ булчирхайнаас тусгай тосорхог шүүрэл ялгаран гардаг. Шувуу хошуугаараа энэ тосорхог шүүрлийг авч биеэ тослон, өд, сөдөө усанд норж, нэвтрэхээс хамгаална.

Шувуу гадуураа хатуу шохойлог бүрхүүл бүхий өндөг төрүүлдэг. Ихэвчлэн үүр засаж, өндгөө эх, эцэг бодьгалууд ээлжлэн дарна. Зарим шувууны өндөгнөөс бараг улаан нүцгэн, нүдээ нээгээгүй, ямар ч арчаагүй ангаахай гарна. Ийм шувуудыг ангаахайдгаг шувууд гэнэ. Өндөгнөөс шууд дэгдээхэй гарч бие даан хоол тэжээлээ эрж гүйдэг шувууд ч бас бий. Эдгээрийг дэгдээхэйдэг шувууд гэнэ.

ХӨХТӨН АМЬТДЫН ЕРӨНХИЙ ШИНЖ

Сүүгээр бойжигчид буюу хөхтөн амьтад нь сээр нуруутан амьтдын дотроос бие бүтцийн хувьд хамгийн өндөр хөгжилтэйд тооцогддог. Хөхтөн амьтад нь амьд зулзага төрүүлэн үржих ба үр төлөө хөгжлийн тодорхой шатанд сүүгээр тэжээдэг. Иймээс тэд сүүлний булчирхайтай болжээ. Бүлээн цустай, биеийн дулаан тогтмол. Мэдрэлийн эрхтнүүдийн хөгжил маш сайн. Сонсох, үнэрлэх эрхтэн онцлог бүтэцтэй болсон байна. Сонсголын эрхтэн нь дотоод, дунд, гадаад чих гэсэн гурван хэсгээс бүрдэл болно. Гадаад чих нь мөгөөрснөөс тогтсон чихний дэлбэн, сонсголын гадаад сүвээс тогтдог. Үнэрлэх эрхтэн нь олон тооны атрия, самалдагтай учир багтаамжийн хувьд үлэмж ихэссэн байдаг.



Хуурай газрын хөхтөн амьтдын мөчид нь хумс юмуу туурайгаар төгссөн байдаг. Энэ нь тэдний хөдөлгөөнд чухал үүрэгтэй. Бугын овгийн амьтад олон салаа ясан эвэртэй байх ба тэр нь жил бүр унаж солигдож байдаг. Харин тугалмайгны овгийн амьтдын эвэр солигддоггүй бөгөөд олон салаа үүсгэхгүй.

Үсний шинж чанар. Хөхтөн амьтдын бие бүхэлдээ үсээр өвч бүрхэгдсэн байдаг. Үсний гадаад өнгө зүс, хэлбэр хэмжээ, бүтцээр нь тухайн амьтны төрөл зүйлийг тодорхойлох боломжтой. Амьтны үсний бохирдол, гэмтлээр ямар аргаар (механик, дулаан, цахилгаан, галт зэвсгийн) агнагдсаныг мэдэх боломжтой. Тухайлбал,

амьтныг нүхэнд нь утаж алснаас үс харлах, түлэгдэх, хярваслагдах, цус хурах шинж тэмдэг ажиглагддаг бол хавхаар агнасан амьтны арьс тасрах буюу үс халцрах, хөлдөж наалдсан анг ховх татаж авснаас үс ноос зулгарч унасан байдаг. Төмөр урхиар барьсан жижиг амьтдын хүзүүний үс ноос урхины ороор холгогдож халцардаг.

Амьтны арьс хөрсжин, үс гүйцэж сор суусан үед агнах нь түгээмэл. Үүнтэй уялдан үс, арьсыг ашиглах зорилгоор ан амьтдыг өөр өөр улиралд агнадаг. Жишээ нь, суусар, солонго, цагаан үен, халиу, нохой зээх, үнэг, хярс, чоно, шилүүс, ирвэсийг гол төлөв өвлийн улиралд, тарвага, зурмыг ихэвчлэн намар тус тус агнадаг. Ер нь жилийн улирал, цаг агаараас шалтгаалан амьтдын үсний өнгө, өтгөн сийрэг, уян хатан чанар, урт богино байдал нь хувьсан өөрчлөгддөг. Булга, суусар мэтийн амьтны өвлийн үсний өнгө, зуныхаас онц ялгардаггүй. Харин цагаан үен, үнэг, чандаганы зүс улирлаар үлэмж хувьсан өөрчлөгддөг. Хавар зөөлөн үст амьтны үс ширэлдэн даахирч, эсгийгийрнэ. Эсгийрэлт нь амьтны арьсны гадаад өнгө үзэмжийг доройтуулна. Ийм учир ангийн арьсны шинжээр агнасан хугацааг баримжаалан тогтоож, хуулиар хориглосон хугацаанд агнасан эсхийг илрүүлж болно. Зарим амьтад жилд 2 удаа гууждаг учир үсний чанар, өнгө өөрчлөгддөгийг бас сайн анзаарч байх хэрэгтэй.

Ан амьтны арьсыг үсэн бүрхүүлийн тархац, хөрсний зузаан, нимгэн зэрэг шинж байдлын онцлогоос хамааруулж хэд хэдэн топографи хэсгүүдэд хуваадаг. Ер нь ан амьтны арьсыг нуруу, хээл гэсэн 2 үндсэн хэсэгт хуваана. Түүнчлэн хоншоор, дух, хүзүү, сэрвээ, хоолой, хажуу дал, өгзөг, хонго, цавь зэрэг нэлээд хэдэн хэсэгт нарийвчлан ангилна. Хоншоор гэж хамрын үзүүрээс хоёр нүдний хоорондын зайг, дух гэж толгойн дээд хэсгийн хоёр нүдний хоорондын зайнаас чих хүртэлх арьсыг, хацар гэж толгойн хоёр талын арьсыг, сэрвээ гэж дал хүртэлх хүзүүний үргэлжлэл хэсгийг, зоо гэж нурууны дагуух буюу арьсны төв хэсгийн арьсыг тус тус нэрлэх бөгөөд ихэнх амьтны арьсны зоо нурууны хэсэг нь нэлээд урт үсэн бүрхүүлтэй, бараандуу байна. Эдгээр топографи хэсгүүдийг мэдснээр хууль бусаар агнагдсан амьтны үсэнд үзлэг хийх, тэмдэглэл хөтлөхөд чухал ач холбогдолтой.

Амьтны эд, эрхтэн. Амьтдын мах, ясан болон цусан эвэр, булчирхай, цус, тос, өд, дотор эрхтнийг ясны жишил анатоми, хэлбэр хэмжээ, өнгө зүс, үнэр зэрэг онцлог шинжээр нь ямар зүйлийн амьтных болохыг таньж болно.

Хууль бус худалдаанд өртөж байгаа амьтдын эд, эрхтэн болох баавгайн савар, донид буюу цөс, хүдрийн заар, бугын чив засаа, цусан эвэр, согооны сүүл, тарваганы арьс, бөхөнгийн эвэр, ирвэсний арьс зэргийг энгийн ажиглалтын аргаар ялган таних бүрэн боломжтой. Хулангийн махыг адууны махнаас, аргалын махыг хонины махнаас, хар сүүлтний махыг цагаан зээр, хонь, ямааны махнаас, чонын махыг нохойн махнаас, баавгайн донидыг үхэр, сарлагийн цөснөөс энгийн нүдэн баримжаагаар ялган таньж болох анатоми, морфологи шинжийг амьтан тус бүрд тодорхойлон өгүүлсэн болно.

Амьтны махыг хуваан жижиглэсэн, яснаас нь салгасан, хэлбэр дүрсийг өөрчлөн боловсруулалт хийж өнгө үнэрийг дарах зэргээр гаднаас нь хараад шууд таньж тодорхойлох боломжгүй болгосон үед тэдгээрийн дээжийг судалгааны лабораторид хүргүүлэн ДНХ-ийн шинжилгээ хийлгэх нь зүйтэй.

ДЭЭД УРГАМЛЫН БҮТЭЦ, ОНЦЛОГ

Дээд ургамлууд нь голчлон хуурай газрын ургамлууд байдаг. Түүхэн хувьсах хөгжлийн хувьд ургамлын амьдралын нилээд урт хугацаа нь устай холбоотой байжээ. Силурийн галавын үед буюу 430 сая жилийн өмнөөс ургамал хуурай газарт шилжсэн түүхтэй.

Анхны хуурай газрын ургамлууд талломт бүтэцтэй болсон. Талломт бүтэц буюу хуурай газар шилжсэнтэй уялдан бат бөх эсийн бүрхүүл, тусгайлан ялгаваржсан эдүүд, амьдрах орчинтой холбоотойгоор бодисын солилцоо, хооллох үндсэн аргатай зохицож вегетатив эрхтэнүүд, бас бэлгийн үржилд зориулагдсан үржлийн эрхтэн сайн хөгжсөн байдаг.


Орчин үеийн дээд ургамлууд нь иш-навчит бүтэцтэй. Ургамлын бие газрын доорх эрхтэн-үндэс, газрын дээрх эрхтэн-найлзуураас бүрдэнэ. Үндэс бол иш-навчит ургамлыг хөрсөнд бэхлэж, тэндээс ус, эрдэс бодисыг шингээн авах үүрэгтэй вегетатив эрхтэн юм. Түүхэн хөгжлийн хувьд үндэс ишнээс хожуу үүссэн. Үндсэрхүү мөчир (ризоиоид)-өөс гаралтай. Харин одоо янз бүрийн гарал үүсэлтэй олон хэлбэрийн үндсүүдийг нийтэд нь үндэсний систем гэж нэрлэх болсон.

Найлзуур бол мөчир, нахиаг өөртөө агуулсан ишний тэнхлэг хэсэг юм. Найлзуур нь хуурай газрын амьдралд шилжсэнтэй холбоотойгоор үүсэж бий болсон. Найлзуур нь меристемдээс хэлбэржсэн нэг дамжуулах багц бүхий иш, навчийг хэлбэржүүлсэн нэгдмэл эрхтэн юм. Найлзуурын үүсэл буюу навч-ишт бүтэц нь ургамлын аймгийн томоохон ароморфоз билээ.

Иш бол үе зайдмалаас тогтох найлзуурын тэнхлэг хэсэг юм. Оройн ба хажуугийн меристемээр уртсаж ургадаг. Өөр дээрээ навч, нахиаг агуулна. Тулгуурын болон дамжуулах үндсэн үүрэгтэй. Ялангуяа үндэснээс навч руу, навчнаас бусад эрхтэн рүү дамжуулна.

Навч бол ишэн дээр хажуугийн байрлал эзлэн фотосинтез, хийн солилцоо, транспирацийн үүрэг гүйцэтгэнэ. Навч нь хавтгай хэлбэртэй, дорсовентрал бүтэцтэй эрхтэн. Үндэс, иш хоёр ургамлын гол тэнхлэгийг бүрдүүлнэ. Найлзуур, үндэс хоёр ургамлын вегетатив эрхтэн бөгөөд хооллох, өсөх процессуудыг нөхцөлдүүлнэ. Ургамлын бие эрхтэн цаашид ялгаваржин хөгжиж үржлийн процесст оролцох цэцэг-үр жимс-үрийг үүсгэдэг.

Бүх дээд ургамлын биеийн бүтэц нэг ерөнхий зүй тогтолтой боловч ургамал бүрт онцлог шинж байх нь ойлгомжтой. Ургамлын бүтэц-үйл ажиллагааны энгийн нэгж нь эс юм. Дээд ургамлын эсүүд гүйцэтгэх үйл ажиллагаатай уялдаатайгаар дээд зэргээр мэргэшиж ялгаваржсан байдаг. Дээд ургамлын эдийг бүрдүүлж байгаа эсүүд нь гарал үүсэл, бүтэцээрээ нэгдмэл, харин гүйцэтгэх үүргээрээ ялгаатай байдаг.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЗАГАС



ТУЛ

Hucho taimen Pallas, 1773

Обыкновенный таймень
Taimen
Zhe luo yu

БИЕИЙН УРТ **1.2-1.8 м**
ЖИН **22-45 кг**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие, толгой оливийн ногоон, сүүл хэсэг рүүгээ улаавтар бор. Өөхөн сэлүүр, сүв болон нурууны сэлүүрүүд гол төлөв хар улаан өнгөтэй. Хэвлий цагаанаас хар саарал болж өөрчлөгдөнө. Ам тэгш, том. Дээд эрүүний урт, нүднээс хойш давсан. Толгой дээрээ жижиг дугуй бараан толботой, биеийн гадаргуудаа Х хэлбэрийн, хагас сар хэлбэрт хар бараан толботой. Хайрс жижиг. Үржлийн үед атуух (эр)-ын биеийн гадаргуу зэсэн хүрэн, сүүлний сэлүүр улаан болно. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Самалдаг, тагнайд хүчирхэг шүдтэй. Заламгайн өргөс 11-12. Хажуугийн шугам 190-242, дунджаар 215 хайрстай. Тул загас 55 наслана. 7 насандаа бэлгэ боловсорч үржилд орно.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Амьтны тухай хууль (2012)-ийн 9.2.8-д зааснаар тул загасыг жил бүрийн 4-р сарын 01-ний өдрөөс 6-р сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Мөн тус хуулийн 9.8.6-д тул загасыг жил бүрийн 10-р сарын 30-ны өдрөөс дараа оны 6-р сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар амьдаар барихыг хориглосон. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Бүхлээр нь юмуу хэсэгчилсэн байдлаар хөлдөөх, давслах, утах, борцлох аргаар боловсруулан савлаж болзошгүй. Төв суурин газрын нийтийн хоолны газар, дэлгүүрүүдэд зарагддаг тохиолдол бий. Амьдаар нь зөөх, худалдаалах, мөнтүрсийг давслан савлаж худалдаалж болзошгүй. Тул загасны толгой болон арьсыг тусгайлан салгаж цэвэрлээд, тэлж хатаан бэлэг дурсгал, чимэглэлийн зориулалтаар худалдаалагдах магадлалтай.

ШИВЭР ХИЛЭМ

Acipenser baerii Brandt, 1869

Сибирский осетр
Siberian sturgeon
Si bi liya xun



БИЕЙН УРТ

1.0-2.0 м

ЖИН

4-201 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

Ховор зүйл (Улаан ном, 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1945 оноос агнахыг хуулиар хориглосон. CITES-ийн II хавсралт, Бонны конвенц (CMS)-ийн II хавсралтад тус тус бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.2.8-д зааснаар шивэр хилэм загасыг жил бүрийн 4-р сарын 01-ний өдрөөс 6-р сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн зүс бараан хүрэн, хэвлий цайвар шар. Бие уртавтарт, ээрүүл хэлбэртэй, нурууг дагасан нэг эгнээ, биеийн хоёр талаар, хэвлийг дагасан нэг эгнээ, бүгд 5 эгнээ ясжсан товхтой. Товхны тоо нуруунд 12-19, биеийн хоёр хажууд 26-44, хэвлийд 9-15. Товхон эгнээний хооронд жижиг ялтас ба ясжсан будаалгатай. Хошууны доод талд байрласан саран хэлбэрийн амтай. Толгойн доод талд хөндлөн эгнээ болсон 4 сахалтай. Арьс, ялангуяа толгойн хэсэгтээ товхон хайрстай. Сүүлний сэлүүр гетероцеркаль, тэгш хэмт бус дээд далбан нь илүү ургасан байх бөгөөд нурууны төгсгөл хэсэг нь тахийн түүн рүү орсон байх ба ганоид хайрстай. Эрүү шүдгүй.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Бүхлээр нь юмуу хэсэгчилсэн байдлаар хөлдөөх, давслах, утах, борцлох аргаар боловсруулан савлаж худалдаалж болзошгүй. Амьдаар нь зөөж, худалдаалах магадлалтай. Түрсийг давслан савлаж худалдаалж болзошгүй бөгөөд хилэмний түрс хар өнгөтэй байдгаараа бусад зүйлийн загасныхаас онцлог юм.

АМАР МӨРНИЙ ХИЛЭМ

Acipenser schrenckii Brandt, 1869

Амурский осетр
Amur Sturgeon
Shi shi xun



БИЕЙН УРТ

1.0-2.9 м

ЖИН

6-200 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Мэдээлэл дутмаг (Улаан данс, 2006)
Нэн ховор зүйл (Улаан ном, 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1995 оноос агнахыг хуулиар хориглосон. CITES-ийн II хавсралт, Бонны конвенц (CMS)-ийн II хавсралтад тус тус бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар амар мөрний хилэм загас (*Acipenser schrenckii*) нь нэн ховор амьтанд хамаарна. Энэ зүйл загасыг Онон голд байх магадлалтай хэмээн үздэг бөгөөд тус голын адгийг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамруулаад байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн гадаад төрхөөрөө шивэр хилэмтэй төстэй. Хошуу уртавтар шөвгөр. Нуруу боровтор буюу бараг хар, хажуугийн товхоос доош хэсэг цайвар, нуурууны сэлүүр болон сүүлний сэлүүр нуруу шигээ өнгөтэй, бусад сэлүүрүүд цайвар. Хөндлөн дугуйран зүсэгдсэн амтай. Сүүлний сэлүүр нь гетероцеркаль хэлбэртэй. Өөрөөр хэлбэл, тэгш хэмт бус дээд далбан нь илүү ургасан байх бөгөөд нурууны төгсгөл хэсэг нь тахийн түүн рүү орсон байдаг. Нуруу, биеийн хажуугийн товх хооронд жижиг ялтастай. Нуруунд 11-17, биеийн хажуугаар 32-47, хэвлийд 6-12 товхтой. Хоёр хажуугийн товхоос дээших биеийн хэсгийг жижигхэн будаалгууд бүрхээгүй, байвал маш жижигхэн. Цээжний сэлүүрийн (P) эхний гуурс маш сайн хөгжсөн. Заламгайн эхний нуманд 36-45 өргөстэй. Заламгайн өргөс дэвүүр хэлбэргүй.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шивэр хилэмний адил бүхлээр нь юмуу хэсэгчилсэн байдлаар хөлдөөх, давслах, утах, борцлох аргаар боловсруулан савлаж худалдаалж болзошгүй. Амьдаар нь зөөж, худалдаалах магадлалтай. Түрсийг давслан савлаж худалдаалж болзошгүй бөгөөд түрс нь хар өнгөтэй.

ЦАГААН ЗАГАС

Coregonus pidschian Gmelin, 1788

Сибирский сиг
Arctic whitefish, pidschian
Mandarin Chinese



БИЕЙН УРТ **<66 см**
ЖИН **<3.5кг**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Европын зэрлэг амьтан болон Байгалийн унаган идээшил нутгийг хамгаалах конвенц (Bern Convention)-ийн III хавсралтад орсон.

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие хажуугаасаа хавчгар, жижиг амтай, хошуу нарийн. Бие мөнгөлөг цайвар, хайрс том, элдэв толбо байхгүй. Нуруу бөгтөр. Өөхөн сэлүүр сайн хөгжсөн, ялангуяа атуухынх нь том. Заламгайн өргөс цөөн (19-25). Хажуугийн шугаманд 71-98 хайрстай. Цагаан загас 13 насална. 5-7 насандаа биеийн урт 38 см хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Амьтны тухай хууль (2012)-ийн 9.2.3-д зааснаар цагаан загасыг жил бүрийн 8-р сарын 01-ний өдрөөс 10-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Бүхлээр нь юмуу хэсэгчилсэн байдлаар хөлдөөх, давслах, нөөшлөх аргаар боловсруулан савлаж худалдаалж болзошгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МӨЛХӨГЧИД



ЦООХОР ХОНИН ГҮРВЭЛ

Phrynocephalus versicolor Strauch, 1876

Пестрая круглоголовка
Toad-headed agama
Bian se sha xi

БИЕЙН УРТ **6 см**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Голдуу хатаасан байдлаар бэлтгэнэ. Хатааж хэлбэршүүлсэн гүрвэлийг засч янзалсан чулуу, мод зэрэг тусгай суурин дээр байрлуулан бэлэг дурсгалын зориулалтаар худалдаалах боломжтой.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Хоолой, хэвлий, нурууны хайрс гөлгөр, харин цээжний хайрс үл мэдэг арзгар. Нурууны голоор байрлах хайрс бусдаасаа хэмжээгээр арай том. Биеийн зүс нь амьдрах орчныхоо ерөнхий өнгийг даган хувьсамтгай, олон янз. Гэвч нуруун тал нь их төлөв саарал, бор саарал юмуу хүрэвтэр, нурууны хоёр талаар хар хүрэн юмуу бараан өнгийн хэд хэдэн толботой. Мөн нуруун дээгүүрээ хар, хар хүрэн, шаравтар, тод саарал зэрэг янз бүрийн өнгийн толбо, тахирласан зураас болон цэгүүдтэй. Сүүлийн үзүүр доод талаасаа хар, дээгүүрээ 9 хүртэл тооны хөндлөн бараан судалтай. Хэвлий цагаан. Ийм судал мөчдийн дээгүүр бас бий. Хоёр суга нь улаан, толгой дугариг.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Цоохор хонин гүрвэлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.



ЗАМБА ГҮРВЭЛ

Laudakia stoliczkana Blanford, 1875

Агама Столички
Mongolian agama
Ju xi shu

БИЕЙН УРТ **15 см**
СҮҮЛНИЙ УРТ **21 см**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Голдуу хатаасан байдлаар бэлтгэнэ. Мөн савтай спиртэнд нэг юмуу хэд хэдээр нь хийж бэхжүүлсэн хэлбэрээр савлан бэлтгэх боломжтой.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн зүс хар, бор өнгөтэй, хүзүү, нурууны хэсгээр шар, улбар шар толботой. Толгойн дээд хэсэг, сүүлийн уг, мөчдийн дээд тал цайвар шаргал. Харин сүүл нь үзүүр тийшээ хар бараан өнгөтэй болно. Хэвлий нь шаргал. Амьдрах газрынхаа хад чулууны хаг өнгөрийг дагасан ивээлт өнгөтэй (хувьсамтгай) амьтан. Дээд уруулын бамбай хайрсны тоо 10-16, үүнээс 6-9 хайрс нь нүднээс урагш оршино. Сүүлний хайрс 3-4 эгнээгээр бүлэглэн үелсэн байна. Толгой, хүзүү, гуя, сүүлийн угаар орших хайрс нь хэмжээгээр томорч, арзгар өргөслөг болсон.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Замба гүрвэлийн тархац нутгийн 51% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ. Хятадын зах зээлд ширхэгийн үнэ 5 доллар хүрдэг байна.

НОХОЙ ГҮРВЭЛ

Teratoscincus przewalskii Strauch, 1887

Сцинковый геккон Пржевальского, Гобийский сцинковый геккон

Plate-tailed gecko

Xi yu sha hu

БИЕИЙН УРТ **9.2 см**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Нохой гүрвэлийн тархац нутгийн 37% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Бүхлээр нь хатаах юмуу этилийн спиртэнд бэхжүүлэн бэлтгэнэ. Спиртэнд хадгалсан гүрвэлийн өнгө цайвардуу шаргал харагдана. Мөн амьдаар нь зөөх, худалдаалах оролдлого гарч болзошгүй. Олон улсын хэмжээнд амьтны дэлгүүрт худалдаалахын зэрэгцээ уламжлалт анагаах ухаанд эмчилгээ сувилгааны зорилгоор ашигладаг.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Сүүлний урт их биеийнхээ уртаас ямагт богино. Толгой том, их бие бөөрөнхийвтөр. Сүүлийн дунд хэсгээс үзүүр хүртэл бие биеэ дэрлэж тогтсон хумс мэт хавтгай том хайрстай. Нүд том, түүний голч нь 5.3 мм хүрнэ. Чихний хоёр сүв нь дундуураа маш нимгэн сарьсан хаалттай тул гэрлийн эсрэг барьж харахад нэвт гэрэлтэнэ. Амьд гүрвэлийг болгоомжгүй барьснаас арьс нь маш амархан зулгарч гэмтэнэ. Нохой гүрвэл цайвар шаргал зүстэй, санчиг, хүзүүн дээгүүрээ хөндлөн хар хүрэн толботой, энэ нь их бие, нурууны дагуу хойшлох тутам цайвар хүрэн болно. Сүүлийн угаас хумслаг хайрс хүртлэх зайд хөндлөн тогтсон хоёр бүдэг цайвар хүрэн толботой. Хэвлий нь цагаан цайвар юмуу үл мэдэг шаравтар. Нуруу, их биеийн хайрс нь хэвлийн хайрснаас жижиг, олон тооны хар цэгтэй. Хэвлийн хайрс нь тийм хар цэггүй учир гөлгөр цагаан, сүүл нь махлаг, нэн хугарамтгай. Сайн ажиглавал хөлийн хуруу тус бүрээс нарийн цацаг мэт сэртэнгүүд хоёр тийш салаалан гарсан байна.





ГОВИЙН ГҮРВЭЛ

Eremias przewalskii Strauch, 1876

Гобийская ящурка
Gobi racerunner
Huang mo ma xi

БИЕЙН УРТ **10 см**
СҮҮЛНИЙ УРТ **7.5-13.5 см**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:
Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Хатааж бэлтгэнэ. Амьдаар нь худалдаалж болзошгүй. Дорно дахины ардын уламжлалт эмнэлэгт эмийн түүхий эдийн зорилгоор олборлон, амьтны дэлгүүрт худалдаалдаг тухай албан бус мэдээлэл бий.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Нүдний доод бамбай хайрс амандаа хүрээгүй. Доод уруулын бамбай хайрс 6-9. Дух хамрын бамбай хайрс ямагт 1, нүдний дээд бамбай хайрс духны болон дух зулайн хайрсаас жижиг мөхлөгөн хайрсаар тусгаарлагдаагүй. Дээд уруулын бамбай хайрс 8-13. Нурууны хайрс гөлгөр, нэг эгнээнд орших хайрсны тоо 30-41. Хоёр гуяны дотор талд, дунд чөмөгний дагуу нэг эгнээгээр цувран байрласан 11-17 сүв бий. Сүүлийн 9-10 дугаар үеийн нэг эгнээнд 26-37 хайрстай. Нуруун тал цайвар шаргал юмуу цайвар боровтор, эсхүл элсэн шаргал зүстэй. Ийм дэвсгэр дээр хүрэтэр өнгийн нарийн судлууд торлосон юмуу том толбо маягтай байрлана.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Говийн гүрвэлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.



ТЭМЭЭН СҮҮЛ МОГОЙ

Eryx tataricus Lichtenstein, 1823

Восточный удавчик
Tatary sand boa
Sha mang

БИЕЙН УРТ **98 см**
СҮҮЛНИЙ УРТ **6-7 см**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэлтэй. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Тэмээн сүүл могойн тархац нутгийн 33% орчим нь Говийн их болон бага дархан цаазат газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Эрүү завсрын бамбай хайрснаас хойш ихэвчлэн 2-3, хааяа 4 бамбай хайрс оршино. Хоёр нүдний хооронд нэг эгнээнд 7-9 тооны зөв биш олон өнцөгт бамбай хайрстай. Нүдний эргэн тойронд 10-14, ихэвчлэн 11-12 хайрс хүрээлэн оршино. Дээд уруулын хоёр дахь бамбай хайрс гурав дахиас ихэвчлэн намхан. Их биеийн хайрс 43-49. Хэвлийн хайрс нарийхан учир их биеийн доод талыг бүрэн эзлээгүй, тоо нь 169-213 байна. Их бие нь шаравтар бор өнгөтэй, түүн дээр бор, хүрэн, хар хүрэн, харавтар өнгийн толбууд нуруу, биеийн хажуугаар байрлана. Хэвлий нь тод бараан өнгийн толбо нилээд шигүү байрласан шаргалдуу цайвар өнгөтэй. Онигордуу нүдтэй, тэр нь хажуу тийш юмуу яльгүй дээш чиглэсэн байх тул сөлийсөн байдалтай харагдана. Тэмээн сүүл могойны сүүл эрхий хуруу мэт мухар байдгаараа бусад могойноос ялгагдана.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Голдуу хатаасан байдлаар бэлтгэнэ. Арьсыг нь авч дэлгэн хатаагаад хуйлсан байж болзошгүй. Хоргүй могой тул амьдаар нь худалдаалах магадлал өндөр.



ЭГЭЛ ЗАГАЛМАЙТ МОГОЙ

Vipera berus Linnaeus, 1758

Обыкновенная гадюка
Adder, common (European) northern viper
Yuan fu she, You she

БИЕЙН УРТ **74 см**

СҮҮЛНИЙ УРТ

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:
Эмзэг (Улаан данс, 2006)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Эгэл загалмайт могойн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Энэ зүйл могойн нурууны нэг эгнээний хайрс 19, сүүлний доорх хайрс эрэгчинд 32-46, эмэгчинд 24-38 хос. Хоншоорын үзүүр дугариг, түүний дээд хажуу ирмэггүй. Толгой нь нүдний өмнөд өнцөгтэй харалдаа дээд хэсгээрээ 3 жижиг, 3 том бамбай хайрсаар (эдгээрийн нэг нь духны, хоёр нь зулайн бамбай хайрс болно) бүрхэгдсэн байна. Энэ могойн их бие цайвар хүрэн зүстэй, нурууг дагаж тахиралсан хар бараан судалтай. Мөн нүднээс завьж хүрсэн хар судал бий. Толгой дээрээ хэрээс хэлбэрийн хээтэй, хэвлий нь цайвар хүрэн юмуу хар толботой. Заримдаа улаан хүрэн юмуу хилэн хар зүстэй могойнууд тохиолдоно. Сүүлний үзүүр цайвар шар эсхүл улбар. Хүүхэн хараа нь босоо.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Голдуу хатаасан байдлаар бэлтгэнэ. Арьсыг нь хуулан дэлгэж хатаагаад хуйлсан байх магадлалтай.



БАМБАЙ ХОНШООРТ МОГОЙ

Gloydus halys Hoge & Romano Hoge, 1981

Обыкновенный (Паласов) щитомордник
Halys (Central Asian) viper, mamushi, shchitomordnik
Hei mei fu

БИЕЙН УРТ	70 см
СҮҮЛНИЙ УРТ	БИЕЙН УРТААС 5.5-8.4 ДАХИН БОГИНО

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:
Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Бамбай хоншоорт могойн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Энэ зүйл могойн нурууны хайрс 23, хэвлийн хайрс 143-187, төгсгөлийн сүвийн бамбай хайрс 1, сүүлний доорх бамбай хайрс 31-56 хос, дээд уруулын бамбай хайрс 7-8 байна. Биеийн ерөнхий зүс их төлөв хул шарга юмуу хар хүрэн. Гэвч биеийн зүс маш хувьсамтгай. Тухайлбал, ой мод бүхий нутгийнх ихэвчлэн тод хар хүрэн, говь цөлийн бүсийнх цайвар юмуу бор шарга байна. Нуруу ба сүүлний дагуу хөндлөн цагаан судалтай. Энэ судал заримдаа дундуураа тасархайтсан байдаг. Биеийн хоёр хажуугаар тууш эгнэсэн цайвар бараан толботой. Хүүхэн хараа нь босоо. Нүд, хамрын сүвийн хооронд гүнзгий хонхортой тул зэрвэс ажиглахад хамрын 4 сүвтэй мэт байдгаараа бусад зүйлийн могойноос хялбар ялгагдана.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Бүхлээр нь хатааж бэлтгэнэ. Гадна арьсыг хуулсан үед эд эрхтнийг ялган таних боломж хомс.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ШУВУУ

НӨМРӨГ ТАС

Aegypius monachus Linnaeus, 1766

Черный гриф
Cinereous or Black Vulture
Tu jiu

ДАЛАВЧНЫ УРТ ЭР	71.5-82.5 см
ЭМ	70.5-81.3 см
ЖИН ЭР	7.8-11.5 кг
ЭМ	7.5-12.5 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2011)

Монгол улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2011)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Нөмрөг тасын дэвэгч болон сүүлний өдийг Монголчууд дээр үеэс нум сумны суманд залуур өд болгон ашиглаж ирсэн. Сүүлийн үед баар цэнгээний газруудад чихмэл хийж тавьдаг болсноос гадна, бөөгийн шашины эд өлгийн хэрэгсэлд тасын өдийг их ашиглаж байна. Тасын буулга хэмээн нэрлэх хоолой орчмын ноолуур бүхий хэсгийг авч ашиглах тал бий. Тасын өд, хумс зэргийг хил гаалиар гаргах боломжтой. Далавчны 1-р дэвүүр өд хар бараан зүстэй, 50-70 орчим см, 2-р дэвүүр өд хүрэн өнгөтэй 30-45 орчим см, сүүлний залуур өд 25-35 см, өдний голд 0.4-1.0 см хүртэл диаметртэй харьцангуй өргөн өдүүд байдаг.



ЕРӨНХИЙ ШИНЖ

Монгол орны хамгийн том махчин шувууны нэг. Эр, эм шувууд биеийн хэмжээгээр бараг ойролцоо. Нисэх үедээ алгуур удаан дэвэлт, өргөн далавчнаас урагш бага зэрэг цухуйх толгой, богино сүүл зэргээрээ бусад шувуунаас амархан танигдана. Эр, эм ялгаагүй бараан хүрэн зүстэй. Нүцгэн толгойг дагзны орчмоор ороон хучсан ноолуур цагаан, хоолойн хзүүвч өд гандмал хүрэн. Толгой том, жижиг өдлөгтэй. Хушуу хүчирхэг, урт, хавчиг, хурц үзүүртэй, хар. Хамрын нүх өргөн, дугуй хэлбэртэй. Бүдүүн, богино хөлтэй. Хуруу урт. Хумс мохоо, хар. Урт, өргөн далавчтай. Нүд хүрэн. Ангаахай нялх үедээ саарал ноолуураар хучигдсан байх ба 40 орчим хоногоос хар бараан өд сөд ургаж эхлэнэ. 90 орчим хоногоос бүрэн өдөлж нисэж эхлэх ба биеийн ерөнхий өнгө зүс бие гүйцсэн шувуунаас арай бараан, гялайсан өдтэй. Толгой дээрх ноолуур хар, хатуу. Гүеэ хар. Хөл, хзүүүний нүцгэн хэсэг, нүд тойрсон хүрээ цагаан.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Бонны конвенц (CMS) болон CITES-ийн II хавсралтад тус тус бүртгэгдсэн. Нөмрөг тасын тархац нутгийн 12.7% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЦАРМЫН БҮРГЭД

Aquila chrysaetos Linnaeus, 1758

Беркут
Golden Eagle
Jin diao



БИЕЙН УРТ	84-96 см
ДАЛАВЧНЫ УРТ	59.0-70.5 см
ЭР	65.0-74.1 см
ЭМ	29.0-33.2 см
СҮҮЛНИЙ УРТ	32.8-36.5 см
ЭР	3.24-4.44 кг
ЭМ	3.75-6.66 кг

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Бонны конвенц (CMS) болон CITES-ийн II хавсралтад тус тус бүртгэгдсэн. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.8.5-д цармын бүргэдийг жил бүрийн 11-р сарын 01-ний өдрөөс дараа оны 10-р сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар амьдаар барихыг хориглосон байдаг. Цармын бүргэдийн тархац нутгийн 9.0% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Эр нь эмээсээ биеэр жижиг. Эр, эм шувуу ижил, ерөнхийдөө хар хүрэн зүстэй. Хэвлий, гуя, сүүлний доод бүрхүүл өд алтлаг улбар шар. Хааяа цээж, хэвлийдээ улбар шар толботой. Дагз, шилэн хүзүү улбар шар. Хар бараан дэвүүр сааралдуу зураастай. Залуур бор саарал, үзүүр хэсэг нь хар хөндлөн судалтай. Нүд бор, хушуу хөх саарал, хөл шар. Хумс хар. Шилбэ хуруугаа хүртэл өдөөр бүрхмэл. Залуу шувуудын ерөнхий зүс арай тод хар бараан, өдний уг цагаан. Толгой, хүзүү тод улбар шар. Залуу шувуу 3 нас хүртлээ сүүлний өд цагаан, харин үзүүр хэсэг нь өргөн хар хөндлөн судалтай. Шилбэ цагаан. 2-р дэвүүрийн дундаас доош хэсэг цагаан байдгаас нисэхдээ далавч нь том цагаан толботой харагддагаар бие гүйцсэн бүргэдүүдээс ялгагдана.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2011)

Монгол улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2011)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Цармын бүргэдийг амьтны хүрээлэнгүүдэд солилцооны хэлбэрээр амьдаар нь худалдаалах, түүний чихмэл, арьс, өд, хумс зэргийг бэлэг дурсгалын байдлаар хилээр нэвтрүүлэх тохиолдол нэлээд байна. Иймээс цармын бүргэдийн өдийг бусад бүргэдүүдийн өдөөс, мөн байгалийн жамаар гуужин унасан өд мөн бишийг таньдаг, ялгадаг болох нь чухал юм. Цармын бүргэдийн өд сүүлний, далавчны, биеийн бүрхүүлийн хэмээн өөр хоорондоо нилээд ялгаатай байдаг ба тэдгээр нь тухайн шувууныхаа насны байдлаас болж өнгө зүс нь өөрчлөгдөнө. Цармын бүргэдийн далавч, сүүл, түүний хучилт том өдүүдийг л хүмүүс ихэнх тохиолдолд сонирхдог. Жишээ нь, Япон улсын нум сум хэрэглэгчдийн холбоо нь манайхаас 25 см-ээс урт сүүл, далавчны өдийг гэрээгээр авдаг. Мөн Баян-Өлгий аймагт цармын бүргэдийн 20 см-ээс богино өдүүдийг 10 орчмоор нь багцалж боогоод бэлэг дурсгалын дэлгүүрүүдэд тавьсан харагддаг. Тэр өднөөс худалдаж авсан гадаадын жуулчид түүнийг авч гарах нь мэдээж. Цармын бүргэдийн хумс харьцангуй том, хурц байдгаас түүгээр түлхүүрийн оосор, хүзүүний зүүлт зэрэг бэлэг дурсгалын зүйл хийдэг. Түүний хумсны урт дунджаар 31.5-60.6 мм, гэвч бусад бүргэдүүдийн хумснаас ялгахад төвөгтэй. Тас шувуу хэдийгээр бүргэдээс биеэр том боловч түүний хумс богино, харьцангуй мохоо байдаг нь өөрөө ан барьдаггүй, үхсэн амьтны сэг зэмээр хооллодогтой холбоотой гэж үздэг. Гэхдээ махчин шувуудын бараг бүх зүйл CITES-ийн хавсралтад орсон байдаг учир тэдгээрийн гаралтай аливаа түүхий эд, бүтээгдэхүүнд зөвшөөрөл авах шаардлагатай.

ШИЛИЙН САР

Buteo hemilasius Temminck & Schlegel, 1844

Мохноногий курганник

Upland Buzzard

Da kuang

БИЕЙН УРТ **61.0-72 см**

ДАЛАВЧНЫ УРТ
ЭР **44.5-48.0 см**

ЭМ **49.0-50.4 см**

СҮҮЛНИЙ УРТ
ЭР **25.5-27.8 см**

ЭМ **28.2 см**

ЖИН **800-1227 гр**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2011)

Монгол улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2011)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шилийн сарыг амьдаар буюу чихмэл байдлаар улсын хилээр гаргах оролдлого гарч болзошгүй. Учир нь энэ шувуу зөвхөн Төв Азид тархсан тул Европ, Африк, Австрали, Америк тивийн хүмүүсийн сонирхолыг ихээр татдаг.



ЕРӨНХИЙ ШИНЖ

Эр, эм хоорондоо ижил, нилээд хар хүрэнгээс цайвар бор хүртэл өнгө зүстэй. Биеийн ар хэсгийн өд улбар шар эмжээр бүхий бор хүрэн, далавчны хар бараан өдний уг, дотоод өдлөгүүд цайвар, залуур хар хөндлөн судалтай, хүрэн. Хэвлий бор шарга хөндлөн ба тууш зураастай. Хушуу, хумс хар. Зэтэр, савар шар. Шилбэ хуруугаа хүртэл өдөөр бүрхмэл. Ангаахай хөгжлийн эхний үедээ хөх саарал ноолуураар бүрхэгдсэн байх ба томрох тусам биеийн хучилт болон дэвүүр өдүүд шар эмжээртэй бор хүрэн өнгөтэй болж ургана. Нисэж буй залуу шувууд хэвлий болон залуур өдөндөө хөндлөн зураасгүй.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Бонны конвенц (CMS) болон CITES-ийн II хавсралтад тус тус бүртгэгдсэн. Шилийн сарын тархац нутгийн 9.0% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг хамрагдаад байна.

ИДЛЭГ ШОНХОР

Falco cherrug Gray, 1834

Соколь
Saker falcon
Lie sun

БИЕЙН УРТ ЭР	42.5-50.0 см
ЭМ	52.0-59.0 см
ДАЛАВЧНЫ УРТ ЭР	104-114 см
ЭМ	38.7-41.5 см
ЖИН ЭР	820-890 гр
ЭМ	970-1130 гр

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2011)

Монгол улс:

Эмзэг (Улаан данс, 2011)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Сүүлийн арав гаруй жилд идлэг шонхорыг амьдаар нь экспортлох, хулгайн аргаар гадаадад гарган худалдаалах явдал их гарах болсон. Мөн түүний чихмэл эсвэл далавч, сүүлний өдийг авч хил нэвтрэх тохиолдол байх бүрэн боломжтой. Иймээс хил, гаалийн байгууллагад ажиллаж буй хүмүүс энэ зүйл шувууг сайн таньдаг болох нь чухал. Түүний сүүлний залуур өд хөндлөн цагаан толботой 18-25 см урт, далавчийн дэвэгч өдүүд мөн хөндлөн толбо бүхий 20-41 см урт, эм шувууных эрийнхээс дунджаар 2-8 см-ээр урт. Тэдгээрийг амьдаар нь гаргахдаа тусгайлан бэлтгэсэн хайрцаг саванд хийнэ. Нүдийг тагласан малгай өмсгөнө. Шонхор барьдаг зориулалтын бээлий байна. Шонхрыг барихын тулд тагтаа ашигладаг учир түүнийг их хэмжээгээр барьж бэлтгэсэн байдаг.



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие гүйцсэн идлэг шонхор нь урт сүүлтэй, цагаан хүрнээс хар бараан зүстэй, цээж, хэвлий, гуя хучигч өдөндөө бараан толбуудтай. Сүүл бараан ба цайвар хөндлөн судлуудтай. Эм идлэгүүдийн өнгө эрийнхээсээ бүдэг, сахал ч төдий ялгарахгүй. Залуу шувуудын хушууны уг, савар хөх цэнхэр, сүүл богино, сахал бүдэг, толбо цөөн зэрэг шинж тэмдгээр бие гүйцсэн шувуунаас ялгагдана. Заримдаа цав цагаан зүстэй ч байх тохиолдол бий. Шонхрын төрлийн шувуудыг хушууны доод ирмэгт байх соёо маягийн товгороор нь бусад махчин шувуудаас амархан ялган таньдаг. Харин идлэг шонхор биеийн хэмжээгээр харьцангуй том байдгаараа бусад шонхруудаас ялгагдана.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

1990-ээд оноос хойш гадаад худалдаанд их өртөж байгаа шувуу. Монгол оронд өндөглөн зусдаг, нүүдлийн шувуу боловч зарим бодьгалууд өвөлжинө. Бонны конвенц (CMS) болон CITES-ийн II хавсралтад тус тус бүртгэгдсэн. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.8.4-д идлэг шонхор шувууг жил бүрийн 11-р сарын 15-ны өдрөөс дараа оны 6-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглосон байдаг. Идлэг шонхор шувууны тархац нутгийн 7.9% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ХОНИН ТООДОГ

Otis tarda Linnaeus, 1758

Дрофа
Great Bustard
Da bao

БИЕЙН УРТ **75-105 см**

ДАЛАВЧНЫ УРТ
ЭР **59.5-63.5 см**

ЭМ **44.0-49.5 см**

ЖИН
ЭР **7-14 кг**

ЭМ **3.8-6.5 кг**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2011)

Монгол улс:

Эмзэг (Улаан данс, 2011)

Нэн ховор зүйл (Улаан ном, 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Эр нь эмээсээ бараг 2 дахин том биетэй. Эр, эм ижил зүстэй бөгөөд толгой, хүзүү хөхөлбий саарал, хэвлий цагаан. Нуруу ерөнхийдөө бор шарга, хөндлөн хар бор судал маягийн толбуудтай. 1 ба 2-р зэргийн дэвүүр өд хар бараан. Уг хэсэгтээ цагаан. Дэвүүрийн дээд жижиг бүрхүүл өд цагаан саарал. Нисэх үед далавчин дээр нь том цагаан толбо тод харагдана. Залуурын захын 5 өд цагаан. Цагаан ирмэгээс дотогш хөндлөн хар судалтай. Эрэгчин нь эрүүн дороо урт сахал маягийн цагаан өдтэй. Залуу шувууд эхний жилийн намар эм шувуутай адил зүстэй. Толгойн магнай, дагз улбар шар, тууш хар толботой. 2-р зэргийн дэвүүр саарал толботой. Хушуу хар өнгөтэй боловч үзүүр нь бор саарал. Хөл бор ногоон. Биеийн зүс 3 наснаас тогтворжин, нас бие гүйцсэн шувууныхтай адил болно.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Хонин тоодог нь манай оронд өндөглөн зусдаг, зарим нутагт хаяа өвөлждөг, нүүдлийн ховор шувуу юм. Бонны конвенц (CMS)-ийн II хавсралтад бүртгэлтэй. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Хонин тоодгийн тархац нутгийн 6.1% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.



ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Хонин тоодгийн Монголд тархсан салбар зүйл (*Otis tarda dybowskii*) нь дэлхийн хэмжээнд ховордож буй шувуу юм. Өдийг нь судалгаа шинжилгээний зориулалтаар гадаадад авч гарах сонирхолтой хүмүүс олон байдаг.



БОРЦГОР ХОТОН

Pelecanus crispus Bruch, 1832

Кудрявый пеликан
White Pelican, Dalmation pelican
Ban zui ti hu

ДАЛАВЧНЫ УРТ

68-72 см

ХОШУУ
УРТ

37-45 см

ӨРГӨН
ЖИН

3.5-4.5 см

10-14 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2011)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2011)

Нэн ховор зүйл (Улаан ном, 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ


Биеийн ерөнхий зүс цагаан, том биетэй. Нуруу бор сааралдуу, дагз, шилний өд урт, буржгар, хөх саарал. Духны хэсэг өдтэй, зөвхөн нүдний орчим өдгүй нүцгэн. Хэвэл цагаан, 1-р зэргийн дэвүүр хар бараан. Хүчирхэг, урт, өргөн хушуутай. Хушуун дороо шар сарьсан ууттай. Орооны үед цул сарьс улаан болж хувирна. Хүзүүгээ арагш нь нугалж, далавчаа хүчтэй, цөөн дэвж ниснэ. Хөл бор. Залуу борцгор хотонгийн нуруу бүдэг тууш толботой. Дагз, шилний өд буржгар биш. Хөл, хушуу хар байна.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож ирсэн. Бонны конвенц (CMS)-ийн I, II хавсралтад болон CITES-ийн I хавсралтад тус тус бүртгэгдсэн. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Борцгор хотонгийн тархац нутгийн 13.2% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Энэ зүйл шувууны хошуугаар хурдан морины хусуур хийдэг нь борцгор хотон Монголд ховордохын үндсэн шалтгаан болдог. Монголоос гадаад оронд гаргах нь бага, харин орж ирэх тохиолдол өндөр байх магадлалтай. Хотонгийн хошуу дотооддоо тэр тусмаа баруун аймагт өндөр үнээр зарагддаг.



ЦЭН ТОГОРУУ

Grus vipio Pallas, 1811

Даурский журавль
White-naped Crane
Bai zhen he

БИЕЙН УРТ

110.0-136.5 см

ДАЛАВЧНЫ УРТ

51-60 см

ЭР

ЭМ

ЖИН

52.1-56.0 см

4-7 кг



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2011)

Монгол улс:

Эмзэг (Улаан данс, 2011)

Нэн ховор зүйл (Улаан ном, 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Цэн тогоруу нь Монголд өндөглөн зусдаг, нүүдлийн зүйл. Бонны конвенц (CMS) болон CITES-ийн I хавсралтад тус тус бүртгэгдсэн. Цэн тогорууны тархац нутгийн 9.9% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Эр нь эмээс биеэр арай том. Бие гүйцсэн шувууны биеийн ерөнхий зүс цагаан саарал, Дух, хацар өдгүй, улаан арьстай. Чихний өд цагаан саарал, толгойн бусад хэсэг, хүзүүний ар тал, хоолой, омрууны хэсэг цагаан. 1-р зэргийн дэвүүр, түүний бүрхүүл өднүүд хар бараан. 2-р зэргийн дэвүүрийн үзүүр мөн хар бараан, угийн хэсэг саарал. 3-р зэргийн дэвүүр бага зэрэг саарал туяатай цагаан. Залуур саарал, үзүүр хэсэгтээ хар. Хушуу шар ногоон, хөл улаан. Эр, эм шувууд ижил зүстэй бөгөөд эрэгчин биеэр арай том. Дэгдээхэй нь нялх балчир үедээ улбар шар зүстэй байснаа намар улбар шар толгойтой болж, хархираа тогорууны залуу шувуутай тун адил зүстэй болно.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Дэлхийн хэмжээнд ховор шувуу учир цэн тогорууг амьдаар нь гадаадын амьтны хүрээлэн, эсвэл амьтан үржүүлгийн төвүүдэд худалдах магадлал өндөр. Мөн чихмэл хийж худалдаалж болзошгүй.



РЕЛИКТ ЦАХЛАЙ

Larus relictus Lonnderi, 1931

Реликтовая чайка
Relict Gull
Yi ou

ДАЛАВЧНЫ УРТ
ЭР 33.7-36.2 см

ЭМ 33.4-35.4 см

ЖИН
ЭР 4.7-5.8 кг

ЭМ 4.2-4.9 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2011)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2011)
Нэн ховор зүйл (Улаан ном, 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Реликт цахлайн чихмэл, өд, өндөг гэх мэт зүйлийг авч гарч болзошгүй. Янз бүрийн зүйл цахлайнууд өөр хоорондоо тун төстэй өндөг гаргах учир ялган танихад нэн төвөгтэй.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Эр, эм ижил зүстэй. Толгой хар, нүднийхээ дээр, дор цагаан судалтай. Хушуу, хөл улаан хүрэндүү. Хүзүү, цээж, хэвэл, сүүл, далавчны дотор тал цагаан. Нуруу, далавчны дээгүүр үнсэн саарал. Залуур өдний үзүүрүүд өргөн бараан судалтай. Дэвүүрүүд үзүүрээсээ дундаа хүртэл хар бөгөөд дээр нь цагаан толбуудтай.

Залуу шувууд эхний жилдээ дух, хүзүү, хоолой цагаан, магнай, дагз бүдэг бараандуу зураастай. Хацрын цагаан өд үзүүрийнхээ ар талаар бараан судалтай. Нуруу, дэвүүрийн дээд бүрхүүл өд цагаан саарал, бүрхүүлийн ирмэг тод цагаан, түүний ар талаар хар бараан судалтай. Сүүлний дээд тал, хавирга, хэвлий тал цагаан. Залуур цагаан, үзүүрийн ар хар бараан судалтай. 1 ба 2-р зэргийн дэвүүр хар, үзүүр хэсэгтээ дусал маягийн цагаан толботой. Хушуу хар бараан, уг хэсэг рүүгээ цайвардуу болно. Хөл бор саарал.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Реликт цахлай манай оронд өндөглөн зусдаг, нүүдлийн ховор шувуу. Бонны конвенц (CMS) болон CITES-ийн I хавсралтад тус тус бүртгэгдсэн. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Реликт цахлайн тархац нутгийн 13.1% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭГЭЛ ШАРШУВУУ

Филин
Eurasian Eagle Owl
Diao xiao

Bubo bubo Linnaeus, 1758



БИЕЙН УРТ	59.0-68.5 см
ЭР	68.0-78.0 см
ЭМ	44.3-46.8 см
ДАЛАВЧНЫ УРТ	47.3-51.8 см
ЭР	2.0-2.9 кг
ЭМ	
ЖИН	

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2011)

Монгол улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2011)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шаршувууны өдийг Казах үндэстний айл бүр гэр орондоо байлган эрхэмлэхийн зэрэгцээ, малгай хувцсандаа хатгаж, морины дэл, сүүлэнд зүүн хэрэглэдэг. Сүүлийн үед бөөгийн шашины эд өлгийн чимэглэлд шаршувууны өдийг ихээр хэрэглэх хандлагатай байна. Эгэл шаршувууны чихмэл, өд, хумс зэргийг авч, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэн улсын хилээр нэвтрүүлэх оролдлого гарч болох юм. Мөн эгэл шаршувууг бүхлээр нь болон махыг дотоодын зах дээр худалдаалах магадлалтай.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Эр, эм, залуу шувууд ерөнхийдөө ижил бор шар зүстэй. Нуруу болон хэвлийн хэсэгт хар судал толботой. *B.b.ussuriensis* хэмээх зүйлхэн хэвлий хэсэгтээ толбогүй. Уртассан чих маягийн хар өд, цайвардуу толбуудтай, дотор талын өдлөгүүдийн эрмэг цагаан. 1-р дэвүүр өдний уг улбар шар, үзүүр нь ямар нэг хэмжээгээр хар судлуудтай. Залуур хөндлөн хар толбуудтай. Нүүрний өд цайвар, саарал. Хоолой цагаан. Хэвлий улбар шар, цээж, гүеэний дагуу байх өргөн хар толбууд хэвлий рүүгээ нарийсна. Бие гүйцсэн эм шувуу эрээс нилээд бараандуу харагдана. Хушуу, хумс хар.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Мэрэгч амьтдын тоо толгойн хэт олшролтыг хязгаарлахад чухал үүрэгтэй шувуу хэмээн үзэж 1972-1987 онд дархан цаазат амьтны тоонд оруулан хамгаалж байв. CITES-ийн II хавсралтад бүртгэлтэй. Эгэл шаршувууны тархац нутгийн 7.8% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨХТӨН АМЬТАД

БАРААН ХЭРЭМ

Sciurus vulgaris Linnaeus, 1758

Обыкновенная белк
Brown squirrel
Song shu



БИЕЙН УРТ	160-280 мм
СҮҮЛНИЙ УРТ	140-220 мм
ЧИХНИЙ УРТ	27-36 мм
ТАВХАЙН УРТ	50-63 мм
ЖИН	200-400 гр

ЕРӨНХИЙ ШИНЖ

Хар бараан сортой, ноолуур үс цайвар саарал өнгөтэй, хэнхдэг цээж орчим цагаан цайвар, сүүл нь хоёр хажуу тийш сэрсийсэн сагсгар, ширүүн хялгасан өтгөн сахлаг үстэй. Урт соотон чихний үзүүрт багц үс ургасан. Жилд 2 удаа гуужина. Эхнийх 2 сарын сүүлээс 5 сарын дунд үе, намрынх 9 сарын дундаас 10 сарын эцэс хүртэл үргэлжилнэ. Толгойн ясны кондилобазаль урт 44-50 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 1/1; соёо 0/0; бага араа 2/1; их араа 3/3=22.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Агнуурын амьтан. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.2 дахь заалтаар бараан хэрэмийг жил бүрийн 2-р сарын 11-ний өдрөөс 11-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тоо хязгаарын дотор ахуйн зориулалтаар орон нутагт зөвшөөрөл авч, хураамж төлж нэг удаагийн эрхийн бичгээр 5 хоногт 1 толгойг агнаж болно. Бараан хэрэмний тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Олон улсын үслэг ангийн худалдаанд нийлүүлэх зорилгоор хууль бусаар их хэмжээгээр агнаж байна. Арьсыг худалдаалдаг. Дээр дурдсан биеийн хэмжээ, өнгө зүс, онцлог шинжээр арьсыг ялган тодорхойлж болно. Нас гүйцсэн хэрэмний арьсны талбайн хэмжээ дунджаар 320-400 см², ноолуурын урт 17-19 см.



МОНГОЛ ТАРВАГА

Marmota sibirica Radde, 1862

Монгольский сурок
Siberian marmot
Cao yuan han ta



БИЕИЙН УРТ	50-63 см
СҮҮЛНИЙ УРТ	9-16 см
ЖИН	2.7-8.0 кг

ЕРӨНХИЙ ШИНЖ

Бахим биетэй, мөчид ахар, хулгар чихтэй. Урд хөл 4, хойт хөл 5 хуруутай. Дагз болон сүүлний үзүүр хар бараан, хацар шанаа цайвар, хэвэл шаргал. Манай оронд монгол тарвага, алтайн тарвага гэсэн 2 зүйл бий. Алтайн тарваганы үс илүү өтгөн сахлаг, сор үсний үзүүр бараан, арьс хэмжээний хувьд харьцангуй том. Хавар ичээнээс гараад бараг сар орчмын дараа гуужина. Толгойн ясны кондилобазаль урт 72-79 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 1/1; соёо 0/0; бага араа 2/1; их араа 3/3=22.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Агнуурын амьтан. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.3 дахь заалтаар тарвагыг жил бүрийн 10-р сарын 16-ны өдрөөс дараа оны 8-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Хуулиар зөвшөөрсөн агнах, барих хугацаанд нэг удаагийн эрхийн бичгээр 3 хоногт 5 толгойг агнаж болно. Монгол тарваганы тархац нутгийн 6% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:
Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Арьсыг хил дамжуулан худалдаалдаг. Арьсны шинж байдлаар хэзээ агнагдсаныг багцаалж болно. Дээр дурдсан биеийн хэмжээ, өнгө зүс, онцлог шинжээр арьсыг ялган тодорхойлно. Дотоодод мах, өөх, дотор эд эрхтэн болох элэг бөөр, ясыг зарж борлуулна. Мах нь онцгой содон үнэртэй, царцахгүй тослог шинжтэй.



АЗИЙН МИНЖ

Castor fiber Linnaeus, 1758

Бобр
Beaver
Hai li

БИЕЙН УРТ	74.0-86.5 см
СҮҮЛНИЙ УРТ	26.5-29.5 см
СҮҮЛНИЙ ӨРГӨН	13.5-15.3 см
ЖИН	16.0-22.5 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)
Нэн ховор зүйл (Улаан ном, 1997; 2013; 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Минжийн арьсаар эд зүйл хийх, махыг нь хүнсэнд хэрэглэх, анхилам үнэрт булчирхайг (үнэртний бүтээгдэхүүнд хэрэглэдэг) нь ашиглах зорилгоор агнадаг. Түүний арьсыг хил дамжуулан худалдаалах магадлалтай. Дээр дурдсан биеийн хэмжээ, өнгө зүс, онцлог шинжээр арьсыг ялган тодорхойлж болно.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Монгол орны хамгийн том мэрэгч. Бие бахим, бөгтөрдүү, толгой нь их бие рүүгээ шууд үргэлжлэн нийлэх тул хүзүү тод илрэхгүй. Чихний дэлбэ хулгар, толгойн үснээс цухуйх төдий. Биеийн зүс ерөнхийдөө цайвар хүрэн, бор шаргал байна. Хэвлий хэсэг бусад хэсгээ бодвол нилээд цайвар. Сор үс нь урт, ширүүн, цайвардуу байх ба өтгөн зөөлөн ноолууртай. Хойд хөлийн сарвуунуудын хооронд усанд сэлж шумбахад зохицсон арьсан холбоос бий. Хойд мөчдийн хоёрдугаар хуруу давхар хумстай. Урд мөчдийн хуруунууд салангид, хөдөлгөөн сайтай, түүгээрээ идэш тэжээлийн зүйл барьж мэрнэ. Хайрсаар бүрхмэл, хавтгай, дээд голоороо таг хянга бүхий сүүлтэй. Сүүлээрээ ус балбаж, чимээ гарган бусаддаа дохио өгнө. Минжийн үүдэн шүд том, маш хүчирхэг цүүц хэлбэртэй, улбар шар өнгөтэй.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1930 оноос агнахыг хуулиар хориглож ирсэн. Минж нутагшуулах Монгол-Германы хамтарсан экспедици 1974, 1975, 1978, 1985, 1988 онд нийт 64 минжийг Ховд, Тэс голуудад нутагшуулснаар тогтвортой популяци бий болжээ. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Азийн минжийн тархац нутгийн 11% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.



СААРАЛ ЧОНО

Canis lupus Linnaeus, 1758

Серый волк
Grey Wolf
Lang, Lobo comun

БИЕЙН УРТ	105-160 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	80-100 см
СҮҮЛНИЙ УРТ	5-50 см
ЖИН	20-80 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэлтэй. Манай оронд түгээмэл тархсан зүйл. 2007-2009 онд тал хээрийн бүс буюу зүүн бүсийн аймаг, сумдын зарим нутагт агнахыг хориглож байсан. Саарал чонын тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.



ЕРӨНХИЙ ШИНЖ

Толгой зантгар, чих соотон, үзүүр нь шовх. Цайвар шаргал өнгөтэй, өтгөн нягт үстэй, зоо хэсгээрээ бараан урт сортой. Сүүл сагсгардуу богино. Хумс бараан хүрэн өнгөтэй. Хөлний уланд 5 саарин товхтой. Урд хөлний дунд хоёр хурууны саарин товх нийлээгүй байна. Бие гүйцсэн чонын толгойн ясны ерөнхий урт нь 22 см, шүд нь нилээд том, хүчирхэг, ялангуяа соёо сайн хөгжсөн. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 2/3; их араа 2/3=42.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Арьс, эд эрхтэнг худалдах болон спорт агнуур, малын дайсан гэж үзэж ихээр агнаж байна. Чонын арьсаар дээл, малгай, хөнжил, дах зэргийг хийж гадаад худалдаанд гаргана. Мөн хөлдөөсөн чоныг бүхлээр нь болон эд эрхтэнг тусгайлан салгаж нойтноор юмуу хатааж худалдаална. Шагай болон соёог гоёл чимэглэлийн зориулалтаар хэрэглэдэг. Саарал чонын гадаад байдал нь нохойтой төстэй боловч хүзүү бүдүүн, сүүж нь шувтан, сүүл нь унжгар. Нохойн арьсны хонго орчмын үс чонынхыг бодвол урт ширэлдмэл байдаг. Чонын нүд нохойтой харьцуулбал толгойн яс, нүүрний араг ясны дээд хэсэгт байрлалтай. Чонын арьсны хар хоншоор нь нохойныхоос нарийвтар урт байдаг. Нохойн арьсны савар, тавхай чонынхоос мохоовтор, өргөн байдаг бөгөөд гол төлөв цагаавтар алаг өнгөтэй. Чонын арьсны нурууны үсэнд огтлолцсон бүдэг буюу тод өнгийн судал мэдэгдэхүйц байдаг ба нохойны арьсанд тийм судал байдаггүй. Эдгээр шинжээр нохойноос ялгана. Эд, эрхтнийг мэргэжлийн шинжээчдээр тодорхойлуулах шаардлагатай.

ШАР ҮНЭГ

Лисица
Red or Common fox
Chi hu

Vulpes vulpes Linnaeus, 1758

БИЕЙН УРТ	70-90 см
СҮҮЛНИЙ УРТ	40-60 см
ЧИХНИЙ УРТ	9-11 см
ЖИН	5-10 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН


Үнэгний арьс олон улсын үслэг ангийн зах зээлд худалдаалагдаг учраас хууль бусаар их хэмжээгээр агнадаг. Арьснаас гадна махыг худалдаалж болзошгүй. Арьсыг өмнө дурдсан биеийн хэмжээ, өнгө зүс, онцлог шинжээр ялгаж болно. Гол онцлог нь чихний ар хар өнгөтэй, сүүлний торгон үзүүрт багц цагаан үстэй.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн галбир төрхөөрөө хярстай төстэй боловч биеэр түүнээс илэрхий том. Сүүл урт, өтгөн үстэй, үзүүр нь цагаан. Хоншоор урт, шөвгөр. Чих соотон бөгөөд үзүүр нь шовх, чихний гадна тал хар өнгөтэй. Өвлийн үс улаан шаргал, зуны үс цайвардуу саарал. Цээж, хэвлий цагаан. Мөчид харьцангуй урт, бараан өнгөтэй. Толгойн ясны кондилобазаль урт 140-160 мм, шанааны өргөн 70-90 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 4/4; их араа 2/3=42.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Агнуурын амьтан. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.2 дахь заалтаар шар үнэгийг жил бүрийн 2-р сарын 11-ний өдрөөс 11-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Хуулиар зөвшөөрсөн агнах, барих хугацаанд 1 удаагийн эрхийн бичгээр 5 хоногт 1 толгойг агнана. Шар үнэгний тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.



ХЯРС ҮНЭГ

Vulpes corsac Linnaeus, 1758

Корсак
Corsac fox
Sha hu



БИЕЙН УРТ	50-60 см
СҮҮЛНИЙ УРТ	25-36 см
ЧИХНИЙ УРТ	6-9 см
ЖИН	2-3 кг

ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн галбир төрхөөрөө үнэгтэй төстэй боловч биеэр илэрхий жижиг. Биеийн өнгө хул-шаргалдуу саарал. Сор үсний үзүүр цагаан тул мөнгөлөг туяатай харагдана. Нуруун тал нь хүрээтэр. Цээж болон хэвлий шаргал туяа бүхий цайвар. Чихний ар тал биеийн өнгөтэй ижил, сүүлний үзүүр цагаан биш. Толгойн ясны кондилобазаль урт 100-120 мм, шанааны өргөн 60-70 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 4/4; их араа 2/3=42.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Агнуурын амьтан. Тал хээрийн бүсийн аймгуудад, ялангуяа үлийн цагаан оготно тархсан нутагт агнахыг сүүлийн 6 жил хориглосон. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.2 дахь заалтаар хярс үнэгийг жил бүрийн 2-р сарын 11-ний өдрөөс 11-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Хуулиар зөвшөөрсөн агнах, барих хугацаанд 1 удаагийн эрхийн бичгээр 5 хоногт 1 толгойг агнана. Хярс үнэгний тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Зөвхөн арьсыг худалдаалдаг. Өмнө дурдсан биеийн хэмжээ, өнгө зүс, онцлог шинжийг ашиглан бусад амьтнаас ялган таньж болно. Үнэгнээс ялгаатай нь хярсны чихний ар тал саарал өнгийн бут үстэй байхад үнэгний чихний арын бут үс хар өнгөтэй байна. Хярсны сүүлний үзүүр таруу байрласан бараан өнгийн сор үстэй бол үнэгний сүүлний үзүүр бүхэлдээ цагаавтар өнгийн үстэй байна. Хярсны үс толгойноосоо сүүлний уг хүртэл мөн нуруу орчимдоо саарал буюу буурал өнгөтэй, хэнхдэг хэвлийдээ цагаавтар цайвар өнгийн үстэй байна.

ШАРНАД ЦӨӨВӨР

Cuon alpinus Pallas, 1811

Красный волк
Asiatic Wild Dog
Chai lang



БИЕЙН УРТ **100-110 см**
СҮҮЛНИЙ УРТ **45-50 см**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Бүс нутгийн хэмжээнд устсан (Улаан данс, 2006)

Нэн ховор зүйл (Улаан ном, 1987; 1997; 2013; 2016)



ЕРӨНХИЙ ШИНЖ

Саарал чоноос биеэр жижиг, үнэгнээс том. Зүс тод улаан зээрд. Хэвэл, суга, цавь, чихний дотор тал цайвар. Сүүл саарал, чоньхоос урт сагсгар, үнэгнийхээс арай богино, жигд улаан буурал. Завж, багалзуурын үс урт, чихний ар тал биеийн өнгөтэй ижил.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1973 оноос агнахыг хуулиар хориглосон. CITES-ийн II хавсралтад орсон. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Шарнад цөөвөр 1969 онд Өмнөговь аймгийн Зөөлөнгийн нуруунд хавханд орж, 1996 онд Байгалийн чанадын бүс нутгаас түүний 4 ширхэг арьс олдсон бөгөөд 2015 оны 8-р сарын 5-нд Говь-Алтай аймагт мазаалайн шилжилт хөдөлгөөнийг хянах зориулалтаар тавьсан хөдөлгөөн мэдрэгч камерт бичигдсэнээр түүнийг Монголд оронд байна хэмээн үздэг. Урьд тархаж байсан нэлээд нутгууд нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Үндсэн бүтээгдэхүүн нь арьс. Энэ амьтны арьс сагсгар үстэй, сэрвээ нуруугаар тод улаан зээрд, хэвэл, суга, цавь орчмын хэсэг цайвар цагаан үстэй. ОХУ, Хятад улсын хооронд хууль бусаар худалдаалагдаж болно. Шар үнэгний арьстай хамт худалдаалж болзошгүй, гол ялгаа нь чихний ар талын үсний өнгө, сүүлний үзүүрийн цацаг үсний өнгөөр ялгана. Шар үнэгний чихний ар тал хар, сүүлний үзүүр цагаан байдаг.

ХҮРЭН БААВГАЙ

Ursus arctos Linnaeus, 1758

Бурый медведь
Brown bear
Zong xiong

БИЕЙН УРТ	147-255 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	63-150 см
СҮҮЛНИЙ УРТ	6-21 см
ЧИХНИЙ УРТ	10 см
ЖИН	52-400 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Мэдээлэл дутмаг (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Мазаалай баавгайтай харьцуулвал, биеийн ерөнхий зүс илүү бараан, урт сор үстэй, биеэр том. Бие үлэмж лагс. Мөч бахим, тавхай үстэй, 5 хуруу нь хүчирхэг бор хумстай. Толгой данхар, хоншоор богино. Хүзүү богино, бүдүүн. Сүүл ахар, үснээс бараг үл цухуйна. Хүзүү, хөл их биеэсээ бараавтар. Залуу баавгайн хэнхдэг, хүзүүний угт цагаан цайвар толботой. Энэ толбо нас ахих тусам багасаж алга болно. Хумс нумлан нугарсан бараан өнгөтэй, урт нь 100 мм хүрнэ. Мазаалай баавгайг бодвол хумс нь шовх, хурц үзүүртэй. Толгойн ясны кондилобазаль урт 258-378 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 4/4; их араа 2/3=42.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэлтэй. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Хүрэн баавгайн тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Хүрэн баавгайн мах, цөс, яс, өөх, тархи, тавхай савар, шөрмөс, арьсыг худалдаална. Арьсыг шалгаж үзэхдээ дээр дурдсан биеийн хэмжээ, өнгө зүс, онцлог шинжийг баримтлана. Цөсийг бусад амьтдынхаас гол ялгах шинж нь жижиг хэлтэрхийг (эсвэл тариурын зүүгээр хатгаад шилэн аягатай усанд зүүгээ дүрэх) шилэн аягатай усанд хийхэд доошоо хүрэн зурвас үүсгэн уусдаг онцлогтой. Шар үхрийн цөстөй андуурагдаж болзошгүй. Сарвууг ялгах гол шинж нь хумс байдаг. Мазаалай баавгайн хумс цайвар шаргал өнгөтэй мохоо, хүрэн баавгайн хумс хар бараан өнгөтэй. Зарим жижиг баавгайн тусад нь салгасан ганц хумс тасын хумстай андуурагдаж болно.



МАЗААЛАЙ БААВГАЙ

Ursus gobiensis Sokolov et Orlov, 1990

Гобийский медведь

Gobi Bear

Ge bi xiong

БИЕЙН УРТ	147-168 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	63-92 см
СҮҮЛНИЙ УРТ	6.2 см
ЧИХНИЙ УРТ	10 см
ЖИН	52-138 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Устаж байгаа (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж байгаа (Улаан данс, 2006)
Нэн ховор, үлдвэр зүйл (Улаан ном, 1997;
2013; 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол оронд мазаалайг 1953 оноос агнахыг бүрмөсөн хориглосон. CITES-ийн I хавсралтад бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Мазаалай баавгайн үндсэн тархац нутгийг Говийн их дархан цаазат газарт хамруулсан байдаг.



ЕРӨНХИЙ ШИНЖ

Ерөнхий төрх хүрэн баавгайтай адил боловч биеэр жижгэвтэр. Бие лагс, хөл бахим, тавхай нүцгэн сайртай, 5 хуруутай. Сүүл ахар, үснээс бараг цухуйж харагдахгүй. Чих харьцангуй жижиг, үзүүр нь дугариг. Хүзүү богино, бахим. Зуны гуужилтын дараа хөхөвтөр хүрэн бор, тачир үстэй, өвөл хавар хүрэвтэр, бор саарал. Хүзүү, хөл их биеэсээ бараавтар. Арьсны сор үс бараан хүрэн, ноолуур үс цайвар шаргал, мөр далны хэсэгт 3 см өргөн, 15-20 см урт цагаан шаргал толботой. Хумс цайвар өнгөтэй, шулуундуу, мохоо, бүдүүн богинохон. Толгойн ясны кондилобазаль урт 258-306 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; түрүү араа 4/4; агт араа 2/3=42.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Арьс, сарвуу, цөс буюу доньд нь хууль бусаар худалдаалагдаж болзошгүй. Арьсны сор үс бараан хүрэн, ноолуур үс цайвар шаргал, мөр далны хэсэгт 3 см өргөн, 15-20 см урт цагаан шаргал толботой. Сарвууны хумс богино мохоодуу, цайвар шаргал өнгөтэй.



ОЙН БУЛГА

Martes zibellina Linnaeus, 1758

Соболь
Sable
Zi diao



БИЕИЙН УРТ	39-53 см
ЭР	
ЭМ	37.5-42.0 см
СҮҮЛНИЙ УРТ	11.8-15.9 см
ЭР	
ЭМ	11.5-14.5 см
ЖИН	1.1-1.8 кг

ЕРӨНХИЙ ШИНЖ

Булга сахлаг зөөлөн, торгомсог үстэй. Тухайн орших нутгийн өвөрмөц байдлаас шалтгаалан нутаг бүхэнд харилцан адилгүй зүстэй булга тохиолдоно. Манай орны булга тархсан Хэнтий, Хөвсгөл, Алтайн уулархаг ойт нутаг нь бие биенээсээ алслагдсан учир булганы зүс ялгаатай байдаг онцлогтой. Ерөнхий зүс өнгөлөг цайвар, шаравтар, хүрэн, хар хүрэн заримдаа хар. Хоолой хавьдаа цагаан саарал юмуу шаравтар өнгийн толботой. Зоо нуруу болон биеийн хажуу, хэвэл талын үс бараан, ноолуур нь үнсэн саарал. Сүүл биеийн хагаст хүрэхгүй. Дагз цайвар. Үс хөрс гүйцсэн булганы нурууны сор үс 32-48 мм, ноолуур 25-40 мм, хондлойн сор үс 39-50 мм, ноолуур 28-40 мм байна. Толгойн ясны кондилобазаль урт 7.2-9.3 см, шанааны өргөн 3.9-5.7 см. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 4/4; их араа 1/2=38.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Эмзэг (Улаан данс, 2006)

Ховор зүйл (Улаан ном, 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглосон. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.2 дахь заалтаар ойн булгыг жил бүрийн 2-р сарын 11-ний өдрөөс 11-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Ойн булгын тархац нутгийн 20% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Зөвхөн түүний арьсыг худалдаалдаг. Дээр дурдсан өнгө зүс, онцлог шинжээр булганы арьсыг ялган танихад хялбар.

ЭРЭЭН ХҮРЭН

Vormela peregusna Guldenstaedt, 1770

Перевязка
Marbled Polecat
Hu you

БИЕЙН УРТ	27-35 см
СҮҮЛНИЙ УРТ	20 см
ЖИН	370-715 гр

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:
Мэдээлэл дутмаг (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 1987; 1997; 2013; 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Толгой жижиг, хоншоор богиновтор, мохоодуу. Чих том, угаараа өргөн, дэлбэгэрдүү дугуй. Мөчид богинохон. Сүүл урт сагсар, Толгой, нуруу, биеийн хажуу халиун бор дэвсгэр дээр элдэв хэлбэрийн цайвар толбуудтай. Хүзүү халтар бараан. Хэвэл бараан. Хоолойноос завж, нүдийг дайрсан өргөн бараан зурвастай. Чахалзуураас нүд, чихний завсраар шургасан тууш, тод цагаан зурвас бий. Уруул, эрүү цагаан. Ерөнхий зүс эрээн. Толгойн ясны кондилобазаль урт 5.2-5.7 см, шанааны өргөн 3-3.7 см. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 3/3; их араа 1/2=34.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Эрээн хүрний тархац нутгийн 19% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Энэ ховор амьтныг санаатай болон санамсаргүйгээр агнаж өмхий үений (*Mustela eversmanni*) арьстай хамт худалдаалах магадлалтай. Мөн чихмэл хэлбэрээр худалдаалж болзошгүй. Ноолуур бүхий хялгасархаг сор үстэй тул үслэг ангийн тоонд орно. Өмхий үений арьс урт, сагсар сор үстэй, жигд хүрэн, халиун зүстэй. Биеийн хэмжээ, хэлбэр галбираар хоорондоо тун төстэй.



ГОЛЫН ХАЛИУ

Lutra lutra Linnaeus, 1758

Речная выдра
Eurasian Otter
Shui ta



БИЕЙН УРТ	55-95 см
СҮҮЛНИЙ УРТ	26-55 см
ЧИХНИЙ УРТ	14-16 см
ЖИН	5.7-10.0 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Мэдээлэл дутмаг (Улаан данс, 2006)
Нэн ховор зүйл (Улаан ном, 1987; 1997;
2013; 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Голын халиуны арьсыг хууль бусаар худалдаалдаг. Иймд дээр дурдсан таних шинжийг анхаарах нь зүйтэй. Арьсыг ялган таних гол шинж нь сүүл сагсгар, хөлийн ул үсгүй, нүцгэн, хуруунууд бараг үсгүй, хоорондоо өргөн арьсан холбоостой. Хамрын сүвний хооронд үсгүй халцгай байдаг.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие сунагар, цээжин тал руугаа шувтан. Толгой жижиг, тавшгар. Мөчид богинохон, хуруунууд сэлэхэд зохилдсон арьсан холбоостой. Тавхайн ул үсгүй. Сүүл үсэрхэг урт, угаараа бүдүүн, үзүүр тийшээ шувтан. Зоо нуруу, хавирга, сүвээ орчмоороо бараан хүрэн, хэвэл, хоолой, гэдсээрээ мөнгөлөг цайвар зүстэй. Сор үс тачирхан, ноолуур өтгөн нягт. Толгойн ясны нүүрний хэсэг богино. Гавлын хайрцаг яс намхан бөгөөд өргөн. Толгойн ясны кондиллобазаль урт 103-126 мм, шанааны өргөн 61-82 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 4/3; их араа 1/2=36.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1930 оноос агнахыг хуулиар хориглож ирсэн. CITES-ийн I хавсралтад бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Голын халиуны тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЦООХОР ИРВЭС

Panthera uncia Schreber, 1775

Снежный барс
Snow Leopard
Хуе diao

БИЕЙН УРТ	110-135 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	60 см
СҮҮЛНИЙ УРТ	80-105 см
ЧИХНИЙ УРТ	6.6-7.2 см
ЖИН	22-55 кг

ЕРӨНХИЙ ШИНЖ

Монгол орны хамгийн том биетэй муур. Гинс (эм) гэнд (эр)-ээс арай жижиг. Мөч богино, сарвууны алга тавхай өргөн, том, хурц махир, нуугдмал урт хумстай, бие сунагар. Толгой жижиг, бөөрөнхийдүү, чих богино дугуйвтар. Цэнхэрдүү туяатай цайвар, шаргал дэвсгэр дээр 6-8 см голч бүхий гархин буюу матигар бараавтар ба хүрэн толбо болон жижиг нягт толботой эрээн цоохор зүстэй. Хэвлий, өөхий, суга, цавь толбогүй. Толгой, духны хэсэгт шигүү жижиг хар толбо бий. Хондлой хавьд тууш бараан зурвастай. Үс нь зөөлөн сор бүхий өтгөн ноолууртай. Сүүлний урт бараг биеийн уртад хүрнэ. Сүүл урт, өтгөн үстэй. Толгойн ясны кондилобазаль урт 158-174 см. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; түрүү араа 3/2; агт араа 1/1=30.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1972 оноос агнахыг хуулиар хориглож ирсэн. CITES-ийн I хавсралт, Бонны конвенц (CMS)-ийн I хавсралтад тус тус бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Цоохор ирвэсний тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

Нэн ховор зүйл (Улаан ном, 1987; 1997; 2013; 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Худалдаалах зорилгоор цоохор ирвэсний арьсыг голдуу толгойн яс, сарвууны хамт үргэлжээр нь бэлтгэдэг. Гэрэл зурагтай харьцуулах аргаар түүний арьсыг таньж тодорхойлоход хялбар. Мах, ясыг хил давуулан худалдаалах магадлалтай. Хэлхээ яс нь маш хөнгөн, нарийн урт. Нарийн таньж тодорхойлоход биологич шинжээчийг оролцуулах шаардлагатай.



ШИЛҮҮС МИЙ

Lynx lynx Linnaeus, 1758

Рысь
Eurasian Lynx
She li



БИЕЙН УРТ	73-106 см
СҮҮЛНИЙ УРТ	10-24 см
ЧИХНИЙ УРТ	7.5-9.9 см
ЖИН	9-32 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шилүүсний арьс хөрслөг, зузаан, үс бөх мөртөө дулаан, үзэмжтэй тул дээл, дах доторлоно. Арьсыг хил дамжуулан худалдаалж болзошгүй. Түүний арьсыг дээр дурдсан таних шинжийг баримтлан ялган таньж болно. Гэрэл зурагтай харьцуулан үзэх шаардлагатай.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Мөч харьцангуй урт эзгэгэр, тавхай том. Чих том, өргөн, хурц үзүүртэй, чихний үзүүрт 5 см хүртэл урт бийр мэт багц үстэй. Сахал хар, цагаан өнгөтэй 7-8 см урт. Зүс боровтор загал бүхий цайвар ягаавтраас улаавтар зээрд, шаравтар буурал. Сүүл богино, үзүүр нь хар үстэй. Толгойн ясны кондилобазаль урт 10.8-15.0 см. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 2/2; их араа 1/1=28.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэлтэй. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад Говийн шилүүс (*Lynx lynx isabellina*)-ийг оруулсан байна. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.2 дахь заалтаар шилүүсийг жил бүрийн 2-р сарын 11-ний өдрөөс 11-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Шилүүсний тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

МАНУУЛ МИЙ

Felis manul Pallas, 1778

Манул
Manul, Steppe cat, Pallas's cat
Tu sun

БИЕЙН УРТ	64-79 см
СҮҮЛНИЙ УРТ	22-30 см
ЧИХНИЙ УРТ	3.7-4.8 см
ЖИН	2.2-5.0 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Мөч богино, бахим. Зүс хөхөлбөр буурал. Зоо нуруундаа 6-7 хөндлөн нарийхан хар бараан судалтай. Чих богино, их биеийн үсэндээ бараг далдарсан. Сүүл богино, хар бараан гархи маягийн хөндлөн судалтай, сүүлний үзүүр хар. Тавхайн ул нь үсгүй шахам. Хошууны хоёр талаар бараан судалтай, түүний дээд үзүүр нь нүдний дотор талын зовхи руу түрж шанааг даган чихний угт хүрнэ. Хүзүүгээрээ хоолойны цайвар үсийг заагласан хар судалтай, өгзөг орчмын үсэнд бараан өнгийн тод судалтай. Толгойн ясны кондилобазаль урт 7.2-8.7 см. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; түрүү араа 2/2; агт араа 1/1=28.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.2 дахь заалтаар мануул мийг жил бүрийн 2-р сарын 11-ний өдрөөс 11-р сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Мануул мийн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Мануул мийг амьдаар нь болон түүний арьсыг хил давуулан худалдаалах боломжтой. Дээр дурдсан биеийн хэмжээ, өнгө зүс, онцлог шинжийг ашиглан ялган таньж болно.





ЦООХОНДОЙ МИЙ

Felis silvestris Schreber, 1775

Степной кот
European Wild Cat
Diao mao

БИЕЙН УРТ	43-91 см
СҮҮЛНИЙ УРТ	23-40 см
ЧИХНИЙ УРТ	6-7 см
ЖИН	3.5-5.8 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Мэдээлэл дутмаг (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 1987; 1997; 2013; 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1996 оноос агнахыг хуулиар хориглож ирсэн. CITES-ийн II хавсралтад бүртгэлтэй. Цоохондой мийн тархац нутгийн 19% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн хэмжээ, галбир төрхөөрөө гэрийн мууртай төстэй. Зоо нурууны дагуу өргөн бараан хүрэтэр юмуу боровтор судалтай. Биеийн хажуугийн цайвар бор, хөхөвтөр саарал дэвсгэр өнгөн дээр хөндлөн эгнэсэн бараан, бор, хүрэтэр толбуудтай. Хэвэл, мөчдийн дотор тал цайвар. Сүүл хойт мөчдөөс урт. Сүүлний үзүүр бараан, түүнээс дээш 4-5 тод бараан өнгийн бөгжилсөн бүслүүртэй. Чих биеийн үснээс цухуйх бөгөөд үзүүртээ 3 см шахам урт, бийр шиг цацаг үстэй. Толгойн ясны кондилобазаль урт 8.2-9.3 см. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; түрүү араа 3/2; агт араа 1/1=30.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Дээр дурдсан таних шинжийг ашиглан уг амьтны арьсыг тодорхойлж болно. Мөн арьсыг гэрэл зурагтай харьцуулан тулгаж үзнэ. Өнгө зүс ижил гэрийн муур тохиолддог боловч чихний үзүүрт байх цацаг үс буюу отго гэрийн мууранд байдаггүй нь тэдгээрийг ялгах гол шинж болно.

ТАХЬ АДУУ

Equus przewalskii Poljakov, 1881

Лошадь Пржевальского
Przewalski's Wild horse or Takhi
Ye ma

БИЕЙН УРТ	220-280 см
МУНДАА ОРЧИМ ЧАЦ	115-146 см
СҮҮЛНИЙ УРТ	92-111 см
ЧИХНИЙ УРТ	14-18 см
ЖИН	200-325 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Устаж байгаа (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж байгаа (Улаан данс, 2006)

Нэн ховор зүйл (Улаан ном, 1997; 2013; 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие лагс, толгой том, хүзүү бахим. Чихний хоорондоос мундаа хүртэл өтгөн шигүү, бараан өнгийн босоо хялгасан дэлтэй. Сүүл урт, бараан хялгастай. Зүс хул хонгор, цайвар хонгор. Хэвэл, суга, цавь, цайвар хонгор. Нуруу зоо дагуу сэвээнээс сүүлний уг хүрсэн нарийхан хүрэн судалтай. Мөчдийн өвдөг боривноос доош бараавтар, заримдаа бэдэртэй. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 0-1/0-1; түрүү араа 3/3; агт араа 3/3=36-40.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1930 оноос агнахыг хуулиар хориглож иржээ. CITES-ийн I хавсралтад бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Тахь адууны тархац нутаг бүхэлдээ улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Арьсыг худалдах магадлалтай. Гол таних шинж дэл босоо, зүс хонгор, нуруу дагуу бараан судалтай. Дээр дурдсан биеийн хэмжээ, өнгө зүс, онцлог шинжээр тодорхойлохын зэрэгцээ гэрэл зурагтай харьцуулах аргаар ялган таньж болно.





ХУЛАН АДУУ

Equus hemionus hemionus Pallas, 1775

Кулан
Asiatic Wild Ass or Khulan
Ye lu

БИЕЙН УРТ	200-260 см
МУНДАА ОРЧИМ ЧАЦ	110-140 см
СҮҮЛНИЙ УРТ	43-49 см
ЧИХНИЙ УРТ	17.5-26.5 см
ЖИН	200-300 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 1987; 1997; 2013; 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Гэрийн адуутай харьцуулахад, толгой том, чих урт, сүүл зөвхөн үзүүрийн хэсэгтээ шингэхэн богино, бараан хялгастай. Ерөнхий зүс хул. Зун улаавтар, өвөл цайвар хул. Мундаанаас сүүлний уг хүртэл зоо нурууны дагуу нарийхан хүрэн бор судалтай. Дэл босоо, ахар, хар өнгөтэй. Дэл, сүүлний хялгас бараан. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 0-1/0-1; түрүү араа 3/3; агт араа 3/3=36-40.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож иржээ. CITES-ийн I хавсралт, Бонны конвенц (CMS)-ийн II хавсралтад тус тус бүртгэлтэй. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Хулан адууны тархац нутгийн 29% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Арьсны хамт бүхлээр нь юмуу мөчлөн бэлтгэдэг. Арьстай гулууз махыг өмнө дурдсан онцлог шинжүүдийг ашиглан таних боломжтой. Гол ялгаа нь сүүлний үзүүрт буй хэсэг богино, бараан хялгас болно. Адууны махтай харьцуулахад үнэр нь төдийлэн хурц биш, өөх багатай, бараан хүрэн өнгөтэй. Хулан адууг толгойн ясаар нь тахь, гэрийн адуунаас хялбар ялгах гол шинж бол түүний дээд эрүү завсарын ясны нийлэх хэсэгт байрлах товгор юм.



ХАВТГАЙ ТЭМЭЭ

Camelus bactrianus ferus Przewalskii, 1883

Дикий верблюд
Bactrian Camel
Shuang teng tuo

БИЕЙН УРТ	225-245 см
ӨНДӨР	180-198 см
СҮҮЛНИЙ УРТ	55-75 см
БӨХНИЙ ӨНДӨР	35 см
ЧИХНИЙ УРТ	17.5-26.5 см
ЖИН	450-690 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Устаж байгаа (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)
Нэн ховор зүйл (Улаан ном, 1997; 2013; 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Гэрийн тэмээнээс ялгахдаа дээр дурдсан таних шинжийг ашиглахаас гадна, хөлийн хумс цайвар байдгаараа нэн онцлог. Бэсрэг буюу гэрийн тэмээтэй эрлийзлэсэн бодгалийг мөн худалдаалж болзошгүй. Бэсрэг нь хавтгай тэмээтэй биеийн галбир төрхөөр ойролцоо тул танихад хялбар.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн галбир гэрийн хоёр бөхт тэмээтэй төстэй боловч бие гоолиг, бөх жижиг, шовгор, үргэлж босоо, хөл, хүзүү урт нарийн, тавхай ялимгүй бага, гонзгойдуу, хумс цайвар шаргал, магнай ялимгүй өргөн хавтгай, хушуу шөмбөгөр, уруул нимгэн. Өрөвлөг, бөхний сагсаг, шил, өвдөгний зогдрын хялгас богино сийрэг, эм ноосны үс тачир, шингэн. Зүс гэрийн тэмээнийхээс цайвар, элсэн шаргалаас хүрэн улаан. Сүүл нарийн, цацаг үс улаавтар. Өвдөг, тойг, өвчүүний саарь бараг мэдэгдэхгүй зэрэг олон ялгаатай. Толгойн ясны урт 46-52 см. Шүдний томъёо: үүдэн шүд 1/3; соёо 1/1; түрүү араа 3/3; агт араа 3/3=36.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1930 оноос хавтгай агнахыг хуулиар хориглож иржээ. CITES-ийн I хавсралтад бүртгэлтэй байсан боловч хавтгайг сүүлийн 10 гаруй жилд нэг ч орон худалдаагүй тул тус хавсралтаас хассан байна. Мөн Бонны конвенц (CMS)-ийн I хавсралтад орсон. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Хавтгай тэмээний тархац нутаг бүхэлдээ улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан.



ЗЭРЛЭГ ГАХАЙ

Sus scrofa Blanford, 1875

Кабан
Wild Boar
Lu wei zhy

БИЕЙН УРТ	125-180 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	80-100 см
СҮҮЛНИЙ УРТ	20-30 см
ЖИН	125-200 кг

ЕРӨНХИЙ ШИНЖ

Толгой урт, хоншоор шонтгор, хүзүү, мөчид богино. Чих дэлдгэр, үзүүртээ урт үстэй. Мөчдийн хөхөн туруу урт. Дээд, доод соёо уруулаас гадагш дорсойн гарч хоорондоо зөрсөн байрлалтай. Бодонгийн соёо мэгжийнхээс урт, том. Зүс бор саарал, хүрэн, бараавтар, 5-7 см хүртэл урт бараан хүрэн өнгийн хялгасан үстэй. Нялх тоорой тууш шаравтар судал бүхий эрэн зүстэй. Толгойн ясны кондилобазаль урт 30-34 см. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; түрүү араа 4/4; агт араа 3/3=44. Бодон дээд эрүүндээ урт хүчирхэг соёотой.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

Ховор зүйл (Улаан ном, 1997; 2013; 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Агнуурын амьтан. Зэгсний зэрлэг гахай (*Sus scrofa nigripes*) нь Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад болон Монгол улсын Улаан ном (1987; 1997; 2013)-нд орсон. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.1 дэх заалтаар зэрлэг гахайг жил бүрийн 12-р сарын 01-ний өдрөөс дараа оны 8-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Зэрлэг гахайн тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Махыг хүнсний зориулалтаар худалдаална. Зэгсний гахайг ойн гахайтай хамт махны чиглэлээр худалдаалах боломжтой. Гахайн элэгийг эмчилгээний зориулалтаар, соёог гоёл чимэглэлийн зорилгоор худалдаална. Махыг арьстай нь гулууслан бэлтгэсэн үед дээр дурдсан шинжийг үндэслэн танихад хялбар. Хэсэглэж жижиглэсэн нөхцөлд 5-7 см урт, бараан хүрэн өнгөтэй ширүүн хялгасан үс, түүний угаар байх цайвар ноолууран үстэй арьсаар нь ялгаж болно.

БАДАНГА ХҮДЭР

Moschus moschiferus Linnaeus, 1758

Кабра
Musk Deer
Yuan She

БИЕЙН УРТ	85-102 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	56-70 см
ХОНДЛОЙН ӨНДӨР	67-80 см
СҮҮЛНИЙ УРТ	4-6 см
ЧИХНИЙ УРТ	8-15 см
ЖИН	9-17 кг

ЕРӨНХИЙ ШИНЖ

Гирээ (эр), гирэгчин (эм) хоёул эвэргүй. Гирээ нь дээд уруулын дороосоо илүү гарч, эрүүнээс доош сөрдийсэн, 7-10 см хүртэл урт, сэлэм хэлбэртэй, хурц, тод цагаан соёотой. Гирэгчний соёо жижиг. Хажуу, зоо хондлойгоороо бүдэг шаравтар толбо бүхий хүрэн бор, бараан хүрэн зүстэй. Хэвэл, мөчдийн дотор тал цайвар. Хондлой сэрвээнээсээ өндөр, урд хөл хойд хөлөөс богино. Урт ширүүн налуу үстэй. Гирээний хэвэлд, хүйсний дэргэдэх арьсан доор заарын булчирхай томбойн харагдана. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 1/1; бага араа 3/3; их араа 3/3=34.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)
Нэн ховор зүйл (Улаан ном, 1997; 2013; 2016)



ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос хүдэр агнахыг хуулиар бүрэн хориглосон. CITES-ийн II хавсралтад орсон. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Баданга хүдрийн тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Баданга хүдрийн заарыг дорно дахины уламжлалт эмчилгээнд ашигладаг. Заар нь гирээний хүйс буюу чивний сүвний хажууд, арьс махны завсар байрлах 4-6 см хэмжээтэй, хүүдий маягийн булчирхай юм. Манай орны нас бие гүйцсэн гирээний хүүдийтэй нэг заар 30-40 грамм байхад Саяны нуруунд амьдардаг мөн энэ зүйл, ижил насны гирээнийх 50 грамм хүрнэ. Харин залуу гирээнийх 15-20 грамм байдаг. Эдгээр нь нойтон жин бөгөөд хатаахад жин нь 50% хорогдоно. Заар нь нойтон үедээ цайвар, нунжгайвтар хагас шингэн байдалтай байх ба хатах үедээ хүрэн өнгөтэй, бутархайтсан бодис болдог. Үнэрний хувьд шээс, шивхтэй төстэй гэхдээ сайн төвлөрч үнэрлэвэл эсгэлэндүү ч гэмээр сэнгэнэсэн үнэр гарна. Мөн гирээний соёог гоёл чимэглэлийн зориулалтаар хэрэглэх магадлалтай.



ХАЛИУН БУГА

Cervus elaphus Linnaeus, 1758

Благородный олень
Red Deer
Ma lu

БИЕЙН УРТ	193-247 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	124-165 см
ЖИН	250-345 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Халиун бугын ясан болон цусан эвэр, чив засаа, согооны сүүл, савыг худалдаална. Бугын цусан эвэр цайвар өнгөтэй, шовгор үзүүргүй мухар, арьсных нь гадуур цэмбэ шиг хилэн үс ургасан, хатаагүй үедээ барихад бамбалзсан зөөлөн байна. Этилийн 96 хувийн спиртэнд хэрчиж хийн хандалсан хэлбэрээр бэлтгэж болно. Эврийг хэрчиж үйрмэглэн нунтаг хэлбэрээр бэлтгэсэн байвал энэ нь үйрүүлсэн ясны үнэртэй байна. Зуны эцэс болоход цусан эвэр хатуурч үс нь хогжирч унаад эцэстээ шаравтар цагаан өнгөтэй ясан эвэр болно. Бугын хатаасан чив 20-40 см урт, гонзгой, хүрэн улаан, цайвар шаргал өнгөтэй хатуу зүйл байна. Бугын чив, согооны сүүл, бусад эд зүйлийг мэргэжлийн биологич шинжээчид тодорхойлно.



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бугынхан дотроо хамгийн том биетэй зүйл. Зуны өнгө шаргал, бор хүрэн, өвлийн зүс бор саарал. Өвлийн үсэн бүрхүүл 3-4 см урт ширүүн сор үс, өтгөн ноолууртай. Тана тод цайвар шаргал өнгөтэй бөгөөд бараан хүрээтэй. Зоргол нуруугаараа толботой. Намрын гуужилтаар толбо нь аажим арилна. Бие гүйцсэн бугын эвэр угаараа 16-30 см бүдүүн, урт нь 97-105 см, жин 5-10 кг, дунджаар 7 кг, эврийн 1, 2-р салаа нь заавал хоёул байх бөгөөд адилхан сайн хөгжсөн байдаг онцлогтой. Согоо эвэргүй. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 1/1; бага араа 3/3; их араа 3/3=34.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд хууль бус агнуурт ихээхэн өртөж, тоо толгой нь эрс цөөрч байгаа зүйл. Агнахыг хуулиар хориглосон. CITES-ийн I хавсралтад бүртгэлтэй. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Халиун бугын тархац нутгийн 11% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.



Согооны сүүл



Халиун бугын чив, засаа

Нойтон

Хатаасан



БОР ГӨРӨӨС

Capreolus pygargus Pallas, 1773

Косуля
Siberian roe Deer
Рао

БИЕИЙН УРТ
ГҮР 110-132 см

ЗҮР 120-127 см

СЭРВЭЭНИЙ ӨНДӨР
ГҮР 80-90 см

ЗҮР 83-90 см

ЖИН
ГҮР 30-39 кг

ЗҮР 35.0-36.7 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Гур (эр), зүр (эм)-ийн зүс өвөл, зун ялгаагүй ижил. Зун тод улаан юмуу улаан зээрд зүстэй, өвөл бор шаргал, цайвар бор, бор саарал буюу хатсан өвсний өнгөтэй төсөөтэй. Тана цагаан. Тана өвөл тодорч, зуны улиралд бүдгэрнэ. Янзага нь нуруугаараа толботой. Гурын эврийн урт 26-30 см, угийн бүдүүн 7-10 см, хамгийн их цалгай 2-р салааны үзүүрээр 19-39 см байна. Гур өвлийн эхээр эврээ гээх ба сар орчмын дараагаас шинэ эвэр ургаж эхлэнэ. Зүр эвэргүй. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0-1/1; бага араа 3/3; их араа 3/3=32-34.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Агнуурын амьтан. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.1 дэх заалтаар бор гөрөөсийг жил бүрийн 12-р сарын 01-ний өдрөөс дараа оны 8-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Бор гөрөөсний тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Бор гөрөөсийн ясан болон цусан эврийг халиун бугын эврийн хамт худалдаалах магадлалтай. Иймээс эврийн ерөнхий галбирыг таних шинжээс анхааран үзэж, харьцуулан ялгаж. Цусан эвэр нь цайвар бор өнгийн хилэн шиг зөөлөн тачир үстэй, салаагүй юмуу 2-3 богинохон мухар салаатай. Мах нь өөхгүй атлаа чанахад тос ялгарна. Түүний махыг хүнсэнд хэрэглэж, арьсыг ахуйн хэрэглээнд ашиглана.



ШИВЭР МОЛЦОГ ХАНДГАЙ

Alces alces pfizenmayeri Zukowski, 1910

Сибирский лось
Elk or Moose
Tuo lu

БИЕЙН УРТ	300 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	240 см
ЖИН	570 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)
Нэн ховор зүйл (Улаан ном, 1987; 1997;
2013; 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие харьцангуй богино, том, лагс. Мөчид урт. Чих урт, сүүл богино. Дээд уруул доод уруулаа бүрхэж унжина. Хоолойдоо арьсан унжлага буюу сүүхтэй. Мэнж (эр)-ийн сүүх сүндэс (эм)-нийхээс том. Мэнж олон салаалсан том эвэртэй. Эврийн уг богино, бүдүүн, дундаа хавтгай далбантай, зөвхөн дээд захаараа олон салаатай. Зүс жигд хар халтар бараан, хөлийн шилбэ хар бараан, хоншоор цайвар. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3=32.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож ирсэн. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Шивэр молцог хандгайн тархац нутгийн 20% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Түүний эврийг бугын эвэртэй хамт худалдаалж болзошгүй. Дээр дурдсан таних шинжээр эврийг ялгаж болно. Эвэр нь дунд хэсэгтээ хавтгай далбантай байдгаараа онцлог. Махыг хэрэглэж, арьсаар нь сур хийнэ. Мах нь шандуун амттай. Хамрын мах тун амттай тул эрхэмлэн нарийн зоогт хэрэглэдэг. Мах эвэр, яс, тос, цус нь эмийн найрлагад ордог. Чив засаа, сүндэсний сүүл, сав, бусад эрхтнийг биологич шинжээчээр тодорхойлуулах нь зүйтэй.



ХАРМӨРНИЙ МОЛЦОГ ХАНДГАЙ

Alces alces cameloides
Milne-Edwards, 1867

Уссурийский лось
Ussurian Elk or Ussurian Moose
We su er tuo lu



БИЕЙН УРТ	250-276 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	170-195 см
ЖИН	400 кг

ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие бахим, мөч урт. Хандгайн зүйс нь нас, улирлаар өөрчлөгдөнө. Эр, эм хоёул бугынх шиг эвэртэй ч салаа нь хоорондоо нийлсэн байдаг. Биеэр шивэр хандгайнаас арай бага. Ерөнхий зүс жигд бараан, мөчид арай цайвар. Эвэр жижиг, хөнгөн, дунд хэсэгтээ хавтгай далбан байхгүй. Энэ хэсгээр эврийн хөндлөн огтлол бугынхтай адил дугариг. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3=32.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)
Нэн ховор зүйл (Улаан ном, 1987; 1997; 2013; 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож ирсэн. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Хармөрний молцог хандгайн тархац нутаг нь бүхэлдээ Нөмрөгийн дархан цаазат газарт хамрагдсан байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Түүний эврийг бугын эвэртэй хамт худалдаалж болзошгүй. Эвэр жижиг, хөнгөн, бугынхтай төстэй. Хөлийн шилбэ цайвар. Чив, засаа бусад эрхтнийг биологич шинжээчээр тодорхойлуулах шаардлагатай.



БУГАН ЦАА

Rangifer tarandus Linnaeus, 1758

Северный олень
Rein Deer
Хун лу



БИЕЙН УРТ
ЭТЭР **191-203 см**

МАНЖИГ
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР
ЭТЭР **167-182 см**

МАНЖИГ **120-132 см**

МАНЖИГ **108-114 см**

ЖИН
ЭТЭР **120-172 кг**

МАНЖИГ **85-102 кг**

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Эмзэг (Улаан данс, 2006)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие урт, хөл богино. Хүзүү урт. Чих жижгэвтэр, үзүүр нь мохоодуу. Этэр (эр), манжиг (эм)-ийн аль аль нь арагш дээш чиглээд үзүүр нь урагш эргэн дугуйрсан олон салаа эвэртэй. Манжигийн эвэр этэрийнхээс цөөн салаатай. Зун хүрэн буурал, бүдэг эрээлж бүхий жигд бор, өвөл бараавтар эрээлж бүхий цайвар саарал зүстэй. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 1/1; бага араа 3/3; их араа 3/3=34.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос цаа буга агнахыг хуулиар хориглож иржээ. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Буган цааны тархац нутгийн ихэнх хэсэг нь Хорьдол-Сарьдагийн дархан цаазат газар, Улаан тайга болон Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Буган цааны цусан эврийг гадаадад худалдаалдаг байсан. Халиун бугынхаас ялгагдах онцлог шинж нь эвэр нийтдээ нимгэн хавтгай. Эврийн үзүүр хэсэг бага зэрэг өргөн хавтгай, тэр нь богино жижиг салаануудтай. Духны дээд салаа урагш эгц чиглэн үзүүр хэсэг нь далбайж өргөсөн жижиг салаануудтай болно. Цусан эвэр голдуу бараан өнгийн хилэн мэт зөөлөн, тачир үсээр бүрхэгдсэн байна.

ХАР СҮҮЛТИЙ

Gazella subgutturosa Guldenstaedt, 1780

Джейран
Goitred or Black-tailed gazelle
E hou ling



БИЕЙН УРТ	110-116 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	64-75 см
СҮҮЛНИЙ УРТ	16-20 см
ЧИХНИЙ УРТ	8-13 см
ЖИН	18-33 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Эмзэг (Улаан данс, 2006)

Монгол улс:
Эмзэг (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн гадаад төрхөөрөө цагаан зээртэй төстэй. Сүүлний үзүүр хар, ооно 25-41 см урт эвэртэй. Ооно ба шаргачин хоёулаа хонгоны цагаан танатай. Тангийн дээд зах сүүлний уг хүрнэ. Зун зоо нуруу улаан шаргал, хэвэл тод цагаан, өвөл цайвар шаргал, хэвлий цагаан. Ооны толгойн ясны кондилобазаль урт 172-224 мм, шаргачных 182-208 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3=32.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1965 оноос агнахыг бүрмөсөн хориглосоор ирсэн. Бонны конвенц (CMS)-ийн II хавсралтад бүртгэлтэй. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Хар сүүлтийн тархац нутгийн 20.1% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Цагаан зээрийн гулууз махтай хамт худалдаалж болзошгүй. Мөн бэлэг дурсгалын зориулалтаар эврийг нь засч бэлтгэсэн байх магадлалтай. Арьстай гулууз махыг цагаан зээрийн адил таних шинжээр харьцуулж ялгаж болно. Хамгийн гол нь сүүл, тангийн онцлогийг нарийвчлан нягтлах нь зөв. Хэрвээ эвэртэй байвал цагаан зээр, хар сүүлтийн эврийн галбирийг зургаас харж харьцуулна.



ЦАГААН ЗЭЭР

Procapra gutturosa Pallas, 1777

Монгольский дзерен, зобастая антилопа
Mongolian or White-tailed Gazella
Huang yang, Huang ling



БИЕИЙН УРТ	105-148 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	62-84 см
СҮҮЛНИЙ УРТ	9-12 см
ЧИХНИЙ УРТ	9.5-12 см
ЖИН	20-39 кг



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзшгүй (Улаан данс, 2006)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Цайвар ухаа, улаан загал зүстэй, хэвлий цагаан. Өгзөгний цагаан тангийн дээд зах сүүлний угаас дээгүүр байна. Сүүл богино, үзүүрийн бараавтар хэсгээс бусад нь цагаан. Өвдөг, шилбэ бараавтар. Ооны толгойн ясны урт 23-26 см, шаргагчных 22-25 см. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3=32.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Бонны конвенц (CMS)-ийн II хавсралтад бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.1 дэх заалтаар цагаан зээрийг жил бүрийн 12-р сарын 01-ний өдрөөс дараа оны 8-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Сүүлийн 6 жил үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хориглосон. Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тоо, хязгаарын дотор ахуйн зориулалтаар орон нутагт зөвшөөрөл олгодог. Цагаан зээрийн тархац нутгийн 8% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Зээрийн махыг гулууз хэлбэрээр худалдаална. Түүний гулууз махыг ямааны махтай хамт худалдаалах магадлалтай. Энэ тохиолдолд махан дээрх үс хялгасыг сайтар нягтлах нь зөв. Мөн буудуулж үхсэн амьтны мах хар хүрэн, нөжирсөн байдалтай байх ба сумны шарх байгаа эсхийг анхааралтай шалгах хэрэгтэй. Зээрийн арьс нимгэн тул илэглэсэн арьсан хүрэм, даачин (гадуур өмсөх өвлийн хувцас) хийнэ. Хүзүүг битүү өвчиж зүсээд морины жолоо хийнэ. Ооны эврийг их хэмжээгээр хил давуулан худалдаалдаг.

СОРГОГ БӨХӨН

Обыкновенный сайгак
Saiga Antelope

Saiga tatarica tatarica Linnaeus, 1766



БИЕЙН УРТ	123-146 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	69-79 см
ЖИН	30-51 кг



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж байгаа (Улаан данс, 2006)
Нэн ховор зүйл (Улаан ном, 1997; 2013; 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Гөрөөсний төрх галбиртай, хонины хэмжээтэй, дунд зэргийн биетэй амьтан. Эр нь эмэгчнээсээ биерхэг. Хэржин (эр) тахираараа 33 см хүртэл урт, гялалзсан цайвар шаргал зүстэй, бөгжилсөн олон товгор цагираг бүхий хос шоорон эвэртэй. Хэрэгчин (эм) эвэргүй. Банхгар, монхор хамрын үзүүр доод уруулаасаа урт гарч, шолхойн унжих бөгөөд гүйхэд савлаж харагдана. Зун тод улаан шаргал, өвөл элсэн шаргал юмуу цайвар сааралдуу зүстэй.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

1930 оноос агнахыг хуулиар хориглосоор иржээ. CITES-ийн I хавсралтад бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. 1950-иад онд Хавтаг, Байтаг уулын арын хотос хоолой, Борцонжийн говьд цөөн тоогоор тохиолддог байжээ. 1970 оны сүүлчээр баруун говийн Аргалант уул орчимд 4 бөхөн харагдсанаас хойш дахин үзэгдээгүй. Согог бөхөнгийн үндсэн байршил нутаг болох Зүүнгарын говийг 1975 оноос улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамруулсан.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Соргог бөхөнгийн эврийг Дорно дахины уламжлалт эмчилгээнд өргөн ашигладаг. ОХУ, Казакстанаас манай орноор хил дамжуулан худалдаалах боломжтой. Эвэр нь 35 см хүртэл урт, гялалзсан хув шаргал өнгөтэй, бөгжилсөн олон товгор цагирагтай.



МОНГОЛ БӨХӨН

**Saiga borealis Tscherski, 1876*

Монгольский сайгак
Mongolian Saiga Antelope
Meng gu ling yang

**Улаанбаатар хотноо 2010 онд зохион байгуулсан Бөхөн хамгаалах Олон улсын хурлаар Монгол бөхөн тусгаар бие даасан зүйл Saiga borealis болохыг талууд хүлээн зөвшөөрчээ.*

БИЕЙН УРТ	110-140 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	63-80 см
СҮҮЛНИЙ УРТ	8-13 см
ЧИХНИЙ УРТ	7-11 см
ЖИН	23-40 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Устаж байгаа (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзшгүй (Улаан данс, 2006)

Нэн ховор, унаган зүйл (Улаан ном, 2016)



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие нь бөгтөр хэлбэртэй. Толгой том, монхор хамартай, хамрын сүв том. Хэрэгчин эвэргүй, хэржин олон төвгөр үетэй, цайвар шаргал өнгөтэй хос шоорон эвэртэй. Зун улаан шаргал, өвөл цайвар саарал, нялх янзага бор хүрэн зүстэй. Хэржингийн толгойн ясны кондлобазаль урт 223-250 мм, хэрэгчнийх 205-229 мм. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/2; их араа 3/3=30.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

1930 оноос агнахыг хуулиар хориглосоор ирсэн. CITES-ийн I хавсралтад бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтанд хамаарна. Монгол бөхөн идээшин нутагладаг Говь Алтай, Ховд аймгийн зарим нутгийг 1993 оноос улсын тусгай хамгаалалтад авчээ. Одоогоор энэ зүйлийн тархац нутгийн 24% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Эвэр нь соргог бөхөнгийнхийг бодвол богино, нарийхан, 25 см хүртэл урт, жижиг, гялалзсан хув шаргал өнгөтэй, бөгжилсөн товгор цагирагтай, бөгжин цагираг нь цөөн байдгаараа ялгагдана. Эвэр нь тунгалаг цайвар, торгон үзүүртээ тод хар өнгөтэй. Эврийн тугалмайд цус хурсан байдлаар нь шинэ хуучныг таньж болно. Үхсэн юм уу агнаад удсан бөхөнгийн эврийн тугалмай сийрэгжинэ. Эврийг хөрөөдөж эсвэл хуга цохиж авдаг. Шинэхэн үедээ хэм нь нягт, сийрэгжээгүй байна. Эврийн уртын хэмжилтээр насыг тогтоох боломжтой. Бөхөнгийн янзага нэг нас хүрэхэд эвэр нь 18 см болно. Үхэж хорогдсон амьтны эврийн тугалмай цусгүйжин сийрэгжиж, ерөнхий өнгө зүс алдагдан өгөршиж, гадарга нь барзайх, хувхайрах зэрэг шинж тэмдэг илэрнэ. Шинэ эврийн тугалмай, угийн ясны судал, нүх ховилд шинэлэг цус хурсан байна. Бөхөнг хууль бусаар агнаж эврийг авсан эсвэл байгалийн жамаар үхсэн амьтны эвэр эсэхийг дээрх байдлаар тодорхойлж болно. Бөхөнгийн эврийг Дорно дахины уламжлалт эмчилгээнд өргөн ашигладаг.

ЯНГИР ЯМАА

Capra sibirica Pallas, 1776

Сибирский козёл
Siberian Ibex
Bei shan yang, Yuan yang

БИЕЙН УРТ	120-136 см
СЭРВЭЭНИЙ ӨНДӨР	70-110 см
СҮҮЛНИЙ УРТ	10-18 см
ЧИХНИЙ УРТ	14-16 см
ЖИН	29-153 кг



ЕРӨНХИЙ ШИНЖ

Гадаад төрхөөрөө гэрийн ямаатай төстэй ч биеэр том, хүзүү богино, бүдүүн. Хөл богино, бахим. Тэх (эр) эмэгж (эм) хоёулаа эвэртэй. Тэх гэдэргээ махийсан сэлэм хэлбэртэй, олон төвөнх үе бүхий 74-140 см урт, бүдүүн мушгирсан эвэртэй. Эмэгж харьцангуй богино, нарийн, 16-38 см урт эвэртэй. Залуу бодгаль ихэвчлэн улаавтар, идэр насных хар хүрэн, хар халтар, хөгшрөх үедээ цайвар халтар зүстэй болно. Тэхийн сахал өтгөн, урт, бараан өнгөтэй. Тэхийн толгойн ясны кондилобазаль урт 26-31 см, эмэгжийнх 23-26 см. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3=32.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Янгир ямааны эвэр, арьс, махыг худалдан борлуулах ба ахуйн хэрэгцээнд ашигладаг. Дээр дурдсан таних шинжийг ашиглан тэх, эмэгжийн эврийг тодорхойлж болно.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Амьтны тухай хууль (2012)-ийн 7.5 дахь заалтын дагуу төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр агнаж, барьж болно. Тус хуулийн 9.7.2 дахь заалтын дагуу тэхийг жил бүрийн 10-р сарын 16-ны өдрөөс дараа оны 7-р сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд олзворын ангийн зориулалтаар агнахыг хориглодог. Янгир ямааны тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Анхааралд өртөхөөргүй (Улаан данс, 2006)

Монгол улс:

Ховордож болзошгүй (Улаан данс, 2006)

Ховор зүйл (Улаан ном, 2016)



АРГАЛЬ ХОНЬ

Ovis ammon Linnaeus, 1758

Горный баран
Argali or Wild Mountain Sheep
Pan yang

БИЕЙН УРТ

110-200 см

СЭРВЭЭНИЙ ӨНДӨР

65-125 см

ЖИН

40-200 кг

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Эмзэг (Улаан данс, 2006)

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2006)
Ховор зүйл (Улаан ном, 1997; 2013; 2016)

ЕРӨНХИЙ ШИНЖ

Хүнд лагс биетэй, хөл харьцангуй урт. Угалз, хомь хоёулаа эвэртэй. Угалз 50-190 см урт, 25 кг хүнд том эвэртэй. Хомийн эвэр угалзныхаас жижиг нарийхан, урт нь 10-30 см. Хомь 10-30 см урт, жижиг, хөнгөн махир эвэртэй. Зуны зүс хүрэвтэр бор, цайвар. Харин өвлийн зүс цайвар. Хэвэл, суга, цавь цайвар цагаан. Толгойн ясны кондилобазаль урт 23-39 см. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3=32.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож иржээ. CITES-ийн II хавсралт, Бонны конвенц (CMS)-ийн II хавсралтад тус тус бүртгэлтэй. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Аргаль хонины тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Аргаль хонины махыг хүнсэнд хэрэглэх зорилгоор агнана. Мах нь ахируун зажлууртай, хонины махыг бодвол бүдүүн ширхэгтэй. Арьсаар нь дээл хүрэм хийнэ. Хууль бусаар агнасан болон үхсэн амьтдын эврийг хил давуулан худалдаална. Сүүлийн үед том угалзын эврээс гадна хомь, залуу амьтдын эврийг гаргах болсон. Эврийг дээр дурдсан таних шинжийн дагуу ялгаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ШАВЖ

АПОЛЛОН

Parnassius apollo

Аполлон
Аполлон
Apollo Butterfly



ЕРӨНХИЙ ШИНЖ

Урд өрөөсөн далавчны урт 35-45 мм, дэвсгэр өнгө нь цагаан. Далавчны гадна ирмэгээр өргөн бүдэг саарал өнгөтэй. Урд далавчин дээр 5 хар толботой. Бие нь үсэрхэг бараан өнгөтэй. Ховдын Улиастайн гол, Хөвсгөл нуурын урд хэсэг болон зүүн эргээр Далбаа гол, Арсай голын хөндий, Саяны нурууны өмнөд хэсэг, Хангайн нуруу, Тарвагатай, Булнайн нуруу, Ерөө голын эх, Хэнтийн нуруу, Богдхан уул зэрэг ихэнхдээ өндөр уулархаг бүс нутгийн намгархаг нуга, наранд ээвэр, эгц, цавчим налуу энгэр бүхий орчинг шүтэж байрших хэдий ч тухайн өндөр уулсын систем дэх томоохон гол, мөрний хөндийн алаг өвст нугаар тохиолдоно.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Түүний байршил нутагт мал олноор бэлчих, хадлан хадах, гоёмсог том эрвээхэй тул олноор цуглуулах зэрэг шалтгаанаас тоо толгойн цөөрч байгаа хэмээн үздэг. CITES-ийн II хавсралтад бүртгэлтэй. Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон. Аполлон эрвээхэйн тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хэсэгчлэгдэн хамрагдсан.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Европын зэрлэг амьтан ба амьдрах орчинг хамгаалах тухай конвенц (Берн)-ийн II хавсралт, Европын холбооны зөвлөлөөс баталсан “Амьдрах орчинг хамгаалах тухай тогтоол (92/43/ЕЕС)”-ын IV хавсралтад тус тус орсон (Гантигмаа, 2014).

Монгол улс:

Ховор зүйл (Улаан ном, 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Гоёмсог том эрвээхэй учир байгаль сонирхогч, судлаач, сониуч хүмүүс замбараагүй барьж, хөнөөсний улмаас ховордсоор байна. Аполлон эрвээхэйг биетээр нь цуглуулгын зорилгоор худалддаг. Түүнийг бүхлээр нь хатааж тусгайлан бэлдсэн хайрцаг, хавтсанд хийж хилээр гаргаж болзошгүй. Энэ зүйлийг гадаадын зарим улс руу хууль бусаар худалдах, тээвэрлэх боломжтой бөгөөд энэ талаар эх сурвалж нь тодорхойгүй зарим аман мэдээ бий.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

УРГАМАЛ

СЭРХЭН ХӨХӨӨЦЭЦЭГ

Gymnadenia conopsea (L.) R. Br.

Кукушник длинношпорцевый

Fragrant orchid

Shouzhancang

ЕРӨНХИЙ ШИНЖ

Суумал цэцгүүд нь 5-15 см урт, өтгөн цацаг баг цэцэг үүсгэнэ. Цэцгийн дагавар навч өвслөг ногоон, нарийхан шувтгар үзүүртэй, үрэвчээсээ урт. Цэцэг нь өтгөн ягаан эсвэл цайвар ягаан. Шадар эрхтний гадаад навчинцар өндгөрхүү мохоо 3-4 мм урт, дотоод нь 5 мм урт. Уруул 5 мм урт, мохоо гурван салбанлаг. Годой нарийхан, 1.5 см урт тахир. Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянганы уулсын ойт хээрийн бүслүүрт татмын нуга, сөөгөн ширэнгэ, ойн нуга ба зах, сийрэг шинэсэн ба хусан ойд ургана.



ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад орсон. Сэрхэн хөхөөцэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй (Улаан данс, 2011)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Тухайн зүйл ургамлын их бие, үндэсний булцууг хатааж бэлтгэн худалдаална. Ургамлыг амьдаар авч гарах магадлалтай. Эмийн болон гоёл чимэглэлийн зориулалтаар түүж ашигладаг.

ГУРВАЛСАН ШҮРЭН ЦЭЦЭГ

Corallorhiza trifida Chatel.

Ладьян трехнадрезный
Coralroot Orchid
Shanhulan

ЕРӨНХИЙ ШИНЖ

Шүхэрхүү, салаалсан үндэслэг иштэй. Салбарласан үндэсгүй, 10-15 см өндөр, шаравтар, туяхан, нүцгэн, ишиндээ 2-4 хальсан угларгатай, шаравтар ногоон өнгийн 2-10 цэцгээс бүрдсэн 2-8 см урт, сийрэг, цацагтай. Ногоон навчгүй, олон наст ургамал. Цэцгийн шадар эрхтний навчинцар 4 мм орчим урт, тэдгээрийн гурав нь босоо, хоёр нь хажуудаа байрлалтай. Цэцгийн уруул навчинцараас ялимгүй богино, зууван бараг бүтэн. Шилмүүст ой, сөөгөн шугуйн хөвдөрхөг хөрсөнд ургана.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Эмзэг (Улаан данс, 2011)



ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад орсон. Гурвалсан шүрэн цэцгийн тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Эмийн зориулалтаар үндэсний булцууг түүж хэрэглэдэг. Олон салаалсан махлаг цайвар шаргал өнгийн үндэстэй. Ургамлыг амьдаар болон үндэслэг ишээр гадаадад худалдаалах магадлалтай.

ХӨХӨӨ ЦҮНХРЭГ

Neottianthe cuculata (L.) Schlechter

Гнездоцветка клобучковая
Cucullated Neottainthe
Eryedoubelian



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:
Устаж байгаа (Улаан данс, 2011)



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нэг см голчтой бөөрөнхий ганц булцуутай, 10-20 см өндөр, туяхан ишиндээ эсрэг суусан 2-5 см урт, 1-3 см өргөн хоёр зууван навчтай. Ишний дээд хэсэгт урт угларга бүхий 1-2 бяцхан навчтай. 6-20 улбар хөх ягаан цэцгээс бүрдэх 3-8 см урт, угаа хүрэл 3 салбанлагтай, дундах нь бусдаасаа өргөн, 5 мм урт, тахир, үзүүртээ бөндгөр годойтой. Шилмүүст ойн сүүдэрсэг, хөвдөрхөг хөрсөнд ургана.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад орсон. Хөхөө цүнхрэгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Гоёмсог үзэмжтэй, анхилуун сайхан үнэртэй цэцгийг сонирхон түүх, ойн мод огтлох, түймэрт нэрвэгдэх зэрэг сөрөг нөлөөллийн улмаас устаж болзошгүй ургамал. Газрын дээд хэсэг болон үндэсний булцууг эмийн түүхий эд болгон хэрэглэдэг. Ургамлыг амьдаар болон үндэсний булцууг худалдаалах магадлалтай.

БУЛЦУУТ ТҮДЭНХАВХ

Calypso bulbosa (L.) Reichb. F.

Калипсо луковичная
Calypso
Budailan

ЕРӨНХИЙ ШИНЖ

Утаслаг үндэстэй, сарьсан бүрээст бяцхан булцуунаас гарсан 8-15 см өндөр 2-3 хальсан угларгатай. Ишний суурьт 3-5 см урт, 2-3 см өндгөрхүү ногоон илтэст, урт бариулт ганц навчтай, үзүүртээ том ягаан цэцэгтэй олон наст ургамал. Шадар эрхтний навчинцар 1.5-2.0 см урт, юлдэрхүү, шовх, саравгар, уруул шаахайрхуу, үзүүртээ дэлбэгэр, суурь хэсэгтээ 3 бөөн шар үсэнцэртэй. Шилмүүст ойн сүүдэрсэг, хөвдөрхөг хөрсөнд ургана.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад орсон. Булцуут түдэнхавхын тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Устаж байгаа (Улаан данс, 2011)

Нэн ховор ургамал (Улаан ном, 1987; 1997; 2016)



ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Эмийн ургамал учраас үндэсний хэсгийг хүмүүс түүж хэрэглэнэ. Гоёмсог цэцэгтэй болохоор хүн, амьтан сониучлан тасдаж нөөцийг нь хомсдуулдаг. Энэхүү зүйл ургамлыг амьдаар болон түүний үндэсний булцууг арилжаалах магадлалтай.

ТОМ ЦЭЦЭГТ СААДГАНЦЭЦЭГ

Cypripedium macranthum Sw.

Башмачок крупноцветковый
Grand Lady's Slipper
Dahualulan

ЕРӨНХИЙ ШИНЖ

Нэлээд бүдүүн, үелэг хөндлөн үндэслэг ишнээс ургасан 20-40 см өндөр иштэй, 8-15 урт, 4-8 см өргөн зууван, цувраа 3-5 навчтай, ишний үзүүрийн дагавар навчны өвөрт 1-2 улбар ягаан том цэцэгтэй, олон наст ургамал. Цэцгийн шадар эрхтний 4 навчинцар 4-5 см урт, нарийн юүлдэрхүү, үзүүр лүүгээ шовх, уруул уртархуу, улбар ягаан өнгөтэй. Сийрэг шинэсэн ой, нарс, хусан ойн төгөл, ойн зах, нугад тун ховор тохиолдоно.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Эмзэг (Улаан данс, 2011),
Нэн ховор ургамал (Улаан ном, 1987;
1997; 2016)



ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад орсон. Томцэцэгт саадганцэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Газрын дээд хэсгийг хүмүүс түүж хэрэглэнэ. Гоёмсог цэцэгтэй болохоор хүн, амьтан сониучлан тасдаж нөөцийг нь хомсдуулдаг. Хөвсгөл орчим, Монгол дагуурын тойргын баруун хэсэг, Хэнтийн тойрогт тохиолдоно. Энэхүү ургамлыг амьдаар болон түүний үндэсний булцууг худалдаалах магадлалтай.

ЦООХОР СААДГАНЦЭЦЭГ

Cypripedium guttatum Sw.

Башмачок пятнистый
Spotted Lady's Slipper, Mosassin flower
Bauhualulan

ЕРӨНХИЙ ШИНЖ

Мөлхөө үндэслэг иштэй, олон наст өвс. Иш 15-30 см өндөр, шүүсэвчит үсэрхэг. Навч 5-10 см урт, 3-4 см өргөн, газрын дээд хэсэг нь хатахдаа харламтгай. Цэцэг ганц, цэцгийн дагавар 1.5-2 см урт, навчирхуу, гонзгой-юлдэрхүү. Шадар эрхтний навчинцар болон уруул цагаан юмуу нил ягаан толбонуудтай, хажуугийнх нь навчинцарууд сунгуу, 1,5-2 см урт, хэлтгий суурьтай, үзүүрээрээ ялимгүй өргөн, дугуйдуу. Ойт хээрийн бүслүүрт ойн нуга, хус-шинэсэн ой, хусан төгөл, нарс-хусан ой, шинэсэн ойд ургана.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад орсон. Цоохор саадганцэцгийн үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газруудад хамруулсан.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй (Улаан данс, 2011)



ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Тус зүйл ургамлын их биеийн газрын дээрх хэсэг нь эмийн чанартай, түүнийг булган хар гэдэг. Гоёмсог цэцэгтэй болохоор хүн, амьтан сониучлан тасдаж нөөцийг нь хомсдуулдаг. Үндэслэг ишээр хөрсөнд үрждэг. Хөвсгөл орчим, Монгол Дагуурын тойргын баруун хэсэг, Хэнтийн тойрогт тохиолдоно.

ШАР СААДГАНЦЭЦЭГ

Cypripedium calceolus L.

Башмачок желтый (известняковый)
Yellow Lady's Slipper
Lulan

ЕРӨНХИЙ ШИНЖ

Хөндлөн бараан үндэслэг иштэй, 20-40 см өндөр, олон наст ургамал. Ишний дунд хэсэгт 6-10 см урт, 2-4 см өргөн, зууван, суумал 3-5 долгиотсон навчтай, үзүүртээ 1 юмуу 2-3 том цэцэгтэй. Цэцгийн шадар эрхтний 4 навчинцар 3-5 см урт, нарийн юүлдэрхүү, мушгирсан улбар хүрэн өнгөтэй, цайвар шар уруул цэцэгтэй. Ойт хээрийн бүслүүрт голын эрэг, хусан төгөл, ойн нуга, цоорхойд ургана.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад орсон. Шар саадганцэцгийн тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Эмзэг (Улаан данс, 2011)
Нэн ховор ургамал (Улаан ном, 1987;
1997; 2016)



ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Хүмүүс газрын дээд хэсгийг тасдан түүнэ. Гоёмсог цэцэгтэй болохоор хүн, амьтан сониучлан тасдаж нөөцийг нь хомсдуулдаг. Энэхүү ургамлыг амьдаар болон түүний үндэсний булцууг авч гарах магадлалтай.

ЦӨЛИЙН АРГАМЖИН ЦЭЦЭГ

Cistanche deserticola Ma

Цистанхе пустынний

Desert Cistanche

Roucongrong

ЕРӨНХИЙ ШИНЖ

Ургамлын нийт урт 50-150 см, баг цэцгийн өнгө цайвар ягаан, дэлбэний гадагш эргэсэн ирмэгийн өнгө мэдэгдэхүйц тод, газар дээрх хэсгийн хайрс урт, харьцангуй чөлөөтэй байрласан учир хатсаны дараа өргөсөрхүү хэлбэртэй болно. Цэцгийн тоо хэдэн зуу хүрнэ. Газар дээрх хэсэг 15-30 см өндөр. Ишний хайрс өргөн, суурьтай нягт. Цэцгийн цоморлиг дэлбээнээс 2-3 дахин богино. Хоолой, доод уруулын гадна тал үсэрхэг. Ургамлын бие нойтон үедээ усархаг зөөлөн. Хөрсний ус сайтай, манхан элс, элсжсэн сайраар загийн үндсэн дээр шимэгчилж, мөлжиж (паразитаар) амьдарна.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 3.3 дахь заалтаар нэн ховор ургамлын жагсаалтад орсон. Цөлийн аргамжин цэцгийн тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Устаж болзошгүй (Улаан данс, 2011)

Нэн ховор ургамал (Улаан ном, 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Ургал үед нь газрын дээрх, доорх хэсгийг ухаж нойтоноор болон зүсэж хатаасан хэлбэрээр ашигладаг. Гадуураа хальсгүй махлаг, зөөлөн бага зэрэг аргуун амттай. 5-15 см, хааяа түүнээс том махлаг цайвар үндэстэй.



ЯГААН ХҮНХОРС

Physochlaena physaloides (L.) G., Don

Физохлена вздутая
Funneled Physochlaina Root
Huashanshen

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Монгол оронд газар сайгүй тохиолдох элбэг ургамал. Гэвч уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, цөлжилт, хэт ашиглалтын улмаас тус зүйл ургамлын тархац нутаг багасаж байгаа. Ягаан хүнхорсын тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Ташуу бүдүүн үндэслэг иштэй, өвслөг, олон наст ургамал. Ихээхэн салаалж мөчирлөсөн, цөөн тооны иштэй. Ишний өндөр нь 10-40 см, ишний ёзоор хавийн навчис хайрсархуу, бусад нь бариултай. Мохоо ухагдмал захтай, өндөг хэлбэрийн навчнуудтай, үр жимснийхээ үед хөөж том болдог сарьслаг цомирлог бүхий юүлүүр хэлбэрийн цэнхэр, ягаан цэцэгтэй. Хээрийн бүсийн хар шороо маягийн нарийн ширхэгт шим сайт хөрс бүхий хуурай хотос хоолой, хааяа чулуурхаг энгэрээр ургана. Асар их хортой ургамалд тооцогддог. Мал иддэггүй. Төвд эмнэлэгт хэрэглэж байжээ.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Махлаг бүдүүн үндэслэг ишийг нь ухан авч худалдаална. Үндэс нь хар бараан холтостой, ширхэглэг цайвар өнгийн зөөлөн эдтэй. Үндэслэг ишний төгсгөл нь салаалж салбарласан. Хурц тод үнэргүй.



ЯГААН ЦЭЭНЭ

Paeonia anomala L.

Пеон Марьин корень
Anomalous Peony
Yuan ya zhong

ЕРӨНХИЙ ШИНЖ

Хошой гурвалсан цуулбар навчнуудтай, 60-80 см хүрэхүйц өндөр том ягаан цэцэгнүүдтэй, олон настай, сагалгар өвслөг ургамал. Бутаараа ургаж, цэцэглэдэг. Хангай, Хэнтийн нурууны ой, ойт хээрийн бүслүүрт шинэсэн ба холимог ой, ойн зах, хусан төгөл, сүүдэрлэг ам, хавцалд ургана. Нутгийн хүмүүс цээнийн ягаан гэж нэрлэдэг.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй



ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамлын үндэслэг ишийг эмийн зориулалтаар ихээр түүж тархац, нөөцийг нь хомсдуулсан тул Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад 2004 онд нэмж оруулжээ. Мал иддэггүй. Ягаан цээнийн тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Олон наст үндэс, үр жимс зэргийг түүж бэлтгэн худалдаалах магадлалтай. Үндэс нь хүрэн бор өнгийн олон давхраат холтостой, ягаавтар туяатай модлог эдээс тогтоно. Түүн дээр ирэх жилийн сэргэлтийн олон нахиа байрлана. Үр жимс нь гялалзсан хар бараан өнгөтэй 0.5 см хүрэх бөгөөд дотроо цайвар шаргал үртэй.

ДЭРЭВГЭР ЖИРГЭРҮҮ

Saposhnikovia divaricata (Turcz.) Schisch

Divaricate Saposhnikovia Root
Fangfeng



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй

Ховор ургамал (Улаан ном, 2016)

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамлын голлосон үндсийг ухаж, хил дамжуулан их хэмжээгээр худалдаалсаны улмаас түүний тархац, нөөц ихээхэн багассан учир Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад 2004 онд нэмж оруулжээ. Дэрэвгэр жиргэрүүгийн тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Сууриасаа эхлэн ихэд салаалсан, бөөрөнхийвтэр бутаар ургадаг олон наст цайвар ногоон өвслөг ургамал. Иш ганц, 30-80 см өндөр. Үндэс орчмын навчис богино бариултай, хөргөөрөө гонзгой, хошоод юмуу гурвантай өдлөг цуулбар. Хурц гүрвэн бүхий дүүжин үрцэг жимстэй. Цагаан цэцэгтэй, давхар шүхэр багцагтай. Хээрийн бүс, уулын хээрийн бүслүүрт хайргархаг, чулуурхаг хээржүү хажуу, бэл хормой, хялгана ба алаг өвст хээр, хээрийн сөөгөн ширэнгэ, заримдаа тариан талбай, атаржсан газар элбэг ургана.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Дэрэвгэр жиргэрүүгийн голлосон үндэс хэсгийг ухаж бэлтгэн худалдаалдаг. Бор шаргал холтос бүхий багавтар үндэс нь хүзүү хэсгээрээ олон тооны цэцэглэх ишний үлдвэртэй, тууш ширхэглэг, цайвар шаргал өнгийн модлогтой, хурц тод үнэргүй.



НАНГИАД ЗЭЭРГЭНЭ

Ephedra sinica Stapf

Хвойник китайский
Ephedra Root
Mahuanggen

ЕРӨНХИЙ ШИНЖ

Сагалгар мөчир бүхий 10-20 см өндөр, жижиг сөөгөнцөр ургамал. Үзүүртээ голдуу мушгирч эргэсэн мөчиртэй, шүүслэг улаан өнгийн жимстэй. Түрүүхэй нь хоёр цэцэгтэй. Нангиад зээргэнэ хээр ба заримдаг цөлийн бүсээр зонхилон тархсан боловч Хангайн уулархаг орны өмнөд захаар бас тохиолдоно. Ер нь нам толгодын чулуу сайртай бэл, сайр бүхий тал нутгаар ургадаг.



ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамлыг их хэмжээгээр түүж бэлтгэн хил дамжуулан худалдаалсаны улмаас түүний тархац, нөөц ихээхэн багассаг байгаа учир Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад 2004 онд нэмж оруулсан. Нангиад зээргэний тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Нангиад зээргэний зөвхөн газрын дээд хэсгийг хэрчмэл байдлаар бэлтгэн савлаж худалдаалдаг. Зэгэл ногоон өнгөтэй, бага зэрэг мушгирсан, амтлахад аргуун, хэл дарвигнуулам хурц амттай.



ЖИНХЭНЭ ОНГОЛ, ХУСНЫ МӨӨГ

Inonotus obliquus Pilat.

Чага

Chaga mushroom

ЕРӨНХИЙ ШИНЖ

Тодорхой хэлбэр дүрсгүй, гадуураа зузаан, арзгар, бараан холтослог. Бие гүйсэн үедээ хэдэн арван сантиметрээс 1 метр хүртэл бүдүүрдэг шимэгч ур мөөг. Хөгширсөн хус бүхий холимог ойд амьд хус, хусны ишэн дээр, заримдаа бургас, нүргэс, тэсэн дээр амьдарна.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамал нь Монгол орны хусан болон холимог ойд голдуу хус модны иш дээр шимэгчлэн ургадаг ховор зүйлийн ур мөөг тул Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад оруулжээ. Жинхэнэ онголын тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй

Ховор ургамал (Улаан ном, 1997; 2013; 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Огтлоход цайвардуу судалтай, үйсэрхүү нягт, ямар нэгэн амт, үнэргүй. Жижиглэж бутласан эсвэл үрж нунтагласан хэлбэрээр бэлтгэсэн байдаг. Буцалсан усанд хийхэд цай шиг хандлагдана.

ГАЗРЫН ҮС, ХАР ӨВС

Nostos flagelliforme Berk.et Curt.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Газрын үс замаг нь бөөгнөрсөн байдалтай, өөр хоорондоо орооцолдсон хар өнгийн, нарийн хугарамтгай утаслагаас тогтсон бөгөөд зарим хэсэг туузархуу болсон байдаг. Энэ хөх ногоон замаг нь хүрэндүү туяа бүхий ногоовтор хүрэндүү өнгөтэй. Утаслаг голчоороо 1 мм хүртэл, өргөссөн туузан хэлбэр бүхий хэсэгтээ 2 мм, заримдаа 3 мм, цөөнгүй тохиолдолд 5-8 мм өргөнтэй болсон байдаг.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамал нь Монгол орны цөл, заримдаг цөлийн кальцаар баялаг, шаварлаг хөрсөнд ургадаг бөгөөд заримдаа уулын хадтай газраар тохиолддог газрын ховор замаг тул Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад оруулжээ. Газрын үсний тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй

Нэн ховор ургамал (Улаан ном, 1997; 2013; 2016)



ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Бөөгнөрсөн хар бараан үсэрхүү. Гараар имэрч үзэхэд амархан хугарамхай. Усанд хийж тавих юмуу буцалгаж хандлахад хөөж томроод цэлцгэр бие үүснэ. Ус, спиртэнд хандлахад өвөрмөц үнэртэй ногоовтор өнгөтэй хандлагдана.

МОНГОЛ ХУНЧИР

Astragalus mongolicus Bge.

Астрагал монгольский
Milkvetch Root
Huangqi



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамлын салаалж салбарласан ишийг эмийн зориулалатаар их хэмжээгээр түүж бэлтгэсний улмаас түүний тархац, нөөц ихээхэн багассаг байгаа учир Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад 2004 онд нэмж оруулсан. Монгол хунчирын тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ЕРӨНХИЙ ШИНЖ

Голлосон үндэстэй, 30-60 см өндөр, хар, цагаан холилдсон үслэгтэй, олон бадриун иштэй, том бутаар ургадаг. Олон наст хуурайсаг буурцагтан. Хос бус өдлөг нийлмэл навчистай, навчинцар 10-18 хос, 4-10 мм өргөн тонгоруу өндгөрхүү эсвэл зууван юмуу гонзгойдуу мөлгөрдүү оройтой зузаан, зөвхөн ар талдаа үсэрхэг. Цэцэг шар юмуу шаргал, сийрэг баг цэцэгтэй, үрэвч болон буурцаг нь тэгш бус хэмтэй, тал саран юмуу гонзгойворт хэлбэртэй урт нарийн шилбэн дээр оршино. Говь хээрийн бүс, ойт хээрийн бүслүүрт чулуурхаг хажуу, байц хадны ёроолд, сийрэг хуурай шинэсэн ой, элсэн эрэг, элс, элсэрхэг хөрстэй тал, сайрын ирмэг, гол, нуурын хайргархаг дэнж, хээрийн сөөгөн ширэнгэнд ургана.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Худалдааны гол түүхий эд нь үндэс. Хар бараан, хүрэн бор, бор шаргал өнгийн холтостой, цайвар шаргал өнгийн шууд ширхэглэг, хааяа голдоо бараан өнгийн судалтай.



УРАЛ ЧИХЭР ӨВС

Glycyrrhiza uralensis Fisch.

Солодка уральская
Liquorice Root
Gancao



ЕРӨНХИЙ ШИНЖ

Хос биш өдлөг гялтганасан хар ногоон навчнуудтай 40-70 см өндөр, олон наст өвслөг ургамал юм. Навчнууд нь өндөг хэлбэртэй байна. Өтгөн, нягт залаа баг цэцэг болж цугларсан цайвардуу-хөх ягаан цэцгүүдтэй. Түүний хадуур мэт нугарсан тахир, уртавтар шугаман хэлбэрийн том буурцагнууд нь нягт хүрэн бөмбөлөг болж бөөгнөрсөн байдаг. Энэ ургамал бүхэлдээ нэг хэлбэрийн наалдамхай булчирхайнуудтай байдаг тул зэвгэр ногоон өнгөтэй. Чихэр өвс хонхор хотос газрын зах, дэрс, дэрс бүхий хулстай ширэнгэ, давс, хужиртай нам газрын товцог элс, гол горхийн захаар, голдуу бөөн бөөнөөрөө ургадаг.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамал нь Монгол орны хээр, говийн бүс нутгаар түгээмэл тархсан байдаг боловч сүүлийн жилүүдэд эм, хүнс, техникийн зориулалтаар их хэмжээгээр түүж бэлтгэсний улмаас түүний тархац, нөөц ихээхэн багассаг байна. Иймд Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад 2004 онд нэмж оруулсан. Урал чихэр өвсний тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:
Үнэлгээ хийгдээгүй

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Түүний зөвхөн үндсийг өргөн ашигладаг. Хүрэн бор, бор шаргал холтостой үндсийг хэрчмэл байдлаар бэлтгэнэ. Үндэсний зөөлөвтөр модлог ихээхэн чихэрлэг, бага зэрэг аргуун амттай.



ЗҮҮНГАРЫН ГОЁО (УЛААН ГОЁО)

Cynomorium songaricum Rupr.

Циноморий джунгарский
Songaria Cynomorium Herd
Suoyang

ЕРӨНХИЙ ШИНЖ

Элсэн товцог, хармагийн үндэс дээр нэг буюу хэд хэдээр бэхлэгдэж ургана. Бие улбар хүрэн юмуу хар бараан өнгөтэй, 5-30 см урт, 1-3 см голчтой, ээрүүлэрхүү монгол баг цэцэгтэй, хүрэн ягаан өнгөтэй, 10-20 см урт, 1-2 см голч бүхий махлаг, зөөлөн иштэй, шимэгч ургамал. Ишний дагуу цуваа байрласан үлдэгдэл төдий хайрсархуу навчтай. Маш жижиг олон тоотой дан юмуу хос бэлэгт цэцэгтэй. Цэцгийн шадар эрхтэн энгийн улаавтар юмуу хүрэн ягаан өнгөтэй, 2-4 мм урт, 1.5 мм өргөн, суурь нарийн шаантгархуу, 1-4 (хааяа 8) навчинцартай. Эр цэцэг дундаа бүдүүн утаслаг шилбэтэй, нэг дохиуртай. Эм цэцэг доор үрэвчтэй. Тавархуу бяцхан амсар бүхий нэг үр боловсрох оронтой. Самранцар хэлбэрийн үр жимс бөмбөлөгөрхүү, жижигхэн, улбар хүрэн өнгөтэй, нэг үртэй.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тусзүйл ургамлыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр түүж хэрэглэдэг ба хил дамжуулан худалдаалах болсон тул 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад оруулсан байна. Зүүнгарын гоёоны тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй

Ховор ургамал (Улаан ном, 1997; 2013; 2016)

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Диаметрээрээ 3-5 см орчим. Нойтон үедээ чийглэг, аргуун амттай. Хатсан үедээ хатуу, амт аргуун.

ЦАГААН УУЛ

Leontopodium campetre (Ldb.) Grub.

Эдельвейс полевой
Leontopodium edelweiss herb

ЕРӨНХИЙ ШИНЖ

Нутгийн иргэд цагаан түрүү юмуу уул өвс (энэ ургамлын цэцгэн сагсыг хучсан өтгөн цагаан унгарилыг урьд хэтний уул болгож хэрэглэж байсан ажээ) гэдэг. Энэ нь бутандаа хэд хэдээрээ бөөгнөрсөн иштэй, бүхэлдүү битүү унгарил үсэнцрээр хучигдсан учир сааралдуу цайвар өнгөтэй, 15-20 см өндөр, олон наст ургамал юм. Түүний ихэнх навчис ишний уг орчмоос гарсан бөгөөд уртавтар тонгоруу өндөг хэлбэртэй, мөн шилбэтэй байна. Ишний навч нь суумал шугаман хэлбэртэй, оройн баг цэцэг болж цугларсан цэцгийн сагс нь гол төлөв цагаан унгарил үсэнцэрээр хучигдсан. Цагаан уул монгол орны ойт хээрийн нутгаар арви багатай боловч нэлээд тааралддаг ба хээрийн бүсийн хойд зах руу элбэг тохиолддог. Мөн Говийн Алтай, Их Богд, Бага Богдын нуруудын дээд бүслүүрт байдаг. Мөн нам өвст уулын хээр, хайрга чулуутай энгэр бэлээр ургахын сацуу сайр дээр ч тохиолдох элбэг ургамал.

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамлыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр түүж хэрэглэдэг ба хил дамжуулан худалдаалах болсоноор тархац, нөөц нь хомсдож байгаа. Цагаан уулын тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.



ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:
Үнэлгээ хийгдээгүй

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Ургамлыг бүхлээр нь авч бэлэг дурсгал, эмийн зориулалтаар ашигладаг. Гадаадын улс оронд өнө мөнхийн билэгдэл болгон бэлэг дурсгалд өргөн хэрэглэдэг. Сүүлийн үед ихээр түүж, бэлэг дурсгал хэлбэрээр гаргах болсон байна.



БАЙГАЛ ГҮҮНХӨХ

Scutellaria baicalensis Georgi.

Шлемник байкальский
Baikal Skullcap
Huangqin

ЕРӨНХИЙ ШИНЖ

Махлагдуу шаргал үндэстэй, жижиг нягт бутаар ургадаг, олон наст өвс. Иш олон, гуурслаг хатуу. Навч энгийн, цувраа, 1-5 см урт, 2-8 мм өргөн сарьслаг юмуу арьслаг зузаан, өвөр тал бараг нүцгэн. Ар талдаа цэг мэт хүнхэр олон шүүсэвчтэй. Цэцэг хөх, ишний үзүүрийн жижиг навчис тус бүрийн өврөөс гарч 8 см хүртэл урт өрөөсгөл цацаг үүсгэнэ. Цомирлогийнхоо хоолой дээр хөндлөн хөхлөгтэй. 6-7 сард цэцэглэж, 7-8 сард үрээ өгнө. Хээрийн бүсийн чулуурхаг хажуу, элсэрхэг ба хайргархаг энгэр, асга, тэгш талд ургана.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:

Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:

Үнэлгээ хийгдээгүй

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамлыг бүхлээр нь болон үндэслэг ишийг түүж эмийн түүхий эд болгон хил дамжуулан худалдаалах болсоноор түүний нөөц ихээхэн хомсдох болсон. Иймд Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад 2004 онд нэмж оруулжээ. Байгал гүүнхөхийн тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.

ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Үндэслэг ишийг бэлтгэн худалдаална. Үндэслэг иш нь мушгирсан урт шувтан хэлбэртэй, гадна тал нь цайвар хүрэн дотроо хулсан шар өнгөтэй, аргасан гашуувтар амттай.

ЭГЭЛ БАВРАН

Pteridium aquilinum (L.) Kuhn.

Папоротник
Bracken Fern

ЕРӨНХИЙ ШИНЖ

1 м урт, 10 мм бүдүүн, урт мөлхөө хар хүрэн үндэслэг иштэй, урт бүдүүн бариул бүхий өөр хоорондоо ихэд алслагдсан навчистай, нэгэн зүйл ойм хэлбэртэн. Навч арьслаг зузаан том, 1 м хүртэл өндөр, илтэс нь гурвалжиндуу бөгөөд гадагш огцом дэрэвгэр, хошоод юмуу гурвантаа өдлөг нийлмэл, богино бариул дээр эсрэг суусан сегментүүдтэй, тэдгээрийн гэдрэг эргэсэн сормослог ирмэгийн доогуур үрцэрт гэрийн товруунууд хальслаг бүрхүүлийнхээ хамт хос зураас мэт үргэлжилж хамгаалагдана. Ойт хээрийн бүслүүрт голын эрэг, ойн зах, хус улиангаран төгөл, нарсан ойд ургана.

ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

Олон улс:
Үнэлгээ хийгдээгүй

Монгол улс:
Үнэлгээ хийгдээгүй

ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Тус зүйл ургамлын залуу найлзуурыг ихээр бэлтгэж нөөцийг нь хомсдуулах болсон тул Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Ховор ургамлын жагсаалтад 2004 онд нэмж оруулжээ. Эгэл бавраны тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хэсэгчлэгдэн хамрагдсан байна.



ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН

Түүний залуу найлзуурыг шинэхэн ургах үед нь түүж нойтон болон хатаасан хэлбэрээр ашигладаг. Хатаасан найлзуур нь гялалзсан бор, хар бараан өнгөтэй, хялбархан хугарамтгай, бага зэрэг гашуун, хэл дарвигнуулам амттай. Усанд хийвэл дэвтэж уян зөөлөн цэлцгэр болно.



ДОЛООДУГААР БҮЛЭГ

ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

1992 оны 1-р сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

Зургадугаар зүйл.

1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.

2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/Шинэчилсэн найруулга/

2016 оны 12-р сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “байнгын ажиллагаатай боомт” гэж Монгол Улсын олон улсын гэрээнд заасан цагийн хуваарийн дагуу байнга ажиллах боомтыг;

3.1.2. “боомтын дэд бүтэц” гэж хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх авто зам, төмөр зам, агаарын тээврийн дэд бүтэц, хилийн хяналтын байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлсэн, хилийн боомтод тавих аюулгүй байдлын шаардлагыг хангасан инженерийн дэд бүтцийг;

3.1.5. “олон улсын боомт” гэж Монгол Улсын олон улсын гэрээний дагуу иргэний харьяаллыг үл харгалзан зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх боомтыг;

3.1.6. “түр ажиллагаатай боомт” гэж боомтын асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу түр хугацаанд ажиллах боомтыг;

3.1.8. “улсын хил дамнасан байгууламж” гэж улсын хилийн шугамыг дайран гарсан төмөр зам, авто зам, газрын тос болон хий дамжуулах хоолой, холбоо, цахилгааны шугам, гүүр, усны далан, хашлага болон бусад байгууламжийг;

3.1.12. “хилийн боомт” гэж улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар төхөөрөмжилсөн, тусгайлан тогтоосон газрыг;

3.1.16. “хилийн хяналтын байгууллага” гэж улсын хил нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт явуулах, бүртгэх эрх бүхий улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналт, гадаадын иргэн, харьяатын байгууллагыг;

3.1.19. “хоёр талын боомт” гэж хил залгаа улстай хилийн боомтын асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу Монгол Улсын болон хил залгаа улсын зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх боомтыг;

3.1.21. “хяналт шалгалтын бүс” гэж хилийн хяналтын байгууллага хилийн боомтод хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах зориулалтаар тусгайлан тоноглогсон газрыг.

4 дүгээр зүйл. Монгол Улсын хил

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил /цаашид “улсын хил” гэх/ гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна.

4.2. Улсын хил халдашгүй дархан байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН ХИЛИЙН ДЭГЛЭМ

16 дугаар зүйл. Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх

16.1. Улсын хилийг газар, ус, агаараар нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу улсын хилээр нэвтрүүлнэ.

17 дугаар зүйл. Улсын хилийн боомт дээр ажиллах хяналт шалгалтын байгууллага

17.1. Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх зорилгоор хилийн боомтод улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллага, виз бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаадын иргэн, харьяатын байгууллага ажиллана.

17.2. Зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтод тогтоосон замаар нэвтрэх бөгөөд улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид шалгуулах үүрэгтэй.

17.3. Хилийн хяналтын байгууллага улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхдээ доор дурдсан дарааллыг баримталж хяналт шалгалт явуулна:

17.3.1. улсын хилээр гарах хөдөлгөөний чиглэлд мэргэжлийн хяналтын, гаалийн, улсын хил хамгаалах байгууллага;

17.3.2. улсын хилээр орох хөдөлгөөний чиглэлд улсын хил хамгаалах, мэргэжлийн хяналтын, гаалийн байгууллага.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1995 оны 3-р сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томъёо

1. Энэ хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ:

- 1/газар, түүний хөрс;
- 2/газрын хэвлий, түүний баялаг;
- 3/ус;
- 4/ургамал;
- 5/амьтан;
- 6/агаар.

2. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/"байгаль орчин" гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна;

2/"ус" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорхи ус хамаарна;

3/"ургамал" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт ургадаг байгалийн болон таримал ой, мод, бүх төрлийн дээд, доод ургамал хамаарна;

4/"амьтан" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна;

5/"агаар" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийн хийн бүрхэвч хамаарна;

6/"байгаль орчинд хортой нөлөөлөх" гэдэгт байгаль орчин, түүний баялгийг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх, сөнөөж мөхөөх үйлдэл /эс үйлдэхүй/ хамаарна.

7/"байгаль орчныг хамгаалах" гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна; /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

8/"байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл" гэж /цаашид "нөхөрлөл" гэж/ нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож,

нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг; /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9/“байгаль орчны мэдээллийн сан” /цаашид “мэдээллийн сан” гэх/ гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдлийг; /Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/

10/“мета мэдээлэл” гэж мэдээний эх сурвалж, хариуцах этгээд, формат, масштаб, чанар, хамрах хүрээ, хугацаа, ашиглалт зэрэг өгөгдлийн талаархи мэдээллийн багцыг. /Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/

11/“байгаль орчинд учруулсан хохирол” гэж байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон, эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтээсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг; /Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/

12/“байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны байгаль орчинд учруулсан хохирол, түүнийг арилгах болон цаашид үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байгаль орчны экологи-эдийн засгийн үнэлгээ, аргачлалын дагуу тогтоосон мөнгөн илэрхийллийг; /Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/

13/“байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлөгч” гэж энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалтад заасан үйлдэл, эс үйлдэхүйг хийсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг. /Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/

14/“байгаль орчны аудит” гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг. /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан объект, тэдгээрийн баялгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг

1. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ:

1/гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

2/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах; /Энэ заалтад 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3/байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх; /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

4/холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах;

5/байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах; /Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

6/сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр

ашиглах, эзэмших. /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

2. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2/байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох;

3/байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх.

4/байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх. /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

5 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи төрийн чиг үүрэг, зарчим

1. Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь зарчим баримтална:

1/хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах байгаль орчны тааламжтай нөхцөл бүрдүүлэх;

2/экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж байгаль орчны тэнцлийг хангах;

3/байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохистой ашиглах нөхцөлийг хангах;

4/байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх.

5/байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах. /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

6 дугаар зүйл. Байгалийн баялгийг өмчлөх, байгаль орчныг хамгаалах /Энэ зүйлийн гарчигт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

1. Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг төрийн өмч мөн бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, эрхийн бичгээр ашиглахаас бусад тохиолдолд халдашгүй байна. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2. Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно.

3. Хууль, гэрээнд заасан журмын дагуу иргэн өмчийн болон эзэмшлийн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ургамал, ой мод, өсгөж үржүүлсэн амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар байгуулсан усан сан, нуур, цөөрмийг өмчилж болно. /Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

4. Байгалийн баялгийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бий болгосон эсэх талаар мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлт, орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тэдгээрт өмчлүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ. /Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

5. Засаг дарга энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалт, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс тухайн нутгийн байгаль орчинд онц их хэмжээний хохирол учирсныг эрх бүхий мэргэжлийн байгууллага хуульд заасан аргачлалаар албан ёсоор тогтоосон тохиолдолд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32.2-т заасан арга хэмжээ авна. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ хэсэгт 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

ХОЁРДУГААР БҮЛЭГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, АУДИТ

/Энэ бүлгийн гарцигт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

7 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээ

1. Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.

2. Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хүсч байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үнэлгээг өөрийн зардлаар хийлгэх буюу үнэлгээг урьд нь тогтоосон бол түүнийг гүйцэтгэсний зардлыг төлнө.

3. Байгаль орчны үнэлгээг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу эрх олгосон аж ахуйн нэгж, байгууллага хийж тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

4. Аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ олгоно. */Энэ хэсэгт 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

5. Дараахь шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ хийх эрх олгоно:

1/үнэлгээний багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь орон тооны мэргэжлийн боловсон хүчин байх; */Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

2/хэмжилт, судалгааны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

3/магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаас батлагдсан байгаль орчны үнэлгээ хийх арга зүйтэй байх; */Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

4/үнэлгээ хийх асуудлаархи мэдээллийн сантай байх.

6.*/Энэ хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

8 дугаар зүйл. Байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ

1. Байгалийн тодорхой төрлийн баялгийн хэмжээг тоо, чанар болон мөнгөн үзүүлэлтээр тодорхойлсныг байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ гэнэ.

2. Үнэлгээгээр байгалийн баялгийн нөөцийн хэмжээ, тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээх арга хэмжээг тогтоож, байгаль орчны улсын нэгдсэн мэдээллийн санд бүртгэнэ. */Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

3. Байгалийн баялгийн нөөцийн мөнгөн үнэлгээг экологи, эдийн засгийн ач холбогдлыг харгалзан төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагатай хамтран тогтооно.

4. Нөөцийн мөнгөн үнэлгээг тухайн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамж, байгальд учруулсан хортой нөлөөлөл, шууд хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох үндэс болгоно.

9 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

1.*/Энэ хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна. */Энэ хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

3. Нөлөөллийн үнэлгээний зардлыг захиалагч этгээд санхүүжүүлнэ.

4. Нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй. /Энэ хэсэгт 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

10 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээ

1. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээнд байгаль орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, илэрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ боловсруулах үйл ажиллагаа хамаарна.

2. Төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажлыг хэрэгжүүлэх зорилгоор байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээний сүлжээ /цаашид "хяналт-шинжилгээний сүлжээ" гэх/-г зохион байгуулж ажиллуулна.

3. Хяналт-шинжилгээний сүлжээгээр дараахь ажлыг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчинд гарах физик, хими, биологийн хувьсал өөрчлөлт, бохирдолтын түвшинд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа хийж байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг тогтоох, үнэлгээ өгөх;

2/байгаль орчин, түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах;

3/хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хортой нөлөө, байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах арга хэмжээний төсөл боловсруулах.

101 дүгээр зүйл. Байгаль орчны аудит

1. Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.

2. Байгаль орчны аудит хийх зардлыг төлөвлөгөөт хугацаанд хийж байгаа тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллага, төлөвлөгөөт бус хугацаанд Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд захиалагч тал хариуцна.

3. Байгаль орчны аудитын үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

4. Байгаль орчны аудит хийх аргачлал, эрх олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5. Төрийн аудитын байгууллагаас байгаль орчны санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй. /Энэ зүйлийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

11 дүгээр зүйл. Байгаль орчны судалгаа, шинжилгээ, түүний санхүүжилт

1. Улсын болон бүс нутгийн хөгжлийн баримжааг тодорхойлох, нэн ховордсон амьтан, ургамлыг нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх, хөрс, ус, агаарыг хамгаалах болон хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах талаархи судалгаа, шинжилгээний ажлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. /Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2. Төрийн захиргааны төв байгууллага, зохих шатны Засаг дарга нь эрдэм шинжилгээний болон холбогдох мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч зохих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн хөрөнгөөр судалгаа, шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлнэ. /Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

12 дугаар зүйл. /Энэ зүйлийг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

ГУРАВДУГААР БҮЛЭГ
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

13 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлогыг тодорхойлох;

2/Засгийн газрын өргөн мэдүүлснээр байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах;

3/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг батлах тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

4/байгалийн баялгийн нөөцийг ашигласны болон орчныг бохирдуулсны төлбөр, хураамжийн дээд, доод хэмжээг тогтоох;

5/устах аюулд орсон амьтан, ургамлын жагсаалтыг батлах, өөрчлөх, байгалийн зарим объектыг улсын тусгай хамгаалалтад авах;

6/хуульд заасан бусад бүрэн эрх.

14 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/байгалийн баялгийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох; */Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан өмчийнх нь хэлбэрийг үл харгалзан зогсоох;

4/амьтан, ургамал, түүнчлэн байгалийн гаралтай түүхий эд экспортлох, импортлоход хил, гааль, хорио цээрийн хяналтыг зохион байгуулах;

5/*Энэ заалтыг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

6/иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг зохион байгуулах;

7/хуульд заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; */Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

2/байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах; */Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

3/байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар салбар дундын болон бүс нутаг хоорондын удирдлага, бодлогын төлөвлөлт, зохицуулалтыг хариуцаж, байгаль орчны чадавхийн хэм хэмжээ, стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран баталж, биелэлтийг зохион байгуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ, хохирол тооцох аргачлалыг батлах; */Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

4/хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох; /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

5/байгаль орчныг хамгаалах талаар улсын захиалга өгч судалгаа, шинжилгээ, зураг төслийн ажил гүйцэтгүүлэх, өөрийн харьяа судалгаа, шинжилгээ, зураг төслийн болон мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг удирдах;

6/байгаль орчны тухай мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах биологийн болон генетикийн нөөцийг тогтвортой ашиглахад чиглэгдсэн уламжлалт мэдлэг, шинэ санаа, амьдралын туршлагыг хэрэглэснээр гарах үр ашгийг тэгш, шударгаар ашиглах явдлыг дэмжих; /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

7/байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад аргачилсан туслалцаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх; /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

8/байгаль орчныг хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

9/Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10/Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар хүчингүй болсонд тооцсон/

11/нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах; /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

12/энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан аргачлалыг батлах; /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

13/байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, экологийн боловсрол, хүмүүжил олгох ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх. /Энэ заалтыг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ заалтын дугаарт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

14/идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах журам боловсруулан батлах; /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ заалтын дугаарыг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчилсөн/ /Энэ заалтын дугаарт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

15/байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих; /Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ заалтын дугаарт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

16/хуульд заасан бусад бүрэн эрх. /Энэ заалтын дугаарыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хууль, 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчилсөн/ /Энэ заалтын дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2.Төрийн захиргааны бусад төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/салбарынхаа хөгжлийн чиг баримтлалд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг тухайлан тусгаж хэрэгжүүлэх;

2/салбартаа байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж үр дүнг жил бүр Засгийн газарт тайлагнах.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;

3/байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих;

4/хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох;

5/байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх.

6/шинээр томилогдсон Засаг даргад тухайн нутгийн байгалийн нөөцийн санг энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-6 дахь заалтад заасан үзүүлэлтээр бүртгэж хүлээлгэн өгөх бөгөөд түүний өөрчлөлтийн тайланг жил тутам хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч байна. */Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: */Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

3/байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх;

4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; */Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

5/нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах; */Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/*

6/аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх. */Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/*

7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх; */Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

8/нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах; */Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

9/тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх; */Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

10/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах. */Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

3. Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай

хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно. /Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ хэсгийг “З.Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль орчны мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.” гэж 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн хэмжээг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;

4/байгаль орчныг хамгаалах талаар Засаг даргын ажлын тайлан хэлэлцэх.

5/нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлд хариуцуулах асуудлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн шийдвэрлэх. /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

6/энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад заасан үнэлэлт, дүгнэлт өгч байх; /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг хянах. /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

2.Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: /Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох;

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгалийн баялгийн ашиглалтад хяналт тавьж, тэдний ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан, засаж тохижуулсан газар, уст цэгийг хүлээн авах;

4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; /Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

5/байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх; /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

6/аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах.

7/энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан шийдвэрийг үндэслэн иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих. /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

8/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах; /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

9/энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх; /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

10/нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах. /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

18 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх

1. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах;

2/нийтийн ашиглалтын байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;

3/байгаль орчныг хамгаалах талаархи Засаг даргын ажлын тайлан сонсох.

4/нөхөрлөл байгуулах талаар багийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэх. /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

2. Баг, хорооны Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах талаархи хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах;

3/хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

4/нутаг дэвсгэртээ орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах, нийтийн хог хаягдлын цэг тогтоох.

5/нөхөрлөлийг байгуулах болон түүний үйл ажиллагаатай холбогдсон саналыг иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж хэлэлцүүлэх. /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ АШИГЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭ

19 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэр

1. Монгол Улс санхүүгийн баталгаа бүхий "Байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-тэй байна.

2. Төр, түүний байгууллага, албан тушаалтан дараахь нийтлэг арга хэлбэрээр байгаль орчныг хамгаална:

1/нэн ховор амьтныг агнах, барих, ургамлыг бэлтгэж ашиглахыг хориглох;

2/нэн ховор, ховор амьтан, ургамлыг Монгол Улсын улаан номонд бүртгэж хамгаалах;

3/байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийн хэм хэмжээ, стандарт тогтоож мөрдүүлэх; /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

4/хүн амд экологийн боловсрол, хүмүүжил олгох, үндэсний өв уламжлалыг эзэмшүүлэх;

5/хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлэн ашиглахыг урамшуулах; /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

6/хот, тосгон, бусад суурин газрын орчинд болон гол, мөрөн, нуур, рашаан, булаг,

шандын эх, ундаргын орчныг хамгаалах, эрүүл ахуйн бүс тогтоох.

7/нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах. /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

21 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдохоос хамгаалах

1. Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлж үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал хаяхыг байгаль орчныг бохирдуулах гэнэ.

2. Бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн бүртгэлийг төрийн захиргааны төв байгууллага хөтөлнө.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар дараахь үүрэгтэй:

1/хортой, аюултай бодис болон хог хаягдлыг гагцхүү тусгайлан тогтоосон зориулалтын газар зөвшөөрөгдсөн аргаар булаах, устгах; /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2/хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях;

3/оршин суугаа /оршин байгаа/ орчноо болон нүүхдээ бууцаа цэвэрлэж, шаардлагатай бол ариутгаж байх;

4/хашаа, байрныхаа орчны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх.

4.Цацраг идэвхт болон химийн хортой, аюултай бодис, тэдгээрийг агуулсан нэгдлийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг хуулиар, үйлдвэрлэл, ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, боловсруулах, булаах, устгах журмыг Засгийн газар тус тус тогтооно. /Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

25 дугаар зүйл. Байгалийн баялгийг нөхөн сэргээх

1. Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчны тэнцлийг хангах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1/ховордсон амьтан, ургамлын ашиглалтыг хязгаарлах, тэдгээрийг үржүүлэх, нутагшуулах, тэжээлээр хангах зэргээр нөөцийг нь нэмэгдүүлэх;

2/байгалийн баялаг ашигласан газар, орчныг засаж сайжруулах, тохижуулах.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байдаггүй амьтныг үржүүлэх, нутагшуулах ургамлыг тарималжуулах, эгэл биетнийг өсгөвөрлөх ажлыг төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий бусад байгууллагын зөвшөөрөл, хяналтын дор гүйцэтгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ

26 дугаар зүйл. Байгаль орчны хяналт

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт орсон/

2. Хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн зэрэг хяналтын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болно. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт орсон/

3. Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, аймаг нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ болон байгаль хамгаалагч тус тус ажиллана. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

4. Улсын байцаагчийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө:

1/улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.4-т заасны дагуу олгоно. /Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөн найруулсан/ /Энэ заалтад 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2/Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар хүчингүй болсонд тооцсон/

3/Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар хүчингүй болсонд тооцсон/

4/байгаль хамгаалагчийг энэ хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан нормативын дагуу сум, дүүргийн улсын байцаагчийн саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга. /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

5. Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшиж дадлагажсан дээд боловсролын зэрэгтэй иргэнийг томилно. / Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ хэсэгт 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн мэргэжлийн сургалтанд хамрагдаж төгссөн иргэнийг байгаль хамгаалагчаар ажиллуулна. /Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

7. Нэг байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн хэмжээ нь өндөр уулын бүсэд 100.0, ойт хээрийн бүсэд 120.0, тал хээрийн бүсэд 500.0, цөлөрхөг хээрийн бүсэд 600.0, цөлийн бүсэд 800.0 мянга хүртэл га, улсын төсвийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ойн зурваст 30 км тутамд нэг байгаль хамгаалагч байх ба энэ нормативийг хот орчмын ногоон бүсэд 70 хувиар багасгаж тооцно. Тухайн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт, дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээг тухайн тусгай хамгаалалттай газрын ангилал, хамгаалах дэглэм, онцлог, ачаалал зэргийг харгалзан Засгийн газар тогтооно. /Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

8. Тухайн орон нутагт байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагчийг томилон ажиллуулж болно. /Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

27 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх, үүрэг

1. Улсын байцаагч дараахь эрхтэй байна:

1/иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;

2/хяналтад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулах;

3/ хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох; /Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

4/хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх;

5/байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх;

6/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах; /Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/

7/Зөрчлийн тухай хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах,

албадлагын арга хэмжээ авах; /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ /Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

8/байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар өгөх.

9/ноцтой зөрчил гаргах үед ашигласан тээврийн хэрэгслийг хураах. /Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/ /Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10/хууль тогтоомж, технологийн зөрчил гаргаж байгаль орчинд хохирол учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын лицензи, зөвшөөрөл, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; /Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

11/байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх. /Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/

2. Улсын байцаагч дараахь үүрэгтэй байна:

1/байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

2/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчлийн шинж байдал / зөрчил гаргагчийн нэр, хаяг, үйлдлийн шинж байдал, учруулсан хохирол, хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл/-ын тухай тэмдэглэл хөтлөн зөрчил гаргагчийн гарын үсэг зуруулах буюу зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбар тэмдэглэл хийх; /Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад захиргааны шийтгэл ногдуулах, тэдгээрийн хууль бус үйл ажиллагааг түдгэлзүүлэн зогсоохдоо түүний үндэслэл, шалтгааныг хууль тогтоомжийн зүйл, заалтын дагуу тодорхойлж, баталсан загвараар үйлдсэн акт буюу торгуулийн хуудаст тэмдэглэх; /Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

4/илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;

5/зөрчил гаргагчаас хуульд заасан үндэслэлээр хураан авсан зүйл, зэвсэг, хэрэгсэл, түр хураасан бичиг баримтын бүртгэлийг үйлдэж эзэнд нь үлдээж, зэвсэг, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж эрх бүхий байгууллагад хугацаанд нь шилжүүлэх. /Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

6/байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах. /Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

28 дугаар зүйл. Байгаль хамгаалагчийн эрх, үүрэг

1. Байгаль хамгаалагч дараахь эрхтэй байна:

1/нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 4, 5-д заасан улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэх;

2/нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7-д заасан улсын байцаагчийн эрхийг хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэгжүүлэх.

2. Байгаль хамгаалагч энэ хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь үүрэгтэй байна:

1/хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах;

2/хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих; /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

4/хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;

5/байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээ авах;

6/хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах.

7/хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. /Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

8/уул, ой модонд бүгсэн оргодол яллагдагч, ялтныг эрэн сурвалжилж байгаа цагдаагийн албанд газар орны онцлог, байгалийн тогтоц, байршлын талаар мэдээлэл өгөх, газарчлах, хамтран ажиллах. /Энэ заалтыг 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/ /Энэ заалтад 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

9/хариуцсан нутаг дэвсгэртээ орших гол, мөрөн, нуурт усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих. /Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/

3. Энэ хуулийн 26 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан шаардлага хангасан байгаль хамгаалагчид байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх олгох бөгөөд эрх олгох журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтарч батална. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

29 дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагч галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх

1. Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл биедээ авч явах эрхтэй.

2. Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хяналт, шалгалт хийх үедээ илэрсэн зөрчил, гадны халдлагыг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд хууль ёсны шаардлагыг нь илт эсэргүүцэн зэвсэг хэрэглэх буюу өөр аргаар хүч хэрэглэн амь насанд нь халдсан;

2/зэрлэг амьтан довтолж амь насанд аюул учруулахад хүрсэн.

3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцвэл резинэн болон цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, резинэн буюу хуванцар сумтай буу зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

4. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төрийн захиргааны төв байгууллага батална.

291 дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагчийн нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх баталгаа

1. Улсын байцаагч, байгаль хамгаалагч нь нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх дараахь баталгаагаар хангагдана:

1/ төрийн албанд 25 ба түүнээс дээш жил, түүнээс сүүлийн 10 жилийг нь байгаль хамгаалах албанд ажилласан байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч

нарыг тэтгэвэрт гарахад нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа байгууллагаас нь нэг удаа олгох; /Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ /Энэ заалтад 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2/ажил үүргээ гүйцэтгэх зориулалтаар унаа, дүрэмт хувцас, галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэлээр хангагдах.

2. Улсын байцаагч, байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын нөлөөгөөр хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт нь дараахь буцалтгүй тусламж, цалингийн зөрүүг олгоно:

1/хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлэгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг ;

2/хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг;

3/амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж;

4/энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндсэн цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг төсвөөс олгож, түүнтэй тэнцэх хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

5/хуульд заасан бусад баталгаа. /Энэ зүйлийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна. Нөхөн төлбөр төлөгч нь тогтоосон хэмжээнээс илүү төлбөр төлсөн тохиолдолд зөрүүг Байгаль орчин, уур амьсгалын сангаас буцаан олгоно. /Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Байгаль орчинд учруулсан хохирлыг дараах байдлаар ангилна:

1/ойн санд учруулсан хохирол;

2/амьтанд учруулсан хохирол;

3/ургамалд учруулсан хохирол;

4/усны нөөцөд учруулсан хохирол;

5/газарт учруулсан хохирол;

6/газрын хэвлийд учруулсан хохирол;

7/хөрсөнд учруулсан хохирол.

3. Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хохиролд байгаль орчны хяналтын улсын байцаагч нөхөн төлбөр ногдуулна.

4. Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-5 дахь заалтад заасан хохирлыг тухайн төрлийн байгалийн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн дор дурдсан хэмжээгээр тогтооно:

1/ойн санд учирсан хохирлыг ойн экологи-эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

2/амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

3/ургамлын аймагт учирсан хохирлыг тухайн ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

4/усны нөөцөд учирсан хохирлыг тухайн сав газрын усны экологи-эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

5/газарт учирсан хохирлыг тухайн ангиллын газрын экологи-эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр.

5. Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6, 7 дахь заалтад заасан хохирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тогтоосон хэмжээг үндэслэн дор дурдсан хэмжээгээр тогтооно:

1/газрын хэвлийд учирсан хохирлыг байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тооцсон хохирлын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

2/хөрсөнд учирсан хохирол, байгаль орчныг бохирдуулснаас үүсэх хохирлыг байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тооцсон хохирлын хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

6. Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1, 2 дахь заалтад заасан хохирлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх авсан мэргэжлийн байгууллагаар хөлсийг төлж тооцуулна.

7. Хохирол тооцсон ажлын зардлыг нөхөн төлбөрт нэмж тооцно.

8. Нөхөн төлбөрийг ногдуулсан байгаль орчны хяналтын улсын байцаагч ажлын 14 хоногт багтаан тухайн төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд уг хугацаанд барагдуулаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна.

56 дугаар зүйл. Экологийн боловсрол, хүмүүжил

/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

1. Засгийн газар албан болон албан бус боловсролын тогтолцооны хүрээнд иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил, байгаль орчныг хамгаалах арга, дадал олгох хөтөлбөрийг баталж биелэлтийг зохион байгуулна.

2. Экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

1/сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуульд байгаль орчныг хамгаалах анхны мэдлэг, хүмүүжил олгох;

2/коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагад мэргэжлийн чиг баримжааг харгалзан байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах шинжлэх ухааны үндэс, эрх зүйн мэдлэг олгох;

3/хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах.

57 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх

/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаагаараа байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана. /Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3. Гэм буруутай этгээд энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хохирлыг нөхөн төлсөн нь түүнд зохих хууль тогтоомжийн дагуу Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй. /Энэ хэсэгт 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

58 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. /Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

59 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н. БАГАБАНДИ

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ
/Шинэчилсэн найруулга/

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Амьтны тухай хууль тогтоомж

2.1. Амьтны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “амьтан” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад заасныг;

4.1.2. “тархац нутаг” гэж тухайн амьтны нутагладаг, нүүдэллэдэг, тэдгээрийн амьдрах тохиромжтой нөхцөл бүрдсэн газар нутгийг;

4.1.3. “нэн ховор амьтан” гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг;

4.1.4. “ховор амьтан” гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг;

4.1.5. “биотехникийн арга хэмжээ” гэж амьтны амьдрах болон идэш тэжээлийн нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг;

4.1.6. “сэргээн нутагшуулах” гэж хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор устах аюулд орсон, ховордсон амьтны зүйлийг урьд амьдарч байсан нутагт нь зориудаар зөөвөрлөн нутагшуулах үйл ажиллагааг;

4.1.7. “агнуурын амьтан” гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг;

4.1.8. “агнуурын нөөц” гэж хэвийн өсөлт, үржилтийг нь алдагдуулахгүй агнах, барих боломжтой агнуурын амьтны тоо, хэмжээг;

4.1.9. “агнуурын бүс нутаг” гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутгийг;

4.1.10. “агнуурын амьтны сүргийн бүтэц” гэж сүрэг дэх амьтдын нас, хүйсийн харьцааг;

4.1.11. “ан агнуурын менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг;

4.1.12. “амьтны нөөцийг хамгаалах” гэж амьтны сүргийн бүтцийн төлөв байдлыг доройтохоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр амьтны нөөцийг зүй зохистой ашиглах, гамшиг, аюулт үзэгдэл, халдварт

өвчин, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, амьтны идэш тэжээлийн төлөө тэмцэл, хорогдлын шалтгааныг олж тодорхойлох, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, сэргээн нутагшуулах, өсгөн үржүүлэх, тэдгээрт хяналт тавих цогц үйл ажиллагааг; /Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

4.1.13. “амьтныг өсгөн үржүүлэх” гэж амьтныг зохих журмын дагуу эзэмшилдээ авч, батлагдсан технологи, норм, нормативын дагуу тэжээврээр үржүүлэх замаар үр төлийг бойжуулан өсгөхийг;

4.1.14. “ангийн буу” гэж хийц, үзэмж, загвараараа байлдааны зэвсгээс ялгаатай, замагтай бууны хүхээнд нэг, дайзанд дөрвөөс илүүгүй, өөрөө цэнэглэгдэгч /хагас автомат/ бууны хүхээнд нэг, дайзанд таваас илүүгүй сумны багтаамжтай галт зэвсгийг;

4.1.15. “спорт агнуур” гэж анчин ан агнах, барих хэрэгцээгээ хангах зорилгоор ан амьтны эд, эрхтэнийг үзүүлэлтийн хувьд сонголт болгоггүй агнах, барихыг;

4.1.16. “олзворын ан” гэж амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтэнийг авах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барихыг;

4.1.17. “агнах, барихыг түр хориглосон ан амьтан” гэж хуулиар агнах, барихыг хориглоогүй ч тархац, нөөц, хэвийн өсөж үржих, амьдрах орчин нөхцөл нь хомсдсон, муудсан, доройтсоны улмаас энэ хуулийн 5.2, 5.3-т заасан эрх бүхий байгууллагаас агнах, барихыг нь тодорхой хугацаагаар хориглосон амьтныг;

4.1.18. “харь амьтан” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа амьтны зүйлийг;

4.1.19. “анчин” гэж аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон анчны үнэмлэхтэй иргэнийг;

4.1.20. “ангийн гаралтай түүхий эд” гэж амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос зэрэг эд эрхтэнийг;

4.1.21. “ан агнуур” гэж ангийн гаралтай түүхий эдийг ашиглах зорилгоор хуулиар заасан хугацаа, арга, хэрэгсэл, зөвшөөрлийн дагуу агнуурын амьтныг агнах, барих үйл ажиллагааг;

4.1.22. “агнуурын зохион байгуулалт” гэж агнуурын амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.23. “ангийн аж ахуй” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30.3-т заасны дагуу агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах үйл ажиллагааг ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу эрхэлдэг мэргэжлийн байгууллагыг;

4.1.24. “амьтны жам ёсны эрх” гэж амьтад идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтэй дасан ижилсэх, айдас цочрол, хомроглон устгагдахаас ангид байхыг;

4.1.25. “амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж тухайн зүйл амьтны амьдрах орчин болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон амьтны мөнгөн үнэлгээ.

5 дугаар зүйл. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар төрийн болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

5.1. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. амьтныг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

5.1.2. агнуурын нөөц ашигласны төлбөрийн дээд, доод хувь, хэмжээг тогтоох;

5.1.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.2. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.1. амьтныг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

5.2.2. агнуурын нөөцийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

5.2.3. амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгах;

5.2.4. энэ хуулийн 23.2-т заасан байгууллагын ажиллах журмыг батлах;

5.2.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.3. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.3.1. амьтныг хамгаалах, нутагшуулах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага зохицуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

5.3.2. агнуурын нөөц бүхий аймаг болон ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.3.3. амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг боловсруулж, Засгийн газраар батлуулах;

5.3.4. сүргийн бүтцийн төлөв байдал, тархац, нөөцийг харгалзан тухайн агнуурын бүс нутагт ан хийх, эсхүл зарим зүйл агнуурын амьтныг агнах, барихыг тодорхой хугацаагаар хориглох;

5.3.5. агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар технологи, норм, нормативыг батлах;

5.3.6. амьтны нөөцийн өөрчлөлтөд хяналт-шинжилгээ хийх, ан, амьтны мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах;

5.3.7. амьтан хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар батлах;

5.3.8. амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;

5.3.9. эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор энэ хуулийн 9.1,9.2, 9.4-9.7-д заасан хугацааг харгалзахгүйгээр амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох.

5.4. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.4.1. амьтныг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

5.4.2. амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгах;

5.4.3. амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилгоор тодорхой агнуурын бүс нутгийг орон нутгийн хамгаалалтад авах;

5.4.4. харьяалах нутаг дэвсгэртээ нэн ховор, ховор амьтныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг баталж, биелэлтэд нь хяналт тавих;

5.4.5. энэ хуулийн 6.1.1-д заасан шийдвэрийн дагуу харьяалах нутаг дэвсгэртээ ашиглалтын талаар хорио, хязгаарлалт тогтоох;

5.4.6. амьтны аймгийн хамгаалалт, ашиглалтын талаар Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх;

5.4.7. энэ хуулийн 22.3-т заасан агнуурын бүс нутгийг тогтоох;

5.4.8. амьтны нөөцийн талаарх мэдээ, тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

5.4.9. харьяалах нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх;

5.4.10. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.5. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.5.1. амьтныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, түүний хэрэгжилттэй

холбогдуулан гаргасан Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

5.5.2. энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.7-6.1.9, 6.1.11-д заасан арга хэмжээг нутаг дэвсгэртээ авч хэрэгжүүлэх;

5.5.3. амьтны мэдээллийн сангийн мэдээ баримтыг харьяалагдах сум, дүүргийн хэмжээгээр нэгтгэн бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

5.5.4. нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг байгаль орчны хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх;

5.5.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.6. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.6.1. харьяалах нутаг дэвсгэртээ амьтан хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө баталж, биелэлтэд нь хяналт тавих;

5.6.2. сум, дүүргийн Засаг даргын амьтан хамгаалах талаар авч хэрэгжүүлэх ажлын тайланг хэлэлцэх;

5.6.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.7. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.7.1. харьяалах нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээг байгаль орчны хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх;

5.7.2. амьтныг эзэмших, ашиглах зөвшөөрлийг энэ хуульд заасан журмын дагуу иргэн, хуулийн этгээдэд олгох;

5.7.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.8. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.8.1. батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх;

5.8.2. амьтан болон агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.8.3. энэ хуулийн 5.3.2-т заасан ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.8.4. харьяалах нутаг дэвсгэртээ ан амьтан болон агнуурын мэдээллийн сан бүрдүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг мэдээллээр хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АМЬТАН ХАМГААЛАХ

6 дугаар зүйл. Амьтныг хамгаалах хэлбэр

6.1. Амьтныг дор дурдсан хэлбэрээр хамгаална:

6.1.1. амьтныг ашиглахад хорио, хязгаарлалт тогтоох;

6.1.2. нэн ховор, ховор амьтныг олон улсын болон Монгол Улсын "Улаан ном", бусад холбогдох гэрээ, конвенцийн хавсралтад бүртгэх;

6.1.3. амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах;

6.1.4. амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах;

6.1.5. амьтны нөөц тогтоож, ашиглалтыг зохицуулах;

6.1.6. амьтныг сэргээн нутагшуулах;

6.1.7. үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;

6.1.8. биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

6.1.9. өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах; /Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.1.10. амьтныг хамгаалах арга хэмжээний үндэслэлийг гаргахад чиглэсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх;

6.1.11. иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах.

6.2. Энэ хуулийн 6.1.1-6.1.6, 6.1.10, 6.1.11-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага, 6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7-6.1.9-д заасан үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл. Нэн ховор, ховор амьтныг хамгаалах

7.1. Нэн ховор амьтанд Мазаалай баавгай /*Ursus arctos gobiensis*/, Хавтгай тэмээ /*Camelus bactrianus ferus*/, Тахь адуу /*Equus ferus przewalskii*/, Ойн буган цаа /*Rangifer tarandus*/, Цоохор ирвэс /*Uncia uncia*/, Баданга хүдэр /*Moshus moschiferus*/, Молцог хандгай /*Alces alces*/, Татаар бөхөн /*Saiga tatarica*/, Голын халиу /*Lutra lutra*/, Азийн минж /*Castor fiber*/, Ойн унтаахай /*Dryomys nitedula*/, Зүүн гарын даахай /*Stylodipus sungorus*/, Борцгор хотон /*Pelicanus crispus*/, Хургач бор /*Paradoxornis heudei*/, Цагаан тогоруу /*Grus leucogeranus*/, Хар мөрний хилим /*Acipenser schrenckii*/, Шаргал үхэрдэй /*Tinca tinca*/, Цөөвөр чоно /*Cuon alpinus*/, Шивэр молцог хандгай /*Alces alces pfizenmayeri*/, Дорнын молцог хандгай /*Alces alces camelooides*/, Соргог бөхөн /*Saiga tatarica*/, Монгол бөхөн /*Saiga borealis*/, Алтайн чацуулин /*Talpa altaica*/, Гозоорой зурам /*Citellus alashanicus*/, Сухайн чичүүл /*Meriones tamariscinus*/, Давжаа алагдаага /*Allactaga elater*/, Цагаантолгойт ямаансүүл /*Oxyura leucocephala*/, Могойч загалай /*Circaetus gallicus*/, Бор бүргэд /*Aguilla clanga*/, Усны нөмрөгбүргэд /*Aguilla clanga*/, Реликт цахлай /*Larus relictus*/ зэрэг амьтан хамаарна.

7.2. Нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно.

7.3. Энэ хуулийн 7.2-т зааснаас бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно.

7.4. Нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

7.5. Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр ховор амьтныг дараах тохиолдолд агнаж, барьж болно:

7.5.1. судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар;

7.5.2. Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн;

7.5.3. тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор.

7.6. Ховор амьтны жагсаалт, ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.

8 дугаар зүйл. Амьтныг сэргээн нутагшуулах

8.1. Мэргэжлийн байгууллага нь шинжлэх ухааны байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу амьтныг сэргээн нутагшуулах үйл ажиллагааг эрхэлж болно.

8.2. Мэргэжлийн байгууллага амьтан сэргээн нутагшуулах үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу явуулна.

9 дүгээр зүйл. Агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацаа

9.1. Агнуурын амьтныг дор дурдсан хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглоно:

9.1.1. бор гөрөөс, цагаан зээр, зэрлэг гахайг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.1.2. ойн булга, хадны суусар, элбэнх, шилүүс, нохой зээх, шар үнэг, хярс үнэг, бараан хэрэм, ойн солонго, усны булга, өмхий хүрэн, мануул мий, хотны үен, цагаан үен, чандага туулай, бор туулайг жил бүрийн 02 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл;

9.1.3. урт сүүлт зурам, тарвагыг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.1.4. заарт хархыг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл;

9.1.5. халздай доргыг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл.

9.2. Ахуйн болон тусгай зориулалтаар дор дурдсан хугацаанд шувуу агнах, загас барихыг хориглоно:

9.2.1. шивэр хөтүү, дагуур ятуу, эрээнхавирга хахилаг, говийн ногтруу, хар хур, эгэл сойрыг жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.2.2. галуу, нугас болон ус, намгийн бусад агнуурын шувууг жил бүрийн 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.2.3. дархадын цагаан загасыг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.2.4. Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;

9.2.5. омоль загасыг жил бүрийн 8 дугаар сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл;

9.2.6. зарам загасыг жил бүрийн 9 дүгээр сарын 05-ны өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл;

9.2.7. алтайн сугас загасыг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.2.8. энэ хуулийн 9.2.3-9.2.7-д зааснаас бусад загасыг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл.

9.3. Агнуурын шувуудын зүйлийн жагсаалтыг шинжлэх ухааны холбогдох байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага батална.

9.4. Тусгай зориулалтаар агнуурын ховор амьтныг агнах, барихыг хориглох хугацааг энэ хуулийн 9.7,9.8-д заасны дагуу тогтооно.

9.5. Судалгаа, шинжилгээ, халдварт өвчнийг эрүүлжүүлэх зорилгоор агнуурын амьтныг агнах, барих тохиолдолд энэ хуулийн 9.1, 9.2, 9.4-т заасан хугацааг харгалзахгүй байж болно.

9.6. Энэ хуулийн 9.1, 9.2, 9.4, 9.5-д зааснаас бусад агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацааг эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9.7. Энэ хуулийн 7.5-д заасан үндэслэлээр агнах ховор амьтныг дор дурдсан хугацаанд олзворын ангийн зориулалтаар агнахыг хориглоно:

9.7.1. угалзыг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл;

9.7.2. тэхийг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 14-ний өдөр хүртэл;

9.7.3. хар сүүлтийн зээрийн ооныг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.7.4. халиун бугыг жил бүрийн 9 дүгээр сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл.

9.8. Энэ хуулийн 7.5-д заасан үндэслэлээр барих ховор амьтныг дор дурдсан хугацаанд судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглоно:

9.8.1. аргаль хонь, янгир ямааг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.8.2. хар сүүлтийн зээрийг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 15-ны өдөр хүртэл;

9.8.3. халиун бугыг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.8.4. идлэг шонхор шувууг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.8.5. цармын бүргэдийг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;

9.8.6. тул загасыг жил бүрийн 10 дугаар сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл.

10 дугаар зүйл. Агнуурын амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл

10.1. Дор дурдсан арга, зэвсэг хэрэгслээр агнуурын амьтан агнах, барихыг хориглоно:

10.1.1. химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;

10.1.2. агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих;

10.1.3. туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих;

10.1.4. тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах;

10.1.5. агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх;

10.1.6. загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх;

10.1.7. ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх;

10.1.8. ан агнах зориулалтын бус буу, сумаар;

10.1.9. гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах.

11 дүгээр зүйл. Агнуурын амьтан агнах, барихтай холбогдсон зарим үйл ажиллагааг хориглох

11.1. Агнуурын амьтан агнах, барихтай холбогдсон дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

11.1.1. шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг агнах, барих; */Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

11.1.2. булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах;

11.1.3. өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих;

11.1.4. агнуурын амьтны үүр, ичээ ухах, гэмтээх;

11.1.5. агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах;

11.1.6. агнуурын амьтныг сайн танилгүй буюу анир чимээнээр таамаглаж буудах;

11.1.7. агнуурын амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах;

11.1.8. ангийн буу, агнуурын амьтан агнах, барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх;

11.1.9. тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах;

11.1.10. хот, тосгоны ногоон бүсэд судалгаа шинжилгээ, халдварт өвчний голомт эрүүлжүүлэх, ан амьтны тоо толгойг зохицуулахаас бусад зорилгоор агнуурын амьтан агнах, барих;

11.1.11. үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих бүх төрлийн торны нүдний хэмжээ 50x50 мм-ээс доош байх;

11.1.12. эрх бүхий мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалтын ажлыг хуульд заасан хугацаанд нь хийлгээгүй аймаг, нийслэл, сум, дүүргийн нутагт агнуурын амьтан агнах, барих;

11.1.13. агнахыг хориглосон ан амьтны ангийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авах.

12 дугаар зүйл. Амьтны гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглох

12.1. Энэ хуулийн 25.3-т заасан тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ АМЬТНЫГ ӨМЧЛӨХ, ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, АН АГНУУР

13 дугаар зүйл Амьтан өмчлөх

13.1. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол төлбөрийг бүрэн төлж ан агнах, барих эрхийн бичиг, гэрээ, тусгай зөвшөөрөлд заасан тоо хэмжээнд багтаан бэлтгэсэн ангийн түүхий эд нь бэлтгэгч этгээдийн өмч болно.

14 дүгээр зүйл. Амьтан эзэмших

14.1. Иргэн, хуулийн этгээд нэн ховроос бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах зорилгоор тодорхой нөхцөл, болзол бүхий гэрээний үндсэн дээр эзэмшүүлж болно.

14.2. Амьтан эзэмшүүлэх журмыг Засгийн газар тогтоож, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

15 дугаар зүйл. Амьтан ашиглах хэлбэр

15.1. Гэмтээлгүйгээр хууль болон гэрээнд заасны дагуу амьтны аль нэг ашигтай шинж чанарыг ашиглах үйл ажиллагааг амьтныг ашиглах гэнэ.

15.2. Амьтныг дор дурдсан хэлбэрээр ашиглаж болно:

15.2.1. эрдэм шинжилгээний ажил, соёл урлаг, гоо зүйн зориулалтаар ашиглах;

15.2.2. хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэг амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглах;

15.2.3. амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүнийг авах зорилгоор ашиглах.

15.3. Амьтныг ашиглах бусад хэлбэрийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

16 дугаар зүйл. Амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар ашиглах

16.1. Судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг ашиглахдаа түүнийг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулахгүйгээр гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл. Амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглах

17.1. Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэг амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэнэ.

17.2. Энэ хуулийн 16.1, 18.1-д заасан хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

18 дугаар зүйл. Амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүнийг авах зорилгоор амьтныг ашиглах

18.1. Амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүн /зөгийн бал, лав, бугын цусан эвэр, хүдрийн заар зэрэг/-ийг авах зорилгоор амьтныг ашиглахдаа эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тамлан зовоохгүй, тэдгээрийн амьдрах орчныг алдагдуулахгүйгээр гүйцэтгэнэ.

18.2. Ховор амьтныг тэжээврээр үржүүлж, эмийн болон бусад түүхий эд бэлтгэх зориулалтаар ашиглахыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

18.3. Амьтныг тэжээврээр үржүүлэхдээ ашиг шимийг дээшлүүлэхийн тулд үржил селекцийн ажил явуулж болно.

19 дүгээр зүйл. Амьтан ашиглах эрхийн зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл

19.1. Амьтан ашиглах эрхийн зөвшөөрлийг дор дурдсан тохиолдолд хүчингүй болгоно:

- 19.1.1. амьтан ашиглах шаардлагагүй болсон буюу түүнийг ашиглахаас татгалзсан;
- 19.1.2. амьтан ашиглах гэрээний хугацаа дууссан;
- 19.1.3. хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг төлөөгүй;
- 19.1.4. амьтан ашиглах эрх олгогдсон хуулийн этгээд татан буугдсан;
- 19.1.5. амьтныг хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомж, гэрээ зөрчсөн.

20 дугаар зүйл. Амьтны цуглуулга

20.1. Амьтны цуглуулгад эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн зорилгоор барьсан амьтан, тэдгээрийн чихмэл, арьс, үс, яс болон амьтны гаралтай бусад зүйлс хамаарна.

20.2. Иргэн, хуулийн этгээдэд ховор амьд амьтны цуглуулга хийх зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

20.3. Иргэн, хуулийн этгээдийн амьтны цуглуулгыг гадаадад гаргах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу олгоно.

21 дүгээр зүйл. Иргэн, нөхөрлөл, амьтан хамгаалах чиглэлийн мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах

21.1. Ан агнах зөвшөөрөл бүхий иргэн ан хийхдээ дараах шаардлагыг хангасан байна:

- 21.1.1. амьтан агнах, барих төлбөр, зөвшөөрлийн хураамж төлсөн байх;
- 21.1.2. энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан агнуурын амьтан агнах, барих хугацааг чанд мөрдөх;
- 21.1.3. ан амьтан агнах, барихдаа энэ хуулийн 10 дугаар зүйлээр хориглосон арга, зэвсэг хэрэгсэл хэрэглэхгүй байх;
- 21.1.4. агнах амьтан нь тухайн сум, дүүргийн агнуурын бүс нутгаас тухайн жилд агнахаар зөвшөөрөгдсөн амьтдын тоо хязгаарт багтаж байх;
- 21.1.5. ан хийх агнуурын бүс нутгаа сум, дүүргийн байгаль хамгаалагчаар заалгасан байх;
- 21.1.6. агнуурын ховор загасыг зөвхөн нэг салаа сэтгүүртэй, үзүүртээ сэртэнгүй дэгээг ашиглаж, хиймэл өгөөшөөр гэмтээлгүй барьж, усанд нь буцааж тавих.

21.2. Ан хийхдээ энэ хуулийн 21.1.1-21.1.6-д заасан шаардлагыг хангаагүй иргэний анчны үнэмлэхийг энэ хуулийн 24.2-т заасан журмын дагуу хурааж, хүчингүй болгоно.

21.3. Агнуурын нөөцийг хамгаалах талаар нөхөрлөл, хуулийн этгээд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.3.1. хариуцаж байгаа агнуурын бүс нутгийнхаа агнуурын нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу тогтвортой ашиглах, эзэмших;

21.3.2. агнуурын нөөцийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 50, 51 дүгээр зүйлд заасан журмыг мөрдөж ажиллах.

21.4. Агнуурын нөөцийг хамгаалах зорилго бүхий мэргэжлийн байгууллага агнуурын нөөцийг хамгаалах талаар бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.4.1. агнуурын нөөц, түүний тооллого бүртгэл, агнуур зохион байгуулалтын ажлыг улс, орон нутгийн болон иргэн, хуулийн этгээдийн захиалга, хөрөнгөөр гүйцэтгэх, тэдгээрийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах;

21.4.2. агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;

21.4.3. агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;

21.4.4. өөрийн гүйцэтгэсэн ажлын үнэн зөвийг хариуцаж, үйл ажиллагааныхаа талаар төрийн захиргааны төв байгууллагад бичгээр тайлагнах;

21.4.5. энэ хуулийн 35.4-т заасны дагуу агнуурын байршил нутагт халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх.

21.5. Амьтны нөөцийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага агнуурын нөөцийг хамгаалах талаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

21.5.1. амьтны тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагатай тохиолдолд асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

21.5.2. амьтны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаарх саналаа холбогдох төрийн байгууллага болон зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн болон иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргад уламжлах;

21.5.3. агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулахад нөхөрлөл, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх;

21.5.4. амьтныг хайрлах ёс зүй, зан заншил, үндэсний уламжлал, хууль тогтоомжийг сурталчлах.

21.6. Төрийн захиргааны төв байгууллага амьтныг хамгаалах талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу амьтны нөөцийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.

22 дугаар зүйл. Агнуурын амьтны сан, түүний байршил нутгийг эзэмших, ашиглах

22.1. Агнуурын амьтны сан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх унаган, нутагшсан буюу нүүдлийн агнуурын хөхтөн амьтан, шувуу, загаснаас бүрдэнэ.

22.2. Агнуурын амьтны байршил нутагт агнуурын амьтан амьдрах нөхцөл бүрдсэн газар, ой, ус хамаарна.

22.3. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь агнуурын амьтны тархац нутагт ан амьтныг агнах, барих агнуурын бүс нутгийг энэ хуулийн 5.3.2-т заасан ан агнуурын менежментийн төлөвлөгөөг үндэслэн тогтооно.

22.4. Агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, ангийн гаралтай түүхий эд бэлтгэх зорилгоор агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг гэрээний дагуу иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж болно.

22.5. Энэ хуулийн 22.4-т заасан гэрээг зохих бэлтгэл хангуулах зорилгоор эхний ээлжинд нэг жилийн хугацаагаар, цаашид арван жилийн давтамжтайгаар 30 хүртэл жилийн хугацаагаар байгуулж болно.

22.6. Энэ хуулийн 22.4-т заасан агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг эзэмшигч нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу эзэмшлийнхээ агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээ авна.

22.7. Иргэн өөрийн өмчийн болон эзэмшлийн, хуулийн этгээд эзэмшлийн газартаа энэ хуулийн 5.3.5-д заасан технологи, норм, нормативын дагуу агнуурын амьтныг тэжээврээр үржүүлж болно.

23 дугаар зүйл. Агнуур зохион байгуулалт, түүний санхүүжилт, амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох

23.1. Агнуур зохион байгуулалтын тайлан, дүгнэлт болон энэ хуулийн 5.3.2-т заасан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд агнуурын бүс нутгийн хэмжээ, хил хязгаарыг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тогтоож өгсөн байна.

23.2. Агнуур зохион байгуулалтыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

23.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ агнуур зохион байгуулалтыг таван жил тутамд хийлгэж, үйлдвэрлэлийн зориулалтаар агналт явуулсан тохиолдолд жил бүр тооллого хийнэ.

23.4. Агнуур зохион байгуулалтыг дараах байдлаар санхүүжүүлнэ:

23.4.1. агнуур зохион байгуулалтын ажлын зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу улсын төсөв, агнуурын нөөц ашигласны төлбөрөөс;

23.4.2. иргэн, хуулийн этгээд гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа агнуурын бүс нутагтаа хийлгэх агнуур зохион байгуулалтын ажлын зардлыг өөрийн хөрөнгөөр.

23.5. Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

24 дүгээр зүйл. Агнуурын амьтан агнах, барих эрх, зориулалт

24.1. Агнуурын амьтны амьдрал, биологи, агнуурын уламжлалт соёлын талаар мэдлэгтэй, ан агнах, барих арга зүй эзэмшсэн, түүнтэй холбогдсон шалгуурыг хангасан иргэнд анчны үнэмлэх олгоно.

24.2. Анчны үнэмлэх олгох, хураах, хүчингүй болгохтой холбогдсон журмыг хууль зүй, байгаль орчны болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.3. Агнуурын амьтныг дараах зориулалтаар агнаж, барина:

24.3.1. үйлдвэрлэлийн;

24.3.2. ахуйн;

24.3.3. тусгай.

25 дугаар зүйл. Агнуурын амьтан агнах, барих зөвшөөрөл

25.1. Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл тус тус авч, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад гэрээ байгуулна.

25.2. Агнуурын амьтан агнах, барих гэрээ, эрхийн бичиг, тусгай зөвшөөрлийн загварыг төрийн захиргааны төв байгууллага батална.

25.3. Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт /цаашид "тодорхойлолт" гэх/ олгоно.

25.4. Энэ хуулийн 25.3-т заасан тодорхойлолтын загвар, олгох журам, тодорхойлолт олгогдвол зохих ан амьтан, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг төрийн захиргааны төв байгууллага батална.

25.5. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 26.2-т заасан агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан харьяалах нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгож болно.

26 дугаар зүйл. Агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох

26.1. Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг, энэ хуулийн 5.3.2, 5.8.1-д заасан агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.

26.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 26.1-д заасан дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум, дүүрэг тус бүрээр тогтооно.

26.3. Тухайн жилд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

27 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих

27.1. Сумын Засаг дарга дараах болзол хангасан хуулийн этгээдтэй үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээ байгуулна:

27.1.1. сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр;

27.1.2. мэргэжлийн боловсон хүчин, анчидтай байх;

27.1.3. агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхтай байх.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасан үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээнд агнах, барих агнуурын амьтны нэр, тоо хэмжээ, агнах хугацаа, газар, бэлтгэх түүхий эдийн нэр төрөл, тоо, төлбөр, хураамжийн хэмжээг тусгана.

28 дугаар зүйл. Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих

28.1. Энэ хуулийн 21.1-д заасан иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болно.

28.2. Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих эрхийн бичигт иргэний овог, эцгийн нэр, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заана.

28.3. Ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих нэг удаагийн эрхийн бичгийг Монгол Улсын иргэнд дор дурдсан хугацаагаар олгоно:

28.3.1. шувуу, тарвага агнаж, загас барихад гурав хүртэл хоног;

28.3.2. энэ хуулийн 28.3.1-д зааснаас бусад агнуурын амьтан агнах, барихад тав хүртэл хоног.

28.4. Энэ хуулийн 28.3-т заасан иргэнд нэг удаагийн эрхийн бичгээр агнах, барихыг зөвшөөрөх агнуурын амьтны тоо хэмжээ нь туурайтан амьтан нэг, тарвага тав, бусад үслэг ан нэг, хөтүү, ятуу, ногтруу шувуу тус бүр арав, ой, хээр, ус, намгийн бусад агнуурын шувуу тав, бусад агнуурын загас арван ширхгээс илүүгүй байна.

28.5. Монгол Улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн Монгол Улсын иргэний адил хэмжээний төлбөр төлж, ахуйн зориулалтаар зөвхөн загас барьж болно.

29 дүгээр зүйл. Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих

29.1. Тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

29.2. Агнуурын амьтныг тусгай зориулалтаар агнах, барих тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна:

29.2.1. агнуурын амьтныг эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар;

29.2.2. иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр;

29.2.3. нутаг дэвсгэрт агнуурын амьтны сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор.

30 дугаар зүйл. Ангийн буу, сумны захиалга, зарцуулалт

30.1. Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тухайн жилд агнах агнуурын амьтны тоо, хэмжээний дээд хязгаарыг үндэслэн цагдаагийн төв байгууллага ангийн буу, сумны гадаад захиалга, хуваарилалтыг төлөвлөж хэрэгжүүлнэ.

30.2. Ангийн буу, сумыг захиалах, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага хянаж, зохион байгуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АМЬТНЫ МЭДЭЭЛЛИЙН САН, ТӨЛБӨР, САНХҮҮЖИЛТ

31 дүгээр зүйл. Амьтны мэдээллийн сан

31.1. Амьтны мэдээллийн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

- 31.1.1. амьтны тархац нутаг, нөөц, түүний үнэлгээ;
- 31.1.2. амьтны судалгааны тайлан, мэдээ баримт;
- 31.1.3. амьтны цуглуулга, лабораторид хадгалсан үр хөврөл;
- 31.1.4. амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах арга хэмжээний мэдээ;
- 31.1.5. агнуурын амьтны тархац, нягтаршлыг аймаг, нийслэлээр харуулсан зураг.

31.2. Амьтны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

32 дугаар зүйл. Амьтан ашигласны төлбөр, агнуурын амьтан агнах, барих төлбөр, хураамж

32.1. Иргэн, хуулийн этгээд амьтан ашиглах, агнуурын амьтан агнах, барихад төлбөр, хураамж төлнө.

32.2. Амьтан агнах, барих болон ашигласны төлбөр, хураамжийн хэмжээ, түүнийг төлөх, төлбөр, хураамжаас хөнгөлөх, чөлөөлөх журмыг хуулиар тогтооно.

33 дугаар зүйл. Амьтныг хамгаалах арга хэмжээний санхүүжилт

33.1. Амьтныг хамгаалах арга хэмжээг улс, орон нутгийн төсөв, иргэн, хуулийн этгээдийн дэмжлэг, олон улсын тусламж, хандивын хөрөнгөөс санхүүжүүлнэ.

33.2. Нэн ховор, ховор амьтны нөөц, тархцыг тогтоох, хамгаалах ажлын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

33.3. Нэн ховор амьтнаас бусад амьтныг хамгаалах арга хэмжээг дор дурдсан байдлаар санхүүжүүлнэ:

33.3.1. иргэн, хуулийн этгээдийн гэрээгээр ашиглаж, эзэмшиж байгаа нутгийн амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээг тухайн газар ашиглагч, эзэмшигчийн хөрөнгөөр;

33.3.2. амьтныг ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд тухайн амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээг өөрийн хөрөнгөөр.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

34 дүгээр зүйл. Амьтны жам ёсны эрхийг хүндэтгэж, энэрэнгүй хандах

34.1. Амьтныг өмчлөх, эзэмших, ашиглах, агнуур хийх үйл ажиллагааг явуулахдаа амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн энэрэнгүй ёсоор хандана.

34.2. Амьтныг агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоногдсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулна.

34.3. Амьтныг тэжээврээр үржүүлэхдээ ашиг шимийг нь нэмэгдүүлэх зорилгоор үржил селекцид оруулж, генийн өөрчлөлттэй болгосон тохиолдолд байгальд нь буцаан тавихыг хориглоно.

35 дугаар зүйл. Амьтны тоо толгойг зохицуулах

35.1. Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно.

35.2. Амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээг бусад амьтны зүйлд гэм хор учруулахгүй,

амьдрах орчин, хэвийн өсөлт, үржилтийг алдагдуулахгүйгээр хэрэгжүүлнэ.

35.3. Ховор амьтны тоо толгойг зохицуулах шаардлагаар сийрэгжүүлэх агналт явуулах зөвшөөрлийг эрдэм шинжилгээний байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага олгож, мэргэжлийн байгууллага хэрэгжүүлнэ.

35.4. Хүн, амьтны эрүүл мэндэд гоц аюултай тахал, галзуу, бусад халдварт өвчин тараадаг болон хэт олширч байгаль орчинд хөнөөл учруулдаг аюултай амьтны зүйлтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

36 дугаар зүйл. Амьтныг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах

36.1. Нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу Засгийн газар олгоно.

36.2. Энэ хуулийн 36.1-д заасан амьтнаас бусад амьтныг амьдаар нь, мөн амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.

36.3. Амьтныг гадаад улсаас оруулах журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.

36.4. Харь амьтныг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр нутагшуулах, өсгөж үржүүлэхийг хориглоно.

36.5. Харь амьтныг ашиглах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37 дугаар зүйл. Амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

37.1. Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

37.2. Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин өсгөж тогтооно.

37.3. Энэ хуулийн 25.3-т заасан тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан, гадаадад гаргахыг завдсан этгээдийг тухайн зүйл ан амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж, нөхөн төлбөр ногдуулна.

37.4. Ан амьтан агнах эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн, түүнчлэн зөвшөөрөлгүй ан амьтан агнасан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна.

38 дугаар зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах

38.1. Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

39 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

39.1. Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчиж зөвшөөрөл, гэрчилгээ олгосон нь гэмт хэргийн шинжгүй бол албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

39.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. */Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

1995 оны 4-р сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ой болон таримал ургамлаас бусад ургамал /цаашид "ургамал" гэх/-ыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж

1. Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. /Энэ зүйлийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

21 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/“байгалийн ургамал” гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамлыг;

2/“байгалийн ургамлын нөөц” гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг дахь нийт хэмжээг;

3/“байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа” гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор хийгдэж байгаа судалгааг;

4/“байгалийн ургамлыг тарималжуулах” гэж байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг хадгалах, түүхий эд болгон ашиглах зорилгоор тарьж ургуулах, үржүүлэх ажиллагааг;

5/“ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж тухайн зүйл ургамлын оршин амьдрах нөхцөл болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон нэгж жингийн мөнгөн үнэлгээг;

6/“харь ургамал” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа зүйл ургамлыг. /Энэ зүйлийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/

3 дугаар зүйл. Ургамлын сан, түүний ангилал

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетнээс ургамлын сан бүрдэнэ.

2. Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан дараахь байдлаар ангилна:

1/нэн ховор;

2/ховор;

3/элбэг.

3. Нэн ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон /энэ хуулийн хавсралтаар тогтоосон/ ургамал хамаарна.

4. Ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал хамаарна. Ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батална.

5. Энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаас бусад ургамлыг элбэг ургамалд тооцно. /Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

4 дүгээр зүйл. Ургамлыг хамгаалах үйл ажиллагааны удирдлага

Ургамлыг хамгаалах үйл ажиллагааны удирдлагыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

5 дугаар зүйл. Ургамлын нөөцийн мэдээллийн сан

1. Ургамлын нөөцийн мэдээллийн сан дараахь үзүүлэлтээс бүрдэнэ:

- 1/ургамлын тархац, нөөцийн хэмжээ, түүний үнэлгээ;
- 2/ургамлын хатаамал, бэлдмэл, үрийн цуглуулга;
- 3/ургамлын судалгааны тайлан, мэдээ баримт;
- 4/ургамлын хяналт-шинжилгээний ажиглалт, хэмжилтийн мэдээ баримт;
- 5/ургамал хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний мэдээ.

2. Ургамлын мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл. Ургамал ашигласны төлбөр

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн өмчийн газар дахь ургамлыг ашиглахдаа хууль тогтоомжид заасны дагуу төлбөр төлнө.

2. Ургамал ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх журмыг хуулиар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

7 дугаар зүйл. Ургамлыг хамгаалах

1. Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

2. Нэн ховор, унаган буюу үлдвэр ургамлын удмын санг хамгаалах зорилгоор ургамлыг тарималжуулах, нутагшуулах ажлыг төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3. Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, хими, биологийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох журмыг хуулиар тогтооно.

4. Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьжаас хамгаалахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид *төрийн захиргааны төв байгууллага* гэх/-ын зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно. /Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5. Нэн ховор ургамал бүхий газрыг тухайн ургамал хамгаалах, нөхөн сэргээхээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэхийг хориглоно.

6. Харь ургамлыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулахыг хориглоно. /Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/

7. Харь ургамлыг байгальд тарималжуулахад зориулалтын хязгаарлаж битүүмжилсэн талбайг ашиглана. /Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/

71 дүгээр зүйл. Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.

2. Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

3. Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ хийх

зардлыг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4. Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэж болох ургамлын төрөл, зүйлийн нэр, түүх дээд хязгаарыг төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно. */Энэ зүйлийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/*

8 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох газар

1. Байгаль орчны тэнцлийг хангах ач холбогдол бүхий дараахь газар нутагт ургамлыг нөөцийнх нь хэмжээг үл харгалзан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглоно:

- 1/хот, тосгон, бусад суурины ногоон бүс;
- 2/гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 километрийн доторхи газар;
- 3/нэн ховор амьтны байршил газар;
- 4/баянбүрд;
- 5/ургамлын бүрхэвч нь талхлагдсан газар;
- 6/элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар;
- 7/хөрсний элэгдлээс хамгаалах зурвас газар.

2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 6, 7-д заасан газар, түүний заагийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-4-т заасан газар мал бэлчээж болно.

9 дүгээр зүйл. Ургамлыг нөхөн сэргээх

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газраа зохих журмын дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлсний дараа сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ УРГАМЛЫГ АШИГЛАХ

10 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зориулалт

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглаж болно.

11 дүгээр зүйл. Ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нэн ховор, ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно. */Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

2. Судалгаа, шинжилгээ, ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор бусдад борлуулахыг хориглоно. */Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

12 дугаар зүйл. Ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах

Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно.

13 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага элбэг ургамлыг хүнсний, техникийн болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах зориулалтаар ашиглаж болно.

2. Эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага ховор болон элбэг ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болно.

3. Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга, ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага

олгоно. */Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

4. Ургамлын үндэс, үндэслэг иш, булцууны 50 ба түүнээс дээш хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тохиолдолд тухайн ургамлыг тарималжуулсан байна. */Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/*

14 дүгээр зүйл. Бэлчээр, хадлангийн ургамлыг мал тэжээх зориулалтаар ашиглах

1. Бэлчээрийн мал аж ахуйн эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суугаа / оршин байгаа/ сум, дүүргийн газар нутагт мал бэлчээх, хадлан авах зэргээр бэлчээр, хадлангийн газар дахь ургамлыг ашиглахдаа Газрын тухай хуулийн 52, 53 дугаар зүйлийг баримтална. */Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нэн ховор ургамлыг хамгаалах зорилгоор түүний ургадаг газар мал бэлчээх, хадлан авахыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн 2 хүртэл жилийн хугацаагаар хориглож болно. */Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

3. Ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах зорилгоор бэлчээр, хадлангийн газрыг хуваарьтай, даацад нь тохируулж ашиглуулах асуудлыг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга шийдвэрлэнэ.

15 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох журам

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг өөрийн зардлаар хийлгэж, тухайн ургамлын нөөцийн хэмжээг тогтоолгож, ашиглахыг хүсч буй ургамлын зүйлийн нэр, эрхтэн, ашиглах зориулалт, хэмжээ, хугацаа, нөхөн сэргээх арга хэмжээг тусгасан төсөл боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага буюу албан тушаалтанд өгнө.

2. Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох байгууллага буюу албан тушаалтан нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ургамал ашиглах тухай хүсэлтийг тухайн этгээдийн боловсруулсан төсөл, түүний талаархи мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хүсэлт хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

3. Ургамлыг ашиглах зөвшөөрлийг эрхийн бичгээр олгоно. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглоно.

4. Эрхийн бичигт ургамлыг түүж бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, ургамлын зүйлийн нэр, эрхтэн, түүж бэлтгэх хэмжээ, хугацаа, газрыг заана.

5. Тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч ургамал ашиглах эрхийн бичгийг үндэслэн ургамлыг түүж бэлтгэх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зааж өгнө.

16 дугаар зүйл. Ургамлыг түүж бэлтгэх журам, хэмжээ, хугацаа

1. Ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг түүж бэлтгэх журам, ашиглахыг зөвшөөрсөн хэмжээ, хугацааг баримтлан түүж бэлтгэнэ.

2. Ургамлыг түүж бэлтгэх журам, хэмжээ, хугацааг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

17 дугаар зүйл. Ургамлыг гадаад улсад гаргах, гадаадын иргэн түүж бэлтгэх

1. Ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2. Гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгалийн ургамлыг аливаа зориулалтаар түүж бэлтгэхийг хориглоно. */Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

3. Ургамлын олон наст үндэс, үндэслэг иш, булцууг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргахыг хориглоно. */Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/*

4. Нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйлийг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд гадаадад

гаргахыг хориглоно. /Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/

5. Судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах ургамлын хэмжээг Засгийн газар тогтооно. /Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/

18 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зорилгоор газар эзэмшүүлэх, ашиглуулах

1. Сум, дүүргийн Засаг дарга ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зорилгоор түүний тархац газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн тодорхой хугацаатайгаар Газрын тухай хуульд заасан журмын дагуу гэрээ байгуулан эзэмшүүлж, ашиглуулж болно.

2. Ургамал ашиглах зорилгоор түүний тархац газрыг эзэмшиж, ашиглах тухай гэрээнд Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зааснаас гадна дараахь зүйлийг тусгана: /Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

1/тухайн газарт ашиглах ургамлын нэр, ашиглах хэмжээ;

2/ургамлыг ашиглах нөхцөл, болзол;

3/гэрээ байгуулагч талуудын тухайн ургамлыг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон эрх, үүрэг, хариуцлага.

3. Ургамлыг ашиглах зорилгоор түүний тархац газрыг эзэмшигч, ашиглагч нь тухайн ургамлыг болон түүний ургах орчинг хамгаалах, нөхөн сэргээх үүрэг хүлээхээс гадна Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх, үүрэгтэй байна. /Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4. Ургамлыг нь ашиглахаас өөр зориулалтаар газрыг гэрээний дагуу эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил, ашиглалтын газар дахь ургамлыг зохих журмын дагуу зөвшөөрөл авч үйлдвэрлэлийн зориулалтаар бол төлбөртэйгээр, ахуйн зориулалтаар бол төлбөргүйгээр ашиглана.

19 дүгээр зүйл. Ургамал ашиглагчийн үүрэг

Ургамал ашиглагч нь дараахь үүрэгтэй байна:

1/ургамлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх;

2/ургамлыг түүж бэлтгэх, нөхөн сэргээх журмыг баримтлах;

3/журам, зөвшөөрөлд заасан хэмжээ, хугацаанд ургамлыг түүж бэлтгэх;

4/нэг наст ургамлыг түүний үр боловсросны дараа түүж бэлтгэх;

5/ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, нөөцийн хэмжээг өөрийн зардлаар тогтоолгон, ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх;

6/ургамлыг нь ашиглах зорилгоор газар эзэмших, ашиглах гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

20 дугаар зүйл. Мансууруулах бодис бүхий ургамал

1. Мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалтыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгож тэдгээрийг тусгай бүртгэлд бүртгэнэ. /Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3. Иргэн, түүнчлэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарихыг хориглоно.

21 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. */Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

22 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н. БАГАБАНДИ

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ХАВСРАЛТ
НЭН ХОВОР УРГАМЛЫН ЖАГСААЛТ
(Монгол, Латин нэрээр)

1. Ильиний аарниг	1. <i>Arnica Iljinii</i>
2. Сибирь агдаргана	2. <i>Zygadenus sibiricus</i>
3. Анхилуун агранз	3. <i>Blebersteinia odora</i>
4. Бавгаруртагчаахай	4. <i>Dictamnus dasycarpus</i>
5. Часулаан алтандусал	5. <i>Tofieldia coccinea</i>
6. Ганцэцэгт алтанзул	6. <i>Tulipa uniflora</i>
7. Цөлийнаргамжинцэцэг	7. <i>Cistanche deserticola</i>
8. Хонин арц	8. <i>Juniperus sabina</i>
9. Навчгүй багалуур	9. <i>Anabasis aphylla</i>
10. Ноосон шилбэт багалуур	10. <i>Anabasis eripoda</i>
11. Сайхны бамбай	11. <i>Valeriana saichanensis</i>
12. Вансэмбэрүү банздоо	12. <i>Saussurea involucrata</i>
13. Төвд баягзаваа	13. <i>Lancea tibetica</i>
14. Цагаанборолзгоно	14. <i>Dasiphora lactiflora</i>
15. Цавцагаан бөлбөө	15. <i>Nymphaea candida</i>
16. Регелийн будраа	16. <i>Iljinia Regelii</i>
17. Монгол буурцгана	17. <i>Chesneya mongolica</i>
18. Монгол бүрэлгэнэ	18. <i>Viburnum mongolicum</i>
19. Саржентийн бүрэлгэнэ	19. <i>Viburnum Sargentii</i>
20. Алтан бэрмэг	20. <i>Limonium aureum</i>
21. Шарбэрээмэг	21. <i>Arnebia guttata</i>
22. Манж гандигар	22. <i>Sambucus manshurica</i>
23. Цэдэнгийн гиш	23. <i>Vicia Tsydenii</i>
24. Ганцсудалт гишүүнэ	24. <i>Rheum uninerve</i>
25. Эгэл годил өвс	25. <i>Acorus calamus</i>
26. Уртнавчит далантовч	26. <i>Androsace longifolia</i>
27. Томнавчит дэгд	27. <i>Gentiana macrophylla</i>
28. Сэвсгэр дэгд	28. <i>Gentiana pulmonaria</i>
29. Бага жагмаа	29. <i>Typha minima</i>
30. Мавританы жамба	30. <i>Malva Mauritiana</i>
31. Соёны жамъянмядаг	31. <i>Trollius sajanense</i>
32. Муркрофтынжигд	32. <i>Elaeagnus Moorcroftii</i>
33. Сибирь жолоо	33. <i>Abies sibirica</i>
34. Зэгэл зогдоргоно	34. <i>Clematis glauca</i>
35. Өргөн зуншилцэцэг	35. <i>Majanthemum dilatatum</i>
36. Бяцханзууч	36. <i>Cardamine parviflora</i>
37. Банзрагчийн зүлгэлж	37. <i>Sertia Banzaragczii</i>
38. Морин зээргэнэ	38. <i>Ephedra equisetina</i>
39. Федченкогийн зээргэнэ	39. <i>Ephedra Fedtschenkoae</i>
40. Алтаргана илаархай	40. <i>Solidago dahurica</i>
41. Төв-азийн лавай	41. <i>Asterthamnus cnetrali-asiaticus</i>

42. Шаравтарлидэр	42. <i>Sophora flavescens</i>
43. Цайвардуумогойн идээ	43. <i>Sedum Pallescens</i>
44. Элсний мөнхцэцэг	44. <i>Helichrysum arenarium</i>
45. Монгол мөнххаргана	45. <i>Ammopiptanthus Mongolicus</i>
46. Намханмухарцагаан	46. <i>Polygonatum Humile</i>
47. Цөлийн мугваа	47. <i>Salvia deserta</i>
48. Алтангагнуур мүгээ	48. <i>Rhodiola Rosea</i>
49. Намгийн наангил	49. <i>Scheuchzeria Palustris</i>
50. Ахарэвэрт нил	50. <i>Viola Brachycera</i>
51. Хоснавчит нилгэнэ	51. <i>Plantanthera Bifolia</i>
52. Тансаг номилгоно	52. <i>Anenarrhena asphodeloides</i>
53. Пржевальскийн нүцгэнүүр	53. <i>Gymnocarpus Przewalskii</i>
54. Хар нэрс	54. <i>Vaccinium Myrtillus</i>
55. Өргөн ойм	55. <i>Dryopteris dilatata</i>
56. Навчтгүй оочгоно	56. <i>Epipogium ephyllum</i>
57. Шивүүр ортууз	57. <i>Oxytropis acanthacea</i>
58. Хэврэгнавчит ортууз	58. <i>Oxytropis fragilifolia</i>
59. Грубовын ортууз	59. <i>Oxytropis Grubovii</i>
60. Эгэлэмхий өвс	60. <i>Peganum harmala</i>
61. Их саадганцэцэг	61. <i>Cypripedium macranthum</i>
62. Шар саадганцэцэг	62. <i>Cypripedium calceolus</i>
63. Бяцхан саахууцэцэг	63. <i>Nuphar pumila</i>
64. Ганцнавчит салжир	64. <i>Gueldenstaedtia monophyla</i>
65. Буржгарсараана	65. <i>Lilium martagon</i>
66. Дагуур сараана	66. <i>Lilium pensylvanicum</i>
67. Кокандсарнай	67. <i>Rosa Kokanica</i>
68. Сийрэг сарнай	68. <i>Rosalaxa</i>
69. Томдохиурт сонгино	69. <i>Allium macrosternon</i>
70. Сармисан сонгино	70. <i>Allium obliquum</i>
71. Тагийн сөд	71. <i>Sanguisorba alpina</i>
72. Хөвдөг сумалж	72. <i>Sagittaria natans</i>
73. Ямаан сэрдэг	73. <i>Saxifraga hirculus</i>
74. Нүцгэн товьцэцэг	74. <i>Mitella nuda</i>
75. Оньт тонхуу	75. <i>Chrysanthemum sinuatum</i>
76. Говийн тост	76. <i>Brachanthemum gobicum</i>
77. Монголчуудын тост	77. <i>Brachanthemum Mongolorum</i>
78. Уулын гуйпланцар	78. <i>Phlomis oreophila</i>
79. Өргөн навчит тутаргана	79. <i>Zizania latifolia</i>
80. Болцуут түдэнхавх	80. <i>Calypso bulbosa</i>
81. Сибирь тэмээнхөх	81. <i>Vince toxicum sibiricum</i>
82. Алтантэрэлж	82. <i>Rhododendron aureum</i>
83. Адамсын тэрэлж	83. <i>Rhododendron Adamsii</i>
84. Дагуур тэрэлж	84. <i>Rhododendron Dahuricum</i>
85. Ледебүрийн тэрэлж	85. <i>Rhododendron Ledebourii</i>
86. Жижигнавчит тэрэлж	86. <i>Rhododendron Pravifolium</i>
87. Тэснавчит тэсмэг	87. <i>Sorbaria sorbifolia</i>

88. Ганболдын удвал	88. <i>Aquilegia Ganboldii</i>
89. Потанийнулаантулам	89. <i>Incarvillea Potaninii</i>
90. Элдэвнавчит улиас	90. <i>Populus diversifolia</i>
91. Төгрөгнавчит үстхиг	91. <i>Drosera rotundifolia</i>
92. Англи үстхиг	92. <i>Drosera anglica</i>
93. Залаархаг хавраг	93. <i>Ferula ferulaeodes</i>
94. Говийн харгана	94. <i>Carragana gobica</i>
95. Хойрго харгана	95. <i>Carragana brachypoda</i>
96. Төвдхаргана	96. <i>Carragana tibetica</i>
97. Газрын хар үс	97. <i>Nematonostoc flagelliforme</i>
98. Цагааннавчит хасзул	98. <i>Olgaea leucophylla</i>
99. Хулан хойрго	99. <i>Potatinia Mongolica</i>
100. Ганган хонгорзул	100. <i>Centaurea pulchella</i>
101. Мөгөөрсхэй хонгорцгоно	101. <i>Rhaponticum carthamoides</i>
102. Кейскегийн хонхорцог	102. <i>Convallaria Keiskei</i>
103. Сүүнорхоодой хонхоодой	103. <i>Codonopsis clematidea</i>
104. Мөнгөлөг хонхотхаргана	104. <i>Halimodendron halodendron</i>
105. Куцнецовын хорс	105. <i>Aconitum Kusnezoffi</i>
106. Потанинийн хотир	106. <i>Zygophyllum Potaninii</i>
107. Алтайн хувиланга	107. <i>Pedicularis altaica</i>
108. Шарилжжиннавчит хувилганга	108. <i>Pedicularis abrotanifolia</i>
109. Монгол хундгана	109. <i>Adonis mongolica</i>
110. Цагаан хүн хорс	110. <i>Physochlaina albiflora</i>
111. Жижиг цангис	111. <i>Oxycoccus microcarpus</i>
112. Дуулгавчинцахирам	112. <i>Orchis militaris</i>
113. Фуксийн цахирам	113. <i>Orchis Fuchsii</i>
114. Хөхөө цүнхрэг	114. <i>Neottianthe cucullata</i>
115. Камчатын цүнхүй	115. <i>Neottia camtschatea</i>
116. Цагаан цээнэ	116. <i>Paeonia lactiflora</i>
117. Тойруулгат чандганчих	117. <i>Paris verticillata</i>
118. Баруунхуурайн чихэр өвс	118. <i>Glycyrrhiza squamulosa</i>
119. Монгол чоногоно	119. <i>Jurinea Mongolica</i>
120. Гиений хаврын шар	120. <i>Gagea heensis</i>
121. Монгол шардалан	121. <i>Tugarinovia mongolica</i>
122. Чулуусагшарилж	122. <i>Artemisia lithophila</i>
123. Жанз шарилж	123. <i>Artemisia tomentella</i>
124. Алтаншар шарилж	124. <i>Artemisia xanthochroa</i>
125. Хүнсний шигмээ	125. <i>Aspicilia esculenta</i>
126. Сөөгөн шимэрс	126. <i>Hedysarum fruticosum</i>
127. Цэнгэлийн шимэрс	127. <i>Hedysarum sanilense</i>
128. Юлдэн шүүдэр ойм	128. <i>Botrychium lanceolatum</i>
129. Гурвалсаншүүрдэс	129. <i>Corrallorhiza trifida</i>
130. Балуун шивэрс	130. <i>Lycopodium clavatum</i>
131. Тагийн шивэрс	131. <i>Lycopodium alpinum</i>
132. Жижигнавчит яшил	132. <i>Rhamnus parvifolia</i>
133. Уссур яшил	133. <i>Rhamnus ussuriensis</i>

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

2007 оны 11-р сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хууль тогтоомж

2.1. Ургамал хамгааллын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “бэлчээр” гэдгийг Газрын тухай хуулийн 3.1.6-д зааснаар ойлгоно;

3.1.2. “таримал ургамал” гэж хүний үйл ажиллагааны оролцоотойгоор зориудаар тарьж ургуулсан ургамал, тэдгээрийн үр, суулгацыг;

3.1.3. “ургамал хамгаалал” гэж бэлчээрийн болон таримал ургамал /цаашид “ургамал” гэх/-ыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааг;

3.1.4. “ургамлын өвчин” гэж ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд өвчин үүсгэгч халдварлан түүний эд, эсийг гэмтээн цаашдын өсөлт, хөгжилт, ургацын чанарт сөргөөр нөлөөлөхийг;

3.1.5. “хөнөөлт шавж” гэж ургамлаар хооллож тархан, түүнд гэмтэл учруулж буй шавжийг;

3.1.6. “хөнөөлт мэрэгч амьтан” гэж ургамлаар хооллож тархан, түүнд гэмтэл учруулж буй мэрэгчийг;

3.1.7. “ургамлын эрүүл ахуйн үзлэг” гэж ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал, химийн бодисын үлдэгдэл зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа эсэхийг шалгахыг;

3.1.8. “ургамал хамгаалах бодис” гэж ургамалд хөнөөл учруулдаг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэхэд хэрэглэх химийн болон биологийн гаралтай бодисыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4 дүгээр зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагаа

4.1. Ургамал хамгааллын үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх, тэмцэх, хорио цээр тогтоох, түүнийг цуцлахтай холбоотой цогц арга хэмжээнээс бүрдэнэ.

4.2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэдэгт ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархаж хөнөөл учруулахаас өмнө түүнийг илрүүлэн мэдээлэх, тархалт, олшролтын шалтгаан, хэмжээ, хүрээг тогтоох, тархаж болзошгүй голомтыг халдваргүйжүүлэх үйл ажиллагаа хамаарна.

4.3. Тэмцэх арга хэмжээ гэдэгт ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлыг тархах, олшрохыг таслан зогсоох, голомтыг устгах, байгалийн тэнцвэрт хэмжээнд нь байлгах зэрэг үйл ажиллагаа хамаарна.

4.4. Хорио цээр тогтоох гэдэгт ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлыг Монгол Улсын нутаг дэвсгэрт тархаж эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор голомтод нь хязгаарлан зогсоох, устгах, ургамал хамгаалах бодисын сөрөг нөлөөллөөс хамгаалахад чиглэсэн арга хэмжээ хамаарна.

5 дугаар зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага

5.1. Ургамал хамгааллын үйл ажиллагааг төв, орон нутгийн, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллага хэрэгжүүлнэ.

5.2. Төв байгууллага нь бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ байна.

5.3. Орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний харъяа байгууллага байна.

5.4. Эрдэм шинжилгээний байгууллага нь ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, олшролт, хөнөөлийн талаар судалгаа, туршилт, зохион бүтээх ажил хийх, түүний үр дүнд үнэлэлт, дүгнэлт гаргах, ургамал хамгаалах арга технологи /цаашид “технологи” гэх/ боловсруулах, урьдчилан мэдээлэх үйл ажиллагааг эрхэлдэг байгууллага байна.

5.5. Мэргэжлийн байгууллага нь ургамал хамгааллын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байна. /Энэ хэсгийг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

ГУРАВДУГААР БҮЛЭГ

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1. Улсын Их Хурал ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. ургамал хамгааллын талаархи төрийн бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоох.

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

7.1. Засгийн газар ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. ургамал хамгааллын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

7.1.2. бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бүс нутгийн хэмжээнд ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;

7.1.3. гадаад орон, олон улсын холбогдох байгууллагатай ургамал хамгаалал, хорио цээрийн талаар хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах;

7.1.4. ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах.

8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1. Төрийн захиргааны төв байгууллага ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. ургамал хамгаалал, хорио цээрийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг зохион байгуулж хэрэгжүүлэх;

8.1.2. ургамал хамгааллын талаархи бодлого, төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, төсвийн төслийг боловсруулж батлуулах;

8.1.3. ургамал хамгааллын талаар мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

8.1.4. ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын жагсаалтыг батлах;

8.1.5. ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу мэргэжлийн байгууллагад олгох; */Энэ заалтад 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

8.1.6. ургамал хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

8.1.7. Монгол Улсад хэрэглэх ургамал хамгаалах химийн бодисоос бусад бодисыг турших, бүртгэх, түүнийг хэрэглэх журмыг батлах;

8.1.8. ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

8.1.9. бэлчээрийн ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтны тархалт, олшролтын тодотгох судалгааг салбарын эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгүүлж, дүгнэлт гаргуулах;

8.1.10. тариалангийн газрын ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын байдалд 3 жил тутам судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулах.

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

9.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, зардлын төслийг хэлэлцэж батлах, биелэлтэд хяналт тавих;

9.1.2. ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, олшролтын төлөв байдал, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрхэн зохион байгуулж байгаа тухай Засаг даргын тайланг хэлэлцэх.

10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. ургамал хамгааллын тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, технологийг мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

10.1.2. нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, зардлын төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;

10.1.3. ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, олшролт, хөнөөлийн тухай төрийн захиргааны төв байгууллагад жил бүр мэдээлэх;

10.1.4. ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;

10.1.5. ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархсан болон тархаж болзошгүй нутаг дэвсгэрийн тухай нийтэд зарлан мэдээлэх;

10.1.6. ургамлын хорио цээр тогтоосон үед тэмцэх арга хэмжээг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд иргэн, хуулийн этгээдийг дайчлан оролцуулах;

10.1.7. ургамал хамгааллын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах; */Энэ заалтад 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

10.1.8. бэлчээр, тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд ургамал хамгааллын талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах.

11 дүгээр зүйл. Эрдэм шинжилгээний байгууллагын бүрэн эрх

11.1. Эрдэм шинжилгээний байгууллага нь ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, зүйлийн бүрэлдэхүүнийг тогтоох, шинжлэх, олшролт, хөнөөлийн талаар судалгаа, туршилт, зохион бүтээх ажил хийх, түүний үр дүнд үнэлэлт, дүгнэлт гаргах;

11.1.2. ургамал хамгаалах бодисын хоруу чанар, түүний ургамал, ус, хөрсөн дэх үлдэцийг тодорхойлох;

11.1.3. ургамал хамгаалах бодисыг турших, тэдгээрийг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хэрэглэх талаар зөвлөмж боловсруулах;

11.1.4. ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах стандарт, технологи боловсруулах, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, иргэн, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.

12 дугаар зүйл. Ургамал хамгааллын талаархи мэргэжлийн байгууллагын бүрэн эрх

12.1. Мэргэжлийн байгууллага ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: *Энэ хэсэгт 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

12.1.1. ургамал хамгааллын үйл ажиллагааны талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж ажиллах;

12.1.2. ургамал хамгааллын үйл ажиллагаанд технологийг чанд мөрдөх;

12.1.3. ургамал хамгааллын үйл ажиллагааны үр дүн, гэрээний биелэлт, зарцуулсан бодисын талаар захиалагчид тайлагнах.

12.2. Ургамал хамгааллын үйл ажиллагааг зөвхөн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТАЛААРХИ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

13 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

13.1. Иргэн, хуулийн этгээд нь ургамал хамгааллын талаар дараахь эрхтэй:

13.1.1. төв, орон нутгийн, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаас ургамал хамгааллын тухай мэдээлэл авах;

13.1.2. ургамал хамгааллын үйл ажиллагааг гүйцэтгүүлэх мэргэжлийн байгууллагаас сонгох;

13.1.3. ургамал хамгааллын үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа мэргэжлийн байгууллагаас уг үйл ажиллагаатай холбоотойгоор гаргасан дүгнэлт, арга хэмжээний талаар тайлбар шаардах, гомдол гаргах.

13.2. Иргэн, хуулийн этгээд ургамал хамгааллын талаар дараахь үүрэгтэй:

13.2.1. ашиглаж, эзэмшиж байгаа болон өмчийн газарт нь ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл өөр газарт тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авах, тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх;

13.2.2. ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авах.

13.3. Иргэн, хуулийн этгээд ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд зааснаар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭР ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

14 дүгээр зүйл. Ургамлын хорио цээр тогтоох

14.1. Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтооно.

14.2. Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал хэд, хэдэн аймгийн бэлчээр, тариалангийн талбайд илэрвэл бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар хорио цээр тогтооно. */Энэ хэсгийг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

14.3. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарахад тавигдах шаардлага, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх нөхцөл, аргыг энэ хуулийн 7.1.4-т заасан журмаар зохицуулна.

14.4. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

14.4.1. ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гаргах, дамжин өнгөрүүлэх;

14.4.2. ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг бэлтгэх;

14.4.3. халдвартай үр, суулгацыг борлуулах, шилжүүлэх, тариалах;

14.4.4. хөнөөлийн голомттой байр, агуулах, хашаа, талбайг ариутгал, халдваргүйжүүлэлт хийхгүйгээр ашиглах.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ

15 дугаар зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт

15.1. Ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2, 10.1-д заасан мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага хэрэгжүүлнэ.

15.2. Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь ургамал хамгааллын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-т заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: */Энэ хэсэгт 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

15.2.1. ургамал хамгааллын үйл ажиллагааны талаархи стандарт, технологийн шаардлагыг хянаж, хэрэгжилтийг хангуулах;

15.2.2. ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах явцад ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх;

15.2.3. ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан илэрвэл нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хориглох, шаардлагатай үед устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ авах;

15.2.4. таримал ургамлын үр, суулгац, ургамал хамгаалах бодисыг үйлдвэрлэх, импортлох, хадгалах, тээвэрлэх, борлуулах, хэрэглэх явцад хяналт тавих.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

16 дугаар зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагааны санхүүжилт

16.1. Ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс болон иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлнэ.

16.2. Ургамал хамгааллын үйл ажиллагааны дараахь зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

16.2.1. энэ хуулийн 8.1.9, 8.1.10-т заасан судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулахад шаардагдах зардал;

16.2.2. бэлчээрийн ургамалд ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан тархаж, хөнөөл учруулах үед түүнтэй тэмцэх зардал;

16.2.3. ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархаж, хөнөөл учруулж болзошгүй үед түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зардал.

16.3. Тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд нь ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

17 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

17.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. */Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

2001 оны 2 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж

2.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдож олгох зөвшөөрлийг Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Ойн тухай, Усны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай, Хувиргасан амьд организмын тухай хуулиар тус тус зохицуулна. /Энэ хэсэгт 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хууль, 2007 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хууль, 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/- гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг;

3.1.2. “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

4 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн агуулга

4.1. Тусгай зөвшөөрөлд дор дурдсан зүйлийг тусгана:

4.1.1. тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

4.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг;

4.1.3. эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл;

4.1.4. тусгай зөвшөөрлийн хугацаа;

4.1.5. тусгай зөвшөөрлөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;

4.1.6. тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон он, сар, өдөр;

4.1.7. тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга /тэмдэг/.

5 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээ

5.1. Тусгай зөвшөөрөл шаардах аж ахуйн үйл ажиллагааг хэрэв тусгайлан заасан бол тухайн нутаг дэвсгэрт явуулна.

5.2. Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно. */Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

5.3. Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

5.4. Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ. */Энэ хэсгийг 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн/*

6 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

6.1. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

6.2. Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.

6.3. Хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана.

6.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох журам

7.1. Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно.

7.2. Хуульд заасан бол хүнсний чиглэлийн үйл ажиллагааг зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ. */Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

7.3. Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.

7.4. Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож болно.

8 дугаар зүйл. Хориглох аж ахуйн үйл ажиллагаа

8.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

8.1.1. хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах; */Энэ заалтад 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

8.1.2. садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих;

8.1.3. казиногийн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4. олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа.

8.2. Энэ хуулийн 8.1.3 дахь заалт нь чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжид хамаарахгүй / Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шаардлага

9.1. Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохдоо дараахь зарчмыг баримтална:

9.1.1. улс орныг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

- 9.1.2. аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх;
- 9.1.3. ил тод, шуурхай байх;
- 9.1.4. зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох.

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох байгууллагын эрх

- 10.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь дараахь эрхтэй:
 - 10.1.1. хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох;
 - 10.1.2. тусгай зөвшөөрлийг бүртгэх;
 - 10.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;
 - 10.1.4. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх;
 - 10.1.5. тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

- 11.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:
 - 11.1.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/;
 - 11.1.2. тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;
 - 11.1.3. тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар; /Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/
 - 11.1.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
 - 11.1.5. тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;
 - 11.1.6. үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх; /Энэ заалтыг 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/
 - 11.1.7. энэ хуулийн 15.5.7; 15.5.8; 15.6.1-15.6.3; 15.6.5; 15.8.3; 15.8.8; 15.8.18; 15.8.20; 15.10.4-15.10.6; 15.10.14; 15.11.1; 15.11.2; 15.12.1-15.12.6-д заасан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг авсан байна. /Энэ заалтад 2005 оны 7 дугаар 1-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан, энэ заалтын дугаарыг 2017 оны 2 дугаар 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/
 - 11.1.8. энэ хуулийн 15.11.4-т заасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд улсын болон бүс, нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах тохиолдолд хяналтын төв албаны, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах тохиолдолд аймаг, нийслэлийн хяналтын албаны дүгнэлт авсан байна. /Энэ заалтыг 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн./

11.2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардаж болохгүй.

11.3. Энэ хуулийн 15.10.5, 15.10.6-д заасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход аймаг, нийслэлийн Засаг дарга саналаа 30 хоногийн дотор Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлээгүй бол зөвшөөрсөн гэж үзнэ. /Энэ хэсгийг 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

11.4. Энэ хуулийн 11.1.6-д заасан дүрс бичлэгийн техник, хэрэгслийн стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөл батална. /Энэ хэсгийг 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

12.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

12.2. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.

12.3. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

12.4. Магадлан шинжилгээ хийлгэх тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно.

12.5. Энэ хуулийн 15.10.17-д заасан тусгай зөвшөөрлийг холбогдох мэргэжлийн холбооны гишүүн хуулийн этгээдэд олгоно. */Энэ хэсгийг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/*

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

13.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

13.2. Тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

13.3. Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уул зөвшөөрлийг сэргээнэ.

14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

14.1. Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь дараахь тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

14.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

14.1.2. хуулийн этгээд татан буугдсан;

14.1.3. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

14.1.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн; /*Энэ заалтад 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

14.1.5. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

14.1.6. стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тогтоомжийг зөрчсөн. */Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн, 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

14.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл

15.1. Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.

15.6. Байгаль орчны чиглэлээр:

15.6.1. озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах;

15.6.2. тэсэрч, дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх; /*Энэ заалтад 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

15.6.3. тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах; /*Энэ заалтад 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хууль, 2008 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт, 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

15.6.4. /*Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

15.6.5. стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах;
15.6.6. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх;
15.6.7. байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх. /Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн/

15.11. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

15.11.1. тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх;

15.11.2. сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архианаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх;

15.11.3. таримал ургамлын үр үйлдвэрлэх;

15.11.4. малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох;

15.11.5. /Энэ заалтыг 2011 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.11.6. ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах;

15.11.7. шинээр малын үүлдэр, омог бий болгох, үр, өндгөн эс, хөврөлийг үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх, бичил биетнийг өсгөвөрлөх, мал, үржүүлгийн бүтээгдэхүүн гадаадад гаргах, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах; /Энэ заалтыг 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

15.12. Эрүүл мэндийн чиглэлээр:

15.12.1. /Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.12.2. хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох; /Энэ заалтад 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

15.12.3. эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх;

15.12.4. мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн угтвар бодис болон эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, импортлох, экспортлох; /Энэ заалтад 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хууль, 2011 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт оруулсан/

15.12.5. /Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.12.6. өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх;

15.12.7. /Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.12.8. ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх; /Энэ заалтыг 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/

15.12.9. биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх; /Энэ заалтыг 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/

15.12.10. /Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.12.11. улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах. /Энэ заалтыг 2011 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/

16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл

/Энэ зүйлийн гарчигт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт оруулсан/

16.1. Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд мэргэжлийн хяналтын байгууллага тусгай зөвшөөрөл олгоно: /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт оруулсан/

16.1.1. */Энэ хэсгийг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

16.2. Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:

16.2.1. */Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

16.2.2. эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

16.2.3. */Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

16.2.4. ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах; */Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

16.2.5. согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;

16.2.6. эмчилгээний гоо заслын үйлчилгээ; */Энэ заалтыг 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/*

16.2.7. түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах. */Энэ заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/*

16.3. Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд сум, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:

16.3.1. агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах;

16.3.2. */Энэ заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

16.3.3. */Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

16.3.4. тамхи худалдах. */Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/*

16.4. Чөлөөт бүсийн захирагч нь энэ хуулийн 16.2.2, 16.2.5, 16.2.6, 16.3.4-т заасан тусгай зөвшөөрлийг олгоно. */Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 12-ний өдрийн хуулиар нэмсэн/*

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон маргааныг шийдвэрлэх

17.1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

18 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1. Энэ хуулийн 6.3, 11.2, 12.1, 12.4, 13.2, 14.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

18.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. */Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

19.1. Энэ хуулийг 2002 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. */Энэ хэсгийг 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

2002 оны 11-р сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенци /цаашид “Конвенци” гэх/-ийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж

2.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж нь Амьтны аймгийн тухай, Байгалийн ургамлын тухай, Ан агнуурын тухай, Гаалийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь зөвхөн дэлхийд ховордсон Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд, түүгээр хийсэн бүтээгдэхүүн /цаашид “эд зүйл” гэх/-ийг олон улсад худалдаалах хүрээнд үйлчилнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ Конвенцийг хэрэгжүүлэх байгууллага

4 дүгээр зүйл. Конвенцийг хэрэгжүүлэх байгууллага

4.1. Конвенцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, орон тооны бус Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд тус тус ажиллана.

4.2. Удирдан зохицуулах болон Шинжлэх ухааны зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх, зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.3. Удирдан зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн нь байгаль орчин, үйлдвэр, худалдаа, хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, гааль, мэргэжлийн хяналт хариуцсан төрийн захиргааны байгууллага, байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагын төлөөлөлтэй байна.

5 дугаар зүйл. Удирдан зохицуулах зөвлөл

5.1. Удирдан зохицуулах зөвлөл дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Монгол Улсад Конвенцийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. Конвенцийн хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх, нэмэлт тайлбар хийх тухай асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5.1.3. Конвенцийн хавсралтад шинээр нэмэлт, өөрчлөлт оруулах санал, Талуудын бага хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл боловсруулж Засгийн газарт уламжлах;

5.1.4. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлоход гаалийн хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг хүчингүй болгох;

5.1.5. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг реэкспортлох болон далай тэнгисээс олборлон оруулах, Конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлоход гэрчилгээ олгох;

5.1.6. энэ хуулийн 6.1-д заасан дүгнэлт, тодорхойлолтыг гаргуулахаар Шинжлэх ухааны зөвлөлд уламжлах;

5.1.7. Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тайланг жил бүр Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх;

5.1.8. холбогдох хууль тогтоомжийн дагуу хураан авсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг борлуулах, устгах, байгальд нь эргүүлэн тавих ажлыг зохион байгуулах;

5.1.9. энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар бусад байгууллагуудтай хамтран ажиллах.

5.1.10. Конвенцийн 3 дугаар хавсралтад оруулах амьтан, ургамлын зүйлийн жагсаалтыг Шинжлэх ухааны зөвлөлтэй хамтран боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах. */Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/*

6 дугаар зүйл. Шинжлэх ухааны зөвлөл

6.1. Шинжлэх ухааны зөвлөл нь дор дурдсан дүгнэлт, тодорхойлолт гаргах үүрэгтэй:

6.1.1. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, далай тэнгисээс олборлон оруулахад тухайн амьтан, ургамал оршин тогтноход хор хохирол учрах эсэх талаарх дүгнэлт;

6.1.2. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтныг импортлож буй этгээд тухайн амьтныг арчилж маллах зохих нөхцөл бүрдүүлснийг нотолсон тодорхойлолт;

6.1.3. Конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан, Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтныг гаршуулж тэжээсэн, ургамлыг тарьж ургуулсан, тэдгээрийн гаралтай эд зүйл болохыг нотолсон дүгнэлт;

6.1.4. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн олон улсын худалдаа хийхэд байгаль орчинд хор хохирол учрах эсэх талаархи дүгнэлт.

6.2. Шинжлэх ухааны зөвлөл нь дор дурдсан асуудлаар Удирдан зохицуулах зөвлөлд зөвлөмж өгнө:

6.2.1. Конвенцийн 2, 3 дугаар хавсралтад орсон амьтан, ургамлын тоо хэмжээг харгалзан экспортыг хязгаарлах шаардлагатай эсэх талаар; */Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

6.2.2. Конвенцийн 2, 3 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн талаар. */Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

6.3. Энэ хуулийн 6.2-д заасан зөвлөмжийг Удирдан зохицуулах зөвлөл хүлээн аваагүй тохиолдолд Шинжлэх ухааны зөвлөл уг зөвлөмжийг хүлээн авах шаардлагатай гэж үзвэл байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжлан шийдвэрлүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД
ХУДАЛДААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

7 дугаар зүйл. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдаа

7.1. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг ашиг олох зорилгоор худалдаалахыг хориглоно.

7.2. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвхөн судалгаа, шинжилгээ хийх, музей, амьтны хүрээлэнд байршуулах, циркэд тоглуулах зориулалтаар олон улсад худалдаалж болно.

7.3. Конвенцийн 2, 3 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг ашиг олох зорилгоор худалдаалж болно. */Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

7.4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалахад тухайн амьтан, ургамлын оршин тогтнох байдалд аюул занал учруулахгүй, цаашид харшлахаар ашиглалт явуулахгүй байлгах нөхцөлийг хангах зорилгоор тусгай журмын дагуу явуулна.

7.5. Энэ хуулийн 7.4-т заасан журмыг байгаль орчны болон гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

7.6. Энэ хуулийг зөрчиж Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалахыг хориглоно.

8 дугаар зүйл. Зөвшөөрөл, гэрчилгээ

8.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, реэкспортлох буюу далай тэнгисээс олборлон оруулах гэрчилгээ авах хүсэлтээ Удирдан зохицуулах зөвлөлд гаргана.

8.2. Удирдан зохицуулах зөвлөл уг хүсэлтийг хүлээн авч зөвшөөрөл, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ.

8.3. Зөвшөөрөл, гэрчилгээ олгох журам болон загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. */Энэ хэсгийг 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

8.4. Зөвшөөрөл, гэрчилгээ нь олгогдсон өдрөөс хойш 6 сарын дотор хүчинтэй байна.

8.5. Зөвшөөрөл, гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

9 дүгээр зүйл. Зөвшөөрөл, гэрчилгээ олгох, олгохоос татгалзах

9.1. Удирдан зохицуулах зөвлөл нь дараахь нөхцөлийг харгалзан зөвшөөрөл, гэрчилгээ олгоно:

9.1.1. энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан дүгнэлт, тодорхойлолтыг авсан эсэх;

9.1.2. Конвенцийн 1, 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох зөвшөөрөл олгохдоо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 6.1.4-т заасан дүгнэлт авсан эсэх;

9.1.3. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хууль тогтоомжид заасны дагуу олж авсан тухай нутгийн захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтны тодорхойлолт;

9.1.4. реэкспортлох гэж буй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг энэ хууль болон зохих зөвшөөрлийн дагуу импортлосон эсэх;

9.1.5. амьтан, ургамлын тээвэрлэлт нь зохих журмын дагуу хийгдсэн болон шаардагдах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх;

9.1.6. Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох зөвшөөрөл олгохдоо импортлогч улсын эрх бүхий байгууллагаас импортын зөвшөөрөл урьдчилан авсан эсэх;

9.1.7. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олж авахдаа Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийн тухай, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд заасан төлбөр, хураамж тушаасан баримт бичиг.

9.2. Удирдан зохицуулах зөвлөл дараахь үндэслэлээр зөвшөөрөл, гэрчилгээ олгохоос татгалзана:

9.2.1. энэ зүйлийн 9.1-д заасан нөхцлүүдийг хангаагүй;

9.2.2. хуурамч баримт бичиг ашигласан нь тогтоогдвол.

9.3. Бусдад шилжүүлсэн, хүчинтэй байх хугацаа дууссан, зөвшөөрөл, гэрчилгээг хүчингүйд тооцно.

10 дугаар зүйл. Хөнгөлөлт

10.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамлыг гаршуулан тэжээсэн, тарьж ургуулсан бол тэдгээрийг Конвенцийн 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамалд хамааруулан үзэж олон улсад худалдаалах зөвшөөрөл, гэрчилгээг энэ хуульд заасан журмын дагуу олгоно.

10.2. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлд хамаарах хувийн хэрэглээний зүйлээ импортлох, эсхүл импорлогч орны зөвшөөрөл шаардагдахаас бусад тохиолдолд экспортлохдоо зөвшөөрөл авахгүй.

10.3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлд хамаарах хувийн хэрэглээний эд зүйлийн жагсаалтыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

10.4. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг дамжуулан өнгөрүүлэхэд аливаа зөвшөөрөл авахгүй.

10.5. Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэлтэй эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд ашиг олох зорилгогүйгээр түр ашиглах, бэлэглэх, хандивлах, солилцох, музейд хадгалуулах зориулалтаар Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвшөөрөлгүй импортлоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

11 дүгээр зүйл. Зөвшөөрөгдсөн боомт

11.1. Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг Монгол улсын хилээр нэвтрүүлэх боомтыг Удирдан зохицуулах зөвлөлийн саналыг үндэслэн гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

12 дугаар зүйл. Конвенци, түүний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах

12.1. Удирдан зохицуулах зөвлөл Конвенци, түүний хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх, нэмэлт тайлбар хийх тухай саналаа боловсруулж 14 хоногийн дотор Засгийн газарт уламжлана.

12.2. Засгийн газар уг асуудлыг 30 хоногийн дотор хэлэлцээд холбогдох шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

12.3. Удирдан зохицуулах зөвлөл Конвенци, түүний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж Засгийн газарт уламжилна.

12.4. Засгийн газар уг асуудлыг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөн Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. */Энэ зүйлийг 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

13.1. Энэ хуулийн хэрэгжилтэд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гаалийн болон орон нутгийн холбогдох байгууллага тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавина

14 дүгээр зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах

14.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 20 хүртэл хувиар тооцож мөнгөн шагналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

15 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

15.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. */Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

2008 оны 5-р сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

(Хэсэгчлэн авав)

I ХЭСЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. /Энэ хэсгийг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Монгол Улсын гаалийн хууль тогтоомж нь Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Хилийн боомтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. /Энэ хэсэгт 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

2.3. Монгол Улсын чөлөөт бүсэд энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно. /Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “бараа” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх ачаа, тээш, эд юмс, валют, валютын үнэт зүйл, улс хоорондын шуудангийн илгээмж, бүх төрлийн эрчим хүч, мал, амьтан, ургамал зэрэг хөдлөх эд хөрөнгө болон энэ хуулийн 3.1.5-д зааснаас бусад тээврийн хэрэгслийг;

3.1.2. “монголын бараа” гэж энэ хуулийн 99.1-д заасан горимын дагуу боловсруулалт хийснээс бусад Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр чөлөөт эргэлтэд байгаа гадаадын барааг;

3.1.3. “гадаадын бараа” гэж энэ хуулийн 3.1.2-т зааснаас бусад барааг;

3.1.4. “чөлөөт эргэлтэд байгаа бараа” гэж гаалийн хууль тогтоомжоор тогтоосон хязгаарлалтгүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт захиран зарцуулах барааг;

3.1.5. “тээврийн хэрэгсэл” гэж бараа болон зорчигчийг улс хооронд тээвэрлэж гаалийн хилээр 6 сараас дээшгүй хугацаагаар нэвтрэх бүх төрлийн тээврийн хэрэгсэл, түүний дотор чингэлэг, ердийн хөсөг, тухайн аяллын хугацаанд тээврийн хэрэгсэлд шаардагдах шатахуун, тосолгооны материал, сэлбэгийг;

3.1.6. “тээвэрлэгч” гэж гаалийн хилээр бараа, зорчигч нэвтрүүлэх, эсхүл гаалийн нутаг дэвсгэрт гаалийн хяналт дор тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг;

3.1.7. “гаалийн мэдүүлэг” гэж мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу шаардагдах мэдээлэл агуулсан бичиг баримтыг;

3.1.8. “мэдүүлэгч” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагад мэдүүлж байгаа аливаа этгээдийг;

3.1.9. “гаалийн хилээр нэвтрүүлэх” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрт оруулах, дамжуулан өнгөрүүлэх, гаргахыг;

3.1.10. “гаалийн зам” гэж гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг Монгол Улсын хил, хилийн гаалийн байгууллагын, эсхүл гаалийн нэг байгууллагаас гаалийн нөгөө байгууллагын хооронд тээвэрлэхээр гаалийн удирдах төв байгууллагаас тусгайлан тогтоосон замыг;

3.1.11. “гаалийн хяналт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хууль тогтоомжийг мөрдүүлж, биелэлтийг нь хангуулах зорилгоор гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх цогц арга хэмжээг;

3.1.12. “гаалийн бүрдүүлэлт” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн бичиг баримтыг, шаардлагатай тохиолдолд барааг шалгах, ногдуулсан татварыг төлсний дараа барааг олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг зөвшөөрөх хүртэлх цогц үйл ажиллагааг;

3.1.13. “гаалийн бүрдүүлэлтийн горим” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаар тогтоосон хэм хэмжээ, нөхцөл, шаардлагыг;

3.1.14. “тарифын бус хязгаарлалт” гэж Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тоон хязгаарлалт тогтоох болон бусад арга хэмжээг;

3.1.15. “хилийн гаалийн байгууллага” гэж хилийн боомт болон олон улсын нисэх онгоцны буудалд ажилладаг гаалийн байгууллагыг;

3.1.16. “гүний гаалийн байгууллага” гэж энэ хуулийн 3.1.15-д зааснаас бусад гаалийн байгууллагыг;

3.1.17. “гаалийн баталгаат бүс” гэж гаалийн баталгаат агуулах, үйлдвэрийн болон үзэсгэлэнгийн газар, барилгын талбай, гаалийн тусгай бүс, татваргүй барааны дэлгүүрийг;

3.1.18. “гаалийн хяналтын бүс” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналт дор ачих, буулгах, шилжүүлэн ачих, хадгалах, тээвэрлэх, гаалийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон байр, агуулах, талбайг;

3.1.19. “гаалийн харилцаанд оролцогч” гэж гаалийн байгууллага болон мэдүүлэгч, гаалийн зуучлагч, тээвэрлэгч, гаалийн түр агуулахын болон баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч, банк, даатгалын байгууллагыг.

4 дүгээр зүйл. Гаалийн нутаг дэвсгэр, гаалийн хил

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийг гаалийн нутаг дэвсгэр гэж үзнэ.

4.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүсийн болон чөлөөт бүсийн нутаг дэвсгэр нь тарифын болон тарифын бус хязгаарлалтын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдоно. */Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

4.3. Монгол Улсын хилийг гаалийн хил гэж үзнэ.

4.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан гаалийн баталгаат бүсийг гаалийн нутаг дэвсгэрээс тусгаарласан шугам болон гаалийн хяналтын бүсийн хилийг гаалийн хилд тооцно.

5 дугаар зүйл. Гаалийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг ашиглах

5.1. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг холбогдох этгээд гаалийн хууль тогтоомжид заасны дагуу гаалийн байгууллагад гаргаж өгнө.

5.2. Гаалийн байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 5.1-д заасан мэдээлэл, бичиг баримтыг хүлээн авч түүнийг гагцхүү гаалийн зорилгоор ашиглах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд задруулах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

5.3. Гаалийн байгууллага, албан тушаалтнаас гаалийн хууль тогтоомжийн дагуу авсан төр, хувь хүний, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг ашиглах, хадгалахтай холбогдсон харилцааг нууцын хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

6 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх зарчим

6.1. Аливаа этгээд энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ /цаашид “олон улсын гэрээ” гэх/-нд заасан нөхцөл, журмын дагуу бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр чөлөөтэй нэвтрүүлэх эрхтэй.

6.2. Хуульд зааснаас бусад тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр орсон үеэс мэдүүлэгчид олгох хүртэл, эсхүл бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлсэн үеэс улсын хилээр гарах хүртэлх хугацаанд тэдгээрийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг хориглоно.

7 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх

7.1. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүхий хилийн боомтоор нэвтрүүлнэ.

7.2. Энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хилийн боомтоор бараа, тээврийн хэрэгслийг гаалийн удирдах төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр нэвтрүүлж болно.

7.3. Энэ хуулийн 7.2-т заасан зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага дор дурдсан тохиолдолд олгоно:

7.3.1. гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үед;

7.3.2. олон улсын гэрээнд заасан;

7.3.3. улсыг батлан хамгаалах зорилгоор гадаад улсаас тусламж авах;

7.3.4. хуульд заасан бусад.

7.4. Энэ хуулийн 7.3-т заасны дагуу бараа, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэхэд гаалийн удирдах төв байгууллага гаалийн албан тушаалтныг томилон ажиллуулна.

7.5. Бараа, тээврийн хэрэгслийг энэ хуулийн 7.2-т заасны дагуу хилээр нэвтрүүлэх тохиолдолд мэдүүлэгч нь гаалийн удирдах төв байгууллагад хүсэлтээ гаргах бөгөөд түүнд холбогдох байгууллагын зөвшөөрөл, бараа, тээврийн хэрэгслийн жагсаалтыг хавсаргана.

8 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах

8.1. Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал улсын хилээр оруулах, гаргахыг хориглох барааны, Засгийн газар тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх барааны жагсаалтыг тухайн барааны ангиллын кодыг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу зааж тус тус батална.

8.2. Улсын хилээр оруулахыг хориглосон барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулахгүй.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан барааг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулсан бол нэн даруй буцаан гаргах ба ийнхүү гаргах боломжгүй бол гаалийн хяналтын бүс, эсхүл түр агуулахад 3 хүртэл хоног хадгалах бөгөөд энэ хугацаанд иргэн, хуулийн этгээд бараагаа буцаан гаргаагүй бол гаалийн байгууллага бараа устгах горимын дагуу арга хэмжээг авна.

8.4. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалттай барааг хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлнэ.

8.5. Улсын хилээр гаргахыг хориглосон барааг гаалийн нутаг дэвсгэрээс гаргахгүй.

8.6. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхгүй.

8.7. Гаалийн удирдах төв байгууллага бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх хилийн боомт, гаалийн байгууллагын байршил, тэдгээрийн ажиллах цагийн хуваарийг болон гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан барааны тухай нийтэд мэдээлнэ.

8.8. Энэ хуулийн 8.3-т заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухайн иргэн, хуулийн этгээд хариуцна.

8.9. Гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхийг завдсан үйлдэл нь энэ хуулийн 8.3-т хамаарахгүй.

9 дүгээр зүйл. Гаалийн бүрдүүлэлт, гаалийн хяналт

9.1. Гаалийн байгууллага, албан тушаалтан нь улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, гаалийн бүрдүүлэлт хийх бөгөөд уг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжид зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно.

256 дугаар зүйл. Сорьц, дээж, загвар авах

256.1. Гаалийн байгууллага, албан тушаалтан нь гаалийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор барааны сорьц, дээж, загварыг авч болно.

256.2. Мэдүүлэгч гаалийн байгууллагын зөвшөөрснөөр сорьц, дээж, загвар авч болно.

256.3. Төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу сорьц, дээж, загвар авахад гаалийн байгууллагын албан тушаалтан болон мэдүүлэгч байлцана.

256.4. Мэдүүлэгч нь сорьц, дээж, загвар авахад туслалцаа үзүүлж, үүнтэй холбогдон гарах зардлыг хариуцна.

256.5. Сорьц, дээж, загварын тоо хэмжээ нь шинжилгээ, дүгнэлтэд хүрэлцэхүйц хамгийн бага хэмжээтэй байна.

256.6. Энэ хуулийн 256.1-256.3-т заасны дагуу барааны сорьц, дээж, загварыг авсан тухай тэмдэглэл хөтлөх бөгөөд уг ажиллагаанд шинжээч, мэргэжилтнийг оролцуулж болно.

256.7. Сорьц, дээж, загвар авах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.

257 дугаар зүйл. Гаалийн хяналтад мэргэжилтнийг оролцуулах

257.1. Гаалийн хяналтыг хэрэгжүүлэхэд техник хэрэгсэл, мэргэжлийн мэдлэг, ур чадвар ашиглах шаардлага гарвал гаалийн байгууллага холбогдох мэргэжилтэнг гэрээний үндсэн дээр гаалийн үйл ажиллагаанд оролцуулж болно.

257.2. Энэ хуулийн 257.1-д заасан мэргэжилтэн дараахь эрх эдэлнэ:

257.2.1. өөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох материалтай танилцах;

257.2.2. гаалийн байгууллагын албан тушаалтны зөвшөөрлөөр тухайн үйл ажиллагаанд хамаарах асуулт тавих;

257.2.3. өөрийн оролцсон үйл ажиллагааны үр дүн, холбогдох бичиг баримттай танилцах, тайлбар хийх.

257.3. Энэ хуулийн 257.1-д заасан мэргэжилтэн дараахь үүрэг хүлээнэ:

257.3.1. гэрээнд заасан үүргээ биелүүлэх;

257.3.2. гаалийн хяналтын тодорхой үйл ажиллагаанд оролцсон болохыг гарын үсгээр баталгаажуулах, уг ажиллагааны явцад олж мэдсэн мэдээллийн нууцыг задруулахгүй байх;

257.3.3. оролцож буй тухайн гаалийн үйл ажиллагаа нь өөрийн нь гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өөрийн нь өмчтэй холбоотой бол уг үйл ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй.

257.4. Гаалийн байгууллагын санаачилгаар гаалийн хяналтад оролцсон мэргэжилтний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

258 дугаар зүйл. Гаалийн хяналт хийхэд төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны оролцоо

258.1. Гаалийн хяналт хийх үед мэргэжлийн хяналт, цагдаагийн зэрэг төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу оролцож болно.

258.2. Энэ хуулийн 258.1-д заасан байгууллага, албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийх хяналт, шалгалтыг гаалийн шалгалттай зэрэг хийж болно.

290 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

290.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

290.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. */Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

299 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

299.1. Энэ хуулийг 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН
ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ**

2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль тогтоомж

2.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай, Хилийн тухай, Ургамал хамгааллын тухай, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “мал эмнэлгийн гэрчилгээ” гэж экспортлогдож буй амьтан, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжид заасан тодорхой нөхцөл шаардлагыг хангаж байгааг гэрчлэн экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажуулалтын баримт бичгийг;

3.1.2. “ургамлын хорио цээрийн гэрчилгээ” гэж экспортлогдож буй ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал байхгүй болохыг гэрчлэн экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажуулалтын баримт бичгийг;

3.1.3. “импортын гэрчилгээ” гэж амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулахыг зөвшөөрч, хилийн боомт, гүний гаалийн дэргэдэх мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчаас /цаашид “улсын байцаагч” гэх/ энэ хуулийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт дурдсан баримт бичгийг /цаашид “экспортын гэрчилгээ” гэх/ хураан авч, оронд нь олгож буй баримт бичгийг;

3.1.4. “эрсдэл” гэж хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс тодорхой хугацааны туршид амьтан, ургамал, хүн амын эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө учруулж болох үр дагаварын хэмжээ өндөрсөх магадлалыг;

3.1.5. “зөвшөөрөгдөх эрсдэл” гэдэг нь амьтан, ургамал, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн эрсдэлийн түвшинг;

3.1.6. “эрсдэлийн задлан шинжилгээ” гэж аюулыг олж тогтоох, эрсдэлийн үнэлгээ гаргах, эрсдэлийг бууруулах, мэдээлэл дамжуулахад чиглэсэн үйл ажиллагааг;

3.1.7. “эрсдэлийн үнэлгээ” гэж импортлогч орны нутаг дэвсгэрт эмгэг төрүүлэгч зүйлүүд нэвтрэн орох, тархахаас үүдэн гарах биологи, эдийн засгийн үр дагаварыг тодорхойлон үнэлэх үйл ажиллагааг;

3.1.8. “эрсдэлийг бууруулах” гэдэг нь эрсдэлийг зөвшөөрөх түвшинд хүргэхэд ашиглаж болох арга хэмжээг тодорхойлох, сонгох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

3.1.9. "аюул" гэж амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс хүн ам, амьтан, ургамлын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болох ямар нэгэн эмгэг төрүүлэгч зүйлийг;

3.1.10. "хог ургамал" гэж ургамлыг тариалж, үржүүлж буй талбайд тархаж ургах өөр ургамлыг.

4 дүгээр зүйл. Хорио цээрийн хяналт, шалгалтад хамаарах зүйл

4.1. Энэ хуулийн хүрээнд дор дурдсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтад хамруулна:

4.1.1. бүх төрлийн сүүн тэжээлтэн тэжээвэр болон зэрлэг амьтан, хэвлээр явагч усны амьтан, шувуу, зөгий, тэдгээрийн үр, хөврөл үр, үржлийн өндөг;

4.1.2. мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, өөх, хүнсний өндөг, арьс, шир, яс, ноос, ноолуур, үс, өлөн, эвэр, туурай, шувууны өд, сөд, сарвуу, чив, засаа, залаа, цөс, булчирхай зэрэг амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн;

4.1.3. байгалийн болон таримал дээд, доод ургамал, мод, тэдгээрийн үр, суулгац, хэсэг;

4.1.4. үр тариа, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээл, үрлэн кофе, хөнгөн болон хүнсний үйлдвэрт хэрэглэгдэх ургамлын гаралтай бусад түүхий эд, ургамлын хатаадас, цуглуулга, тасалбар, зүсмэл мод, түүний хэсэг, бүх төрлийн жимс, жимсгэнэ, гурил, будаа, элсэн чихэр, амтлагч зэрэг ургамлын гаралтай аливаа зүйлс;

4.1.5. цус болон цусны ийлдэс, сийвэн;

4.1.6. ангийн олзвор;

4.1.7. төрөл бүрийн эмгэг төрүүлэгч хорхой, шавьж, бичил биетний өсгөвөр, биотехнологийн аргаар гарган авсан хувиргасан амьд организм; */Энэ заалтад 2007 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

4.1.8. амьтны хүүр, сэг, ялгадас, эмгэгт материал;

4.1.9. хөрс, хүлэр, чулуу;

4.1.10. тээврийн хэрэгсэл, чингэлэг, сав, баглаа боодол, чигжээс, зөөлөвч, дэвсгэр, хашлага, хөвөнгийн "хөөвөр", амьтны тоног хэрэгсэл, уяа татлага.

5 дугаар зүйл. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх

5.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын /цаашид "хорио цээрийн хяналт, шалгалт" гэх/ талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. хорио цээрийн хяналт, шалгалтын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

5.1.2. гадаад улс, олон улсын байгууллагатай мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн талаар хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах;

5.1.3. амьтны гоц халдварт өвчин болон ургамлын гадаад хорио цээртэй өвчний халдвар, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал улсын хилээр нэвтрэн тархах эрсдэл үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдал бүрдсэн үед улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн хилийн боомтод хорио цээр тогтоох, тогтоосон хорио цээрийг цуцлах;

5.1.4. энэ хуулийн 5.1.3-т заасан хорио цээр тогтоосон үед баримтлах нийтлэг журам /дэглэм/-ыг тогтоох;

5.1.5. ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудыг тогтоох;

5.1.6. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам, зааврыг батлах;

5.1.7. амьтан, ургамал түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журмыг батлах;

5.1.8. хилийн боомтод амьтан, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

5.2. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн /цаашид "амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн" гэх/-д шинжилгээ, эмчилгээ, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэл хийх үйлчилгээний хөлсний жишиг үнийг улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн санхүүгийн асуудал эрхэлсэн сайд тогтооно.

5.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ импортоор оруулж ирсэн амьтан, ургамлыг хууль тогтоомжид заасны дагуу хорио цээрийн дэглэмд байлгах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавина.

6 дугаар зүйл. Хорио цээрийн улсын хяналт, шалгалт, түүний зохион байгуулалт

6.1. Хорио цээрийн улсын хяналт, шалгалт нь хилийн боомт, гүний гаалиар нэвтрүүлж буй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд хорио цээрийн хяналт, шалгалтыг хийж, зөрчилтэй болон эрсдэлтэй зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоход чиглэгдэнэ. /Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.2. Хорио цээрийн улсын хяналт, шалгалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хорио цээрийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн эрх бүхий байгууллага /цаашид "хяналтын байгууллага" гэх/, хилийн боомт, гүний гааль бүхий газарт хүнсний аюулгүй байдалд хяналт тавих эрх бүхий улсын байцаагч тус тус хэрэгжүүлнэ. /Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6.3. /Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

7 дугаар зүйл. Улсын мэргэжлийн хяналтын байгууллагын эрх, үүрэг

7.1. Улсын мэргэжлийн хяналтын байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1 хорио цээрийн хяналт, шалгалтын талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хангах;

7.1.2. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын болон гаалийн хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалт хийх ажлыг өдөр тутмын удирдлагаар хангах, хяналт тавих;

7.1.3. амьтан, ургамал, хүнснийхээс бусад түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлохын өмнө эрсдэлийн задлан шинжилгээ хийж импортын мэдэгдэл олгох; /Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

7.1.4. Монгол Улсын хилээр нэвтэрсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний мэдээллийн сан бүрдүүлж, улсын хэмжээнд нэгтгэх, хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх;

7.1.5. улсын байцаагчийн хийсэн үзлэг, бичиг баримтын шалгалтаар илэрсэн зөрчил нь энэ хуулийн 13.1-д хамаарч байгаа бол тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлогч улсад буцаах буюу устгах арга хэмжээ авахуулах;

7.1.6. улсын байцаагчийг мэргэжлийн удирдлагаар хангах, мэргэшүүлэх;

7.1.7. гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын байгууллагатай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах;

7.1.8. Малын эрүүл мэндийн олон улсын байгууллагаас тогтоосон "А" жагсаалтын өвчин /цаашид "амьтны гоц халдварт өвчин" гэх/, ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, хог ургамал, мэрэгч амьтан /цаашид "ургамлын хорио цээртэй зүйл" гэх/ илэрсэн тохиолдолд тухайн хилийн боомт, гүний гаальд хорио цээр тогтоох саналыг Засгийн газарт оруулах, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг хянах;

7.1.9. шаардлагатай бол экспортлох эрх бүхий үйлдвэр, аж ахуйн нэгжид мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн үзлэг, хянан магадлагаа хийх. /Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

8 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх үүрэг

8.1. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: */Энэ хэсэгт 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

8.1.1. экспортын гэрчилгээнд бичигдсэн мэдээлэл нь бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, худалдааны гэрээ, тээврийн хэрэгслийн талаархи мэдээлэл, амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо, хэмжээтэй тохирч буй эсэхийг шалгах;

8.1.2. бүтээгдэхүүн, түүхий эдийн сав, баглаа боодол, тээвэрлэлтийн нөхцөл нь импортлогч улсын шаардлагад нийцсэн, хаяг, шошго нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах; */Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

8.1.3. хилээр нэвтрүүлж буй ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хорио цээрийн анхдагч үзлэг хийх;

8.1.4. хилээр нэвтрүүлж буй амьтан нэг бүрийг бүртгэж, эрүүл мэндийн үзлэг хийх;

8.1.5. анхдагч болон эрүүл мэндийн үзлэгээр халдварт өвчний шинж тэмдэг, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын байранд түр саатуулж, лабораторийн шинжилгээний дээж авч, хорио цээрийн хяналтад оруулах;

8.1.6. экспортын гэрчилгээ бусад дагалдах бичиг баримт зөрчилтэй, тээвэрлэлтийн нөхцөл нь энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан шаардлага, нөхцөлийг хангаагүй бол амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхгүй байх;

8.1.7. хорио цээрийн хяналтанд байгаа амьтан, ургамал, түр саатуулагдсан түүхий эд, бүтээгдэхүүнтэй холбогдсон асуудлыг энэ хуулийн 13, 14, 15, 16 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх;

8.1.8. экспортын гэрчилгээ болон дагалдах бичиг баримт, хорио цээрийн нөхцөлийн талаар зөрчил илрээгүй эрүүл амьтан, ургамал, гэмтэж муудаагүй түүхий эд, бүтээгдэхүүнд импортын гэрчилгээ олгож, улсын хилээр нэвтрүүлэх;

8.1.9. үзлэг, шалгалт, шинжилгээ хийсэн, хорио цээрийн хяналтад оруулж түр саатуулсан, экспортлогч улсад буцаасан, устгасан болон улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаархи бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, мэдээг тогтоосон хугацаанд улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлэх;

8.2. Улсын байцаагч нь ажлын байр, үзлэг, шинжилгээний багаж, хэрэгсэл болон амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг хийх, хорио цээрт оруулж түр саатуулах зориулалтын тусгайлан тоноглож, төхөөрөмжилсөн хашаа, байр, талбай, агуулах, багаж хэрэгсэл, болон устгал хийх байгууламжаар хангагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АМЬТАН, УРГАМАЛ, ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ

9 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих нийтлэг шаардлага

9.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд иргэн, хуулийн этгээд дараахь нийтлэг шаардлагыг хангасан байна: 9.1.1. Монгол Улсаас гадаад улстай амьтан, ургамлын хорио цээрийн талаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид заасан стандарт, удирдамж, зөвлөмжийн нөхцөлийг мөрдөх;

9.1.2. экспортлогч улсын хорио цээрийн хяналт, баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээтэй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг хорио цээрийн үзлэг, шалгалтанд оруулах;

9.1.3. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийн хашлага, дэвсгэр, сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэлд хорио цээрийн үзлэг, шалгалтыг хилийн боомт, гүний гаалийн хяналтын талбай дээр хийлгэх;

9.1.4. биологийн эмгэгт материал, бичил биетний омог, өсгөврийн дээж, хөрс, хөрстэй ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар хил нэвтрүүлэх ба хүлээн авагч улсын холбогдох этгээдэд хүргэх хүртэл сав, баглаа боодол, битүүмжлэлийг задлахгүй байх.

10 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлоход тавих шаардлага

10.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлоход энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

10.1.1. тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн нь амьтны гоц халдварт өвчин гараагүй, ургамлын хорио цээртэй зүйл тархаагүй тайван улс, бүсээс гаралтай байх;

10.1.2. тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний зөвшөөрөгдөх эрсдэлийг тогтоолгосон байх.

11 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн экспортлоход тавих шаардлага

11.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

11.1.1. импортлогч улстай тохиролцсон хорио цээрийн нөхцөл, эсхүл хорио цээрийн талаархи Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, олон улсын байгууллагаас гаргасан стандарт, удирдамж, зөвлөмжид нийцсэн байх;

11.1.2. экспортын шаардлага хангаж буйг нотолж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгосон байх.

12 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг дамжуулан өнгөрүүлэхэд тавих шаардлага

12.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэхэд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

12.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлтээ энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд улсын мэргэжлийн хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэж, зохих мэдэгдэл авсан байх;

12.1.2. амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлийн дэгдэлт гараагүй тайван улс, бүсээс гаралтай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн байх;

12.1.3. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чингэлэгийн лац, ломбо бүрэн бүтэн байх.

12.2. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг дамжуулан өнгөрүүлэх үед улсын мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслээс буулгахыг хориглоно.

12.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас болон амрах, услах, тэжээх зорилгоор амьтныг маршрутын дагуу урьдчилан тогтоосон цэгт улсын байцаагчийн хяналтын дор тээврийн хэрэгслээс буулгах үйл ажиллагаанд энэ хуулийн 12.2 дахь хэсэг хамаарахгүй.

12.4. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх замд амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн тохиолдолд улсын мэргэжлийн хяналтын байгууллага энэ тухай импортлогч, экспортлогч улсын хяналтын эрх бүхий байгууллагад яаралтай мэдэгдэж, энэ хуулийн 13, 14, 15, 16 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.

13 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэхийг хориглох

13.1. Дараахь тохиолдолд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно:

13.1.1. энэ хуулийн 10.1, 11.1-д заасан шаардлагыг хангаагүй;

13.1.2. хорио цээрийн хяналт, шалгалтанд ороогүй, эсхүл гэрчилгээнд бичигдсэн

мэдээлэл зөрүүтэй буюу дагалдах бичиг баримт нь хуурамч болох нь хяналт, шалгалтын явцад тогтоогдсон.

13.2. Энэ хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан шаардлагыг хангаагүй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглож, энэ тухай улсын мэргэжлийн хяналтын байгууллага нь экспортлогч улсын хилийн боомтын хяналтын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

13.3. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан үндэслэлээр амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон тухай мэдэгдлийг улсын байцаагч хариуцагч иргэн, хуулийн этгээдэд гардуулан өгнө.

13.4. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон тухай мэдэгдэл хүлээн авсан иргэн, хуулийн этгээд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлогч улсад буцаах үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэх үед түр саатуулах

14.1. Улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтаар өвчний шинж тэмдэг илэрсэн амьтан, шавьж илэрсэн ургамал, гэмтэж муудсан нь тогтоогдсон түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын байцаагч 21 хүртэл хоногийн хугацаагаар түр саатуулж, энэ тухай мэдэгдлийг хариуцагч иргэн, хуулийн этгээдэд гардуулан өгнө.

14.2. Түр саатуулах тухай мэдэгдэл хүлээн авсан иргэн, хуулийн этгээд хилийн боомт, гүний гаалийн хяналтын талбайд тусгайлан бэлтгэсэн хашаа, байр, агуулах, талбайд улсын байцаагчийн шийдвэрээр, түүний хяналтын дор амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгслээс буулгаж нарийвчилсан үзлэг хийлгэнэ.

14.3. Улсын байцаагч хорио цээрийн нарийвчилсан үзлэг хийж, шинжилгээний дээж аван холбогдох лабораторид хүргүүлнэ. Дээж хүлээн авсан лаборатори нь 14 хоногийн хугацаанд багтаан шинжилгээний хариуг гаргана.

14.4. Лабораторийн шинжилгээний хариу болон хорио цээрийн хугацаанд хийсэн ажиглалт, үзлэгийн дүнг үндэслэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх эсэхийг хилийн боомт, гүний гаалийн мэргэжлийн хяналтын байгууллага шийдвэрлэнэ.

14.5. Лабораторийн шинжилгээнд орсон зүйлээс амьтны гоц халдварт өвчин оношлогдсон, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн бол амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийг тээвэрлэхэд хэрэглэсэн хашлага, тоног хэрэгсэл, өвс, тэжээлийн үлдэгдэл, дэвсгэр, сав, баглаа, боодол, чигжээсийг энэ хуулийн 15.2-т заасны дагуу устгана.

14.6. Энэ хуулийн 12.1.1-д заасан шаардлагыг хангаагүй амьтан ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тодорхой хугацаагаар түр саатуулж, экспортлогч улсын хорио цээрийн хяналтын байгууллагад мэдэгдэн, зөрчлийг арилгуулсаны үндсэн дээр дамжуулан өнгөрүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

15 дугаар зүйл. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах

15.1. Хорио цээрийн хяналт, шалгалтын явцад дараахь нөхцөл байдал үүссэн бол амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг устгана:

15.1.1. энэ хуулийн 13.1, 13.2-т заасны дагуу амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад экспортлогч орны хилийн боомтын эрх бүхий байгууллагад мэдэгдэхэд буцааж хүлээн авахаас татгалзсан;

15.1.2. тухайн амьтан нь гоц халдварт өвчний халдвартай болох нь оношлогдсон;

15.1.3. тухайн ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд ургамлын гадаад хорио цээртэй зүйл илэрсэн;

15.1.4. хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, горим зөрчсөний улмаас түүхий эд, бүтээгдэхүүнд учирсан гэмтэл нь хүн, амьтны эрүүл мэндэд хор хөнөөл учруулж болзошгүй нь тогтоогдсон;

15.1.5. түүхий эд, бүтээгдэхүүнд үүссэн хими, биологи, цацрагийн бохирдлын түвшин олон улсын стандартын зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрсэн.

15.2. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах ажлыг тухайн хилийн боомт, гүний гааль байрлаж буй сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг улсын байцаагчийн хяналтын дор зохих журмын дагуу гүйцэтгэнэ.

15.3. Энэ хуулийн 15.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ амьтныг тарчлаахгүй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээргүй, халдвар үүсгэгчийг бүрэн устгаж чадахуйц аргыг хэрэглэнэ.

16 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд эмчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх

16.1. Улсын байцаагчийн хяналтын дор мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн дараахь зүйлд эмчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийнэ:

16.1.1. амьтны гоц халдвартаас бусад халдвартай өвчин оношлогдсон болон эерэг урвал үзүүлсэн амьтан;

16.1.2. ургамлын дотоод хорио цээртэй зүйл илэрсэн ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн;

16.1.3. энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд хэрэглэсэн хашлага, тоног хэрэгсэл, өвс, тэжээлийн үлдэгдэл, дэвсгэр, сав, баглаа боодол, чигжээс, тэдгээртэй адилтгах зүйлс;

16.1.4. энэ хуулийн 15.1.1, 16.1.1, 16.1.2-т заасан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн ачсан тээврийн хэрэгсэл, чингэлэг, тэдгээртэй адилтгах бусад зүйлс;

16.1.5. энэ хуулийн 15.1.2, 15.1.3-т заасан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн байсан байр, агуулах, талбай, халдвараар бохирлогдсон байж болзошгүй орчны хөрс, барилга, байгууламж.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн болон тээврийн хэрэгсэл, хашлага бусад зүйлд холбогдох мэргэжлийн байгууллагаар эмчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгүүлсэний үндсэн дээр хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЗОРЧИГЧИЙН ГАР ТЭЭШ БОЛОН ИЛГЭЭМЖИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

17 дугаар зүйл. Зорчигчийн гар тээшийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн шаардлага

17.1. Зорчигчийн хувийн хэрэглээний амьтан, ургамал, түүхий эд бүтээгдэхүүнд шаардлагатай тохиолдолд улсын байцаагч анхдагч үзлэг хийнэ.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан үзлэгийн явцад, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн, амьтны гоц халдварт өвчин гарсан улс, бүс нутгаас гаралтай болох нь тогтоогдсон амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын байцаагч энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна. 17.3. Энэ хуулийн 17.1 дэх хэсэг нь үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнд хамаарахгүй.

18 дугаар зүйл. Амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний илгээмжид тавих хорио цээрийн хяналт

18.1. Илгээмжийн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бүхий илгээмж ирсэн тухай мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын холбогдох байгууллагад мэдэгдэж үзлэг, шалгалт хийлгэнэ.

18.2. Энэ хуулийн 10.1.1-д заасан нөхцөлийг хангасан, хорио цээрийн анхдагч үзлэгээр ургамлын хорио цээртэй зүйл илрээгүй, гэмтэж муудаагүй түүхий эд, бүтээгдэхүүнийг илгээмжээр хил нэвтрүүлнэ.

18.3. Энэ хуулийн 18.2 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангаагүй илгээмжийг илгээгчид мэдэгдэж буцаах буюу устгах арга хэмжээ авна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
АМЬТАН, УРГАМАЛ, ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН АЧСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ
УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ

19 дүгээр зүйл. Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тавих шаардлага

19.1. Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь дараахь шаардлагыг хангасан байна:

19.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал, таатай нөхцөлийг хангасан, халуун, хүйтний хэмийг тохируулах боломжтой байхаар тоноглогдсон байх;

19.1.2. тээвэрлэлтийн өмнө технологийн дагуу цэвэрлэж, ариутгаж халдваргүйжүүлсэн байх;

19.1.3. чингэлэг, хашлагыг нээх үед амьтны хэвтэр, ялгадас, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн асгарахааргүй ачигдсан байх.

19.2. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага, тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн өмнөх ариутгал, халдваргүйжүүлэлтийн журмыг улсын мэргэжлийн хяналтын төв байгууллага тогтооно.

20 дугаар зүйл. Тээврийн хэрэгсэлд хийх хорио цээрийн үзлэг, шалгалт

20.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх үед дараахь үзлэг шалгалт хийнэ: 20.1.1. энэ хуулийн 19.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх;

20.1.2. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд дагалдах бичиг баримт нь тээврийн хэрэгслийн талаархи мэдээлэлтэй тохирч буй эсэх;

20.1.3. тээврийн хэрэгсэл нь амьтны гоц халдварт болон халдварт өвчний үүсгэгч, ургамлын хорио цээртэй зүйлсээр бохирлогдсон эсэх.

20.2. Хорио цээрийн хяналт, шалгалтын үед амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг зөвхөн улсын байцаагчийн хяналтын дор тээврийн хэрэгслээс буулгана.

20.3. Үзлэг шалгалтаар тээврийн хэрэгсэлд хорио цээртэй зүйл илэрвэл дээж авч лабораторийн шинжилгээнд өгнө.

20.4. Үзлэг шалгалт хийх үед тээвэрлэгчийн төлөөлөгчийг байлцуулна.

21 дүгээр зүйл.Тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх

21.1. Хорио цээртэй зүйлээр халдварлагдсан тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллага, иргэн улсын байцаагчийн хяналтын дор зохих журмын дагуу хийнэ.

21.2. Тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх талбайг улсын байцаагч тогтооно.

21.3. Тээвэрлэгч нь тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх нөхцөлөөр хангана.

22 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийг хорио цээрт оруулах

22.1. Амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлийн голомт үүссэн бүс нутгаас амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн ачсан тээврийн хэрэгслийг хилийн боомт дээр ирмэгц улсын мэргэжлийн хяналтын байгууллагын шийдвэрээр хорио цээрт оруулна.

22.2. Энэ хуулийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу хорио цээрт оруулсан тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйжүүлэлт хийнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ
ИМПОРТ, ЭКСПОРТЫН ӨМНӨХ ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ

23 дугаар зүйл. Импортын мэдэгдэл

23.1. Амьтан, ургамал, хүнснийхээс бусад түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох иргэн, хуулийн этгээд хүсэлтээ улсын мэргэжлийн хяналтын байгууллагад дор дурдсанаас доошгүй хугацааны өмнө гаргана: */Энэ хэсэгт 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

23.1.1. салаа туурайтай амьтан, адуу импортлоход 60 хоног;

23.1.2. тахиа, галуу, нугас, цацагт хяруул, гургууль зэрэг тэжээвэр шувуу импортлоход 40 хоног;

23.1.3. таримал болон байгалийн ургамлын үр суулгац импортлоход 30 хоног;

23.1.4. Энэ хуулийн 23.1.1-23.1.3-т зааснаас бусад амьтан, ургамал, түүхий эд, зарим бүтээгдэхүүнийг оруулахад 20 хоног.

23.2. Хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээд нь дараахь мэдээллийг улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлтийн хамт ирүүлнэ:

23.2.1. амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах бичиг баримт;

23.2.2. импортлогч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар; */Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

23.2.3. амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл;

23.2.4. нэвтрүүлэх хилийн боомт, хугацаа;

23.2.5. түүхий эд, бүтээгдэхүүний тоо хэмжээ, боловсруулалтын байдал, /хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, шинэ гэх мэт/ савлалт, шошго, чанар, аюулгүй байдлын талаархи мэдээлэл.

23.3. Улсын мэргэжлийн хяналтын байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

23.3.1. тухайн амьтан, ургамал, хүнснийхээс бусад түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл олгож, хилийн боомт, гүний гаалийн мэргэжлийн хяналтын байцаагчид хүргүүлэх; */Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

23.3.2. зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээнээс хэтэрсэн, түүнийг бууруулах боломжгүй тохиолдолд хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэх.

24 дүгээр зүйл. Импорт, экспортын өмнөх хорио цээрийн хяналт, шалгалт, баталгаажуулалт

24.1. Хууль болон олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол импортлох салаа туурайтныг 21, адууг 15, тахиа, нугас, галуу, цацагт хяруул, гургуулийг 21, ургамлын үр 60, ургамлын суулгац, үржүүлгийн материалыг 30 хоногийн хугацаанд экспортлогч улсын нутаг дэвсгэр дээр хорио цээрийн хяналтад оруулна.

24.2. Энэ хуулийн 24.1-д заасан амьтныг үржлийн болон эдэлгээний зориулалтаар импортлох бол хорио цээрийн хяналтад байх хугацааны турш өдөр бүр эрүүл мэндийн үзлэг хийж, биеийн халууныг хэмжин тэмдэглэл хөтөлнө.

24.3. Энэ хуулийн 24.1-д заасан амьтан, ургамлыг экспортлоход импортлогч улстай байгуулсан гэрээ, хэлэлцээр болон энэ хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн хорио цээрт оруулж, үзлэг, шинжилгээ хийнэ. Шинжилгээг олон улсын стандартад нийцсэн аргаар хийнэ.

25 дугаар зүйл. Импорт, экспортын гэрчилгээ

25.1. Импортын гэрчилгээг экспортлогч улсын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн эрх бүхий байгууллагаас олгосон экспортын гэрчилгээ, улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон импортын мэдэгдэл, шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагч олгоно.

25.2. Экспортын гэрчилгээг хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан тусгайлан эрх олгосон мэргэжлийн байгууллага олгоно.

25.3. Экспорт, импортын гэрчилгээ нь олон улсын амьтны халдварт өвчний болон ургамал хамгааллын байгууллагын баталсан загварын дагуу хийгдэж, экспортлогч, импортлогч улсын харилцан тохиролцсон хэлээр бичигдсэн байна.

25.4. Экспортын гэрчилгээг тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг ачуулахын өмнө 24 цагийн дотор олгосон байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЭРСДЭЛИЙН ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ЗӨВШӨӨРӨГДӨХ ЭРСДЭЛ

26 дугаар зүйл. Эрсдэлийн задлан шинжилгээ, үнэлгээ хийх

26.1. Монгол Улсын хүн ам, амьтан, ургамлын эрүүл мэндийг хамгаалах, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлээс урьдчилан сэргийлэх зорилгоор импортын эрсдэлийн задлан шинжилгээ хийнэ.

26.2. Эрсдэлийн задлан шинжилгээгээр импортлож буй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнээс дараахь зүйлд учирч болох аюулыг тодорхойлно: 26.2.1. хүн ам, амьтан, ургамлын эрүүл мэндэд;

26.2.2. улсын эдийн засагт;

26.2.3. хүрээлэн буй орчинд.

26.3. Эрсдэлийн задлан шинжилгээг дор дурдсан үндэслэлээр хийнэ:

26.3.1. импортын уламжлалт харилцаагүй улс, бүс нутгаас анх удаа мал, амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн Монгол Улсад импортлох бол;

26.3.2. импортын уламжлалт харилцаатай боловч тухайн улсад амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн, хими, физикийн бохирдлын эрсдэл өссөн байж болзошгүй нөхцөлд Монгол Улсад импортлох бол;

26.3.3. хэд хэдэн улсын нутаг дээгүүр дамжуулан тээвэрлэх бол.

26.4. Эрсдэлийн задлан шинжилгээг улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас томилогдсон мэргэжлийн баг гүйцэтгэнэ.

27 дугаар зүйл. Зөвшөөрөгдөх эрсдэлийг тооцох

27.1. Эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг улсын мэргэжлийн хяналтын байгууллага болон хилийн боомт, гүний гаалийн мэргэжлийн хяналтын байгууллага олон улсын стандарт, удирдамж, зөвлөмжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

27.2. Зөвшөөрөгдөх эрсдэлтэй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний импортыг хүлээн зөвшөөрч мэдэгдэл олгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

28 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх

28.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх, тээвэрлэх иргэн, хуулийн этгээд дараахь эрх эдлэнэ:

28.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон хорио цээрийн нөхцөл, шаардлагын талаархи мэдээллийг хорио цээрийн байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

28.1.2. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх талаар гаргасан хүсэлтийг энэ хуулийн 23.3-д заасан хугацаанд шийдвэрлүүлэх;

28.1.3. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэхийг хориглосон, саатуулсан талаар албан ёсны тайлбар авах;

28.1.4. хорио цээрийн үзлэг, шалгалт, хяналтын талаар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах.

29 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг

29.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх, тээвэрлэх иргэн, хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

29.1.1. энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлт, мэдээллийг улсын мэргэжлийн хяналтын байгууллагад ирүүлэх;

29.1.2. улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаар улсын мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчид мэдүүлэх;

29.1.3. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед экспорт, импортын болон бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, худалдааны гэрээ, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг улсын байцаагчид шалгуулах;

29.1.4. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг үзлэг, шинжилгээнд хамруулах;

29.1.5. улсын мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

29.1.6. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд шинжилгээ хийж баталгаажуулах, тэдгээрийг саатуулах, эмчилгээ, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийхэд шаардагдах зардлыг хариуцах.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

30 дугаар зүйл. Хорио цээрийн хяналт, шалгалтын үйл ажиллагааны санхүүжилт

30.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн арга хэмжээтэй холбогдуулан дараахь зардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ:

30.1.1. хил, гүний боомтод амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн буюу илэрч болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан хэрэгжүүлэх хорио цээр, ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалын арга хэмжээнд шаардагдах хөрөнгө.

31 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, хорио цээрийн үзлэг, шалгалт хийхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх

31.1. Иргэн, хуулийн этгээд улсын байцаагчийн хооронд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, хорио цээрийн үзлэг, шалгалт хийхтэй холбогдон үүссэн маргааныг улсын мэргэжлийн хяналтын байгууллага шийдвэрлэх бөгөөд тухайн шийдвэрийг эс зөвшөөрвөл иргэн, хуулийн этгээд, улсын байцаагч нь шүүхэд гомдол гаргаж болно.

32 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

32.1. Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

32.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. /Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 01-р сарын 8-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ, ТАРИФЫН БУС БУСАД ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ БҮЛЭГ БАРААНЫ ЖАГСААЛТЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтыг 1 дүгээр хавсралт, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолоор баталсан улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны нэр төрлийг нарийвчлан гаргаж, Гаалийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн кодоор оруулан батлах эрхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т олгосугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ БҮЛЭГ БАРААНЫ ЖАГСААЛТ

№	Бүлэг барааны бичиглэл	Улсын хилээр нэвтрэх ялгаа
1.	Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэг-лэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал*	Гаргах, оруулах
2.	Судалгаа, шинжилгээний зориулалттайгаас бусад этилийн спирт	Оруулах
3.	Пиво ундааны хаягдал лаазнаас бусад хаягдал хар болон өнгөт төмөрлөг /ширэм, төмөр, ган, зэс, гууль, хөнгөн цагаан, тэдгээрийн хайлш/, цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй хар болон өнгөт төмөрлөг, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн	гаргах

* Эмчилгээний зориулалтаар хилээр оруулж ирэх мансууруулах бодис, ургамлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтоор хил нэвтрүүлнэ.

/1999 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 11 дүгээр, 2005 оны 46 дугаар, 2006 оны 3 дугаар тогтоолоор орсон нэмэлтийг тусгав./ /2006 оны 92 дугаар тогтоолоор орсон хасалтыг хийв. 2008-1-28/

**МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ТАРИФЫН БУС БУСАД ХЯЗГААРЛАЛТАЙ НЭВТРҮҮЛЭХ
БҮЛЭГ БАРААНЫ ЖАГСААЛТ**

1	Бүлэг барааны бичиглэл	Улсын хилээр нэвтрэх ялгаа
1	Ураны хүдэр ба түүний баяжмал	Гаргах
2	Онцгой хортой химийн бодис	Гаргах, оруулах
3	Зайлшгүй хяналтад байх эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай эд эрхтэн, донорын цус	Гаргах, оруулах
4	Буу, зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл, техник, тэдгээрийн эд анги, тоног хэрэглэл, тэсрэх бодис	Гаргах, оруулах
5	Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл	Түр гаргах
6	Ердийн түүх соёлын зүйл, амьтан, ургамал, эрдэс судлал, анатоми, археологи палеон-тологи, угсаатны зүй болон зоос судлалын чиглэлийн олдвор болон цуглуулга	Гаргах
7	Үржлийн мал	Гаргах
8	Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээж	Гаргах
9	Мал, амьтны үр хөврөл, бичил биетний өсгөвөр	Гаргах

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 08-р сарын 25-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ /Ховор ургамлын жагсаалт/

Байгалийн ургамлын тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ховор ургамлын жагсаалтыг хавсралтын ёсоор баталсугай /Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2004 оны 165-р тогтоолоор нэмэлт, Засгийн газрын 2015 оны 410-р тогтоолоор өөрчлөлт орсон/.

2. "Ховор ургамлыг эмиин үйлдвэрлэл болон ахуйн зориулалтаар бэлтгэх, ашиглах журам"-ыг 1995 оны 10 дугаар сард багтаан батлан гаргахыг Байгаль орчны яам /З.БАТЖАРГАЛ/, Эрүүл мэндийн яам /П.НЯМДАВАА/-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Байгаль орчн сайд

П.ЖАСРАЙ
З.БАТЖАРГАЛ

Засгийн газрын 1995 оны 153 дугаар
тогтоолын хавсралт

ХОВОР УРГАМЛЫН ЖАГСААЛТ (Монгол, латин нэрээр)

1. Давхарацан авлис	<i>Smelovskia bifurcata</i>
2. Ацан ажигана	<i>Stellaria dichotoma</i>
3. Дунд ажигана	<i>Stellaria media</i>
4. Дэрэн ажигана	<i>Stellaria pulvinata</i>
5. Цацраган ажигана	<i>Stellaria radians</i>
6. Унжгар азаргана	<i>Cirsium pendulum</i>
7. Регелийн алаглигцэцэг	<i>Minuartia Regeiana</i>
8. Туйлын алаглигцэцэг	<i>Minuartia arctica</i>
9. Цэх алаглигцэцэг	<i>Minuartia stricta</i>
10. Нүцгэн алтанбөөр	<i>Chrysosplenium nudicaule</i>
11. Нугараа алтантовч	<i>Matricaria recutita</i>
12. Геблерийн алтанцэгцүүхэй	<i>Hypericum Gebleri</i>
13. Голөвсөрхүү альчинга	<i>Butemus junceus</i>
14. Бүнгийн ангалзуур	<i>Lagochilus Bungei</i>
15. Богданы арвай	<i>Hordeum Bogdani</i>
16. Төрөлсөг арзгана	<i>Cousinia affinis</i>
17. Бөөнөг арзгар	<i>Sparganium glomeratum</i>
18. Дагуур арц	<i>Juniperus dahurica</i>
19. Хуурамч хонин арц	<i>Juniperus pseudosadina</i>
20. Нүцгэн багваахай	<i>Taraxacum glabrum</i>
21. Турьхан багваахай	<i>Taraxacum macilentum</i>
22. Үнгээмэл навчитбагваахай	<i>Taraxacum armerifolium</i>
23. Сунагар баглуур	<i>Anabasis elatior</i>
24. Зантгар бамбай	<i>Valeriana capitata</i>
25. Эмийн бамбай	<i>Valeriana officinalis</i>
26. Чуйн банга	<i>Crepis czuensis</i>

27. Дорогостайскийн банздоо	<i>Saussurea Dorogostaiskii</i>
28. Екатерины банздоо	<i>Saussurea Catharinae</i>
29. Клеменцийн банздоо	<i>Saussurea Klementzii</i>
30. Мөсний банздоо	<i>Saussurea glacialis</i>
31. Навчирхэг банздоо	<i>Saussurea foliosa</i>
32. Өргөн навчит банздоо	<i>Saussurea latifolia</i>
33. Хурц банздоо	<i>Saussurea acuminata</i>
34. Тагийн барагжаа	<i>Woodsia alpina</i>
35. Гельцерийн башир	<i>Dianthus Hoeltzeri</i>
36. Зүүнгарын башир	<i>Dianthus soongoricus</i>
37. Ревердаттын биелэг өвс	<i>Poa Reverdattoi</i>
38. Хэвтээ биелэг өвс	<i>Poa supina</i>
39. Хэнтийн биелэг өвс	<i>Poa kenteica</i>
40. Гоо ботууль	<i>Festuca venusta</i>
41. Комаровын ботууль	<i>Festuca Komarovii</i>
42. Литвиновын ботууль	<i>Festuca Litvinovii</i>
43. Дөрвөлжин бөлбөө	<i>Nymphaea tetragona</i>
44. 5-рановын бөөнгөнө	<i>Rhizoplaca Baranovii</i>
45. Лазтгай навчит бударга	<i>Suaeda iinifolia</i>
46. Нанчиггсаг бударгана	<i>Salsola foliosa</i>
47. Ягаан бударгана	<i>Salsola rosacea</i>
48. Падгардуу бударганцар	<i>Climacoptera subcrassa</i>
49. Халбагандуу буниас	<i>Bunias cochlearioides</i>
50. Том үрт бурз	<i>Galatella macrosciadia</i>
51. Их бушилз	<i>Kobresia robusta</i>
52. Монгол бүйлэс	<i>Amygdalus mongolica</i>
53. Өвөр-уралын бүрээ	<i>Onosma transrhymnense</i>
54. Дэлхээ бүүргэнт	<i>Pulicaria prostrata</i>
55. Говийн бэрмэг	<i>Limonium gobicum</i>
56. Грубовын бэрмэг	<i>Limonium Grubovii</i>
57. Усан гагнаа	<i>Tillaea aquatica</i>
58. Комаровын ганга	<i>Thymus Komarovii</i>
59. Монгол ганга	<i>Thymus mongolicus</i>
60. Павловын ганга	<i>Thymus Pavlovii</i>
61. Ягаан ганга	<i>Thymus roseus</i>
62. Жижиг гандбадраа	<i>Veronica perpusilla</i>
63. Порфирын гандбадраа	<i>Veronica Porphyriana</i>
64. Невскийн ганцаахай	<i>Lysiella Nevskii</i>
65. Алтлаг цэцэгт гичгэнэ	<i>Potentilla chrysantha</i>
66. Зүймэг гичгэнэ	<i>Potentilla inbricata</i>
67. Иконниковын гичгэнэ	<i>Potentilla Ikonnikovii</i>
68. Норвегийн гичгэнэ	<i>Potentilla norvegica</i>
69. Регелийн гичгэнэ	<i>Potentilla/ Regeliana</i>
70. Элсний гичгэнэ	<i>Potentilla arenosa</i>
71. Семеновын гиш	<i>Vicia Semenovii</i>
72. Хос цэцэгт гиш	<i>Vicia geminiflora</i>
73. Япон гиш	<i>Vicia japonica</i>
74. Гөлгөр говой	<i>Goldbachia Laevigata</i>
75. Иконниковын говой	<i>Goldbachia Ikonnikovii</i>
76. Зүүн гарын гоёо	<i>Cynomorium soongaricum</i>
77. Санчирын гол гэсэр	<i>Aster Sanczirii</i>
78. Уелиг гол өвс	<i>Juncus articulatus</i>

- | | |
|-------------------------------------|--------------------------------------|
| 79. Мажар гозоохой | <i>Juncellus pannoynicus</i> |
| 80. Гажиг гурив-үрт | <i>Aulackspermum anomalum</i> |
| 81. Наалдамхай гүүн хөх | <i>Scutellaria viscidula</i> |
| 82. Навтгар гүүн хөх | <i>Scutellaria supina</i> |
| 83. Паулсын гүүн хөх | <i>Scutellaria Paulsenii</i> |
| 84. Жинхэнэ доёлз | <i>Moneses uniflora</i> |
| 85. Дөрвөн эвэрт дөрвөлж | <i>Tetracme quadricornis</i> |
| 86. Тагийн дурваалиг | <i>Phleum alpinum</i> |
| 87. Голөвсдүү дэвхэргэнэ | <i>Ereoaogonia juncea (arenaria)</i> |
| 88. Товчин дэвхэргэнэ | <i>Eromogonia androsacea</i> |
| 89. Цагаан дэгд | <i>Gentiana algida</i> |
| 90. Эргийн дэгд | <i>Gentiana riparia</i> |
| 91. Согтоонги дэрс | <i>Achnatherum inebrians</i> |
| 92. Юлдэн ерөндгөнө | <i>Vincetoxicum lanceolatum</i> |
| 93. Зайдуу ерхөнгө | <i>Eremopyrum distans</i> |
| 94. Тепентиновын жав | <i>Eucedanum terebinthaceum</i> |
| 95. Дагуур жавай | <i>Cimicifuga dahurica</i> |
| 96. Анхилзуурархуу жавхаа | <i>Ziziphora clinopodioides</i> |
| 97. Алтайн жамъянмядаг | <i>Trollius Altaicus</i> |
| 98. Ягаан жамъянмядаг | <i>Trollius Lilacinus</i> |
| 99. Арави задарга /ацхайрс/ | <i>Schismus arabicus</i> |
| 100. Зүүнгарын заяахай | <i>Ligularia soongarica</i> |
| 101. Долгиолог зираа | <i>Lactuca undulata</i> |
| 102. Этузнавчит зогдоргоно | <i>Clematis aethusifolia</i> |
| 103. Говийн зорлог /азар/ | <i>Calligonum gobicum</i> |
| 104. Голөвсдүү зорлог /улаан түлээ/ | <i>Calligonum junceum</i> |
| 105. Дөл зохимон | <i>Senecio flammeus</i> |
| 106. Өргөний зохимон | <i>Senecio argunensis</i> |
| 107. Яваны зулзган цагаан | <i>Oenanthe javanica</i> |
| 108. Прежевальскийн зурман сүүл | <i>Puccinellia Przevalskyi</i> |
| 109. Гурвалсан зууч | <i>Cardamine Trifida</i> |
| 110. Том навчит зууч | <i>Cardamine macrophylla</i> |
| 111. Цагаан цэцэгт зууч | <i>Cardamine leucantha</i> |
| 112. Үндэслэмтгий зэгс | <i>Scirpus radicans</i> |
| 113. Чөдөр зэллэг цэцэг | <i>Calystegia hederacea</i> |
| 114. Мартагдсан зэллэг цэцэг | <i>Calustegia subvolubilis</i> |
| 115. Гөлгөр ивэргэнэ | <i>Herniaria glabra</i> |
| 116. Эгэл идрээ | <i>Cichorium intybus</i> |
| 117. Эгэл исрэг | <i>Oxalis acetosella</i> |
| 118. Гурвалжин их зул | <i>Synurus deltiodes</i> |
| 119. Зөөлөн лавай | <i>Asterothamnus molliusculus</i> |
| 120. Үнэгэн сүүлхэй лидэр | <i>Sophoria alopecuroides</i> |
| 121. Ильиний лууль | <i>Chenopodium Iljinii</i> |
| 122. Цацаглаг лууль | <i>Chenopodium chinopodioides</i> |
| 123. Цайвардуу маалинга | <i>Linum pallescens</i> |
| 124. Эгэл маалинга | <i>Linum usitatissiraum</i> |
| 125. Маралхай марал цэцэг | <i>Tanacetum tanacetoides</i> |
| 126. Потанины махирс | <i>Lyciura Potaninii</i> |
| 127. Бөөн цэцэгт мийнхумс | <i>Nepeta densiflora</i> |
| 128. Нүцгэн мийнхумс | <i>Nepeta pannonica</i> |
| 129. Өлчир мүгэз | <i>Rhodiola algida</i> |
| 130. Туурсны наадгай | <i>Agrostemma githago</i> |

131. Манин намгалж	<i>Callitriche hermaphroditica</i>
132. Сайхны намуу	<i>Papaver saichanense</i>
133. Хангайн намуу	<i>Papaver changaica</i>
134. Атамантархуу нахимдаг	<i>Stenocoelium athamahtoides</i>
135. Ахар цомирлогт нил	<i>Viola brachysepala</i>
136. Патрэны нил	<i>Viola Patrinii</i>
137. Толгодын нил	<i>Viola collina</i>
138. Шоргор нил	<i>Viola acuminata</i>
139. Эгэл нишингэ	<i>Phragmites communis</i>
140. Зэгслиг нуудгай	<i>Crypsis schoenoides</i>
141. Сүүдрийн ойн цагаан	<i>Moehringia umbrosa</i>
142. Бохир ортууз	<i>Oxytropis sordida</i>
143. Горбуновын ортууз	<i>Oxytropis Gorbunovii</i>
144. Комаровын ортууз	<i>Oxytropis Komarovii</i>
145. Крыловын ортууз	<i>Oxytropis Krylovii</i>
146. Ладыгины ортууз	<i>Oxytropis Ladyginii</i>
147. Монгол ортууз	<i>Oxytropis mongolica</i>
148. Нарийн ортууз	<i>Oxytropis tenuis</i>
149. Сапожниковын ортууз	<i>Oxytropis Saposhnikovii</i>
150. Сутайн ортууз	<i>Oxytropis sutaica</i>
151. Сэлмэн ортууз	<i>Oxytropis falcate</i>
152. Хоёр цэцэгт ортууз	<i>Oxytropis diantha</i>
153. Арзгар оточ өвч	<i>Bunium capillifolium</i>
154. Цөлийн өнчинцэрэв	<i>Krylovia eremophila</i>
155. Шар саахуу цэцэг	<i>Nuphar Lutea</i>
156. Дэвүүр үрт сагай	<i>Pugionium pterocarpum</i>
157. Крыловын садагнагва	<i>Lophanthus Krylovii</i>
158. Бунгийн салаагана	<i>Chorispora Bungeana</i>
159. Бушийн сараана	<i>Lilium Buschianum</i>
160. Потанины сараана	<i>Lilium Potaninii</i>
161. Альбертын сарнай	<i>Rosa Albertii</i>
162. Бегерийн сарнай	<i>Rosa Beggeriana</i>
163. Хавтгай хатгуурт сарнай	<i>Rosa platyacantha</i>
164. Монгол сиймбий	<i>Batrachium mongolicum</i>
165. Кауфманы сиймбий	<i>Batrachium Kauffmanii</i>
166. Монгол сиймхийлэг	<i>Melandrium mongolicum</i>
167. Шивүүрт сондуут	<i>Acanthophyllum pungens</i>
168. Алтайн сонгино	<i>Allium altaicuro</i>
169. Максимовичийн сонгино	<i>Allium Maximoviczii</i>
170. Цагаан цэцэгт сонгино	<i>Allium galanthum</i>
171. Эмгэн сонгино	<i>Allium condensatum</i>
172. Сэвгүй сорвоо	<i>Calamagrostis inexpansa</i>
173. Турчаниновын сорвоо	<i>Calamagrostis Turczaninovii</i>
174. Нэлгэмэр сунараа	<i>Asperula humifusa</i>
175. Хадны сунараа	<i>Asperula saxicola</i>
176. Арзгар сухай	<i>Tamarix hispida</i>
177. Тагийн сүүт өвс	<i>Euphorbia alpina</i>
178. Сөөгөнцөр сүхлээ	<i>Securinega suffruticosa</i>
179. Комаровын таван салаа	<i>Plantago Komarovii</i>
180. Нам тайжийн жинс	<i>Echinops nanus</i>
181. Толгойрхог тайр	<i>Gypsophila cephalotes</i>
182. Грубовын тарваган шийр	<i>Thermopsis Grubovii</i>

- | | |
|---------------------------------|--------------------------------------|
| 183. Монгол тарваган шийр | <i>Thermopsis mongolica</i> |
| 184. Урт буурцагт тарваган шийр | <i>Thermopsis longicapra</i> |
| 185. Үсхий тарваган шийр | <i>Thermopsis hirsutissima</i> |
| 186. Ширэнгийн тарна | <i>Polygonum dumetorum</i> |
| 187. Днеприйн тахилж | <i>Middendorfia borysthenica</i> |
| 188. Том үрт тольт өвс | <i>Calutzkya macrocapra</i> |
| 189. Жинхэнэ том үрт | <i>Megacarpaea megalocarpa</i> |
| 190. Тагийн тосондой | <i>Pinguicula alpine</i> |
| 191. Монгол тост | <i>Brachanthemum mongolicum</i> |
| 192. Ледебурын төлөгч-өвс | <i>Achillea Ledebourii</i> |
| 193. Шоргор төлөгч-өвс | <i>Achillea acuminata</i> |
| 194. Таван судалт төмөрдээ | <i>Lathyrus quinquenervius</i> |
| 195. Нугын туйпланцар | <i>Phlomis pratensis</i> |
| 196. Халхын голын тунхуу | <i>Chrysanthemum chalchingolicum</i> |
| 197. Зүүнгарын тутаргалж | <i>Piptatherum songaricum</i> |
| 198. Жижиг жимст тэмээлж | <i>Camelina microcarpa</i> |
| 199. Нугын тэшиг | <i>Tretocarya pratensis</i> |
| 200. Анхил улаагана | <i>Ribes fragrans</i> |
| 201. Анхилуун улаагана | <i>Ribes graveolens</i> |
| 202. Арзаахай улаагана | <i>Ribes hispidulum</i> |
| 203. Элдэв үст улаагана | <i>Ribes heterotrichum</i> |
| 204. Анхил цагаан улалж | <i>Carex laliacea</i> |
| 205. Бага улалж | <i>Carex parva</i> |
| 206. Сэлэнгийн улалж | <i>Carex selengensis</i> |
| 207. Туулайн улалж | <i>Carex leporina</i> |
| 208. Цагаан улалж | <i>Carex alba</i> |
| 209. Еротерусын улбуудай | <i>Cortusa Brotheri</i> |
| 210. Дайрт унаган сүүл | <i>Schizachne callosa</i> |
| 211. Хөвдөг усан хөрш | <i>Potamogeton natans</i> |
| 212. Гялгар усан хөрш | <i>Potamogeton lucens</i> |
| 213. Мохоодуу усан хөрш | <i>Potamogeton obtusifolius</i> |
| 214. Уртхан усан хөрш | <i>Potamogeton praelongus</i> |
| 215. Бяцхан цэцэгт хависгана | <i>Scorzonera parviflora</i> |
| 216. Грубовын хависгана | <i>Scorzonera Grubovii</i> |
| 217. Маалингадуу хавтгалж | <i>Meniocus linifolius</i> |
| 218. Гоо хадаасгана | <i>Centaurium pulchellum</i> |
| 219. Лозелийн хамбий | <i>Sisymbrium Loeselii</i> |
| 220. Өргөсхөнт хамбий | <i>Sisymbrium subspinescens</i> |
| 221. Алтайн хамбил | <i>Draba altaica</i> |
| 222. Олон толгойт хамбил | <i>Draba multiceps</i> |
| 223. Сибирь хамбил | <i>Draba sibirica</i> |
| 224. Тэмээн харгана | <i>Caragana spinosa</i> |
| 225. Зарзаахай харцгана | <i>Hieracium echioides</i> |
| 226. Маалинган навчит хасалгана | <i>Diarthron linifolium</i> |
| 227. Ломоносовын хасзул | <i>Olgaea Lomonossovii</i> |
| 228. Налчгар хайрст хонгорзул | <i>Centaurea adpressa</i> |
| 229. Нүцгэн хонгорзул | <i>Centaurea calva</i> |
| 230. Хүрэн хонин зажлууур | <i>Linaria hepatica</i> |
| 231. Зэгэл хоногбудаа | <i>Setaria glauca</i> |
| 232. Хангайн хонхлой | <i>Adenophora changaica</i> |
| 233. Ерөндөг хорс | <i>Aconitum anthoroideum</i> |
| 234. Комаровын хорс | <i>Aconitum Komarovii</i> |

235. Говийн хотир	<i>Zygophyllum gobicum</i>
236. Кашгар хотир	<i>Zygophyllum kaschgaricum</i>
237. Орхигдмол хотир	<i>Zygophyllum neglectum</i>
238. Өдлөг хотир	<i>Zygophyllum sianum</i>
239. Өргөн навчит хотир	<i>Zygophyllum latifolium</i>
240. Шовгор хотир	<i>Zygophyllum micronatum</i>
241. Нохойн хэлэрхүү хотой	<i>Leonurus panzerioides</i>
242. Ижлийн хошоон	<i>Melilotus Wolgicus</i>
243. Цагаан хошоон	<i>Melilotus albus</i>
244. Мөлхөө хошоонгор	<i>Trifolium repens</i>
245. Потанийн хөвдөл	<i>Cetraria Potaninii</i>
246. Дагуур хөвөнцөр	<i>Epilobium dahuricum</i>
247. Үсхий хөвөнцөр	<i>Epilobium hirsutum</i>
248. Будгийн хөхөргөнө	<i>Isatis tinctoria</i>
249. Хавтагнавчит хөхтолгой	<i>Eryngium planum</i>
250. Барзгартүрүүт хувиланги	<i>Pedicularis dasystachys</i>
251. Цуулбар хувиланги	<i>Pedicularis fissa</i>
252. Шөмбөгөр хувиланги	<i>Pedicularis proboscidea</i>
253. Гажиг хулсанз	<i>Arundinella hirta</i>
254. Далжгар хумилж	<i>Alchemilla cyrtopleura</i>
255. Крыловын хумилж	<i>Alchemilla Krylovii</i>
256. Мөлгөр хумилж	<i>Alchemilla hebescens</i>
257. Павловын хумилж	<i>Alchemilla Pavlovii</i>
258. Хангайн хумилж	<i>Alchemilla changaica</i>
259. Сибирь хундгана	<i>Adorns sibirica</i>
260. Алтайн хунчир	<i>Astragalus altaicus</i>
261. Байтагийн хунчир	<i>Astragalus baitagensis</i>
262. Гранитовын хунчир	<i>Astragalus Granitovii</i>
263. Грегорийн хунчир	<i>Astragalus Gregorii</i>
264. Дани хунчир	<i>Astragalus danicus</i>
265. Дэрвээн хунчир	<i>Astragalus squarrosa</i>
266. Жимийн хунчир	<i>Astragalus dshinensis</i>
267. Курчум хунчир	<i>Astragalus Kurtschumensis</i>
268. Үнэгэн хунчир	<i>Astragalus vulpinus</i>
269. Хангайн хунчир	<i>Astragalus changaicus</i>
270. Хөөнгө буурцагт хунчир	<i>Astragalus physocarpus</i>
271. Ширүүн хунчир	<i>Astragalus scabrisetiformus</i>
272. Сормост хургалж	<i>Eragrostis cilianensis</i>
273. Хуурамч /марцны/ хурганчих	<i>Rumex pseudonatronatus</i>
274. Сибирь хуш	<i>Pinus sibirica</i>
275. Цөөн мөчирт хэрээннүдэн	<i>Asparagus oligoclonus</i>
276. Хөрөл хялгана	<i>Stipa consanguinea</i>
277. Улбар хялгана	<i>Stipa rubens</i>
278. Цөлийн хялгаст	<i>Strigosella africana</i>
279. Дэгнүүлтэйхэн цагаансуль	<i>Elymus praecaespitosus</i>
280. Өндөр цагаансуль	<i>Elymus excelsus</i>
281. Памир цагаансуль	<i>Elymus pamiricus</i>
282. Федченкогийн цагаансуль	<i>Elymus Fedtschenkoii</i>
283. Давсны цахилдаг	<i>Iris halophila</i>
284. Юнатовын цомбогоно	<i>Microstigma Junatovii</i>
285. Толбот цэгцээхэй	<i>Achyrophorus maculatus</i>
286. Ягаан цээнэ	<i>Paeonia anojala</i>

287. Арзгар жимст чоногоно	<i>Jurinae chaetocarpa</i>
288. Гендерсоны чонохор	<i>Poacynum Hendersonii</i>
289. Гашуувтар цэсэнцэр	<i>Solarium depilatum</i>
290. Бөхөөн чонын өргөс	<i>Carduus nutans</i>
291. Охоотын чөдөр өвс	<i>Atragene ochotensis</i>
292. Сибирь чулуудай	<i>Petrosimonia sibirica</i>
293. Литвиновын чулуудай	<i>Petrosimonia Litwinovii</i>
294. Ботуульхай шагшуурга	<i>Scholochloa festucacea</i>
295. Нүцгэн үрт шадалзай	<i>Rochelia leiocarpa</i>
296. Каспийн шарбударгана	<i>Kalidium caspicum</i>
297. Боргоцойлог шаргас	<i>Halocnemum atrobilaceum</i>
298. Алатав шиваантиг	<i>Pyrethrum alatavicum</i>
299. Гоё шиваантиг	<i>Pyrethrum pulchrum</i>
300. Хангайн шиваантиг	<i>Pyrethrum changaicum</i>
301. Саглагар шивэл	<i>Equisetum ramosissimum</i>
302. Цоохор шивэл	<i>Equisetum variegatum</i>
303. Нэг наст шивэрс	<i>Lycopodium annotinum</i>
304. Дагуур шимэрс	<i>Hedysarum dahuricum</i>
305. Бөхөгөр шогшрог	<i>Melica nutans</i>
306. Бүрсгэр шорно	<i>Frankenia pulverulenta</i>
307. Тэнгисийн шүдэлж	<i>Najas marina</i>
308. Их шүүдэргэнэ	<i>Chelidomum majus</i>
309. Нүцгэн шүхэргэнэ	<i>Cenolophium denudatum</i>
310. Монгол шээрэнгэ	<i>Silene Mongolica</i>
311. Жинхэнэ эвэр урт	<i>Carpoceras ceratocarpum</i>
312. Шивүүрт эмгэншилбэ	<i>Atraphaxis spinosa</i>
313. Нягт эмгэншилбэ	<i>Atraphaxis compacta</i>
314. Грубовын эрхэнцэг	<i>Torularia Grubovii</i>
315. Ганган юлт	<i>Goniolimon callicomum</i>
316. Говийн ялгуун цэцэг	<i>Cleome gobica</i>
317. Гэрцэгт ягаалзай	<i>Braya siliquosa</i>
(Засгийн газрын 2004 оны 165-р тогтоолоор 318-355 дугаарт зүйлүүд нэмэгдсэн)	
318. Азийн төлөгч өвс	<i>Achillea asiatica</i>
319. Хар хорс	<i>Aconitum turczaninowii</i>
320. Элсний цулхир	<i>Agriophyllum pungens</i>
321. Шулуун сонгино /гогод/	<i>Allium linaria</i>
322. Анхил сонгино /гогод/	<i>Allium odorum</i>
323. Шувуун хөл /сарвуун/	<i>Allium anisopodium</i>
324. Халиар сонгино	<i>Allium victorialis</i>
325. Цагаан шаваг	<i>Artemisia rutifolia</i>
326. Хар шаваг /сайхан шаваг/	<i>Artemisia santolinifolia</i>
327. Монгол хунчир	<i>Astragalus mongolicus</i>
328. Пагдгар бадаан	<i>Bergenia crassifolia</i>
329. Илдэн игүүшин	<i>Cacalia hastate</i>
330. Жижиг жимст сархи	<i>Camelina microcarpa</i>
331. Феддийн аргамжин цэцэг	<i>Cistanche feddina</i>
332. Цагаан яргай	<i>Cornus alba</i>
333. Час улаан долоогоно	<i>Crataegus sanquinea</i>
334. Нангиад зээргэнэ	<i>Ephedra sinica</i>
335. Сахлай дигд	<i>Gentiana barbata</i>
336. Урал чихэр өвс	<i>Glycyrrhiza uralensis</i>
337. Өргөст тошлой	<i>Grossularia acicularis</i>

338. Сэрхэн хөхөө цэцэг
339. Зайдуу өдлөг нүцэгнүр
340. Хадны нүцэгнүр
341. Сиймхий цэгцүүхэй
342. Шар цахилдаг
343. Потаниний цахилдаг
344. Алтайн далан хальс
345. Өрөл
346. Урт навчит балгана
347. Өргөст ортууз
348. Үнэгэн сүүлхэй тарна
349. Хурган мэхээр
350. Дэрэвгэр жиргэрүү
351. Байгаль гүүн хөх
352. Үлдэн могойн идээ
353. Сибирь ерөндгөнө
354. Эгэл бавран
355. Нарсны төрлийн модны үр

Хар (Lichenes)

1. Шоландрийн Асахин
2. Барановын бөөнгөнө
3. Каневскийн бутанцар
4. Торлог сархилж
5. Урт согсоргоно
6. Комаровын хөвдөл
7. Потанины хөвдөл
8. Тагийн хөвдөл
9. Хээрийн хөвдөл
10. Памирыы тэвгэнэ
11. Хангайн шигмээ

Замаг (Algae)

1. Эрхэн ватрахос Пермум
2. Ногоон дунелла
3. Кожовскийн кладофор
4. Монгол ооцистис
5. Монгол толифотрикс

Хөвд (Moss)

1. Ээмгэрхүү огстреми
2. Марциусын ореас
3. Козловын Птеригонеурум
4. Богино хүзүүт трематогон

Меер (Fingi)

1. Ширэгний гандмаг
2. Жинхэнэ онгол
3. Улиангарын таахай
4. Том цүлдмэг
5. Шилбэт эндоптихум

- Gymnadenia conopsea*
Gymnocarpium remotepinnatum
Gymnocarpium robertianum
Hypericum perfoliatum
Iris flavissima
Iris potanini
Lonicera altaica
Malus baccata
Murycaria longifolia
Oxytropis aciphylla
Polygonum alopecuroides
Polygonum viviparum
Saposhnikovia divaricata
Scutellaria baicalensis
Sedum aizoon
Vincetoxicum sibiricum
Pteridium aquilium
Pinus (Засгийн газрын 2015 оны 410-р тогтоолоор өөрчилсөн).

- Asahinea schklandero*
Rhizoplaca baranovii
Cladonia kanewckii
Lobaria retigera
Usnea longissima
Cetraria komarovii
Cetraria potanini
Cetraria alvarensis
Cetraria steppae
Squamaria pamirica
Aspicilia changaica

- Batrachospermum Moniliforme*
Dunaliella viridis
Cadophora Kozlovii
Oocystis mongolica
Tolypothrix mongolica

- Aongstroemia julacea*
Oreas martiana
Pterygoneurum Kozlivii
Trematogon brevicollus

- Lepista caespitosa*
Inonotus obliquus
Leccinum aurantiacum
Leucopaxillus giganteus
Endoptychum agaricoides

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 01-р сарын 11-ний өдөр

Дугаар 7

Улаанбаатар хот

ЖАГСААЛТ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (Ховор амьтны)

Амьтны аймгийн тухай хуулийн 7.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ховор амьтны жагсаалт”-ыг 1 дүгээр, “Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай /Засгийн газрын 2013-3-16-ны 93-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/.

2. Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журмыг мөрдүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай /Засгийн газрын 2013-3-16-ны 93-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Жагсаалт, үнэлгээ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг батлах тухай” Засгийн газрын 2001 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 264 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Л.ГАНСҮХ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ХОВОР АМЬТНЫ ЖАГСААЛТ (Монгол, латин нэрээр)

Нэг. Хөхтөн

1. Дорны сармаахай	<i>Vespertilio superans</i>
2. Ойн булга	<i>Martes zibellina</i>
3. Говийн шилүүс	<i>Lynx lynx isabellina</i>
4. Суусар булга	<i>Martes foina</i>
5. Эрээн хүрнэ	<i>Vormela peregusna</i>
6. Хүрэн баавгай	<i>Ursus arctos</i>
7. Хулан адуу	<i>Equus hemionus hemionus</i>
8. Зэгсний зэрлэг гахай	<i>Sus scrofa nigripes</i>
9. Халиун буга	<i>Cervus elaphus</i>
10. Хар сүүлтий	<i>Gazella subgutturosa</i>
11. Аргаль хонь	<i>Ovis ammon</i>
12. Янгир ямаа	<i>Capra sibirica</i>
13. Элсний тажигдаахай	<i>Sabbingotus kozlovi</i>
14. Соотон алагдаахай	<i>Euchoreutes naso</i>

Хоёр. Шувуу

1. Одой галуу	<i>Anser erythropus</i>
2. Байгалийн нугас	<i>Anas formosa</i>

3. Ундар шумбуур
4. Хан бүргэд
5. Ооч ёл
6. Азийн цууцил
7. Монгол хулан жороо
8. Хонин тоодог
9. Усны бух
10. Бичил одой бух
11. Зээрд дэглий
12. Манхин галуу
13. Гэээгт нугас
14. Хуруут хун
15. Хархираа тогоруу
16. Цагаан сүүлт нөмрөг
17. Алтайн хойлог
18. Зэрлэг гургуул
19. Загийн бор
20. Ойн шийхнүүхэй
21. Шагшуургын шатан сүүлт
22. Өгөөлэй шулганаа
23. Наран хөмрөг
24. Шар элэгт хөмрөг

Aythya nyroca
Aquila heliaca
Gypaetus barbatus
Limnodromus semipalmotus
Podoces hemdersoni
Otus tarda
Botaurus stellaris
Ixobrychus minutus
Ardea purpurea
Anser albifrons
Anas Falcata
Cygnus olor
Grus grus
Haliaeetus albicilla
Tetraogallus altaicus
Phasianus colchicus
Passer ammodendri
Anthus trivialis
Locustella luscinioides
Saxicola insignis
Emberiza yessoensis
Emberiza aureola

Гурав. Мөлхөгч

1. Говийн нүцгэн хуруут гүрвэл
2. Тойрмын хонин гүрвэл
3. Толбот могой гүрвэл
4. Тэмээн сүүл могой
5. Нарийн могой
6. Эгэл загалмайт могой

Cyrtapodion elongatus
Phrynosephalus helioscopus
Eremias arguta potanini
Eryx tataricus
Coluber spinalis
Vipera berus

Дөрөв. Хоёр нутагтан

1. Шивэр гүлмэр
2. Ногоон бах
3. Модны мэлхий
4. Дорнодын мэлхий

Salamandrella keyserlingii
Bufo danatensis
Hyla japonica
Rana chensinensis

Тав. Загас

1. Тул

Hucho taimen

Зургаа. Дугуй амтан

1. Номхон далайн могор

Lampetra japonica

Долоо. Шавьж

1. Төст царцаа
2. Эмэлжановын голио
3. Дамнуурга цэнхэр соно

Eclipophleps similis
Eulithoxenus emeljanovi
Aeshna juncea mongolica

4. Шүтээн цох
5. Дорнын заар эвэрт цох
6. Аполлон эрвээхэй
7. Эверсманны дэвүүр
8. Штуббендорфын дэвүүр
9. Фэб дэвүүр
10. Зүүн сибирийн дэвүүр
11. Махаон дэвүүр
12. Одон бүгэг эрвээхэй
13. Инжирийн шумбуур
14. Голт борын шумбуур
15. Бэр цэцэгч шумбуур
16. Хөвдний үхэр хэдгэнэ
17. Модестус үхэр хэдгэнэ
18. Спорадикус үхэр хэдгэнэ
19. Байгалийн үхэр хэдгэнэ
20. Ихэр ирлэг ялаа

Scarabaeus typhoon
Aromia moschata orientalis
Parnassius apollo
Parnassius eversmanni
Parnassius stubbendorfi
Parnassius phoebus
Parnassius tenedius
Parnassius mashaon
Macroglossum stellatarum
Deilephila elpenor
Sphinx ligustri
Hemaris tityus
Bombus muscorum
Bombus modestus
Bombus sporadicus
Bombus subbaicalensis
Satanas gigas

Найм. Хавч хэлбэртэн

1. Хар мөрний хавч
2. Голын хавч

Leander modestus
Cambaroides dauricus

Ес. Зөөлөн биетэн

1. Дагуурын сувдан хясаа
2. Дэлт танан хясаа
3. Сэлэнгийн танан хясаа
4. Монгол танан хясаа

Dahurinaia dahurica
Cristaria plicata
Anodonta sedakovi
Middendorffinaia mongolica

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 12-р сарын 05-ны өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

ЖАГСААЛТ, ҮНЭЛГЭЭ, ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ХУВЬ ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Амьтны аймгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Хөвөр амьтны жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт (ЗГ-ын 2012 оны 1 дүгээр сарын 11-ний 7 дугаар тогтоолоор 1 дүгээр хавсралт хүчингүй болсон), “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-г 2 дугаар хавсралт, “Агнуурын нөөц ашигласны төлбөр, агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хувь хэмжээ”-г 3 дугаар хавсралт, “Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг хэмжээ”-г 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай. (Энэ тогтоолын 4-р хавсралтад ЗГ-ын 2011-3-2-ны өдрийн 65-р тогтоол, 2016-11-23-ны өдрийн 155-р тогтоолоор тус тус өөрчлөлт орсон)

2. Ан амьтныг тэжээврээр үржүүлж эмийн болон бусад түүхий эд бэлтгэх зориулалтаар ашиглах журмыг 2001 онд багтаан баталж мөрдүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболдод үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтад зааснаас бусад ан амьтныг агнах, барих, гадаадад гаргах төлбөр болон хураамжийн хувь хэмжээг тухайн амьтны тархац, экологи-эдийн засгийн ач холбогдол, агнах, барих зориулалтыг харгалзан тухай бүр тогтоож байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Жагсаалт, үнэлгээ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг батлах тухай” Засгийн газрын 1995 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 152 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад зарим өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 118 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Байгаль орчны сайд

У.БАРСБОЛД

**ГАДААДЫН ИРГЭНД ТУСГАЙ ТӨЛБӨРТЭЙГЭЭР АГНУУЛАХ АГНУУРЫН АМЬТНЫ
ОЛЗВОРЫН ЖИШИГ ҮНЭ, ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

/тооцооны нэгж/ (ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон)

	Ан амьтны нэр	олзворын жишиг үнэ	төлбөр	хураамж
Нэг. Хөхтөн				
1	Угалз а/ алтайн	24000,0	17000,0	4000,0
	б/ говийн	14000,0	10000,0	2000,0
2	Тэх а/ алтайн /ЗГ-ын 2011 оны 65-р тогтоолоор өөрчлөлт орсон/ /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	3000,0	2100,0	500,0
	б/ говийн /ЗГ-ын 2011 оны 65-р тогтоолоор өөрчлөлт орсон/ /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	2600,0	1850,0	450,0
3	Халиун буга /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	1600,0	1000,0	340,0
4	Хар сүүлтий	500,0	325,0	125,0
5	Цагаан зээр /ЗГ-ын 2011 оны 65-р тогтоолоор өөрчлөлт орсон/ /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	250,0	160,0	60,0
6	Бор гөрөөс /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	700,0	500,0	160,0
7	Зэрлэг гахай /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	320,0	200,0	70,0
8	Баавгай	2500,0	1600,0	650,0
9	Чоно	250,0	160,0	65,0
10	Шилүүс	2000,0	1300,0	500,0
11	Үнэг	80,0	50,0	20,0

12	Хярс	60,0	40,0	15,0
13	Дорго	80,0	50,0	20,0
14	Нохой зээх	300,0	200,0	70,0
15	Мануул	80,0	50,0	20,0
Хоёр. Шувуу				
16	Хур	100,0	65,0	25,0
17	Сойр	120,0	75,0	30,0
18	Ой хээрийн бусад агнуурын шувуу /ЗГ-ын 2011 оны 65-р тогтоолоор өөрчлөлт орсон/ /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	20,0	12,0	5,0
19	Галуу	10,0	6,0	2,0
20	Нугас /ЗГ-ын 2011 оны 65-р тогтоолоор өөрчлөлт орсон/ /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	18,0	10,0	6,0
Гурав. Загас				
21	Тул: бариад усанд нь эргүүлж тавих /ЗГ-ын 2011 оны 65-р тогтоолоор өөрчлөлт орсон/ /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	150,0	100,0	30,0
22	Тулын олзворыг авч гарах бол: /ЗГ-ын 2011 оны 65-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/			
	а/ урт нь 1м хүртэл	100,0	70,0	20,0
	б/ урт нь 1м-ээс дээш	200,0	130,0	50,0
23	Бусад агнуурын загас /ЗГ-ын 2011 оны 65-р тогтоолоор өөрчлөлт орсон/ /ЗГ-ын 2016 оны 155-р тогтоолоор өөрчлөлт орсон/	24,0	14,0	6,0

Жич: Тусгай зориулалтаар ус, намаг, ой, хээрийн агнуурын шувууг агнах, барихад нэг удаад зөвшөөрөгдөх тоо 20 хүртэл, агнуурын бусад загасны тоо 30 хүртэл байхаар тооцно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 01-р сарын 25-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

ҮНЭЛГЭЭ, ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-г 1 дүгээр, “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Үнэлгээ, хураамжийн хувь хэмжээ батлах тухай” Засгийн газрын 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 248 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Л.ГАНСҮХ

АН АМЬТНЫ ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

Нэг. Хөхтөн /мян.төгрөгөөр/

№	Амьтны нэр	Латин нэр	Экологи-эдийн засгийн үнэлгээ	
			эр	эм
I. Туруутан				
1	Халиун буга	<i>Cervus elaphus</i>	6600.00	7500.00
2	Хүдэр	<i>Moschus moschiferus</i>	3000.00	3500.00
3	Шивэр хандгай Мөрний хандгай	<i>Alces alces pfizenmayeri</i> <i>Alces alces cameloides</i>	10000.00	12000.00
4	Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	11000.00	13000.00
5	Янгир ямаа	<i>Capra sibirica</i>	2700.00	3100.00
6	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	330.00	400.00
7	Цаа буга	<i>Rangifer tarandus valentinae</i>	5000.00	6000.00
8	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	500.00	550.00
9	Хар сүүлтий	<i>Gazella subgutturosa</i>	1700.00	2000.00
10	Монгол бөхөн Соргог бөхөн	<i>Saiga tatarica mongolica</i> <i>Saiga tatarica tatarica</i>	2000.00	2200.00
11	Ойн зэрлэг гахай	<i>Sus scrofa sibiricus</i>	700.00	800.00
12	Зэгсний зэрлэг гахай	<i>Sus scrofa nigripes</i>	2900.00	3300.00
II. Туурайтан				
13	Хулан адуу	<i>Equus hemionus</i>	9700.00	11000.00
14	Тахь	<i>Equus przewalski</i>	11000.00	13000.00
III. Саарьтан				
15	Хавтгай	<i>Camelus bactrianus ferus</i>	19000.00	21300.00
IV. Махчтан				
16	Саарал чоно	<i>Canis lupus</i>	510.00	600.00
17	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	110.00	130.00
18	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	100.00	120.00
19	Нохой элбинх	<i>Nyctereutes procyonoides</i>	260.00	300.00

20	Хүрэн баавгай	<i>Ursus arctos</i>	6500.00	7500.00
21	Мазаалай	<i>Ursus arctos gobiensis</i>	19000.00	22000.00
22	Ойн булга	<i>Martes zibellina</i>	450.00	510.00
23	Суусар булга	<i>Martes foina</i>	470.00	530.00
24	Нохой зээх	<i>Gulo gulo</i>	730.00	840.00
25	Ойн үен	<i>Mustela sibirica</i>	23.00	26.00
26	Солонго үен	<i>Mustela altaica</i>	21.00	24.00
27	Цагаан үен	<i>Mustela erminea</i>	21.00	24.00
28	Хотны үен	<i>Mustela nivalis</i>	21.00	24.00
29	Хүрэн үен	<i>Mustela eversmanni</i>	21.00	24.00
30	Усны үен	<i>Mustela vison</i>	25.00	30.00
31	Эрээн хүрнэ	<i>Vormela peregusna</i>	60.00	70.00
32	Халздай дорго	<i>Meles meles</i>	510.00	600.00
33	Голын халиу	<i>Lutra lutra</i>	2400.00	2700.00
34	Цоохор ирвэс	<i>Uncia uncia</i>	11200.00	13000.00
35	Шүлүүс мий	<i>Lynx lynx</i>	2300.00	2600.00
36	Говийн шүлүүс мий	<i>Lynx lynx isabellina</i>	2600.00	3000.00
37	Мануул мий	<i>Otocolobus manul</i>	440.00	500.00
38	Цоохондой мий	<i>Felis silvestris</i>	850.00	950.00
V.Туулайтан				
39	Бор туулай	<i>Lepus tolai</i>	35.00	40.00
40	Чандага туулай	<i>Lepus timidus</i>	40.00	45.00
VI.Мэрэгчтэн				
41	Бараан хэрэм	<i>Sciurus vulgaris</i>	32.00	36.00
42	Замба жирх	<i>Tamias sibiricus</i>	4.00	5.00
43	Алтайн тарвага	<i>Marmota baibacina</i>	180.00	210.00
44	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	170.00	200.00
45	Төв азийн минж	<i>Castor fiber birulai</i>	1300.00	1500.00
46	Заарт ондоотор	<i>Ondatra zibethicus</i>	120.00	130.00

Хоёр. Шувуу /мян.төгрөгөөр/

№	Шувууны нэр	Шувууны латин нэр	Экологи-эдийн засгийн үнэлгээ
I.Усны шувуу			
1	Улаангүеэ гахуун	<i>Gavia stellata</i>	30.00
2	Хилэнгүеэ гахуун	<i>Gavia arctica</i>	37.00
3	Халтар шунгуур	<i>Podiceps nigricollis</i>	7.00
4	Ухаа шунгуур	<i>Podiceps auritus</i>	8.00
5	Буурал шунгуур	<i>Podiceps grisegena</i>	12.00
6	Отгот шунгуур	<i>Podiceps cristatus</i>	18.00
7	Хурган шунгуур	<i>Podiceps ruficollis</i>	5.00
8	Борцгор хотон	<i>Pelecanus crispus</i>	6570.00
9	Тураг гогой	<i>Phalacrocorax carbo</i>	31.00
10	Усны бухшувуу	<i>Botaurus stellaris</i>	18.00
11	Бичил одойбух	<i>Ixobrychus minitus</i>	5.00
12	Бөртөт одойбух	<i>Ixobrychus eurhythmus</i>	5.00
13	Цагаан дэвлээ	<i>Ardeola bacchus</i>	9.00
14	Ногоовор зашин	<i>Nycticorax nycticorax</i>	14.00
15	Цасч тэглэй	<i>Egretta alba</i>	25.00
16	Хурган тэглэй	<i>Egretta garzetta</i>	10.00
17	Хөх дэглий	<i>Ardea cinerea</i>	19.00
18	Зээрд дэглий	<i>Ardea purpurea</i>	25.00
19	Цагаан халбагант	<i>Platalea leucorodia</i>	110.00
20	Дорнын өрөвтас	<i>Ciconia boyciana</i>	380.00
21	Хар өрөвтас	<i>Ciconia nigra</i>	204.00
22	Ягаан нал	<i>Phoenicopterus roseus</i>	84.00
23	Бор галуу	<i>Anser anser</i>	58.00
24	Буурал галуу	<i>Anser fabalis</i>	61.00
25	Манхин галуу	<i>Anser albifrons</i>	77.00
26	Одой галуу	<i>Anser erythropus</i>	119.00
27	Хээрийн галуу	<i>Anser indicus</i>	110.00
28	Хошуу галуу	<i>Anser cygnoides</i>	211.00
29	Гангар хун	<i>Cygnus cygnus</i>	376.00
30	Хуруут хун	<i>Cygnus olor</i>	480.00

31	Гунгар хун	<i>Cygnus bewickii</i>	125.00
32	Модны анхир	<i>Dendrocygna javanica</i>	27.00
33	Хондон ангир	<i>Tadorna ferruginea</i>	17.00
34	Анхидал ангир	<i>Tadorna tadorna</i>	20.00
35	Зэрлэг нугас	<i>Anas platyrhynchos</i>	23.00
36	Зэрлэгшир нугас	<i>Anas poecilorhynchos</i>	20.00
37	Ногоохон нугас	<i>Anas crecca</i>	7.00
38	Байгалийн нугас	<i>Anas formosa</i>	143.00
39	Гэээгт нугас	<i>Anas falcata</i>	13.00
40	Бор нугас	<i>Anas strepera</i>	16.00
41	Зээрд нугас	<i>Anas penelope</i>	13.00
42	Шовтгоралаг нугас	<i>Anas acuta</i>	16.00
43	Цагаанхөмсөгт нугас	<i>Anas guerguedula</i>	9.00
44	Халбага нугас	<i>Anas clypeata</i>	15.00
45	Мандир уранхажин	<i>Aix galericulata</i>	30.00
46	Улаанхушуу биваан	<i>Netta rufina</i>	15.00
47	Улаанхүзүү шумбуур	<i>Aythya ferina</i>	16.00
48	Ундар шумбуур	<i>Aythya nyroca</i>	12.00
49	Ухаа шумбуур	<i>Aythya baeri</i>	50.00
50	Гэээгт шумбуур	<i>Aythya fuligula</i>	17.00
51	Тэнгисийн шумбуур	<i>Aythya marila</i>	11.00
52	Хотгуужин чөрх	<i>Histrionicus histrionicus</i>	12.00
53	Мөнгөлөг шунгаахай	<i>Clangula hyemalis</i>	14.00
54	Алаг шунгаач	<i>Bucephala clangula</i>	16.00
55	Тольт монхдой	<i>Melanitta deglandi</i>	24.00
56	Цагаантолгой ямаансүүлт	<i>Oxyura leucocephala</i>	90.00
57	Цахиур бохио	<i>Mergus albellus</i>	10.00
58	Сэвгэр бохио	<i>Mergus serrator</i>	16.00
59	Хумхин бохио	<i>Mergus merganser</i>	20.00
II. Махчин шувуу			
60	Загасч явлаг	<i>Pandion haliaetus</i>	238.00
61	Балч гоорбис	<i>Pernis apivorus</i>	80.00
62	Согсоот гоорбис	<i>Pernis ptilorhyncus</i>	84.00

63	Сохор элээ	<i>Milvus migrans</i>	78.00
64	Саарал хулд	<i>Circus cyaneus</i>	36.00
65	Хээрийн хулд	<i>Circus macrourus</i>	77.00
66	Нугын хулд	<i>Circus pygargus</i>	51.00
67	Алаг хулд	<i>Circus melanoleucus</i>	36.00
68	Намгийн хулд	<i>Circus aeruginosus</i>	40.00
69	Дорнын хулд	<i>Circus spilonotus</i>	42.00
70	Үлэг харцага	<i>Accipiter gentilis</i>	86.00
71	Морин харцага	<i>Accipiter nisus</i>	23.00
72	Үүрсээ харцага	<i>Accipiter badius</i>	22.00
73	Шунгаач харцага	<i>Accipiter gularis</i>	15.00
74	Тарлан сар	<i>Buteo lagopus</i>	70.00
75	Шилийн сар	<i>Buteo hemilasius</i>	84.00
76	Талын сар	<i>Buteo rufinus</i>	74.00
77	Ойн сар	<i>Buteo buteo</i>	67.00
78	Саржуу харцгай	<i>Butastur indicus</i>	22.00
79	Могойч загалай	<i>Circaetus gallicus</i>	140.00
80	Уулын согсоотбүргэд	<i>Spizaetus nipalensis</i>	220.00
81	Бахим бүргэдэй	<i>Hieraaetus pennatus</i>	64.00
82	Харсун бүргэдэй	<i>Hieraaetus fasciatus</i>	58.00
83	Тарважи бүргэд	<i>Aquila nipalensis</i>	253.00
84	Бор бүргэд	<i>Aquila clanga</i>	353.00
85	Хан бүргэд	<i>Aquila heliaca</i>	513.00
86	Цармын бүргэд	<i>Aquila chrysaetos</i>	402.00
87	Усны нөмрөгбүргэд	<i>Haliaeetus leucoryphus</i>	525.00
88	Цагаан сүүл нөмрөг бүргэд	<i>Haliaeetus albicilla</i>	1052.00
89	Ооч ёл	<i>Gypaetus barbatus</i>	540.00
90	Дэлт ёлон	<i>Neophron percnopterus</i>	190.00
91	Нөмрөг тас	<i>Aegypius monachus</i>	972.00
92	Ухаа хажир	<i>Gyps fulvus</i>	540.00
93	Хималайн хажир	<i>Gyps himalayensis</i>	807.00
94	Цагаан шонхор	<i>Falco rusticolus</i>	322.00
95	Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>	16000.00

96	Шилийн шонхор	<i>Falco pelegrinoides</i>	66.00
97	Эгэл шонхор	<i>Falco peregrinus</i>	62.00
98	Шууман шонхор	<i>Falco subbuteo</i>	23.00
99	Хайргууна шонхор	<i>Falco columbarius</i>	22.00
100	Турамтай шонхор	<i>Falco vespertinus</i>	20.00
101	Амарын шонхор	<i>Falco amurensis</i>	28.00
102	Зээрд шонхор	<i>Falco naumanni</i>	37.00
103	Начин шонхор	<i>Falco tinnunculus</i>	21.00
III. Тахиатан			
104	Цагаан ахууна	<i>Lagopus lagopus</i>	17.00
105	Цэвдгийн ахууна	<i>Lagopus mutus</i>	17.00
106	Хар хур	<i>Lyrurus tetrix</i>	36.00
107	Эгэл сойр	<i>Tetrao urogallus</i>	86.00
108	Нургийн сойр	<i>Tetrao parvirostris</i>	74.00
109	Шивэр хөтүү	<i>Tetrastes bonasia</i>	10.00
110	Алтайн хойлог	<i>Tetraogallus altaicus</i>	130.00
111	Эрээнхавирга хахилаг	<i>Alectoris chukar</i>	14.00
112	Дагуур ятуу	<i>Perdix dauurica</i>	7.00
113	Эгэл бөднө	<i>Coturnix coturnix</i>	3.00
114	Наран бөднө	<i>Coturnix japonica</i>	3.00
115	Зэрлэг гургуул	<i>Phasianus colchicus</i>	73.00
116	Гурван шивнүүрт	<i>Turnix tanki</i>	2.00
117	Алаг тогоруу	<i>Grus japonensis</i>	733.00
118	Цагаан тогоруу	<i>Grus leucogeranus</i>	771.00
119	Хархираа тогоруу	<i>Grus grus</i>	220.00
120	Цэн тогоруу	<i>Grus vipio</i>	680.00
121	Хар тогоруу	<i>Grus monacha</i>	610.00
122	Өвөгт тогоруу	<i>Grus virgo</i>	112.00
123	Усны түнжүүр	<i>Rallus aquaticus</i>	4.00
124	Цагааномруут түнжүүхэй	<i>Amauornis phoenicurus</i>	3.00
125	Тоодон түнжгэр	<i>Porzana porzana</i>	2.00
126	Оодон түнжгэр	<i>Porzana pusilla</i>	2.00
127	Бичилхэн түнжгэр	<i>Porzana exquisita</i>	3.00

128	Явган түнжин	<i>Crex crex</i>	4.00
129	Хажилгат ханчир	<i>Gallinula chloropus</i>	6.00
130	Халзан түнжүү	<i>Fulica atra</i>	15.00
131	Хонин тоодог	<i>Otis tarda</i>	465.00
132	Жороо тоодог	<i>Chlamydotis undulata</i>	210.00
133	Өнгөт хараалжир	<i>Rostratula benghalensis</i>	5.00
134	Буурал сүвээцагаан	<i>Pluvialis squatarola</i>	4.00
135	Азийн сүвээцагаан	<i>Pluvialis fulva</i>	3.00
136	Хүзүүвчит хиазат	<i>Charadrius hiaticula</i>	3.00
137	Нарийн хиазат	<i>Charadrius dubius</i>	2.00
138	Зэвэн хиазат	<i>Charadrius leschenaultii</i>	2.00
139	Монгол хиазат	<i>Charadrius mongolus</i>	2.00
140	Дорнын хиазат	<i>Charadrius veredus</i>	3.00
141	Тэнгисийн хиазат	<i>Charadrius alexandrinus</i>	2.00
142	Урианхайн цагаанхиазат	<i>Eudromias morinellus</i>	2.00
143	Хээрийн хавтгалж	<i>Chettusia gregaria</i>	4.00
144	Умардын хавтгаалж	<i>Vanellus vanellus</i>	4.00
145	Саарал зуунхурга	<i>Microsarcops cinereus</i>	5.00
146	Алаг хайргач	<i>Arenaria interpres</i>	3.00
147	Эгэл хилэнжигүүр	<i>Himantopus himantopus</i>	5.00
148	Алаг ээтэн	<i>Recurvirostra avosetta</i>	6.00
149	Сүүлцагаан хөгчүү	<i>Tringa ochropus</i>	2.00
150	Шугуйн хөгчүү	<i>Tringa glareola</i>	9.00
151	Үхэр хөгчүү	<i>Tringa nebularia</i>	4.00
152	Улаанхөлт хөгчүү	<i>Tringa totanus</i>	3.00
153	Хар хөгчүү	<i>Tringa erythropus</i>	3.00
154	Бүрдний хөгчүү	<i>Tringa stagnatilis</i>	2.00
155	Буурал хөгчүүхэй	<i>Heteroscelus brevipes</i>	3.00
156	Цэлдэн хөгчүүхэй	<i>Heteroscelus incana</i>	3.00
157	Эгэл хайргынхөгчүү	<i>Actitis hypoleucos</i>	2.00
158	Матигар хөгчүүлэг	<i>Xenus cinereus</i>	2.00
159	Нарийн сэлээхэй	<i>Phalaropus lobatus</i>	2.00
160	Улаан сэлээхэй	<i>Phalaropus fulicarius</i>	2.00

161	Ноцоо ноололдой	<i>Phylomachus pugnax</i>	3.00
162	Одой элсэг	<i>Calidris minuta</i>	2.00
163	Шартүрүүт элсэг	<i>Calidris ruficollis</i>	2.00
164	Савар элсэг	<i>Calidris subminuta</i>	2.00
165	Темминскийн элсэг	<i>Calidris temminckii</i>	1.00
166	Хадуур элсэг	<i>Calidris ferruginea</i>	2.00
167	Хар элсэг	<i>Calidris alpina</i>	2.00
168	Сүүл элсэг	<i>Calidris acuminata</i>	2.00
169	Гурвалж элсэг	<i>Calidris alba</i>	2.00
170	Шармаг элсэг	<i>Calidris canutus</i>	2.00
171	Сямби шалчиг	<i>Limicola falcinellus</i>	3.00
172	Бичил салалж	<i>Lymnocyrtus minimus</i>	3.00
173	Шөвгөн хараалж	<i>Gallinago gallinago</i>	4.00
174	Шугуйн хараалж	<i>Gallinago megala</i>	4.00
175	Замбын хараалж	<i>Gallinago stenura</i>	4.00
176	Өнчин хараалж	<i>Gallinago solitaria</i>	4.00
177	Буурал хомноот	<i>Scolopax rusticola</i>	6.00
178	Бичилхэн тутгалжин	<i>Numenius minutus</i>	5.00
179	Морин тутгалжин	<i>Numenius arquata</i>	4.00
180	Мадагаскар тутгалжин	<i>Numenius madagascariensis</i>	5.00
181	Бэсрэг тутгалжин	<i>Numenius phaeopus</i>	4.00
182	Морин цууцал	<i>Limosa limosa</i>	5.00
183	Хурган цууцал	<i>Limosa lapponica</i>	4.00
184	Хараалжин цууцил	<i>Limnodromus scolopaceus</i>	4.00
185	Азийн цууцил	<i>Limnodromus semipalmatus</i>	18.00
186	Ухаа хөгт	<i>Glareola maldivarum</i>	3.00
187	Бэсрэг хайлгана	<i>Stercorarius pomarinus</i>	11.00
188	Годон хайлгана	<i>Stercorarius parasiticus</i>	4.00
189	Итэлгэн цахлай	<i>Larus ichthyaetus</i>	58.00
190	Реликт цахлай	<i>Larus relictus</i>	171.00
191	Хурган цахлай	<i>Larus minutus</i>	4.00
192	Хүрэнтолгойт цахлай	<i>Larus ridibundus</i>	4.00
193	Бортолгойт цахлай	<i>Larus brunnicephalus</i>	5.00

194	Шөвгөр цахлай	<i>Larus genei</i>	7.00
195	Мөнгөлөг цахлай	<i>Larus argentatus</i>	12.00
196	Үхэр цахлай	<i>Larus cachinnans</i>	20.00
197	Мөсний цахлай	<i>Larus hyperboreus</i>	19.00
198	Харсүүлт цахлай	<i>Larus crassirostris</i>	9.00
199	Үүлэн цахлай	<i>Larus canus</i>	8.00
200	Гурванхуруут захлай	<i>Rissa tridactyla</i>	7.00
201	Хүзүүвчит ягаандай	<i>Rhodostethia rosea</i>	6.00
202	Хилэн хараалзай	<i>Chlidonias niger</i>	2.00
203	Буурал хараалзай	<i>Chlidonias leucopterus</i>	2.00
204	Цагааншанаа хараалзай	<i>Chlidonias hybridus</i>	3.00
205	Бахим амуулай	<i>Gelochelidon nilotica</i>	4.00
206	Морин шунгуулай	<i>Hydroprogne caspia</i>	10.00
207	Эгэл хараалай	<i>Sterna hirundo</i>	3.00
208	Хурган хараалай	<i>Sterna albifrons</i>	2.00
IV.Тагтаатан			
209	Монгол ногтруу	<i>Syrhaptus paradoxus</i>	4.00
210	Ойн тагтаа	<i>Columba palumbus</i>	7.00
211	Хүнхэл тагтаа	<i>Columba oenas</i>	5.00
212	Хүрэвтэр тагтаа	<i>Columba eversmanni</i>	5.00
213	Хөхвөр тагтаа	<i>Columba livia</i>	4.00
214	Хадны тагтаа	<i>Columba rupestris</i>	4.00
215	Буулгат хүүрэгэнэ	<i>Streptopelia decaocto</i>	4.00
216	Өрнийн хүүрэгэнэ	<i>Streptopelia turtur</i>	4.00
217	Дорнын хүүрэгэнэ	<i>Streptopelia orientalis</i>	3.00
218	Өөдсөн хүүрэгэнэ	<i>Streptopelia senegalensis</i>	4.00
219	Эгэл хөхөө	<i>Cuculus canorus</i>	2.00
220	Ханамал хөхөө	<i>Cuculus saturatus</i>	2.00
221	Хурган хөхөө	<i>Cuculus poliocephalus</i>	2.00
222	Жагар хөхөө	<i>Cuculus micropterus</i>	2.00
223	Цагаан уульж	<i>Nyctea scandiaca</i>	280.00
224	Эгэл шаршувуу	<i>Bubo bubo</i>	454.00
225	Соотон гуйванга	<i>Asio otus</i>	50.00

226	Хулгар гуйванга	<i>Asio flammeus</i>	56.00
227	Ердийн орволго	<i>Otus scops</i>	15.00
228	Ойн орволго	<i>Otus sunia</i>	15.00
229	Савагт ариан	<i>Aegolius funereus</i>	32.00
230	Хотны бүгээхэй	<i>Athene noctua</i>	28.00
231	Буслаг сүлиг	<i>Glaucidium passerinum</i>	12.00
232	Харсуун бэгбаатар	<i>Surnia ulula</i>	51.00
233	Хув ууль	<i>Strix uralensis</i>	148.00
234	Угалзан ууль	<i>Strix nebulosa</i>	148.00
V.Бор шувуутан			
235	Монгол хуланжороо	<i>Podoces hendersoni</i>	130.00
236	Наран энхэтбязлуухай	<i>Bombycilla japonica</i>	10.00
237	Наран ажиндар	<i>Megalurus pryeri</i>	10.00
238	Өгөөлэй шулганаа	<i>Saxicola insignis</i>	42.00
239	Бахимхушуу хурагч	<i>Paradoxornis heudei</i>	30.00
240	Бургасны ураншувуу	<i>Remiz pendulinus</i>	7.00
241	Янковскийн хөмрөг	<i>Emberiza jankowskii</i>	10.00
242	Наран хөмрөг	<i>Emberiza yessoensis</i>	11.00

Гурав. Загас /мян.төгрөгөөр/

№	Загасны нэр	Латин нэр	Экологи-эдийн засгийн үнэлгээ
1	Амарын хилэм	<i>Asipenser schrenckii</i>	1330.00
2	Шивэр хилэм	<i>Asipenser baerii baicalensis</i>	700.00
3	Тул	<i>Hucho taimen</i>	211.00
4	Зэвгэ	<i>Brachymystax lenok</i>	17.00
5	Цагаан загас	<i>Coregonus pidschian</i>	20.00
6	Цагаан хадар	<i>Coregonus chadary</i>	13.00
7	Байгалийн омоль	<i>Coreginus migratorius</i>	19.00
8	Пельд	<i>Coregonus peled</i>	14.00
9	Монгол хадран	<i>Thymallus brevirostris</i>	5.00
10	Хөвсгөл хадран	<i>Thymallus nigrescens</i>	5.00
11	Сибирь хадран	<i>Thymallus arcticus</i>	4.00
12	Амарын хадран	<i>Thymallus grubii</i>	4.00

13	Цурхай	<i>Esox lucius</i>	20.00
14	Амарын цурхай	<i>Esox reicherti</i>	8.00
15	Улаан нүдэн	<i>Rutilus rutilus</i>	5.00
16	Байгалийн сугас	<i>Leuciscus baicalensis</i>	2.00
17	Зүүнгарын сугас	<i>Leuciscus dzungaricus</i>	3.00
18	Бух сугас	<i>Leuciscus idus</i>	9.00
19	Амарын сугас	<i>Leuciscus waleckii</i>	2.00
20	Алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i>	7.00
21	Нохой сугас	<i>Oreoleuciscus angusticephalus</i>	43.00
22	Улаан живэрт	<i>Pseudaspius leptcephalus</i>	10.00
23	Үхэрдэй	<i>Tinca tinca</i>	11.00
24	Морин загас	<i>Hemibarbus labeo</i>	3.00
25	Толбот морин загас	<i>Hemibarbus maculatus</i>	3.00
26	Цагаан догтор	<i>Erythroculter erythropterus</i>	67.00
27	Улаан далбаат	<i>Chanodichthys mongolicus</i>	12.00
28	Өлгөр цагаан	<i>Culter alburnus</i>	12.00
29	Алтлаг хэлтэг	<i>Carassius carassius</i>	9.00
30	Мөнгөлөг хэлтэг	<i>Carassius gibelio</i>	6.00
31	Булуу цагаан	<i>Cyprinus carpio</i>	19.00
32	Цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	9.00
33	Гутаар	<i>Lota lota</i>	13.00
34	Алгана	<i>Perca fluviatilis</i>	5.00
35	Амарын хөөлөнхэй	<i>Pseudorasbora parva</i>	4.00
36	Зантаахай загас	<i>Mesocottus haitej</i>	64.00

**АН АМЬТНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, АН АМЬТАН АГНАХ,
БАРИХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

Нэг. Хөхтөн /мян.төгрөгөөр/

№	Ан амьтны нэр			Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ		Ахуйн зориулалтаар ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ
	Монголоор	Англиар	Хүйс	Үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих	Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих	
1	Халиун буга	<i>Cervus elaphus</i>	эр		1320.0	
			эм		1500.0	
2	Хүдэр	<i>Moschus moschiferus</i>	эр		600.0	
			эм		700.0	
3	Шивэр хандгай Мөрний хандгай	<i>Alces alces pfizenmayeri</i> <i>Alces alces cameloides</i>	эр		2000.0	
			эм		2400.0	
4	Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	эр		2200.0	
			эм		2600.0	
5	Янгир ямаа	<i>Capra sibirica</i>	эр		540.0	
			эм		620.0	
6	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	эр		66.0	66.0
			эм		80.0	80.0
7	Цаа буга	<i>Rangifer tarandus valentinae</i>	эр		1000.0	
			эм		1200.0	
8	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	эр	100.0	100.0	100.0
			эм	110.0	110.0	110.0
9	Хар сүүлтий	<i>Gazella subgutturosa</i>	эр		340.0	
			эм		400.0	
10	Монгол бөхөн Соргог бөхөн	<i>Saiga tatarica mongolica</i> <i>Saiga tatarica tatarica</i>	эр		400.0	
			эм		440.0	
11	Ойн зэрлэг гахай	<i>Sus scrofa sibiricus</i>	эр		140.0	140.0
			эм		160.0	160.0
12	Зэгсний зэрлэг гахай	<i>Sus scrofa nigripes</i>	эр		580.0	
			эм		660.0	

13	Хулан адуу	<i>Equus hemionus</i>	эр		1940.0	
			эм		2200.0	
14	Тахь	<i>Equus przewalski</i>	эр		2200.0	
			эм		2600.0	
15	Хавтгай	<i>Camelus bactrianus ferus</i>	эр		3800.0	
			эм		4260.0	
16	Саарал чоно*	<i>Canis lupus</i>	эр эм		102.0	102.0
17	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	эр эм		22.0	22.0
18	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	эр эм		20.0	20.0
19	Нохой элбинх	<i>Nyctereutes procyonoides</i>	эр эм		52.0	
20	Хүрэн баавгай	<i>Ursus arctos</i>	эр эм		1300.0	
21	Мазаалай	<i>Ursus arctos gobiensis</i>	эр эм		3600.0	
22	Ойн булга	<i>Martes zibellina</i>	эр эм		90.0	90.0
23	Суусар булга	<i>Martes foina</i>	эр эм		94.0	94.0
24	Нохой зээх	<i>Gulo gulo</i>	эр эм		146.0	
25	Ойн үен	<i>Mustela sibirica</i>	эр эм		4.3	
26	Солонго үен	<i>Mustela altaica</i>	эр эм		4.2	
27	Цагаан үен	<i>Mustela erminea</i>	эр эм		4.2	
28	Хотны үен	<i>Mustela nivalis</i>	эр эм		4.2	
29	Хүрэн үен	<i>Mustela eversmanni</i>	эр эм		4.2	
30	Усны үен	<i>Mustela vison</i>	эр эм		5.0	
31	Эрээн хүрнэ	<i>Vormela peregusna</i>	эр эм		12.0	
32	Халздай дорго	<i>Meles meles</i>	эр эм		102.0	102.0
33	Голын халиу	<i>Lutra lutra</i>	эр эм		480.0	
34	Цоохор ирвэс	<i>Uncia uncia</i>	эр эм		2240.0	
35	Шүлүүс мий	<i>Lynx lynx</i>	эр эм		460.0	

36	Говийн шүлүүс мий	<i>Lynx lynx isabellina</i>	эр эм		520.0	
37	Мануул мий	<i>Otocolobus manul</i>	эр эм		88.0	
38	Цоохондой мий	<i>Felis silvestris</i>	эр эм		170.0	
39	Бор туулай	<i>Lepus tolai</i>	эр эм		7.0	7.0
40	Чандага туулай	<i>Lepus timidus</i>	эр эм		8.0	8.0
41	Бараан хэрэм	<i>Sciurus vulgaris</i>	эр эм	6.4	6.4	6.4
42	Замба жирх	<i>Tamias sibiricus</i>	эр эм		0.8	
43	Алтайн тарвага	<i>Marmota baibacina</i>	эр эм		36.0	36.0
44	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	эр эм	34.0	34.0	34.0
45	Төв азийн минж	<i>Castor fiber birulai</i>	эр эм		260.0	
46	Заарт ондоотор	<i>Ondatra zibethicus</i>	эр эм	24.0	24.0	24.0

Хоёр. Шувуу /мян.төгрөгөөр/

№	Ан амьтны нэр		Агнуурын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ		Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ
	Монголоор	Англиар	Үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих	Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих	
I.Усны шувуу					
1	Улаангүеэ гахуун	<i>Gavia stellata</i>		6.0	
2	Хилэнгүеэ гахуун	<i>Gavia arctica</i>		6.4	**
3	Халтар шунгуур	<i>Podiceps nigricollis</i>		1.4	
4	Ухаа шунгуур	<i>Podiceps auritus</i>		1.6	
5	Буурал шунгуур	<i>Podiceps griseigena</i>		2.4	
6	Отгот шунгуур	<i>Podiceps cristatus</i>		3.6	**
7	Хурган шунгуур	<i>Podiceps ruficollis</i>		1.0	
8	Борцгор хотон	<i>Pelecanus crispus</i>		1314.0	
9	Тураг гогой	<i>Phalacrocorax carbo</i>	6.2	6.2	**

10	Усны бухшувуу	<i>Botaurus stellaris</i>		3.6	
11	Бичил одойбух	<i>Ixobrychus minitus</i>		1.0	
12	Бөртөт одойбух	<i>Ixobrychus eurhythmus</i>		1.0	
13	Цагаан дэвлээ	<i>Ardeola bacchus</i>		1.8	
14	Ногоовор зашин	<i>Nycticorax nycticorax</i>		2.8	
15	Цасч тэглэй	<i>Egretta alba</i>		5.0	
16	Хурган тэглэй	<i>Egretta garzetta</i>		2.0	
17	Хөх дэглий	<i>Ardea cinerea</i>		3.8	
18	Зээрд дэглий	<i>Ardea purpurea</i>		5.0	
19	Цагаан халбагант	<i>Platalea leucorodia</i>		22.0	
20	Дорнын өрөвтас	<i>Ciconia boyciana</i>		76.0	
21	Хар өрөвтас	<i>Ciconia nigra</i>		40.8	
22	Ягаан нал	<i>Phoenicopterus roseus</i>		16.8	
23	Бор галуу	<i>Anser anser</i>		11.6	**
24	Буурал галуу	<i>Anser fabalis</i>		12.2	**
25	Манхин галуу	<i>Anser albifrons</i>		15.4	**
26	Одой галуу	<i>Anser erythropus</i>		23.8	
27	Хээрийн галуу	<i>Anser indius</i>		22.0	
28	Хошуу галуу	<i>Anser cygnoides</i>		42.2	
29	Гангар хун	<i>Cygnus cygnus</i>		65.2	
30	Хуруут хун	<i>Cygnus olor</i>		96.0	
31	Гунгар хун	<i>Cygnus bewickii</i>		25.0	
32	Модны анхир	<i>Dendrocygna javanica</i>		5.4	
33	Хондон ангир	<i>Tadorna ferruginea</i>		3.4	**
34	Анхидал ангир	<i>Tadorna tadorna</i>		4.0	**
35	Зэрлэг нугас	<i>Anas platyrhynchos</i>		4.6	**
36	Зэрлэгшир нугас	<i>Anas poecilorhynchos</i>		4.0	**
37	Ногоохон нугас	<i>Anas crecca</i>		1.4	**
38	Байгалийн нугас	<i>Anas formosa</i>		28.6	
39	Гэээгт нугас	<i>Anas falcata</i>		2.6	
40	Бор нугас	<i>Anas strepera</i>		3.2	**
41	Зээрд нугас	<i>Anas penelope</i>		2.6	**
42	Шовтгоралаг нугас	<i>Anas acuta</i>		3.2	**

43	Цагаанхөмсөгт нугас	<i>Anas guerguedula</i>		1.8	
44	Халбага нугас	<i>Anas clypeata</i>		3.0	**
45	Мандир уранхажин	<i>Aix galericulata</i>		6.0	
46	Улаанхушуу биваан	<i>Netta rufina</i>		3.0	**
47	Улаанхүзүү шумбуур	<i>Aythya ferina</i>		3.2	**
48	Ундар шумбуур	<i>Aythya nyroca</i>		2.4	
49	Ухаа шумбуур	<i>Aythya baeri</i>		10.0	
50	Гэээгт шумбуур	<i>Aythya fuligula</i>		3.4	**
51	Тэнгисийн шумбуур	<i>Aythya marila</i>		2.2	
52	Хотгуужин чөрх	<i>Histrionicus histrionicus</i>		2.4	
53	Мөнгөлөг шунгаахай	<i>Clangula hyemalis</i>		2.8	
54	Алаг шунгаагч	<i>Bucephala clangula</i>		3.2	**
55	Тольт монхдой	<i>Melanitta deglandi</i>		4.8	**
56	Цагаантолгой ямаансүүлт	<i>Oxyura leucocephala</i>		18.0	
57	Цахиур бохио	<i>Mergus albellus</i>		2.0	
58	Сэвгэр бохио	<i>Mergus serrator</i>		3.2	
59	Хумхин бохио	<i>Mergus merganser</i>		4.0	**
II. Махчин шувуу					
60	Загасч явлаг	<i>Pandion haliaetus</i>		47.6	
61	Балч гоорбис	<i>Pernis apivorus</i>		16.0	
62	Согсоот гоорбис	<i>Pernis ptilorhyncus</i>		16.8	
63	Сохор элээ	<i>Milvus migrans</i>		15.6	
64	Саарал хулд	<i>Circus cyaneus</i>		7.2	
65	Хээрийн хулд	<i>Circus macrourus</i>		15.4	
66	Нугын хулд	<i>Circus pygargus</i>		10.2	
67	Алаг хулд	<i>Circus melanoleucus</i>		7.2	
68	Намгийн хулд	<i>Circus aeruginosus</i>		8.0	
69	Дорнын хулд	<i>Circus spilonotus</i>		8.4	
70	Үлэг харцага	<i>Accipiter gentilis</i>		17.2	
71	Морин харцага	<i>Accipiter nisus</i>		4.6	
72	Үүрсээ харцага	<i>Accipiter badius</i>		4.4	
73	Шунгаагч харцага	<i>Accipiter gularis</i>		3.0	
74	Тарлан сар	<i>Buteo lagopus</i>		14.0	

75	Шилийн сар	<i>Buteo hemilasius</i>	16.8	
76	Талын сар	<i>Buteo rufinus</i>	14.8	
77	Ойн сар	<i>Buteo buteo</i>	13.4	
78	Саржуу харцгай	<i>Butastur indicus</i>	4.4	
79	Могойч загалай	<i>Circaetus gallicus</i>	28.0	
80	Уулын согсоотбүргэд	<i>Spizaetus nipalensis</i>	44.0	
81	Бахим бүргэдэй	<i>Hieraaetus pennatus</i>	12.8	
82	Харсун бүргэдэй	<i>Hieraaetus fasciatus</i>	11.6	
83	Тарважи бүргэд	<i>Aquila nipalensis</i>	50.6	
84	Бор бүргэд	<i>Aquila clanga</i>	71.2	
85	Хан бүргэд	<i>Aquila heliaca</i>	102.6	
86	Цармын бүргэд	<i>Aquila chrysaetos</i>	80.4	
87	Усны нөмрөгбүргэд	<i>Haliaeetus leucoryphus</i>	105.0	
88	Цагаансүүл нөмрөгбүргэд	<i>Haliaeetus albicilla</i>	210.4	
89	Ооч ёл	<i>Gypaetus barbatus</i>	108.0	
90	Дэлт ёлон	<i>Neophron percnopterus</i>	36.0	
91	Нөмрөг тас	<i>Aegyptus monachus</i>	194.4	
92	Ухаа хажир	<i>Gyps fulvus</i>	108.0	
93	Хималайн хажир	<i>Gyps himalayensis</i>	161.4	
94	Цагаан шонхор	<i>Falco rusticolus</i>	64.4	
95	Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>	3200.0	
96	Шилийн шонхор	<i>Falco peregrinoides</i>	13.2	
97	Эгэл шонхор	<i>Falco peregrinus</i>	12.2	
98	Шууман шонхор	<i>Falco subbuteo</i>	4.6	
99	Хайргууна шонхор	<i>Falco columbarius</i>	4.4	
100	Турамтай шонхор	<i>Falco vespertinus</i>	4.0	
101	Амарын шонхор	<i>Falco amurensis</i>	5.6	
102	Зээрд шонхор	<i>Falco naumanni</i>	7.4	
103	Начин шонхор	<i>Falco tinnunculus</i>	4.2	

III. Тахиатан

104	Цагаан ахууна	<i>Lagopus lagopus</i>		3.4	**
105	Цэвдгийн ахууна	<i>Lagopus mutus</i>		3.4	**
106	Хар хур	<i>Lyrurus tetrix</i>		7.2	**
107	Эгэл сойр	<i>Tetrao urogallus</i>		17.2	
108	Нургийн сойр	<i>Tetrao parvirostris</i>		14.8	**
109	Шивэр хөтүү	<i>Tetrastes bonasia</i>		2.0	**
110	Алтайн хойлог	<i>Tetraogallus altaicus</i>		26.0	
111	Эрээнхавирга хахилаг	<i>Alectoris chukar</i>		2.8	**
112	Дагуур ятуу	<i>Perdix dauurica</i>		1.4	**
113	Эгэл бөднө	<i>Coturnix coturnix</i>		0.6	**
114	Наран бөднө	<i>Coturnix japonica</i>		0.6	**
115	Зэрлэг гургуул	<i>Phasianus colchicus</i>		14.6	
116	Гурван шивнүүрт	<i>Turnix tanki</i>		0.4	
117	Алаг тогоруу	<i>Grus japonensis</i>		146.6	
118	Цагаан тогоруу	<i>Grus leucogeranus</i>		154.2	
119	Хархираа тогоруу	<i>Grus grus</i>		44.0	
120	Цэн тогоруу	<i>Grus vipio</i>		136.0	
121	Хар тогоруу	<i>Grus monacha</i>		122.0	
122	Өвөгт тогоруу	<i>Grus virgo</i>		22.4	
123	Усны түнжүүр	<i>Rallus aquaticus</i>		0.8	
124	Цагааномруут түнжүүхэй	<i>Amauornis phoenicurus</i>		0.6	
125	Тоодон түнжгэр	<i>Porzana porzana</i>		0.4	
126	Оодон түнжгэр	<i>Porzana pusilla</i>		0.4	
127	Бичилхэн түнжгэр	<i>Porzana exquisita</i>		0.6	
128	Явган түнжин	<i>Crex crex</i>		0.8	
129	Хажилгат ханчир	<i>Gallinula chloropus</i>		1.2	
130	Халзан түнжүү	<i>Fulica atra</i>		3.0	**
131	Хонин тоодог	<i>Otis tarda</i>		93.5	
132	Жороо тоодог	<i>Chlamydotis undulata</i>		42.0	
133	Өнгөт хараалжир	<i>Rostratula benghalensis</i>		1.0	
134	Буурал сүвээцагаан	<i>Pluvialis squatarola</i>		0.8	**
135	Азийн сүвээцагаан	<i>Pluvialis fulva</i>		0.6	**

136	Хүзүүвчит хиазат	<i>Charadrius hiaticula</i>		0.6	
137	Нарийн хиазат	<i>Charadrius dubius</i>		0.4	**
138	Зэвэн хиазат	<i>Charadrius leschenaultii</i>		0.4	
139	Монгол хиазат	<i>Charadrius mongolus</i>		0.4	
140	Дорнын хиазат	<i>Charadrius veredus</i>		0.6	
141	Тэнгисийн хиазат	<i>Charadrius alexandrinus</i>		0.4	**
142	Урианхайн цагаан хиазат	<i>Eudromias morinellus</i>		0.4	
143	Хээрийн хавтгалж	<i>Chettusia gregaria</i>		0.8	
144	Умардын хавтгаалж	<i>Vanellus vanellus</i>		0.8	**
145	Саарал зуунхурга	<i>Microsarcops cinereus</i>		1.0	
146	Алаг хайргач	<i>Arenaria interpres</i>		0.6	**
147	Эгэл хилэнжигүүр	<i>Himantopus himantopus</i>		1.0	
148	Алаг ээтэн	<i>Recurvirostra avosetta</i>		1.2	**
149	Сүүлцагаан хөгчүү	<i>Tringa ochropus</i>		0.4	**
150	Шугуйн хөгчүү	<i>Tringa glareola</i>		1.8	**
151	Үхэр хөгчүү	<i>Tringa nebularia</i>		0.8	
152	Улаанхөлт хөгчүү	<i>Tringa totanus</i>		0.6	**
153	Хар хөгчүү	<i>Tringa erythropus</i>		0.6	**
154	Бүрдний хөгчүү	<i>Tringa stagnatilis</i>		0.4	**
155	Буурал хөгчүүхэй	<i>Heteroscelus brevipes</i>		0.6	
156	Цэлдэн хөгчүүхэй	<i>Heteroscelus incana</i>		0.6	
157	Эгэл хайргынхөгчүү	<i>Actitis hypoleucos</i>		0.4	**
158	Матигар хөгчүүлэг	<i>Xenus cinereus</i>		0.4	
159	Нарийн сэлээхэй	<i>Phalaropus lobatus</i>		0.4	
160	Улаан сэлээхэй	<i>Phalaropus fulicarius</i>		0.4	
161	Ноцоо ноололдой	<i>Phylomachus pugnax</i>		0.6	
162	Одой элсэг	<i>Calidris minuta</i>		0.4	

163	Шартүрүүт элсэг	<i>Calidris ruficollis</i>	0.4	**
164	Савар элсэг	<i>Calidris subminuta</i>	0.4	**
165	Темминскийн элсэг	<i>Calidris temminckii</i>	0.4	**
166	Хадуур элсэг	<i>Calidris ferruginea</i>	0.2	**
167	Хар элсэг	<i>Calidris alpina</i>	0.4	
168	Сүүл элсэг	<i>Calidris acuminata</i>	0.4	
169	Гурвалж элсэг	<i>Calidris alba</i>	0.4	
170	Шармаг элсэг	<i>Calidris canutus</i>	0.4	
171	Сямби шалчиг	<i>Limicola falcinellus</i>	0.6	
172	Бичил салалж	<i>Lymnocyptes minimus</i>	0.6	
173	Шөвгөн хараалж	<i>Gallinago gallinago</i>	0.8	**
174	Шугуйн хараалж	<i>Gallinago megala</i>	0.8	
175	Замбын хараалж	<i>Gallinago stenura</i>	0.8	**
176	Өнчин хараалж	<i>Gallinago solitaria</i>	0.8	
177	Буурал хомноот	<i>Scolopax rusticola</i>	1.2	**
178	Бичилхэн тутгалжин	<i>Numenius minutus</i>	1.0	
179	Морин тутгалжин	<i>Numenius arquata</i>	0.8	**
180	Мадагаскар тутгалжин	<i>Numenius madagascariensis</i>	1.0	
181	Бэсрэг тутгалжин	<i>Numenius phaeopus</i>	0.8	
182	Морин цууцал	<i>Limosa limosa</i>	0.8	**
183	Хурган цууцал	<i>Limosa lapponica</i>	0.8	
184	Хараалжин цууцил	<i>Limnodromus scolopaceus</i>	0.8	
185	Азийн цууцил	<i>Limnodromus semipalmatus</i>	3.6	
186	Ухаа хөгт	<i>Glareola maldivarum</i>	0.6	
187	Бэсрэг хайлгана	<i>Stercorarius pomarinus</i>	2.2	
188	Годон хайлгана	<i>Stercorarius parasiticus</i>	0.8	
189	Итэлгэн цахлай	<i>Larus ichthyaetus</i>	11.6	
190	Реликт цахлай	<i>Larus relictus</i>	34.2	
191	Хурган цахлай	<i>Larus minutus</i>	0.8	

192	Хүрэнтолгойт цахлай	<i>Larus ridibundus</i>		0.8	**
193	Бортолгойт цахлай	<i>Larus brunnicephalus</i>		1.0	
194	Шөвгөр цахлай	<i>Larus genei</i>		1.4	
195	Мөнгөлөг цахлай	<i>Larus argentatus</i>		2.4	**
196	Үхэр цахлай	<i>Larus cachinnans</i>		4.0	
197	Мөсний цахлай	<i>Larus hyperboreus</i>		3.8	
198	Харсүүлт цахлай	<i>Larus crassirostris</i>		1.8	
199	Үүлэн цахлай	<i>Larus canus</i>		1.6	
200	Гурванхуруут захлай	<i>Rissa tridactyla</i>		1.4	
201	Хүзүүвчит ягаандай	<i>Rhodostethia rosea</i>		1.2	
202	Хилэн хараалзай	<i>Chlidonias niger</i>		0.4	
203	Буурал хараалзай	<i>Chlidonias leucopterus</i>		0.4	**
204	Цагааншанаа хараалзай	<i>Chlidonias hybridus</i>		0.6	
205	Бахим амуулай	<i>Gelochelidon nilotica</i>		0.8	
206	Морин шунгуулай	<i>Hydroprogne caspia</i>		2.0	
207	Эгэл хараалай	<i>Sterna hirundo</i>		0.6	**
208	Хурган хараалай	<i>Sterna albifrons</i>		0.4	
IV. Тагтаатан					
209	Монгол ногтруу	<i>Syrhaptus paradoxus</i>		0.8	**
210	Ойн тагтаа	<i>Columba palumbus</i>		1.4	
211	Хүнхэл тагтаа	<i>Columba oenas</i>		1.0	
212	Хүрэвтэр тагтаа	<i>Columba eversmanni</i>		1.0	
213	Хөхвөр тагтаа	<i>Columba livia</i>		0.8	**
214	Хадны тагтаа	<i>Columba rupestris</i>		0.8	**
215	Буулгат хүүрзгэнэ	<i>Streptopelia decaocto</i>		0.8	
216	Өрнийн хүүрзгэнэ	<i>Streptopelia turtur</i>		0.8	
217	Дорнын хүүрзгэнэ	<i>Streptopelia orientalis</i>		0.6	**
218	Өөдсөн хүүрзгэнэ	<i>Streptopelia senegalensis</i>		0.8	

219	Эгэл хөхөө	<i>Cuculus canorus</i>		0.4	
220	Ханамал хөхөө	<i>Cuculus saturatus</i>		0.4	
221	Хурган хөхөө	<i>Cuculus poliocephalus</i>		0.4	
222	Жагар хөхөө	<i>Cuculus micropterus</i>		0.4	
223	Цагаан уульж	<i>Nyctea scandiaca</i>		56.0	
224	Эгэл шаршувуу	<i>Bubo bubo</i>		90.8	
225	Соотон гуйванга	<i>Asio otus</i>		10.0	
226	Хулгар гуйванга	<i>Asio flammeus</i>		11.6	
227	Ердийн орволго	<i>Otus scops</i>		3.0	
228	Ойн орволго	<i>Otus sunia</i>		3.0	
229	Савагт ариан	<i>Aegolius funereus</i>		6.4	
230	Хотны бүгээхэй	<i>Athene noctua</i>		5.6	
231	Буслаг сүлиг	<i>Glaucidium passerinum</i>		2.4	
232	Харсуун бэгбаатар	<i>Surnia ulula</i>		10.2	
233	Хув ууль	<i>Strix uralensis</i>		29.6	
234	Угалзан ууль	<i>Strix nebulosa</i>		29.6	
V.Бор шувуутан					
235	Монгол хуланжороо	<i>Podoces hendersoni</i>		26.0	
236	Наран энхэтбялзуухай	<i>Bombycilla japonica</i>		2.0	
237	Наран ажиндар	<i>Megalurus pryeri</i>		2.0	
238	Өгөөлэй шулганаа	<i>Saxicola insignis</i>		8.4	
239	Бахимхушуу хурагч	<i>Paradoxornis heudei</i>		6.0	
240	Бургасны ураншувуу	<i>Remiz pendulinus</i>		1.4	
241	Янковскийн хөмрөг	<i>Emberiza jankowskii</i>		2.0	
242	Наран хөмрөг	<i>Emberiza yessoensis</i>		2.2	

Гурав. Загас /мян.төгрөгөөр/

№	Ан амьтны нэр		Соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнах, барих агнуурын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ	Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ
	Монголоор	Англиар		
1	Амарын хилэм	<i>Asipenser schrenckii</i>		
2	Шивэр хилэм	<i>Asipenser baerii baicalensis</i>		
3	Тул	<i>Hucho taimen</i>		
4	Зэвгэ	<i>Brachymystax lenok</i>	***	**
5	Цагаан загас	<i>Coregonus pidschian</i>	***	**
6	Цагаан хадар	<i>Coregonus chadary</i>	***	**
7	Байгалийн омель	<i>Coreginus migratorius</i>	***	**
8	Пельд	<i>Coregonus peled</i>	***	**
9	Монгол хадран	<i>Thymallus brevirostris</i>	***	**
10	Хөвсгөл хадран	<i>Thymallus nigrescens</i>	***	**
11	Сибирь хадран	<i>Thymallus arcticus</i>	***	**
12	Амарын хадран	<i>Thymallus grubii</i>	***	**
13	Цурхай	<i>Esox lucius</i>	***	**
14	Амарын цурхай	<i>Esox reicherti</i>	***	**
15	Улаан нүдэн	<i>Rutilus rutilus</i>	***	**
16	Байгалийн сугас	<i>Leuciscus baicalensis</i>	***	**
17	Зүүнгарын сугас	<i>Leuciscus dzungaricus</i>	***	**
18	Бух сугас	<i>Leuciscus idus</i>	***	**
19	Амарын сугас	<i>Leuciscus waleckii</i>	***	**
20	Алтайн сугас	<i>Oreoleuciscus potanini</i>	***	**

21	Нохой сугас	<i>Oreoleuciscus angusticephalus</i>	***	**
22	Улаан живэрт	<i>Pseudaspilus leptocephalus</i>	***	**
23	Үхэрдэй	<i>Tinca tinca</i>		
24	Морин загас	<i>Hemibarbus labeo</i>	***	**
25	Толбот морин загас	<i>Hemibarbus maculatus</i>	***	**
26	Цагаан догтор	<i>Erythroculter erythropterus</i>	***	**
27	Улаан далбаат	<i>Chanodichthys mongolicus</i>	***	**
28	Өлгөр цагаан	<i>Culter alburnus</i>	***	**
29	Алтлаг хэлтэг	<i>Carassius carassius</i>	***	**
30	Мөнгөлөг хэлтэг	<i>Carassius gibelio</i>	***	**
31	Булуу цагаан	<i>Cyprinus carpio</i>	***	**
32	Цулбуурт	<i>Parasilurus asotus</i>	***	**
33	Гутаар	<i>Lota lota</i>	***	**
34	Алгана	<i>Perca fluviatilis</i>	***	**
35	Амарын хөөлөнхэй	<i>Pseudorasbora parva</i>	***	**
36	Зантаахай загас	<i>Mesocottus haitej</i>		

Тайлбар: /*/ -Мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнахад төлбөр хураамжаас чөлөөлнө.

/**/ -Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын дагуу ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээг тогтооно.

/***/ -Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын дагуу үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийн хэмжээг тогтооно.

-Төл амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг тухайн бие гүйцсэн бодьгалийн экологи-эдийн засгийн үнэлгээний 70 хувиар тооцож, тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 03-р сарын 16-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Амьтны тухай хуулийн 5.2.4, 7.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ыг 1 дүгээр, “Ховор амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай /Засгийн газрын 2017 оны 9-р тогтоолоор 1, 2-р хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон/.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 291 дүгээр тогтоол, “Жагсаалт, журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 7 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ыг 2 дугаар” гэснийг болон 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд

Н.АЛТАНХУЯГ
С.ОЮУН

ХОВОР АМЬТАН АГНАХ, БАРИХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх) нь халдварт өвчний голомтыг тогтоох зорилгоор ховор амьтныг агнах, барих зөвшөөрлийг эрдэм шинжилгээний байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн албан бичгээр, бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийн маягтаар олгоно.

1.3. Тусгай зөвшөөрлийн маягт, спорт агнуур болон олзворын агнуурын чиглэлээр амьтан агнах, барих гэрээний үлгэрчилсэн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хоёр. Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсанаар ойлгоно

2.1. “Эрдэм, шинжилгээ” гэдэгт амьтны биеийн бүтцийг судлах, эд, эрхтэнд нь гэмтэл учруулалгүйгээр судалгааны багаж, тэмдэг зүүх, хэмжилт хийх, эд эрхтэнээс сорьц авахыг;

2.2. “Соёл, урлагийн зориулалт” гэдэгт үндэстэн, ястны уламжлалт зан үйл, музейн үзмэр, урлагийн бүтээл, амьтны хүрээлэн, соёлын үзвэрт ашиглахыг;

2.3. “Эмчилгээний зориулалт” гэдэгт эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийн дагуу эмийн үйлдвэрлэл, эмчилгээний зорилгоор гаршуулан үржүүлэх замаар ашиглахыг;

2.4. “Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч” гэж тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сумын Засаг дарга, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагатай Амьтны тухай хуулийн 22.5-д зааснаар эхний ээлжинд нэг жилийн хугацаатайгаар, цаашид арван жилийн давтамжтайгаар 30 хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

2.5. “Зуучлагч байгууллага” гэдэгт спорт агнуур болон олзворын чиглэлийн агнуурыг анчдад зуучлах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг хуулийн этгээдийг.

Гурав. Судалгаа шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнах, барих тусгай зөвшөөрөл олгох

3.1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан ан амьтны чиглэлийн мэргэжлийн байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллага нь ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнах, барих хүсэлтийг төрийн захиргааны төв байгууллагад бичгээр гаргана.

3.2. Ховор амьтныг судалгаа шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнах, барих хүсэлтэд амьтны зүйлийн нэр, тоо толгой, үндэслэл, агнах болон барих арга зүй, хугацаа, аймаг, сум, агнуурын бүс нутгийн нэрийг тодорхой заана.

3.3. Улсын тусгай хамгаалалттай газарт ховор амьтан барих тохиолдолд энэхүү журмын 3.2-т зааснаас гадна тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай байгуулсан гэрээг хавсаргана.

3.4. Төрийн захиргааны төв байгууллага нь зөвшөөрлийг олгохдоо холбогдох төрийн болон судалгаа, шинжилгээ, эрүүл мэнд, мал эмнэлэг, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлт гаргуулж болно.

Дөрөв. Спорт агнуур болон олзворын чиглэлээр ан амьтан агнах тусгай зөвшөөрөл олгох

4.1. Тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч дараа онд тусгай зөвшөөрлөөр агнах амьтны тоо хэмжээний саналыг батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөө, хяналтын үнэлгээг үндэслэн жил бүрийн 10 дугаар сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ. /Энэ заалтыг ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөн найруулсан/

4.2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь энэхүү журмын 4.1-д заасан хүсэлт, аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд үндэслэн дараа онд тусгай зөвшөөрлөөр агнах амьтны тоо хэмжээний саналыг аймгийн хэмжээнд нэгтгэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ. /Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон/

4.3. Төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай гэж үзвэл ан амьтны тоо толгойн хяналтын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагчийн хөрөнгөөр хийлгэж болно.

4.4. Төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын санал, аймгийн болон агнуурын бүс нутгийн батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөө, энэхүү журмын 4.3-т заасан үнэлгээний дүгнэлтийг харгалзаж дараа онд тусгай зориулалтаар спорт болон олзворын чиглэлээр агнах, барих амьтны тоо хэмжээний саналыг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлнэ. /Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон/

4.5. Тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг Засгийн газар баталснаас хойш ажлын 14 хоногт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараа онд тусгай зөвшөөрлөөр агнах, барих амьтны тоо толгойг агнуурын бүс нутгаар хуваарилан батална.

4.6. Энэхүү журмын 2.4-т заасан байгууллага нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, зуучлагч байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж, заасан хуваарийн дагуу ан амьтан агнах ажлыг зохион байгуулна. /Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон/

4.7. Тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч байгууллага нь гадаадын анчдад зуучлах үүргийг өөрөө хариуцан гүйцэтгэж байгаа тохиолдолд зөвхөн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулж болно. /Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон/

4.8. Тухайн агнуурын бүс нутаг нь орон нутгийн тусгай хамгаалалттай газарт бүртгэгдсэн тохиолдолд энэхүү журмын 4.6, 4.7-д заасан гэрээг аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулна. /Энэ заалтыг ЗГ-ын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөн найруулсан/

4.9. Төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудлыг хариуцсан нэгж энэхүү журмын 4.6, 4.7-д заасан гэрээний эх хувь, агнуулах ангийн төлбөр, хураамжийг төлсөн санхүүгийн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгоно.

Тав. Спорт агнуур болон олзворын чиглэлээр ан амьтан барих тусгай зөвшөөрөл олгох

5.1. Амьтны тухай хуулийн 22.3-т заасны дагуу сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрийн нутаг дэвсгэртээ нарийвчилсан агнуур зохион байгуулалтад үндэслэн спорт агнуурын зорилгоор загас, олзворын чиглэлээр ховор шувуу барих газрыг тогтооно. Загасчлах газар нь агнуурын ховор загасны амьдрах орчинтой давхардах эсэхийг шийдвэрт тодорхой тусгана.

5.2. Агнуурын ховор загасны амьдрах орчинд зөвхөн Амьтны тухай хуулийн 21.1.6-д заасан аргаар загасчилна.

5.3. Төрийн захиргааны төв байгууллага агнуурын ховор загас, шувуу барих тусгай зөвшөөрлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга, зуучлагч байгууллагатай хийсэн гэрээ, барих ангийн төлбөр, хураамжийг төлсөн баримтыг үндэслэн олгоно /Энэ заалтад Засгийн газрын 2017 оны 9-р тогтоолоор өөрчлөлт орсон/.

5.4. Агнуурын ховор загас барих нэг удаагийн тусгай зөвшөөрлийн хугацаа 14 хоног хүртэл байна. Агнуурын ховор загас барих тусгай зөвшөөрлийн төлбөрийг хүн/хоноогоор тооцно.

Зургаа. Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч байгууллагад тавигдах шалгуур үзүүлэлт

6.1. Энэхүү журмын 2.4-т заасан байгууллага нь хариуцаж байгаа агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.

6.2. Ан агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймаг, сумын Засаг даргатай хамтран дүгнэж, тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад жил бүр хүлээлгэн өгнө.

6.3. Зуучлагч байгууллагатай хийсэн ховор амьтан агнах, барих ажил үйлчилгээний гэрээний биелэлтийг хангана.

6.4. Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч байгууллага нь энэхүү журмын 4.6, 4.7-д заасан ховор амьтан агнах, барих гэрээний биелэлтийн тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад жил бүрийн 11 дүгээр сарын 15-наас өмнө хүргүүлнэ.

6.5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу тусгай зориулалтаар агнаж, барьсан ан амьтны төлбөрийн орлогын 50-иас доошгүй хувийг агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна.

6.6. Агнуурын бүс нутагт тусгай зөвшөөрлөөр агнаж, барьсан ан амьтны төлбөрийн 50-иас доошгүй хувийг зөвхөн тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна.

Долоо. Зуучлагч байгууллагад тавих шалгуур үзүүлэлт /Энэ хэсгийг Засгийн газрын 2017 оны 9-р тогтоолоор нэмсэн/

7.1. Зуучлагч байгууллага нь энэхүү журмын 4.6, 4.7-д заасны дагуу ховор амьтан агнах, барих ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

7.2. Зуучлагч байгууллага гадаадын болон дотоодын анчдад зуучлан ан хийлгэх мэргэжлийн боловсон хүчинтэй байна.

7.3. Зуучлагч байгууллага спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр амьтан агнах, барихдаа Амьтны тухай хуульд хориглохоор заасан арга, зэвсэг хэрэгсэл хэрэглэхгүй, хориглосон үйл ажиллагааг явуулахгүй.

7.4. Ховор амьтан агнах, барих ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээний биелэлтийн тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Найм. Бусад /Энэ хэсгийг Засгийн газрын 2017 оны 9-р тогтоолоор нэмсэн/

8.1. Засгийн газрын болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу тухайн жилд гадаадын иргэд (анчид)-д зуучлан агнуулах хуваарьт заасан ангаас угалз, тэхийг бүрэн агнуулж чадаагүй, эсхүл нийт ангийнхаа 75-аас доошгүй хувийг борлуулж чадаагүй зуучлагч байгууллагын дараа жилийн хуваарийг хасч тогтооно.

8.2. Зуучлагч байгууллага нь тухайн жилд гадаадын иргэд (анчид)-ээр тусгай зориулалтын анг агнуулахдаа хууль тогтоомжид хориглосон арга, хэрэгсэл ашигласан, эсхүл агнуурын бүс нутгийн хилийн заагаас гадна агнуулсан бол түүний агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах арга хэмжээг авна.

8.3. Иргэн, хуулийн этгээд нь энэ журам болон “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ыг зөрчсөн тохиолдолд тэдгээрийн мэргэжлийн байгууллагын эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

1995 оны 10-р сарын 24-ний өдөр

Дугаар 139/А/148

Улаанбаатар хот

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

/Монгол оронд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалт/

Байгалийн ургамлын тухай монгол улсын хуулийн 20 дугаар зүйлийн 1 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ:

1. Монгол оронд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалтыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарих ажилд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

З.БАТЖАРГАЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Л.НЯМДАВАА

*Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайдын
1995 оны 10-р сарын 24-ний өдрийн хамтарсан
тушаалын хавсралт*

**МОНГОЛ ОРОНД УРГАДАГ МАНСУУРУУЛАХ
БОДИС БҮХИЙ УРГАМЛЫН ЖАГСААЛТ**

1. Мансуурлагч намуу
2. Таримал олс
3. Хогийн олс

Papaver somni ferum
Connabis sativa
Cannabis ruderalis

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

2007 оны 10-р сарын 01-ний өдөр

Дугаар 292

Улаанбаатар хот

ЖУРАМ, ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ

/Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээжийг гадаад улсад гаргах журам/

“Амьтны аймгийн тухай хууль”-ийн 23 дугаар зүйл, “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль”-ийн 8, 9 дүгээр зүйл, “Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээжийг гадаад улсад гаргах журам”-ыг 1 дүгээр, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц /CITES/-ийн дагуу олгох зөвшөөрлийн гэрчилгээ”-ний загварыг 2 дугаар, “Амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийн экспортын зөвшөөрөл”-ийн загварыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Тушаал хүчингүй болгох, зөвшөөрлийн загвар батлах тухай” Байгаль орчны сайдын 2004 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 174 дүгээр тушаалын 2, 4, 6 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

АН АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, АН АМЬТНЫ ХОЛБОГДОЛТОЙ СУДАЛГААНЫ АЖЛЫН СОРЬЦ, ДЭЭЖИЙГ ГАДААД УЛСАД ГАРГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Хөхтөн амьтан, шувуу, загас, хоёр нутагтан, хэвлээр явагсад, шавьж болон /цаашид “ан амьтан” гэх/ тэдгээрийн гаралтай түүхий эд, амьтны холбогдолтой судалгааны сорьц, дээжийг аливаа зориулалтаар гадаад улсад гаргахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээжийг гадаад улсад гаргах зөвшөөрлийг олгоход “Амьтны аймгийн тухай хууль”, “Ан агнуурын тухай хууль”, “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль”, “Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоол болон Байгаль орчны сайдын 2001 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг мөрдлөг болгоно.

1.3. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, олон улсын болон гадаадын байгууллага, Монгол Улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс энэхүү журмыг нэгэн адил мөрдөнө.

Хоёр. Ан амьтныг гадаад улсад гаргах

2.1. Нэн ховор ан амьтныг гадаад улсад гаргах зөвшөөрлийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2.2. Нэн ховор ан амьтнаас бусад ан амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг Засгийн газраас тогтоосон тоо хэмжээнд багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгоно.

2.3. Ан амьтныг гадаад улсад гаргах зөвшөөрлийг нэг загварын, нэгдсэн дугаар бүхий хэвлэмэл тусгай маягтаар олгоно. Зөвшөөрөл олгох нэгж, албан тушаалтныг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

Гурав. Ан амьтаны гаралтай түүхий эд, судалгааны сорьц, дээжийг гадаад улсад гаргах

3.1. Ан амьтны гаралтай түүхий эд, судалгааны сорьц, дээжийг гадаад улсад гаргах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч уг түүхий эд, сорьц, дээжийн гарал үүсэл, тоо хэмжээ, чанар байдал, тэдгээрийг хэзээ, хаанаас ямар зөвшөөрлөөр хэрхэн бэлтгэсэн, эсвэл худалдан авсан, уг зүйлийг бэлтгэхтэй холбогдсон төлбөр, хураамжийн барагдуулалт, энэхүү экспортын үйл ажиллагаа нь олон улсын холбогдох гэрээ, конвенц, Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг нарийвчлан хянана.

3.2. Ан амьтны гаралтай түүхий эд, судалгааны сорьц, дээжийг гадаад улсад гаргах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дор дурдсан баримтыг бүрдүүлсэн байна.

а/ тухайн түүхий эд, сорьц дээжийг бэлтгэхийн тулд ан амьтныг агнаж, барихад эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл;

б/ агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтныг агнах, барих зөвшөөрлийн хураамжийг төлсөн тухай баримт;

в/ тухайн түүхий эдийг худалдан авсан бол энэ тухай хоёр талын хамтран үйлдсэн тэмдэглэл байхын зэрэгцээ энэ журмын 3.2-ын а,б-д заасан баримт бичгийг хавсаргасан байх;

г/ судалгаа, шинжилгээний ажил хийж сорьц, дээж авах тухай гадаад, дотоодын байгууллагатай хийсэн гэрээ, хэлэлцээ, судалгааны ажлын удирдамж,

уг сорьц, дээжийг гадаад улсад гаргах зөвшөөрөл хүсэх тухай албан бичиг; д/ боловсруулаагүй тарвага зурамны арьс, тарвага зурамнаас авч бэлтгэсэн түүхий эд, сорьц, дээжинд ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай байгалийн голомтод халдварт өвчнийг эсэргүүцэн судлах байгууллагын тодорхойлолт.

3.3. Гадаад улсад гаргах зориулалтаар ан амьтныг агнах, барихдаа “Ан агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дугаар заалт, 2 дахь хэсгийн 5 дугаар заалт, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт болон “Жагсаалт, үнэлгээ, төлбөр хураамжийн хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг үндэслэн ан амьтан барих төлбөр, хураамжийг тухайн амьтныг барих зөвшөөрөл авахдаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллалад төлөх бөгөөд уг байгууллага нь мөн хуульд заасан хувь хэмжээгээр төлбөр хураамжийн мөнгийг улсын төвлөрсөн төсөв болон холбогдох сумын төсөвт шилжүүлнэ.

Дөрөв. Гадаад улсад гаргахыг хориглох ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд

4.1. Монгол улсын ан агнуурын хуулиар агнах, барихыг хориглосон ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг гадаад улсад гаргахыг хориглоно.

4.2. Зохиох журмын дагуу бэлтгэгдсэн бугын цусан ба ясан эвэр, холбогдох зөвшөөрөлтэйгөөр гадаадын анчдын агнасан ангийн олзворын зүйл /эвэр, арьс, шир г.м/ энэ зүйлийн 1-д хамаарахгүй.

Тав. Бусад зүйл

5.1. Ан амьтныг хамгаалах зорилгоор зарим ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны сорьц, дээжийг гадаад улсад гаргахыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь, 15 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу бүрэн буюу тодорхой хугацаагаар хориглоно.

5.2. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц /CITES/-ийн I ба II хавсралтад орсон амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг гадаад улсад гаргах зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Конвенцийн Монголын талын Удирдан зохицуулах зөвлөлийн дарга олгоно.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Монгол улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Соёмбо

МОНГОЛ УЛС
MONGOLIA

Албан
Лого

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ
MINISTRY OF NATURE AND ENVIRONMENT

**АН АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙГ ГАДААДАД ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ
PERMIT FOR EXPORT FOR ANIMALS, THEIR PARTS AND DERIVATIVES**

Үйлчлүүлэгч байгууллагын нэр, регистрийн дугаар, хаяг, утас/ Seller, address, registration	ЭХ ХУВЬ/ ORIGINAL					
	Зөвшөөрлийн дугаар/ Permit ¹			Хүчинтэй хугацаа/ Valid until		
Хүлээн авагч/ Impoter	Гэрээний дугаар/ Contract number			Он,сар, өдөр, / Date		
	Гарал үүсэл/ Country of origin			Хүлээн авах улс/ Country of destination		
Тээвэрлэх төрөл/ Transport type	Төлбөрийн нөхцөл/ Terms of payment					
	Валютын нэр/ Currency		Ханш/ Rate	Хэлцлийн төрөл/ Type of trade		
Гарах боомт/ Port	Техникийн нөхцөл/ Special conditions					
Барааны код/ Code	Ан амьтны шинжлэх ухааны болон ерөнхий нэр/ Scientific name (genus and species) and common name of animal	Амьд бол нас/ хүйс age/sex if alive	Хэмжих нэгж Unit	Тоо хэмжээ Quantity	Нэгж үнэ Unit price	Бүгд үнэ Total

Дүн/Total

..... Он, сар, өдөр/Date

Тэмдэг/Stamp

Олгосон/issued by

Гарын үсэг/ Signature

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД, ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ**

2008 оны 3-р сарын 26-ны өдөр

Дугаар 120/51

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

/Амьтныг шинжлэх ухааны зориулалтаар барьж, тэмдэглэх журам/

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, “Амьтны аймгийн тухай хууль”-ийн 12.3 дахь заалт, “Ан агнуурын тухай хууль”-ийн 7.1, 11.2.1 дэх заалт, “Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, ан амьтныг барих, тэмдэглэх ажлыг журамлах зорилгоор ТУШААХ нь:

1. “Амьтныг шинжлэх ухааны зориулалтаар барьж, тэмдэглэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газар /А.Энхбат/-т, амьтныг барьж, тэмдэглэх заавар боловсруулж, батлуулахыг Биологийн хүрээлэн /Ц.Жанчив/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД

Г. ШИЙЛЭГДАМБА

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б. ЧАДРАА

АМЬТНЫГ ШИНЖЛЭХ УХААНЫ ЗОРИУЛАЛТААР БАРЬЖ, ТЭМДЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсад амьтныг шинжлэх ухааны зориулалтаар барьж, тэмдэглэн судлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмын “тэмдэглэх” гэдэгт амьтанд бүх төрлийн бөгж, ээмэг, хүзүүвч, микрочип (идэвхигүй бичил дамжуулагч), радио, акустик ба сансарын долгион дамжуулагч багаж, тусгай будагч бодис зэрэг бусад тэмдэг зүүх, тэмдэглэгээ хийх үйл ажиллагааг ойлгоно.

1.3. Журмын “шинжлэх ухааны зориулалтаар” гэдэгт гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, баг, эрдэмтэн, судлаачдын зүгээс амьтны биологи, экологийн судалгаа, хяналт шинжилгээ хийх, өвчин эмгэгийн тархалтыг хянах, популяцийн хөдлөл, нүүдэл, шилжилт хөдөлгөөн, зан төрхийг судлах, эзэмшил нутгийг тодорхойлох, тоо толгойн үнэлгээ хийх зэрэг судалгааны ажил хамаарна.

1.4. Аж ахуйн зорилгоор тэжээвэр амьтан барих тэмдэглэхэд энэхүү журам хамаарахгүй.

1.5. Тив, бүс нутгийн хэмжээнд хэрэглэдэг, хүлээн зөвшөөрсөн тэмдгийг Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр хэрэглэж болно.

Хоёр. Оролцогч талуудын хүлээх эрх, үүрэг

2.1. Оролцогч талууд гэдэгт Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага, Биологийн хүрээлэн, хэрэгжүүлэгч этгээдүүд гэсэн 3 субъект хамрагдана.

2.2. Хэрэгжүүлэгч этгээд гэдэгт амьтан барьж, тэмдэглэх хүсэлт гаргаж, зөвшөөрөл авсан гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач байж болно.

2.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.3.1. Биологийн хүрээлэнгийн саналыг үндэслэн хэрэгжүүлэгч этгээдэд амьтан барьж, тэмдэглэх зөвшөөрөл олгох, эсвэл олгохоос татгалзах;

2.3.2. Шаардлагатай бол Биологийн хүрээлэн болон хэрэгжүүлэгч этгээдээс нэмэлт мэдээлэл гаргаж өгөхийг шаардах;

2.3.3. Энэ журмын 3-р зүйлд заасан амьтныг барьж, тэмдэглэх зааврыг батлаж, мөрдүүлэх;

2.4. Биологийн хүрээлэн нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.4.1. Амьтныг барьж, тэмдэглэх тухай хэрэгжүүлэгч этгээдээс тавьсан хүсэлтийг хүлээн авч, судлаж, хянаж нягтлаад ажлын 14 хоногт багтаан санал өгөх;

2.4.2. Амьтныг барьж тэмдэглэх талаар журмын 3 дугаар зүйлд заасан зааврыг боловсруулж, батлуулах;

2.4.3. Энэ журмын 2.3.1-д заасны дагуу зөвшөөрөл авсан хэрэгжүүлэгч этгээдтэй гэрээ байгуулж амьтны тэмдэг олгож зарцуулалтанд хяналт тавих;

2.4.4. Амьтныг барьж, тэмдэглэхтэй холбогдсон мэдээллийн санг энэхүү журмын 4.1-д заасны дагуу байгуулах, хөтлөх, нээлттэй, хүртээмжтэй байлгах;

2.5. Хэрэгжүүлэгч этгээд нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.5.1. Ямар амьтныг, хэзээ, хаанаас, хэдийг, ямар арга зүйгээр барих, уг амьтнаас ямар төрлийн, хэдий хэмжээний дээж авах, ямар тэмдэг тавих, ажлын үр дүнг хэрхэн тайлагнах зэргийг дэлгэрэнгүй дурдсан төсөл, хүсэлтээ Биологийн хүрээлэнд хүргүүлэх;

2.5.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн нөхцөлд 2.4.3-д заасан гэрээ байгуулах;

2.5.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрөлд дурдагдсан тоо хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр амьтныг барьж, тэмдэглэх;

2.5.4. Амьтныг барьж, тэмдэглэх ажлыг гүйцэтгэхдээ журмын 3-д заасан зааврыг мөрдөх;

2.5.5. Амьтныг барьж, тэмдэглэхтэй холбогдон бий болсон мэдээллийг журмын 4.1-д заасны дагуу мэдээллийн санд оруулах, шаардлагатай тохиолдолд оролцогч талуудтай мэдээллээ солилцох;

Гурав. Амьтныг барьж, тэмдэглэх заавар

3.1. Амьтныг барьж, тэмдэглэх заавар нь амьтантай энэрэнгүй харьцах, түүнд гэмтэл, үхэл учруулахгүйгээр барьж, тэмдэглэх, буцаан тавих, тэмдэглэгдсэн амьтнаас холбогдох мэдээллийг авахтай холбогдсон үйл ажиллагааны болон менежментийн арга хэмжээг тусгасан баримт бичиг юм.

3.2. Амьтныг барьж, тэмдэглэх заавар нь дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

3.2.1. амьтан барих зөвшөөрөгдсөн болон хориотой арга, хэрэглэх бодис, ан амьтантай хэрхэн харьцах, зүүх ээмэг, бөгж, хүзүүвч зэргийг тодорхойлох;

3.2.2. Биологийн хүрээлэн, хэрэгжүүлэгч этгээдийн хооронд байгуулах гэрээний загвар, ажлын үр дүнг хэрхэн тайлагнах;

3.2.3. Амьтанд хэрэглэх тэмдэг дээр ямар мэдээлэл оруулж болох зэргийг бүрэн тусгасан байна.

Дөрөв. Мэдээллийн сан

4.1. Амьтныг барьж, тэмдэглэхтэй холбогдон бий болсон мэдээллийн санд дараах мэдээлэл багтсан байна. Үүнд:

4.1.1 Амьтанд зүүсэн тэмдэгний төрөл, дугаар, тэмдэглээний хэлбэр;

4.1.2. Тэмдэглэсэн амьтны зүйлийн нэр, нас, хүйс, морфологийн болон бусад хэмжилтийн үзүүлэлт;

4.1.3. Амьтныг барьж, тэмдэглэсэн огноо, цаг, минут, газар нутгийн нэр, солбилцол, өндөршил, ландшафтын төрөл;

4.1.4. Тэмдэглэсэн амьтны бүртгэгдсэн дохиолол, түүний давтамж, байршил, шилжилт хөдөлгөөн, нүүдлийн зам, биологи, экологийн холбогдолтой мэдээлэл;

4.1.5. Тэмдэг зүүсэн, олсон, зураг авсан хүний талаарх мэдээлэл зэрэг болно.

4.2. Мэдээллийн сан гадаад, дотоодын мэргэжлийн баг, байгууллага, эрдэмтэн, судлаачдад нээлттэй, хүртээмжтэй байна.

Тав. Ан амьтанд зүүх тэмдэгийг өмчлөх

5.1. Амьтанд зүүх тэмдгийг өмчлөх асуудлыг Биологийн хүрээлэн, хэрэгжүүлэгч этгээдийн хооронд байгуулсан гэрээг үндэслэн Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

5.2. Улс, орон нутгийн төсөв, Байгаль хамгаалах сан, олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр хийлгэсэн тэмдэг төрийн өмч байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

2008 оны 06-р сарын 04-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хууль»-ийн 7.3 дахь, “Ан агнуурын тухай хууль”-ийн 14.1.5 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэнд агнуулсан болон гадаад оронд амьдаар нь гаргасан ан амьтны төлбөр, хураамжийн орлогыг төвлөрүүлэх валютын орлогын шинэ данс нээсэнтэй холбогдуулан Байгаль орчны сайдын 2008 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 79 тоот тушаалаар батлагдсан “Ан амьтан агнах барих зөвшөөрөл олгох журам”-ын 17.12-д “. . Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Хадгаламж банкн дахь 1700012264” гэж заасныг “Монгол банк дахь Байгаль орчны яамны 3332414 “ гэж өөрчилсүгэй.

2. Агнуурын амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэлд моторт завь гэж ороогүй тул “Ан амьтан агнах барих зөвшөөрөл олгох журам”-ын 17.10-д заасан “. . бөгөөд загасчлах явцад моторт завийг голын ай сав газарт ашиглахыг хориглоно” гэдгийг хассугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

CITES-ийн ЗӨВШӨӨРЛИЙН БИЧГИЙН ЗАГВАР



CONVENTION ON
INTERNATIONAL TRADE IN
ENDANGERED SPECIES OF
WILD FAUNA AND FLORA



ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН
ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН
ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИ

PERMIT / CERTIFICATE №

- EXPORT
 RE-EXPORT
 IMPORT
 OTHER

Original

2. Valid until
Хүчинтэй байх хугацаа

3. Importer (name and address) Импортлогчийн нэр, хаяг			4. Exporter (name and address, country) Экспортлогчийн нэр, хаяг, улсын нэр		
3a. Country of importer Импортлогч улсын нэр			Signature of the applicant Хүсэлт тавигчийн гарын үсэг		
5. Special conditions Тусгай нөхцөл			6. Name, address, national seal/stamp and country of Management Authority		
<p>For live animals, this permit or certificate is only valid if the transport conditions conform to the Guidelines for Transport of Live Animals or, in the case of air transport, to the IATA Live Animals Regulations.</p> <p>Амьд амьтныг агаараар тээвэрлэхэд олон улсын агаараар амьд амьтан тээвэрлэх журмын дагуу, бусад тохиолдолд амьд амьтныг тээвэрлэх тусгай зааврын нөхцлийг хангасан тохиолдолд зөвшөөрөл олгоно.</p>			 <p>MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM Government Building #2 United Nations Street 5/2, Ulaanbaatar-15160, MONGOLIA Tel: 976-51-261726 Fax: 976-11-321401 E-mail: mne@mongol.net</p>		
5a. Purpose of the transaction (see reverse) Худалдааны зорилго		5b. Security stamp № Маркны дугаар			
7/8. SCIENTIFIC NAME (genus and species) AND COMMON NAME OF ANIMAL OR PLANT Шинжлэх ухаан (төрөл зүйл)-ын болон ерөнхий нэр		9. Description of specimens, including identifying marks or numbers (age/sex if live) Зүйлийн биетийн тодорхойлолт, таних шинж, дугаар (хэрэв амьд бол нэслүйе)		10. Appendix No and source Хавсралтын дугаар, гарал үүсэл	11. Quantity (including unit) Тоо хэмжээ (хэмжих нэгж)
11a. Total exported/Quota Экспортын тоо/Зөвшөөрөгдсөн тоо		A			
B					
C					
12. Country of origin * Эхэлж экспортлосон улсын нэр *	Permit No Зөвшөөрлийн дугаар	Date Он сар өдөр	12a. Country of last re-export Хамгийн сүүлд рэ-экспортлосон улсын нэр	Certificate No Зөвшөөрлийн дугаар	Date Он сар өдөр
12b. Number of the operation ** or date of acquisition *** Үйл ажиллагааны дугаар ** эсвэл олж эзэмшсэн хугацаа ***					
<p>* Country in which the specimens were taken from the wild, bred in captivity or artificially propagated (only in case of re-export) Зүйлийн биет нь ямар орноос гаралтай, зэрлэг эсвэл гаршуулсан, таримал эсэх (зөвхөн рэ-экспортлох тохиолдолд)</p> <p>** Only for specimens of Appendix-I species bred in captivity or artificially propagated for commercial purposes I-хавсралтанд орсон зүйлийн биетийг зөвхөн гаршуулж, тарималжуулан арилжааны зориулалтаар худалдаалах тохиолдолд</p> <p>*** For pre-Convention specimens Конвенцид элсэхээс өмнө олж авсан зүйлийн биетүүд</p>					
13. THIS PERMIT IS ISSUED BY: Зөвшөөрлийн бичгийг олгосон:					
 <p>Security stamp, signature and official seal Баталгаат марк, гарын үсэг, тамга</p>					
Place Олгосон газар			Date Он сар өдөр		
14. EXPORT ENDORSEMENT: Хил, гаалийн байгууллагын экспортын зөвшөөрөл:			15. Bill of Lading/Air Waybill Number Ачааны баримт /Аяллын дугаар		
Block Дугаар	Quantity Тоо хэмжээ	A			



МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ
ТҮҮХИЙ ЭД, ЗҮЙЛИЙГ ГАДААДАД ГАРГАХ
ЗӨВШӨӨРӨЛ

0170021

20___ оны ___ дугаар
сарын ___ -ны өдөр

№

Улаанбаатар хот

1. Иргэн, байгууллагын нэр,
регистрийн дугаар
2. Иргэн, байгууллагын хаяг,
утас /факс/-ны дугаар
3. Мэргэжлийн байгууллагын
гэрчилгээний дугаар
4. Экспортлох улсын нэр
5. Худалдан /хүлээн/
авагчийн нэр
6. Түүхий эдийн нэр
/олон улсын нэршил/
7. Тоо хэмжээ /тоо, үсгээр/
8. Техникийн болон тээвэрлэх
нөхцөл
9. Гарах боомтын нэр
10. Зөвшөөрлийн хүчинтэй
байх хугацаа
11. Зөвшөөрөл олгосон:

Эрх бүхий албан тушаалтан 1.
/нэр, гарын үсэг, тамга/ 2.



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн
А/27 тоот тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ
ТҮҮХИЙ ЭД, ЗҮЙЛИЙГ ГАДААДААС ОРУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ

0160051

Улаанбаатар хот

20___ оны ___ дугаар
сарын ___ -ны өдөр

№

1. Иргэн, байгууллагын нэр,
регистрийн дугаар
2. Иргэн, байгууллагын хаяг,
утас /факс/-ны дугаар
3. Мэргэжлийн байгууллагын
гэрчилгээний дугаар
4. Импортлох улсын нэр
5. Худалдан /хүлээн/
авагчийн нэр
6. Түүхий эдийн нэр
/олон улсын нэршил/
7. Тоо хэмжээ /тоо, үсгээр/
8. Техникийн болон тээвэрлэх
нөхцөл
9. Орох боомтын нэр
10. Зөвшөөрлийн хүчинтэй
байх хугацаа
11. Зөвшөөрөл олгосон:
Эрх бүхий албан тушаалтан 1.
/нэр, гарын үсэг, тамга/ 2.



МОНГОЛ УЛС

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн
А/27 тоот тушаалын 6 дугаар хавсралт

АН АГНАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
SPECIAL HUNTING PERMIT

Дугаар /Permit number/ . 0170527

Аймаг /Province/

Сум /Soum/

Зуучлагч байгууллага /Outfitters/

Агнуурын бүс нутаг /Hunting area/

Анчны нэр /Name of hunter/

Менеджментийг хариуцагч /management authority/

Улс /Country/

Агнах ангийн зүйлийн нэр, тоо толгой /Game species, quota/

Олгосон он, сар, өдөр /Issued date/

оны ... сарын ... өдөр

Хүчинтэй хугацаа /Hunting period/

Тамга /stamp/

Зөвшөөрөл олгосон /Permission issued by/

Гарын үеэг /Signature/



МОНГОЛ УЛС

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн
А/27 тоот тушаалын 7 дугаар хавсралт

0170108

ЗАГАС БАРИХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
SPECIAL FISHING PERMIT

Дугаар /Permit number/

Аймаг /Province/

Сум /Soum/

Зуучлагч байгууллага /Outfitters/

Отгор /Fishing camp/

Загасчны нэр /Name of angler/

Голын сав газар /River basin/

Улс /Country/

Барих загасны зүйлийн нэр, тоо /Fish species, quantity/

Олгосон он, сар, өдөр /Issued date/

оны ... сарын ... өдөр

Хүчинтэй хугацаа /Fishing period/

Зөвшөөрөл олгосон /Permission issued by/



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны
04 дүгээр сарын 03-ны өдрийн А/75 дугаар
тушаалын 4 дүгээр хавсралт

АХУЙН ЗОРИУЛАЛТААР АН АМЬТАН АГНАХ, ЗАГАС БАРИХ ЭРХИЙН БИЧИГ

..... оны р сарын ны өдөр

№ 0019400

.....
.....
.....
/оршин суудаг газрын хаяг/

.....-Д

/овог, нэр, регистрийн дугаар/

.....
.....
.....
/сум, дүүрэг, газрын нэр/

.....-ийг

/ан амьтны нэр тоо, үсгээр/

..... оны р сарын -ны өдрөөс оны р сарын
..... -ны өдрийг дуустал / / хоногийн хугацаанд агнах,
барих эрхийн бичиг олгов.

Хураамжинд төгрөг хураав.

Хугацаа дуусмагц хүчингүй.

Тэмдэг

ЭРХИЙН БИЧИГ Олгосон

.....
/албан тушаал, овог, нэр/

.....
/гарын үсэг/

Хүлээн авсан

.....
/гарын үсэг/

ГАРАЛ ҮҮСЛИЙН БИЧИГ

Сери

Дугаар0017800

Аймаг..... Сум

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бэлтгэгчийн нэр, хаяг

Ан амьтны тоо хэмжээ

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бэлтгэх эрхийн бичиг эсхүл гэрээний
дугаар

Түүхий эдийн нэр, төрөл:

Олгосон он..... сар..... өдөр

Хүчинтэй хугацаа сар

Олгосон

/тэмдэг/

.....
/Гарал үүслийн бичиг олгосон улсын байцаагчийн овог нэр, тэмдэг, гарын үсэг/

ТАЛАРХАЛ

Тус гарын авлагын анхны хэвлэлийг эмхэтгэн хянасан Х.Тэрбиш, Ё.Онон, Л.Амгалан, А.Баясгалан, Б.Ичинхорлоо, Д.Суран, Л.Тэмүүжин, Н.Цэвээнмядаг, хэвлэлийн эхийг бэлтгэсэн Ж.Ганбаяр, Э.Шинэцэцэг, зураач Б.Энхзол нарт юуны өмнө талархсанаа илэрхийлье. Энэхүү хоёр дахь хэвлэлийг бэлтгэх санаачлагыг гаргаж, хамтран ажилласан Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын нийт хамт олон, Хууль сахиулах их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа М.Эрдэнэбаяр, МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Байгалийн ухааны салбарын Биологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), профессор Х.Тэрбиш, доктор (Ph.D), профессор Д.Суран болон гэрэл зураг өгч дэмжсэн бүх хүмүүстээ талархлаа.

АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ

- Адъяа, Я. (2007). *Монгол тарвага* (Биологи, экологи, хамгаалал, аж ахуйн холбогдол). ШУА-ийн Биологийн хүрээлэн, Хөхтний экологийн лаборатори (Хоёр дахь хэвлэл). Улаанбаатар (Монгол, Англи хэл дээр)
- Ананьева, Н.Б., Мунхбаяр, Х., Орлов, Н.Л., Семенов, Д.В., Тэрбиш, Х. (1997). *Земноводные и пресмыкающиеся Монголии*. Пресмыкающиеся. КМК Лтд. Москва. 416 стр.
- Баасанжав, Г., Цэнд-Аюуш, Я. (2001). *Монгол орны загас*. Улаанбаатар хот. 180 х.
- Бадамханд, Ж. (2014). *Монгол орны агнуурын амьтдын лавлагаа*. ВСИ Хэвлэлийн компани. Улаанбаатар
- Банников, А.Г. (1954). *Млекопитающие Монгольской Народной Республики*. Труды Монгольской комиссии, вып. 53. Академия наук СССР. Москва
- Батсайхан, Н., Самъяа, Р., Шар, С., Кинг, С.Р.Б. (2010). *Монгол орны хөхтөн амьтад таних гарын авлага*. Лондоны Амьтан судлалын Нийгэмлэг. Лондон
- Боркин, Л.Я., Воробьева, Э.И., Даревский, И.С., Кузьмин, С.Л., Мөнхбаяр, Х., Семенов, Д.В. (1988). *Земноводные и пресмыкающиеся МНР*. Земноводные. М.: Наука. 248 стр.
- Гантигмаа, Ч. (2014). Шавжийн бүлэг. *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн үндэсний анхдугаар тайлан*. (Эмхэтгэсэн: Мягмарсүрэн, Ш., Гомбобаатар, С., Мөнхжаргал, М., Конабой, Н). Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Степ форвард хөтөлбөр, Лондоны амьтан судлалын нийгэмлэг, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. х.10
- Грубов, В.И. (2008). *Монголын гуурст ургамал таних бичиг*. Улаанбаатар. 503 х.
- Дуламцэрэн, С. (1970). *Монгол орны хөхтөн амьтан тодорхойлох бичиг*. Шинжлэх Ухаан Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 241 х.
- Дуламцэрэн, С., Цэнджав, Д., Авирмэд, Д. (1989). *БНМАУ-ын амьтны аймаг, Хөхтөн амьтан*. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 160 х.
- Дуламцэрэн, С. (2003). *Дэлэнтний ангилал зүй, ангилбарын монгол нэрс*. Монголын нэр томъёоны комиссын мэдээ. 1 148: 75 х.

- Дулмаа, А., Шагдарсүрэн, О. (1973). *БНМАУ-ын агнуурын амьтан ба ан хамгаалал*. ШУА-ийн хэвлэлийн газар Улаанбаатар. 252 х.
- Лигаа, У., Даариймаа, Ш., Цэрэннадмид, П. Жанчивдорж, Н., Сарангэрэл, У., Бат- Энэрэл, Б. (2009). *Монгол орны ховор ургамлын зурагт лавлах*. Улаанбаатар. 388 х.
- Лхагвасүрэн, Б. (2012). *Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн тайлан*. (Захиалагч: Байгаль орчин, аялал жуулчлалын яам; Санхүүжүүлэгч: НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар; Хамтран ажилласан: БОАЖЯ, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн үндэсний зөвлөл, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Монголын шувуу судлалын нийгэмлэг). Улаанбаатар
- Монгол улсын Засгийн газар. (2011). *Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр* (Монгол улсын Засгийн газрын 2011 оны 9-р сарын 21-ний өдөр 277 дугаар тогтоол, хавсралт 1). Улаанбаатар
- Мөнхбаяр, Х., Тэрбиш, Х., Мөнхбаатар, М. (2010). *Монгол орны хоёрнутагтан, мөлхөгчид*. Улаанбаатар. Мөнхийн үсэг. 78 х.
- Мөнхбаяр, Х., Тэрбиш, Х., Мөнхбаатар, М. (2013). *Мөлхөгч, хоёр нутагтан*. Монгол улсын Улаан ном, Гуравдугаар хэвлэл. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. Улаанбаатар. х. 189-208.
- Мэндсайхан, Б., Дгебуадзе, Ю.Ю., Пүрэвдорж, С. (2017). *Монгол орны загасны лавлах*. Улаанбаатар
- Мягмарсүрэн, Ш., Гомбобаатар, С., Мөнхжаргал, М., Конабой, Н. (2014). *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн үндэсний анхдугаар тайлан*. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Степ форвард хөтөлбөр, Лондоны амьтан судлалын нийгэмлэг, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар
- Тэрбиш, Х., Мөнхбаяр, Х., Clark, E.L., Мөнхбат, Ж., Monks, E.M., Мөнхбаатар, М., Baillie, J.E.M., Батсайхан, Н., Боркин, Л.Я., Самъяа, Р., Семенов, Д.В. (Эмхэтгэгчид, редакторууд). (2006). *Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн Улаан данс*. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот (Англи, Монгол хэлээр)
- Өлзийсайхан, Б. (2009). *Услэг түүхий эд судлал*. Улаанбаатар
- Өлзийхутаг, Н. (1985). *БНМАУ-ын бэлчээр, хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг*. БНМАУ-ын Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэн. Улаанбаатар
- Өлзийхутаг, Н. (1989). *Монгол орны ургамлын аймгийн тойм*. Улаанбаатар
- Эрэгдэндавга, Б. (1969). *Амьтан судлал*. Улаанбаатар
- Соколов, В.Е., Орлов, В.Н. (1980). *Определитель млекопитающих МНР*. Наука. Москва. 351 стр.

- Цэнджав, Д. (2002). *Монгол орны баданга хүдэр (Mochus moschiferus L., 1758)* (Биологи, экологи, тархац, тэжээж үржүүлсэн туршлага). Дэлхийн Байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар. ШУА-ийн Биологийн хүрээлэн, Mongolian Musk deer Conservation Foundation. Жинст-Харганат хэвлэлийн газар. Улаанбаатар (Монгол, Англи хэл дээр)
- Шагдарсүрэн, О. (1966). *Монгол орны агнуурын амьтад*. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар
- Шагдарсүрэн, О (ред.), Жигж, С., Цэнджав, Д., Дуламцэрэн, С., Болд, А., Мөнхбаяр, Х., Дулмаа, А., Эрдэнэжав, Г., Өлзийхутаг, Н., Лигaa, У., Санчир, Ч. (1987). *БНМАУ-ын улаан ном*. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 181 х.
- Шийрэвдамба, Ц., Адъяа, Я., Ганболд, Э., Цэрэнханд, Г. (Ерөнхий редактор, редакторууд). (2016). *Монгол улсын Улаан ном*. БОАЖЯ. (Санхүүжүүлэгч: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Дэ Нэйче Консерванси (TNC) байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар). Улаанбаатар
- Clark, E. L., Мөнхбат, Ж., Дуламцэрэн, С., Baillie, J. E.M., Батсайхан, Н., Самъяа, Р., Stubbe, M (эмхэтгэгчид ба редакторууд). (2006). *Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс*. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 1. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот (Монгол, Англи хэлээр)
- Gombobaatar, S, and Monks, E.M. (compilers), Seidler, R., Samiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu. S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch. (editors) (2011). *Regional Red List Series Vol.7. Birds*. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society (In English)
- Gombobaatar, S (compiler), Brown, H.J., Sumiya, D., Tseveenmyadag, N., Boldbaatar, Sh., Baillie, J.E.M., Batbayar, G., Monks, E.M., Stubbe, M (editors). (2011). *Summary Conservation Action Plans for Mongolian Birds*. Regional Red List Series Vol. 8. Zoological Society of London, Mongolian Ornithological Society and National University of Mongolia. 145 pp.
- Nyambayar, D., Oyuntsetseg, B., and Tungalag, R. (compilers), Jamsran, Ts., Sanchir, Ch., Bachman S., Soninkhishig, N., Gombobaatar, S., Baillie, J.E.M., and Tsendeekhuu Ts. (editors) (2011). *Regional Red List Series Vol. 9. Plants (Part1)*. Zoological Society of London, National University of Mongolia (In English and Mongolian)
- Осock, J., Баасанжав, Г., Baillie, J. E. M., Эрдэнэбат, М., Kottelat, M., Мэндсайхан, В., Smith, К (Эмхэтгэсэн, Редактор). (2006). *Монгол орны загасны Улаан данс*. Бүс нутгийн Улаан данс цуврал. Боть. 3. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон (Англи, Монгол хэл)

АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС

<http://www.legalinfo.mn/>

<http://www.mne.mn/>

<https://www.ezagas.mn/>

<http://naturewallpaperfree.com/mobile/animals-bears/nature-wallpaper-1280x720-1858-659c099c.jpg> (хүрэн баавгай)

<http://www.polar.psu.edu/wp-content/uploads/2016/02/77741341-0f4b-42e5-b4c2-b455a5edff68.jpg> (буган цаа)

http://zhivotnue.ru/image/dicie_zhivotnue/gruzynu/bober/bober_2.jpg (азийн минж)

<https://ih0.redbubble.net/image.26943622.6600/flat,1000x1000,075,f.u4.jpg> (шивэр молцог хандгай)

<http://news.nationalgeographic.com/content/dam/news/photos/000/872/87230.jpg> (баданга хүдэр)